LINGO LAB

Mongolian Language
for Beginners



Bayarmaa Khalzaa

CD Included

Халзаагийн Баярмаа

Монгол хэл

(Эхлэн суралцагчдад зориулав)

Улаанбаатар 2012

© Халзаагийн Баярмаа 2010, 2012
© Энэхүү номыг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулахыг хатуу хориглонс.

ISBN 978–99929–78–49

DDC 494.23077
Б – 384

Хянасан: Х. Олонбаяр
Gillian Parker
Jennifer Roseman

Эхийг хэвлэлтэд бэлдсэн: Ewen Kitto
Х. Баярмаа

Хавтасны зургийг: Ewen Kitto

CD-д дасгалуудыг уншсан: Х. Баярмаа
Х. Олонбаяр
Naomi Joy McKenzie

Proofreading: Olonbayar Khalzaa
Gillian Parker
Jennifer Roseman

Typesetting: Ewen Kitto
Bayarmaa Khalzaa

Cover photo: Ewen Kitto

CD readings: Bayarmaa Khalzaa
Olonbayar Khalzaa
Naomi Joy McKenzie

© Bayarmaa Khalzaa 2010, 2012
© This book may not be copied or reproduced without the permission of the copyright owner.

Оршил

Энэхүү ном нь монгол хэлийг эхлэн сурч буй оюутнуудад зориулагдсан бөгөөд оюутнуудыг энгийн болон энгийн нийлмэл өгүүлбэрээр ярьж сургахад голлон анхаарсан юм.

- Уг ном нь тавин хичээлтэй бөгөөд таван хичээл тутамд давтлага хичээл, тесттэй.
- Хорин янзын нөхцөл байдалд хэрэглэгдэх үг, хэллэгүүдийг багтаасан.
- Хэлзүйг англиар тайлбарлаж, ойлгоход хялбар болгох үүднээс хүснэгт ашиглан үзүүлэв.
- Дасгалуудад оюутанд тулгардаг бодит нөхцөл байдлуудыг тусгасан ба уг номд хэрэглэгдсэн үйл үгсийг англи орчуулгын хамт хавсралтад жагсаан оруулсан.
- Монгол хүмүүсийн нэр нь үгсийн сангийн үгсээс ихэвчлэн бүрддэг учраас зарим тохиолдолд нэр үг үү, хүний нэр үү гэдгийг ялгахад оюутнуудад төвөгтэй байдгийг харгалзан үзэж, эмэгтэй хүний нэрийн ард "маа," эрэгтэй хүний нэрийн ард "хүү"-г тус тус залгаж хэрэглэв. Жишээ нь: Энхмаа, Баярхүү
- Ярианы хэлэнд зарим үг өргөлтөө алдан өмнөх үгтэйгээ хураагдан хэлэгдэх явдал өргөн тохиолддог бөгөөд ярианд хэрхэн хэлэгдэхийг дөрвөлжин хаалтанд хийж харуулав. Жишээ нь: хийх гэж байгаа [hiihgjaigaa]

Энэхүү номыг хийхэд үнэтэй санал зөвлөгөө өгч тусалсан Kathy Sananikone, Rebecca McGregor, Caleb B. Sprenger, Ewen Kitto, Gillian Parker, Jennifer Roseman, Х. Олонбаяр, Naomi Joy McKenzie болон бусад оюутан, найз нөхдөдөө гүн талархал илэрхийлье.

Халзаагийн Баярмаа

Э–шуудангийн хаяг: mongolianed@yahoo.com

Introduction

This book is for beginner students of the Mongolian language. The goal is to have students learn to speak in simple and simple – complex sentences.

- This book has fifty lessons. After every five lessons, there is a review lesson and a test.
- Useful words and expressions for twenty different situations are given throughout the book.
- Grammar is explained in English and tables are used to make it easier to understand.
- Exercises reflect the type of situations students may face. Verbs used in this book are listed in the appendix with English translations.
- Mongolian names often consist of real words, which make it difficult for students to know if a word is a name or just a word. In order for students to recognize names easily, "маа" is added to women's names and "хүү" to men's names. For example, Энхмаа and Баярхүү.
- In colloquial speech, it is common for some words to lose their stress and combine with the preceding word. The spoken forms are given in brackets after the written forms. For example, хийх гэж байгаа [hiihgjaigaa].

I'm very thankful to Kathy Sananikone, Rebecca McGregor, Caleb B. Sprenger, Ewen Kitto, Gillian Parker, Jennifer Roseman, Kh. Olonbayar, Naomi Joy McKenzie and other students and friends for giving worthwhile advice and help.

Bayarmaa Khalzaa

E–mail address: mongolianed@yahoo.com

Гарчиг

Contents

Оршил	Introduction	3
Нэгдүгээр хичээл	**Lesson 1**	**8**
Монгол цагаан толгой	Mongolian alphabet	8
Хоёрдугаар хичээл		**12**
Өргөн хэрэглэгддэг зарим үг, хэллэг	***Some useful words and expressions***	***12***
"Н" гийгүүлэгч	Consonant "н"	14
"З, ж, ц, ч" гийгүүлэгч	Consonants "з, ж, ц and ч"	14
"Г" гийгүүлэгч	Consonant "г"	14
Гуравдугаар хичээл		**15**
Үе	Syllables	15
Эгшиг зохицох ёс	Vowel harmony	18
Дөрөвдүгээр хичээл		**19**
Тооны нэр	Numbers	19
Нэр үгийн нөхцөл (-тай[3], -гүй)	Noun suffix (with, don't have or without)	22
Тавдугаар хичээл		**24**
Асуух сул үг	Question particles	24
Мэндчилгээ	***Greetings***	***29***
Давтлага хичээл	**Review Lesson**	**30**
Тест	**Test**	**32**
Зургадугаар хичээл		**33**
Тэмдэг нэр	Adjectives	33
Долдугаар хичээл		**36**
Өнгө	Colors	36
Хувцас	Clothes	36
Долоо хоног	Week	37
Сар	Months	38
Наймдугаар хичээл		**39**
Харьяалахын тийн ялгал	Genitive case	39
Есдүгээр хичээл		**42**
Биед хамаатуулах нөхцөл	Possessive suffixes	42
Үндэс үүсгэх "-х" дагавар	Suffix "-х"	43
Хүнтэй танилцах	***To get to know people***	***44***
Аравдугаар хичээл		**45**
Үйл үгийн зарим хэлбэр	Some verb forms	45
Үйл үгийн үндэс	Verb stems	47
Давтлага хичээл		**49**
Тест		**52**
Арван нэгдүгээр хичээл		**53**
Өнгөрсөн цаг	Past tense	53
Ерөнхийлөн хамаатуулах нөхцөл (аа[4])	Possessive suffix (аа[4])	58
Хүнтэй уулзаад явахдаа	***When you meet someone and leave***	***60***
Арван хоёрдугаар хичээл		**61**
Баймж үг (дуртай, дургүй)	Modal verbs (like, don't like)	61
Баймж үг (хэрэгтэй, хэрэггүй)	Modal verbs (need, don't need)	63
Арван гуравдугаар хичээл		**65**
Ирээдүй цаг	Future tense	65

Арван дөрөвдүгээр хичээл 68
Хамтрахын тийн ялгал (-тай[3]) Comitative case (have, with) 68
Талархал илэрхийлэх ***To express thankfulness*** ***70***
Арван тавдугаар хичээл 71
Одоо цаг Present tense 71

Давтлага хичээл 75
Тест 77

Арван зургадугаар хичээл 78
Үйл үгийн -маар[4] нөхцөл Verb suffix -маар[4] (want to) 78
Зөөлний тэмдэгтэй холбоотой дүрэм Rules related to the soft sign 80
Хэрхэн цаг хэлэх How to say time 81
Арван долдугаар хичээл 83
Байгаль, цаг агаар Nature and weather 83
Хоол хүнс ***Foods*** ***85***
Арван наймдугаар хичээл 86
Захирах хүсэх төлөв (2-р бие) Imperative mood (for second person) 86
Арван есдүгээр хичээл 89
Холбоос үгс (Яагаад гэвэл, учраас) Conjunctions (Because, that's why) 89
Хорьдугаар хичээл 92
Одоо үргэлжлэх цаг Present continuous tense 92
Өнгөрөн үргэлжлэх цаг Past continuous tense 92
Гудамжны зарим хаяг ***Some signs on the street*** ***96***

Давтлага хичээл 97
Тест 99

Хорин нэгдүгээр хичээл 100
Орон заасан үгс Positional words 100
"Байх" үйл үг The verb "to be" 102
Хорин хоёрдугаар хичээл 103
Тодорхой тийн ялгалтай хэрэглэгддэг зарим үйл үг ***Some verbs which are used with specific cases*** 103
Өгөх оршихын тийн ялгал (-д/-т) Dative and locative case (in, at, for, to) 104
Хорин гуравдугаар хичээл 108
Хөндлөнгийн үг Direct speech 108
Дэлгүүрт ***At the store*** ***110***
Хорин дөрөвдүгээр хичээл 111
Баймж үг (дуртай, дургүй) Modal verbs (like, don't like) 111
Хорин тавдугаар хичээл 113
Нэр үгийн олон тоо Plural form for noun 113
Бичгийн хэрэгсэл Stationery items 116

Давтлага хичээл 117
Тест 119

Хорин зургадугаар хичээл 120
Хүний бие, эрүүл мэнд People's body and health 120
Хичээлд хэрэглэгддэг үгс ***Words that are used in a lesson*** ***122***
Хорин долдугаар хичээл 123
Баймж үг (хэрэгтэй, хэрэггүй) Modal verbs (need, don't need) 123
Хорин наймдугаар хичээл 125
"Байх" үйл үг The verb "to have (something)" 125
...-сан[4]д баярлалаа Thank you for ...-ing 126

Хорин есдүгээр хичээл **127**
Гарахын тийн ялгал (-аас[4]) Ablative case (from, of, than) 127
...-аас[4] ... хүртэл from ... to (until) ... 129
Гучдугаар хичээл **130**
Хөндлөнгийн үг Direct speech 130
-аас[4] шалтгаалах to depend on 131
Давтлага хичээл **132**
Тест **135**
Гучин нэгдүгээр хичээл **136**
Харьцуулсан зэрэг (-аас[4]) Comparative (than) 136
Давуу зэрэг (хамгийн) Superlative (-est/most) 138
Гучин хоёрдугаар хичээл **139**
-ж/-ч чадах to be able to 139
Уучлал гуйх ***To ask for forgiveness*** ***140***
Гучин гуравдугаар хичээл **141**
-ж/-ч болох May 141
Гучин дөрөвдүгээр хичээл **143**
байх аа, магадгүй, юм шиг байна probably, I think maybe, It looks (seems, etc.) like 143
Ресторанд ***At the restaurant*** ***145***
Гучин тавдугаар хичээл **146**
Үйл үгийн -аад[4] нөхцөл Verb suffix -аад[4] (then, and) 146
Автобусанд ***In the bus*** ***149***

Давтлага хичээл **150**
Тест **152**

Гучин зургадугаар хичээл **153**
Үйл үгийн нөхцөл (-ж/-ч) Verb suffix -ж/-ч (and) 153
Таксинд ***In the taxi*** ***155***
Гучин долдугаар хичээл **156**
Зарим мал, амьтан г.м. Some livestock, animals, etc. 156
Гучин наймдугаар хичээл **158**
"Тэгэх" үйл үг Verb "to do so" 158
Аялага үгс ***Interjections*** ***159***
Гучин есдүгээр хичээл **160**
Чиглэхийн тийн ялгал (руу[2]/луу[2]) Directive case (to (towards), at) 160
Дөчдүгээр хичээл **163**
Үйлдэхийн тийн ялгал (-аар[4]) Instrumental case (by, out of, with, during, as, for) 163
Утсаар ярих ***To talk on the phone*** ***169***

Давтлага хичээл **170**
Тест **173**

Дөчин нэгдүгээр хичээл **174**
Заахын тийн ялгал (-ыг[2],-г) Accusative case (Specific direct object) 174
Дөчин хоёрдугаар хичээл **180**
Захирах хүсэх төлөв (1-р бие) Imperative mood (First person) 180
Үндэс үүсгэх -хан[4] дагавар Suffix -хан[4] (It describes a group.) 182
Хүмүүсийг ерөөх ***To say a blessing to people*** ***183***
Дөчин гуравдугаар хичээл **184**
Баймж үг (ёстой) Modal verbs (have to, must, to be supposed to) 184
Ямар нэгэн асуудал гарсан үед ***When there is a problem*** ***186***
Дөчин дөрөвдүгээр хичээл **187**
Энгийн өнгөрсөн цагууд Simple past tenses 187
Саяхан өнгөрсөн цаг Recent past tense 187

Дөчин тавдугаар хичээл **190**
Мэдэгдэлгүй өнгөрсөн цаг — Not personally witnessed past tense — 190

Давтлага хичээл **193**
Тест 1 ..... **197**
Тест 2 ..... **198**

Дөчин зургадугаар хичээл **199**
Яриандүг хэрхэн хураагдан хэлэгдэх нь — How words are shortened in spoken language — 199
Нийлмэл цагууд — Compound tenses — 199
Асуух сул үгс — Question particles — 199
Баяр хүргэх — ***To give congratulations*** — ***201***
Дөчин долдугаар хичээл **202**
билээ?/билүү? — again? (I forgot/I can't remember.) — 202
биз дээ? — isn't it?/is it?, didn't you?/did you? etc. — 203
тийм ээ? — right? — 204
Дөчин наймдугаар хичээл **206**
Ойрын ирээдүй цаг — Near future tense — 206
Эрүүл мэндтэй холбоотой хэллэг — ***Expressions related to health*** — ***207***
Дөчин есдүгээр хичээл **208**
"нь" нөхцөлийн хэрэглээ — Usages of "нь" — 208
Тавьдугаар хичээл **211**
л = зөвхөн, ч = бас — only, also — 211
орчим (-аад), гаруй, шахам — about, more than, almost — 212

Давтлага хичээл **214**
Тест **216**

Дасгалуудын хариу ..... **Key to exercises** **217**

Хавсралт ..... **Appendix** **252**
Энэхүү номд хэрэглэгдсэн үйл үгс — The verbs that are used in this book — 252
Үйл үгийн цагууд — Verb tenses — 257
Нэр үгийн тийн ялгалын нөхцөлүүд — Noun cases — 258
Зөв бичгийн дүрэм — Spelling rules — 259
Гал тогооны өрөө — Kitchen — 260
Унтлагын өрөө — Bedroom — 260
Угаалгын өрөө — Bathroom — 260
Зочны өрөө — Living room — 260

Зарим ёс заншил ..... **Some traditions (Dos and don'ts)** **261**

Ном зүй ..... **Bibliography** **262**

Нэгдүгээр хичээл (Lesson 1)

Монгол цагаан толгой (Mongolian alphabet)

	Printing	Cursive	Pronunciation
1.	**А а**	*А а*	[ah]
2.	**Б б**	*Б б*	[beh]
3.	**В в**	*В в*	[weh]
4.	**Г г**	*Г г*	[geh]
5.	**Д д**	*Д д*	[deh]
6.	**Е е**	*Е е*	[yeh]
7.	**Ё ё**	*Ё ё*	[yaw]
8.	**Ж ж**	*Ж ж*	[jeh]
9.	**З з**	*З з*	[dzeh]
10.	**И и**	*И и*	[ee]
11.	**й**	*й*	[ee]
12.	**К к**	*К к*	[kah]
13.	**Л л**	*Л л*	[il]
14.	**М м**	*М м*	[im]
15.	**Н н**	*Н н*	[in]
16.	**О о**	*О о*	[ô]
17.	**Ө ө**	*Ө ө*	[ö]
18.	**П п**	*П п*	[peh]
19.	**Р р**	*Р р*	[ir]
20.	**С с**	*С с*	[iss]
21.	**Т т**	*Т т*	[teh]
22.	**У у**	*У у*	[oh]
23.	**Ү ү**	*Ү ү*	[oo]
24.	**Ф ф**	*Ф ф*	[feh]
25.	**Х х**	*Х х*	[kheh]
26.	**Ц ц**	*Ц ц*	[tseh]
27.	**Ч ч**	*Ч ч*	[cheh]
28.	**Ш ш**	*Ш ш*	[ish]
29.	**Щ щ**	*Щ щ*	[ishcheh]
30.	**ъ**	*ъ*	Hard sign
31.	**ы**	*ы*	[ee]
32.	**ь**	*ь*	Soft sign
33.	**Э э**	*Э э*	[eh]
34.	**Ю ю**	*Ю ю*	[yo]
35.	**Я я**	*Я я*	[yah]

Mongolian has 35 letters:

13 vowels (эгшиг)	а, о, у, э, ө, ү, и (е, ё, ю, я, й, ы)
20 consonants (гийгүүлэгч)	б, в, г, д, ж, з, к, л, м, н, п, р, с, т, ф, х, ц, ч, ш, щ
2 signs (тэмдэг үсэг)	ъ, ь

- The letters **к**, **п**, **ф**, **щ** are only used in foreign words.
- The letters **й**, **ы**, **ъ** and **ь** never occur at the beginning of words.
- The letter **й** is never by itself. It is used with the vowels **а**, **о**, **э**, **ү**, **у** and **и** (ай, ой, эй, үй, уй and ий) to create diphthongs.
- The letters **ъ** and **ь** have no sound and they are used before suffixes of the imperative mood for first person (я, е and ё) to separate those suffixes from previous consonants. For example, явъя (Let me go), харъя (Let me see), болъё (Let me become), үзье (Let me watch), өгье (Let me give).
- The letter **ь** occurs in masculine words, changes the sound of vowels and differentiates words. For example, ам [am] — mouth, амь [æm] — life.

Дасгал 1 (Exercise 1)

Үсгүүдийг бич. (Write the letters.)

Cursive	Practice writing cursive
А а	
Б б	
В в	
Г г	
Д д	
Е е	
Ё ё	
Ж ж	
З з	
И и	
й	
К к	
Л л	
М м	
Н н	
О о	
Ө ө	
П п	
Р р	
С с	
Т т	
У у	
Ү ү	
Ф ф	
Х х	
Ц ц	
Ч ч	
Ш ш	
Щ щ	
ъ	
ы	
ь	
Э э	
Ю ю	
Я я	

Дасгал 2 (Exercise 2)

Уе, үгсийг дээрээс доош нь бич. (Write the syllables and the words from top to bottom.)

Ба	Ав	лаа	хаашаа
Ва	Он	халуун	тийш
Гэ	Эс	мал	уйл
До	Ут	хөөлий	уйл
Жо	Эц	сөөл	ээжтэй
Зу	Ич	нэр	хойно
Ки	Аж	хоног	ялаа
Ла	Ин	хаан	ёсоор
Мө	боров	рашаан	хөгулаа
Ну	олбол	хуруу	сэвэн
Ро	баар	хавар	нээх
Су	харвах	суу	юунь
Та	үзэв	ноосо	ахлин
Фа	гэр	холс	явъя
Ху	байгаа	тухай	боль
Цэ	шог	хатан	ферм
Чи	дараа	уут	Монгол
Шү	модон	хэзээ	Америк
Яг	хаад	ихэр	Франц
Эл	жам	хийх	Англи
Од	зожиг	цоож	Аффрик
Ог	хааж	байц	Канад
Ар	зүгээр	байцаа	Улаанбаатар
Ус	хүзүү	чолоо	сургуулиасаа
Их	хаз	очих	ороолтоороо
Үз	кино	хаагаач	оглоожингоо
Ол	танк	шороо	эгчийнхээсээ

Дасгал 3 (Exercise 3)

Бичлэгийг сонсоод дагаж хэл. (Listen to the syllables and then repeat them.)

Задгай үе (Open syllables)

Б	В	Г	Д	Ж	З	Л	М	Н	Р	С	Т	Х	Ц	Ч	Ш	
ба	ва	га	да	жа	за	ла	ма	на	ра	са	та	ха	ца	ча	ша	**А**
бо	—	го	до	жо	зо	ло	мо	но	ро	со	то	хо	цо	чо	шо	**О**
бу	—	гу	ду	жу	зу	лу	му	ну	—	су	ту	ху	цу	чу	шу	**У**
бэ	вэ	гэ	дэ	—	зэ	лэ	мэ	нэ	рэ	сэ	тэ	хэ	цэ	—	—	**Э**
бө	вө	гө	дө	жө	зө	лө	мө	нө	рө	сө	тө	хө	цө	чө	шө	**Ө**
бү	—	гү	дү	жү	зү	лү	мү	нү	—	сү	тү	хү	цү	чү	шү	**Ү**
би	ви	ги	ди	жи	—	ли	ми	ни	ри	си	ти	хи	—	чи	ши	**И**

Битүү үе (Closed syllables)

	В	Г	Д	Ж	З	Л	М	Н	Р	С	Т	Х	Ц	Ч	Ш
А	ав	аг	ад	аж	аз	ал	ам	ан	ар	ас	ат	ах	ац	ач	аш
О	ов	ог	од	—	оз	ол	ом	он	ор	ос	от	ох	оц	оч	—
У	ув	уг	уд	уж	—	ул	ум	ун	ур	ус	ут	ух	—	уч	—
Э	эв	эг	эд	эж	эз	эл	эм	эн	эр	эс	эт	эх	эц	эч	эш
Ө	өв	өг	өд	өж	—	өл	өм	өн	өр	өс	өт	өх	өц	өч	өш
Ү	үв	үг	үд	үж	үз	үл	үм	үн	үр	үс	үт	үх	—	—	—
И	ив	иг	ид	иж	из	ил	им	ин	ир	ис	ит	их	—	ич	иш

Дасгал 4 (Exercise 4)

Эгшиг болон жишээ үгсийг сонсоод, дараа нь дэвтэртээ бич. (Listen to the vowels and example words and then write them in your notebook.)

	Short vowels	Examples	**Long vowels**	Examples	**Diphthongs**	Examples
Masculine	**а**	ав	**аа**	аав	**ай**	айв
	о	нор	**оо**	ноор	**ой**	нойр
	у	ул	**уу**	уул	**уй**	уйл
Feminine	**э**	эр	**ээ**	-ээр	**эй**	-ээрэй
	ө	өр	**өө**	өөр	—	—
	ү	үл	**үү**	үүл	**үй**	үйл
Neutral	**и**	им	**ий**	ийм	—	—

Хоёрдугаар хичээл

Өргөн хэрэглэгддэг зарим үг, хэллэг (Some useful words and expressions)

Дасгал 1

Хэллэгүүдийг сонсоод цээжил. (Listen to the expressions and memorize them.)

А: — Сайн байна уу?
Б: — Сайн, сайн байна уу?
А: — Сайн.
Таны (чиний) нэр хэн бэ?
Б: — Миний нэр .....
Таныг хэн гэдэг вэ?
А: — Намайг ..... гэдэг.
А: — Баяртай.
Б: — Баяртай.
А: — Баярлалаа.
Б: — Зүгээр (зүгээр).
А: — Уучлаарай.
Б: — Зүгээр (зүгээр).
А: — Сонин сайхан юу байна?
Б: — Тайван даа.

A: — How are you?
B: — I'm fine, how are you?
A: — I'm fine.
What is your name?
B: — My name is .....
What is your name?
A: — My name is .....
A: — Bye.
B: — Bye.
A: — Thank you.
B: — You are welcome.
A: — Excuse me/Sorry.
B: — No problem.
A: — What's new?
B: — Nothing.

Дасгал 2

Үг, хэллэгүүдийг сонсоод цээжил. (Listen to the words and expressions and then memorize them.)

Тийм. [tii]	Yes.	Юу гэнэ ээ?	What did you say?
Үгүй. [güü]	No.	Одоохон./Байж бай.	Wait a minute.
За.	Okay.	Байна уу?	Hello? (on the phone)
Тийм байх аа.	I think so.	Харин та?	And you?
Үгүй байх аа.	I don't think so.	Харин тийм.	I agree.
Тэгээрэй.	Please.	Тийм шүү дээ. [tiishdee]	YES!/That's right.
Тэгнэ ээ.	I will.	Үгүй шүү дээ. [güüshdee]	Oh, no!
Тийм үү?	Really?	Та бас./Та ч гэсэн.	You, too.
Хамаагүй.	It doesn't matter.	Би бас./Би ч гэсэн.	Me, too.

Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан үндсэн долоон эгшгийг хэлэх, сонсох дасгалыг доорх дарааллаар хий.
(Do exercises below on pronouncing and listening to the seven basic vowels using the given words.)

1. Багш бүх үг, үсгийг уншиж, оюутан сонсоно.

2. Оюутан бүх үг, үсгийг уншина.
3. Багш үсэг, үгсийг энд тэндээс нь уншиж, оюутан багшийн хэлсэн үг, үсгийн өмнөх дугаарыг хэлнэ.
4. Оюутан үсэг, үгсийг энд тэндээс нь уншиж, багш оюутны хэлсэн үг, үсгийн өмнөх дугаарыг хэлнэ.

1. The teacher will read all the words and letters and the student will listen to them.
2. The student will read all of them.
3. The teacher will read words and letters randomly and the student will tell the numbers that are in front of words or letters that the teacher said.
4. The student will read words and letters randomly and the teacher will tell the numbers that are in front of words or letters that the student said.

1. а	1. ар	1. хар	1. ад
2. о	2. ор	2. хор	2. од
3. у	3. ур	3. хур	3. уд
4. э	4. эр	4. хэр	4. эд
5. ө	5. өр	5. хөр	5. өд
6. ү	6. үр	6. хүр	6. үд
7. и	7. ир	7. хир	7. ид

Дасгал 4

Үгсийг унш. (Read the words.)

дар	даар	дайр	бур	буур	буйр
хан	хаан	хайн	тул	туул	туйл
тар	таар	тайр	хэл	хээл	хээлтэй
хаг	хааг	хайг	сэр	сээр	сээртэй
ор	-оор	ойр	хөр	хөөр	хөрөө
тор	тоор	тойр	өр	өөр	өрөө
үх	үүх	үйх	мөр	мөөр	мөрөө
бах	баах	байх	хол	хоол	хоолой

хол	хоол	хойлог	эрвээхэй	байгаа
тос	тоос	тостой	эмээтэй	байгаатай
үс	үүс	үйс	хөдөөнөөс	хайгаарай
хүл	хүүл	хүйл	эрээрэй	хараарай
үр	үүр	үйр	ороорой	мэдээрэй
буд	бууд	буйд	өгөөрэй	бодоорой
цар	цаар	цайр	уугаад	хөрөөдөөрэй
шар	шаар	шайраг	ийшээ	нүдүүрээрээ

Дасгал 5

Үгсийг сонсоод дагаж хэл. (Listen to the words and then repeat them.)

"Н" гийгүүлэгч (Consonant "н")

1. If after "**н**," there are no vowels or consonants other than **х** or **г**, "**н**" sounds like [ng].
2. If after "**н**," there are vowels or consonants other than **х**, **г**, **б**, **м** or **п**, "**н**" sounds like [n].
3. If after "**н**," there is a **б**, **м** or **п**, "**н**" sounds like [m].

1. **[ng]**	2. **[n]**	3. **[m]**
хаан	хаана	Улаанбаатар
байн	байна	Сайн байна уу?
хан	хана	Таны нэр хэн бэ?
он	оно	модон байшин
Монгол	өндөг	хүйтэн мөс
хонхор	онц	улаан перц

Дасгал 6

Үгсийг сонсоод дагаж хэл. (Listen to the words and then repeat them.)

"З, ж, ц, ч" гийгүүлэгч (Consonants "з, ж, ц and ч")

зам	жам	хацар	чоно
аз	жар	байцаа	тогооч
за	аж	цаг	чигээрээ
хэзээ	жа	цацах	чухал
зузаан	журам	цамц	эгч

Дасгал 7

Үгсийг сонсоод дагаж хэл. (Listen to the words and then repeat them.)

"Г" гийгүүлэгч (Consonant "г")

If "**г**" is at the beginning of words or at the end of words without vowels after it, it sounds like [**g**]. If there are vowels behind it, it sounds like [**gh**]. If **т**, **ц**, **ч**, **ш** or **с** are behind it, it sounds like [**h**].

1. **[g]**	2. **[gh]**	3. **[gh]**	4. **[h]**
баг	бага	маргааш	тагтаа
буг	буга	байгаа	цагтаа
таяг	аяга	зургаа	ормогц
гэр	гарга	толгойгоо	хөргөгч
гадаа	болго	малгайгаа	тэгчих
гэрэл	өлгө	хоолойгоо	багш
гудамж	эргэ	байгаагаа	төгс

Гуравдугаар хичээл

Ye (Syllables)

In the Mongolian language, syllables are always divided in front of consonants. Therefore, the second syllable in a word always starts with a consonant. First syllables can start with either vowels or consonants.

- If there is a single consonant in the middle of a word, we divide the word in front of that consonant.
- If there are two consonants together in a word, we divide it between them.
- If there are three consonants together in a word, we divide it in front of the third consonant.

Syllables can consist of **v, vc, vcc, vccc, cv, cvc, cvcc, cvccc** (v — vowels, c — consonants). A single consonant cannot be a syllable. For example:

v	а/мар	**vccc**	эрхт	**cvcc**	харш/лах
vc	эр/дэм	**cv**	са/мар	**cvccc**	талст
vcc	урт/дах	**cvc**	мар/тах		

The stress of a word is on the short vowel of the first syllable, long vowels and diphthongs. Short vowels that are after the first syllable are never pronounced strongly and, if following **н** or **г**, are not pronounced at all. For example:

хэл(э)х	хүлээх(э)д	ург(а)м(а)л
өг(ө)х	хар(а)ндаа	өлг(ө)х(ө)д
үз(э)г	угаах(а)д	он(о)х(о)д
байн(а)	онгойлг(о)х	хөрг(ө)гч(и)нд
гарг(а)	хуурайл(а)х	хулгайл(а)х(а)д
сан(а)	мөрг(ө)х(ө)д	үйлдв(э)рл(э)х(э)д

Дасгал 1

Үгсийг багштайгаа унш. (Read the words with your teacher.)

цаг	гар	цөгц	үхэр
нэг	гэр	хамт	и-хэр
хэл	хүс	талст	о-доо
хар	лам	ха-мар	мэд-лэг
нэр	мэх	ур-гах	мар-тах
мах	хөл	өв-дөх	зөв-лөх
хор	хүн	хэ-лэх	өвт-гөх
хөх	хун	хү-сэх	урт-дах
хуш	жор	хо-ром	амт-лах

Дасгал 2

Сэдвийг сонсоод, дараа нь үгсийг үеэр тасалж унш. (Listen to the text and then complete the reading exercise by dividing the words into syllables.)

For example (Жишээ нь): А/хын сэт/гэл

Ахын сэтгэл[1]

Нэгэн орой Төрхүүг ажлаасаа гаран машиныхаа дэргэд ирэхэд нэг ноорхой хувцастай жаал хүү цоо шинэхэн машиныг нь тойрон алмайран харж байлаа. "Энэ таны машин уу?" гэж хүүг асуухад Төрхүү "Тийм ээ. Ах маань миний төрсөн өдрөөр надад бэлэглэсэн юм" гэв. Хүүг "Хөөх! Би ..." гээд чимээгүй болоход Төрхүү тийм ахтай ч байсан болоосой гэж хүсэж байгаа байх даа гэж бодсон боловч хүүгийн хэлсэн үгийг сонсоод маш их гайхлаа. Хүү "Би таны ах шиг тийм ах байсан ч болоосой" гэв.

Төрхүүг "Машинаар явж үзэх үү?" гэхэд хүү зөвшөөрч машинд нь суулаа. Жаахан яваад хүү "Тэр шатны хажууд зогсоод өгөөч" гэв. Хүү машинаас буугаад шатаар дээш өгсөн гүйлээ. Удалгүй хүү эрэмдэг дүүгээ үүрэн доош бууж ирээд "Энэ машиныг ах нь түүнд төрсөн өдрөөр нь бэлэглэсэн юм. Нэг өдөр би чамд бас машин бэлэглэнэ ээ. Тэгээд чи өөрөө машинаараа явж, миний чамд ярьж өгдөг зүйлсийг үзэх болно" гэж хэлэв.

Дасгал 3

Доорх сэдвийн үгсийн хоёрдугаар үеэс хойш орсон богино эгшгүүдийг хаалтанд хийж унш. (Хаалтанд байгаа үсгүүд балархай дуудагдана.) (In the text below, put the short vowels found after the second syllables in parentheses. (Letters in parentheses are unstressed.))

For example (Жишээ нь): ир(э)х(э)д

Ахын сэтгэл[1]

Нэгэн орой Төрхүүг ажлаасаа гаран машиныхаа дэргэд ирэхэд нэг ноорхой хувцастай жаал хүү цоо шинэхэн машиныг нь тойрон алмайран харж байлаа. "Энэ таны машин уу?" гэж хүүг асуухад Төрхүү "Тийм ээ. Ах маань миний төрсөн өдрөөр надад бэлэглэсэн юм" гэв. Хүүг "Хөөх! Би ..." гээд чимээгүй болоход Төрхүү тийм ахтай ч байсан болоосой гэж хүсэж байгаа байх даа гэж бодсон боловч хүүгийн хэлсэн үгийг сонсоод маш их гайхлаа. Хүү "Би таны ах шиг тийм ах байсан ч болоосой" гэв.

Төрхүүг "Машинаар явж үзэх үү?" гэхэд хүү зөвшөөрч машинд нь суулаа. Жаахан яваад хүү "Тэр шатны хажууд зогсоод өгөөч" гэв. Хүү машинаас буугаад шатаар дээш өгсөн гүйлээ. Удалгүй хүү эрэмдэг дүүгээ үүрэн доош бууж ирээд "Энэ машиныг ах нь түүнд төрсөн өдрөөр нь бэлэглэсэн юм. Нэг өдөр би чамд бас машин бэлэглэнэ ээ. Тэгээд чи өөрөө машинаараа явж, миний чамд ярьж өгдөг зүйлсийг үзэх болно" гэж хэлэв.

1 The literal translation of this text is in the Key to Exercises.

Дасгал 4

Сэдвийг сонсоод, дараа нь ямар нэгэн тэмдэглэгээ хийлгүйгээр унш. (Listen to the text and then read it without adding in any marks.)

Найзууд[2]

Нэгэн хараагүй охин бүх хүмүүсийг, өөрийгөө ч бас үзэн яддаг байсан бөгөөд жаргал зовлонгоо хуваалцдаг ганц эрэгтэй найзтай байв. Нэг өдөр охин найздаа "Энэ дэлхий ертөнцийг ганц удаа ч болов харах боломж надад олдвол би чамтай гэрлэж, бүх насаараа хамт амьдарна" гэж хэлэв.

Тэр өдрөөс хойш удалгүй нүдний донор олдож, охин мэс засал хийлгэв. Охин хамгийн эхлээд эрэгтэй найзыгаа харахыг хүссэн бөгөөд эмч нүднийх нь боолтыг авахад өмнө нь найз нь зогсож байсан ба хоёр нүд нь боолттой байлаа. Яг тэр үед охины түүнтэй гэрлэх хүсэл үгүй болов. Найз нь "Чи надтай гэрлэнэ биз дээ?" гэж асуухад охин дуугарсангүй.

Хэдэн өдрийн дараа охинд найзаас нь нэгэн зурвас ирсэн бөгөөд "Хоёр нүдээ хайрлаж яваарай. Минийх байсан юм шүү!" гэж бичсэн байлаа.

Дасгал 5

Сэдвийг сонсоод, хэлний угийн "н" болон үгийн дунд орсон "г"-гийн доогуур зурж, унш. (Listen to the text. Underline the letters "н" (if there is no vowel behind it) and "г" (if it is in the middle of a word) and then read the text.)

Шудрага хүү[2]

Аав ээж нь Эрдэнэд "Чи хөл бөмбөг тоглоод хичээлээ хийхгүй байна. Бид маргаашийн тэмцээнийг үзээд цаашид хөл бөмбөг тоглох үгүйг чинь шийднэ" гэж хэлэв.

Тэмцээн маш сонирхолтой болж, хамгийн сүүлд Эрдэнийн баг нэг багтай хотын аврагын төлөө тоглов. Хоёр баг эсрэг багийнхаа хаалганд нэг нэг бөмбөг оруулсан байсан бөгөөд тэмцээний цаг дуусч байсан учраас эсрэг багийнхаа хаалганд бөмбөг оруулах нь хоёр багт чухал байв. Багийнх нь нэг хүү Эрдэнэд бөмбөг дамжуулахад тэрээр бөмбөгийг өшиглөж, хаалганд оруулав. Хүүхдүүд маш их баярлаж, түүнд баяр хүргэж байлаа. Харин Эрдэнэ баярлаж хөөрсөнгүй.

Хэдэн минутын дараа шагнал авах болоход тэр шагнал авахаас татгалзав. Хүмүүс маш их гайхаж байлаа. Эрдэнэ хүмүүсээс уучлалт гуйж, багийнх нь хүүхэд түүн рүү бөмбөг дамжуулахад бөмбөг гарт нь хүрснийг хэлэв.

2 The literal translations of these texts are in the Key to Exercises.

Эгшиг зохицох ёс (Vowel harmony)

If a masculine vowel is in the first syllable, then masculine vowels will be in the next syllables; if a feminine vowel is in the first syllable, feminine vowels will be in the next syllables. "И" can be in both masculine and feminine words. (Names may consist of both masculine and feminine words. For example: Наранцэцэг, Батхүү.)

Mongolian is an agglutinative language and suffixes are added to nouns or verb stems. Suffixes that have vowels in them usually have four forms and are added to words according to vowel harmony. For example, a suffix of the past tense has four forms (**-сан**, **-сэн**, **-сон** and **-сөн),** which are added to the verb stem. For example: ав → авсан, эхэл → эхэлсэн, ол → олсон, өг → өгсөн.

Дасгал 6

Үгсийг уншаад эгшиг хэрхэн зохицож байгааг ажигла. (Read the words and pay attention to vowel harmony.)

авах	хонох	хүүхэдтэйгээ	холимог
маргааш	хоорондоо	өглөө	ашиг
хаалгаараа	эмээ	өргөмөл	хариад
ургах	эргэлдэх	өглөөнөөс	хонгио

Дасгал 7

Цэгийн оронд тохирох эгшгүүдийг бичээд Дасгал 6-гаас харж зас. (Write the appropriate vowels in the space; then look at Exercise 6 and correct them.)

ав...х	хон...х	хүүхэдт... ...г... ...	холим...г
марг... ...ш	хоор...нд... ...	өгл... ...	аш...г
хаалг... ...р... ...	эм... ...	өрг...м...л	хари...д
ург...х	эрг...лд...х	өгл... ...н... ...с	хонги...

Дасгал 8

Үгсийг сонсоод дагаж хэл. (Listen to the words and then repeat them.)

тав — тавь[3]	сор — сорь	салах — салхи	сорох — сорих
хал — халь	хол — холь	барах — барих	урах — урих
хана — хань	бод — бодь	харах — харих	архи
тана — тань	бол — боль	дарх — дархи	ариун
хар — харь	ор — орь	туурах — туурвих	танхим
ах — ахь	дуул — дууль	болох — болих	урхи
хор — хорь	уул — ууль	хорох — хорих	хуулиас

3 If there is a soft sign or the letter "и", the tongue moves slightly up and forward when we say vowels.

Дөрөвдүгээр хичээл

Тооны нэр (Numbers)

Дасгал 1

Тоонуудыг сонсоод, дагаж хэлэн тогтоо. (Listen, repeat and memorize the numbers.)

0. Тэг
1. Нэг
2. Хоёр
3. Гурав
4. Дөрөв
5. Тав
6. Зургаа
7. Долоо
8. Найм
9. Ес
10. Арав
11. Арван нэг
12. Арван хоёр
13. Арван гурав
14. Арван дөрөв
15. Арван тав
16. Арван зургаа
17. Арван долоо
18. Арван найм
19. Арван ес
20. Хорь
21. Хорин нэг
30. Гуч
31. Гучин нэг
40. Дөч
41. Дөчин нэг
50. Тавь
51. Тавин нэг
60. Жар
61. Жаран нэг
70. Дал
71. Далан нэг
80. Ная
81. Наян нэг
90. Ер
91. Ерэн нэг
100. Зуу
101. Зуун нэг
1000. Мянга
1001. Мянга нэг
1 000 000. Сая
1 000 000 000. Тэрбум

Дасгал 2

Хоосон нүднүүдийг бөглөж бич. (Fill in the blank boxes.)

	1	2	3	4	5	6	7	8	9
10							арван долоо		
20		хорин хоёр							
30					гучин тав				
40									дөчин ес
50	тавин нэг								
60			жаран гурав						
70				далан дөрөв					
80						наян зургаа			
90								ерэн найм	

Дасгал 3

Доорх тоонуудыг хоёроос гурван удаа уншиж цээжлээд дараа нь үсгээр бичсэн хэсгийг цаасаар даран, тоонуудыг хэлж, өөрийгөө шалга. (After reading the numbers below two or three times and memorizing them, put a piece of paper over the words, say the numbers, then check yourself.)

25	хорин тав
95	ерэн тав
150	(нэг) зуун тавь
650	зургаан зуун тавь
300	гурван зуу
450	дөрвөн зуун тавь
500	таван зуу
1500	(нэг) мянга таван зуу
1800	мянга найман зуу
1750	мянга долоон зуун тавь
2500	хоёр мянга таван зуу
7000	долоон мянга
7500	долоон мянга таван зуу
9000	есөн мянга
9500	есөн мянга таван зуу
11	арван нэг
111	(нэг) зуун арван нэг
22	хорин хоёр
222	хоёр зуун хорин хоёр
33	гучин гурав
333	гурван зуун гучин гурав
44	дөчин дөрөв
444	дөрвөн зуун дөчин дөрөв
55	тавин тав
555	таван зуун тавин тав
66	жаран зургаа
666	зургаан зуун жаран зургаа
77	далан долоо
777	долоон зуун далан долоо
88	наян найм
888	найман зуун наян найм
99	ерэн ес
999	есөн зуун ерэн ес
1111	(нэг) мянга нэг зуун арван нэг
2222	хоёр мянга хоёр зуун хорин хоёр
3333	гурван мянга гурван зуун гучин гурав
4444	дөрвөн мянга дөрвөн зуун дөчин дөрөв
5555	таван мянга таван зуун тавин тав
6666	зургаан мянга зургаан зуун жаран зургаа
7777	долоон мянга долоон зуун далан долоо
8888	найман мянга найман зуун наян найм
9999	есөн мянга есөн зуун ерэн ес

Note: If other numbers or nouns are after a number, except for one and two, the first number takes "**н**." For example: зуу**н** тав, зуу**н** ном, хоёр ном, нэг ном.

The number one alone does not need "н" but when combined with other numbers, it must have "н." For example: арван нэгэ**н** ном, хорин нэгэ**н** ном.

If 1000 is in front of other numbers, it does not take "н," but if it is in front of nouns, it takes "н." For example: 1500 — мянга таван зуу, 1010 — мянга арав, 5200 — таван мянга хоёр зуу, 1000 ном — мянга**н** ном, 5000 хүн — таван мянга**н** хүн.

Дасгал 4

Унш. (Read.)

12 үзэг[4] — 12 pens	34 багш — 34 teachers	1 дэвтэр — 1 notebook
3 ном — 3 books	2500 төгрөг — 2500 togrogs	2 харандаа — 2 pencils
25 цүнх — 25 purses	100 доллар — 100 dollars	32 оюутан — 32 students

Note: When Mongolians say years, we say them as whole numbers.
For example: 1995 он — мянга есөн зуун ерэн таван он (year of 1995).

4 When nouns are with numbers that show plural, they do not use plural suffixes.

1996 он	1970 он	1966 он	2001 он
1999 он	1991 он	1977 он	2003 он
1988 он	1939 он	2000 он	2020 он

Note: When we say phone numbers, we say them two by two.
For example: 99 20 45 55 — ерэн ес, хорь, дөчин тав, тавин тав.

99 06 31 28	95 16 02 10	50 35 22 34	11 45 40 13
99 36 43 34	96 66 35 44	88 37 75 04	11 45 00 11
91 16 35 77	50 15 01 11	88 55 22 88	11 67 30 08

Дасгал 5

А. Доорх кодыг ашиглан үгсийг бич. (Using the code below, write the words.)

Код:

А = нэг	И = арав	Р = арван ес	Ш = хорин найм
Б = хоёр	й = арван нэг	С = хорь	Щ = хорин ес
В = гурав	К = арван хоёр	Т = хорин нэг	ъ = гуч
Г = дөрөв	Л = арван гурав	У = хорин хоёр	ы = гучин нэг
Д = тав	М = арван дөрөв	Ү = хорин гурав	ь = гучин хоёр
Е = зургаа	Н = арван тав	Ф = хорин дөрөв	Э = гучин гурав
Ё = долоо	О = арван зургаа	Х = хорин тав	Ю = гучин дөрөв
Ж = найм	Ө = арван долоо	Ц = хорин зургаа	Я = гучин тав
З = ес	П = арван найм	Ч = хорин долоо	

14-10-15-10-11	26-23-15-25	5-16-13-13-1-19
21-1-15-31	16-34-22-21-1-15	2-1-4-28
22-13-1-1-15-2-1-1-21-1-19	25-1-19-1-15-5-1-1	5-33-3-21-33-19
14-16-15-4-16-13	21-17-4-19-17-4	15-16-14

Б. Дээрх кодыг ашиглан мэддэг үгсээ бич. (Write words that you know using the code above.)

Нэр үгийн -тай[3] нөхцөл (Noun suffix -тай[3])

-тай[3] (have or with) / **-гүй** (don't have or without)

Би дэвтэр**тэй**.	I **have** a notebook.	Би номгүй.	I don't have a book.
Би дэвтэр**гүй**.	I **don't have** a notebook.	Би багштай.	I have a teacher.
Би номтой.	I have a book.	Би багшгүй.	I don't have a teacher.

сүүтэй цай (milk tea), зураг**тай** ном (book **with** pictures), мах**тай** хоол (food **with** meat)

Spelling rules:

After nouns with **а** or **у**	**-тай**	After nouns with **о**	**-той**
After nouns with **э, ү, ө** or **и**	**-тэй**	After all nouns	**-гүй**

Дасгал 6

Өгүүлбэрийг "-тай[3]," "-гүй" нөхцөлийг ашиглан гүйцээ. (Complete the sentences using the suffixes "-тай[3]" or "-гүй.")

А. For example (Жишээ нь): Би хоёр үзэгтэй. (I have two pens.)

1. Би таван харандаа.....
2. Би сайн ширээ.....
3. Би арван сандал.....
4. Би сайн цүнх.....
5. Би сайн аав.....
6. Би сайн ээж.....
7. Би гурван ах.....
8. Би нэг эгч.....
9. Би дөрвөн дүү.....
10. Би сайн эмээ.....
11. Би сайн өвөө.....
12. Би сайн найз.....
13. Би хоёр багш.....
14. Би арван оюутан.....
15. Би есөн хүүхэд.....
16. Би таван охин.....

Шинэ үгс: ширээ — table, сандал — chair, аав — father, ээж — mother, ах — brother, эгч — sister, дүү — younger sibling, эмээ — grandmother, өвөө — grandfather, найз — friend, хүүхэд — child, охин — daughter

Б. For example (Жишээ нь): Би үзэггүй. (I don't have a pen.)

1. Би харандаа.....
2. Би сандал.....
3. Би ах.....
4. Би дүү.....
5. Би эрэгтэй дүү.....
6. Би эмэгтэй найз.....
7. Би жолооч.....
8. Би охин.....
9. Би хүү.....
10. Би оюутан.....
11. Би хүүхэд.....
12. Би багш.....

Шинэ үгс: жолооч — driver, манай — our, танай — your, эрэгтэй — male, эмэгтэй — female, хүү — son

Дасгал 7

Эмнэх дасгалын шинэ үгс болон "-тай[3]" нөхцөлийг ашиглан өөрийнхөө (найзынхаа, ахынхаа, багшийнхаа г.м.) тухай ярь. (Tell about yourself (your friends, your brother, your teacher, etc.) using the new words from the previous exercise and using the suffix "-тай[3].")

For example (Жишээ нь): Миний эгч нэг хүүхэдтэй. Манай эгч сайн найзтай.

1. Би .....
2. Манай монгол[5] найз .....
3. Манай багш .....
4. Манай ах .....

Дасгал 8

Монгол, англи үгсийг зөв харгалзуулан холбож зур. (Match the Mongolian and English words by connecting them with lines.)

ширээ	father	жолооч	your
аав	sister	манай	chair
ээж	younger sibling	танай	son
ах	grandmother	сандал	driver
эгч	table	эрэгтэй	our
дүү	child	эмэгтэй	pen
эмээ	friend	хүү	male
өвөө	daughter	дэвтэр	year
найз	brother	цүнх	purse
хүүхэд	mother	үзэг	female
охин	grandfather	он	notebook

5 Mongolia (the country) is spelled with capital letter "М" like "Монгол (улс)." Mongolian (as an adjective) is spelled with a small "м," like "монгол багш." This is also true for other country names.

Тавдугаар хичээл

Асуух сул үг (Question particles)

Spelling rules:

		If the last word of a sentence ends with a short vowel or consonant	If the last word of a sentence ends with a long vowel or diphthong
If a sentence has no question pronoun	If the last word of a sentence has **а**, **о** or **у**	уу	юу
	If the last word of a sentence has **э**, **ө**, **ү** or **и**	үү	юү

	If the last word of a sentence ends with any vowel or consonant besides **н**, **м** or **в**	If the last word of a sentence ends with **н**, **м** or **в**
If a sentence has a question pronoun	вэ	бэ

For example (Жишээ нь):

1. Сайн байна уу? — How are you?
2. Та багш уу? — Are you a teacher?
3. Энэ таны үзэг үү? — Is this your pen?
4. Энэ таны харандаа юу? — Is this your pencil?
5. Энэ таны ширээ юү? — Is this your table?
6. Та үзэгтэй юү? — Do you have a pen?
7. Энэ юу вэ? — What is this?
8. Энэ хэд вэ? — How much is this?
9. Чингис хаан хаана байна вэ? — Where is King Chinggis?
10. Таны нэр хэн бэ? — What is your name?
11. Энэ ямар ном бэ? — What kind of book is this?
12. Энэ хэний сав бэ? — Whose container is this?

Асуух төлөөний үгс (Question pronouns):

хэн	who	хэд(эн)	how many
юу	what	ямар	what (what kind)
хэзээ	when	аль	which
хаана	where	яаж	how (with verbs)
яагаад	why	хир	how (with adjectives)

Дасгал 1

Хамтрахын тийн ялгал болон асуух сул үгсийг ашиглан асуултыг гүйцээж, хариул. (Complete the questions using the comitative case and question particles and answer them.)

Жишээ нь: Та ах... ? Та хэдэн ах... ?

— Та ахтай юу? (Do you have a brother?) — Та хэдэн ахтай вэ? (How many brothers do you have?)
— Тийм, би ахтай. (Yes, I have a brother.) — Би хоёр ахтай. (I have two brothers.)

1. Та харандаатай юу? Та хэдэн харандаатай вэ?
2. Та сандалтай юу? Та хэдэн сандалтай вэ?
3. Чи цүнхтэй юу? Чи хэдэн цүнхтэй вэ?
4. Та эгчтэй юу? Та хэдэн эгчтэй вэ?
5. Чи дүүтэй юу? Чи хэдэн дүүтэй вэ?
6. Та эрэгтэй дүү..... ..... ? Та хэдэн эрэгтэй дүү..... ..... ?
7. Чи эмэгтэй найз..... ..... ? Чи хэдэн эмэгтэй найз..... ..... ?
8. Та жолооч..... ..... ? Та хэдэн жолооч..... ..... ?
9. Чи охин..... ..... ? Чи хэдэн охин..... ..... ?
10. Та хүү..... ..... ? Та хэдэн хүү..... ..... ?
11. Чи оюутан..... ..... ? Чи хэдэн оюутан..... ..... ?
12. Та хүүхэд..... ..... ? Та хэдэн хүүхэд..... ..... ?
13. Чи эрэгтэй багш..... ..... ? Чи хэдэн эрэгтэй багш..... ..... ?

Дасгал 2

Цэгийн оронд асуух сул үг бичиж, асуултад хариул. (Write the question particles and answer the questions.)

Жишээ нь:
Таны ах хэдэн настай вэ? (How old is your brother?)
Миний ах 40 настай. (My brother is 40 years old.)

1. Та хэдэн настай ..... ?
2. Таны эгч хэдэн настай ..... ?
3. Чиний эрэгтэй дүү хэдэн настай ..... ?
4. Таны эмэгтэй дүү хэдэн настай ..... ?
5. Таны хүү хэдэн настай ..... ?
6. Таны охин хэдэн настай ..... ?
7. Тэр эмэгтэй хүн хэдэн настай ..... ?
8. Таны эхнэр/нөхөр хэдэн настай ..... ?
9. Таны багш хэдэн настай ..... ?
10. Таны найз хэдэн настай ..... ?

Шинэ үгс: эхнэр — wife, нөхөр — husband, хүн — person, нас — age

Дасгал 3

Нэр үгст хамтрахын тийн ялгалын нөхцөл залгаж бичин, асуулт зохио. (Add the correct comitative suffix to the nouns, then make questions.)

Жишээ нь: Би гурван сайн дэвтэртэй.
Та гурван сайн дэвтэртэй юу? (Do you have three good notebooks?)
Та **хэдэн** сайн дэвтэртэй вэ? (How many good notebooks do you have?)
Хэн гурван сайн дэвтэртэй вэ? (Who has three good notebooks?)

1. Би хоёр үзэг.....
2. Би сайн харандаа.....
3. Багш арван ширээ.....
4. Тэр сайн багш.....
5. Би гурван ах.....
6. Би нэг эгч.....
7. Би таван дүү.....
8. Тэр, хоёр найз.....
9. Тэр арван хүүхэд.....

Дасгал 4

Доор өгөгдсөн үгс болон "-тай³" нөхцөлийг ашиглан гэрийнхээ талаар бичээд асуулт зохио. (Write about your house using the words given below and the suffix "-тай³", then make questions.)

Жишээ нь: Би байртай. Та байртай юу?
Манай байр гурван өрөөтэй. Танай байр хэдэн өрөөтэй вэ?
Манай өрөө дөрвөн цонхтой. Танай өрөө хэдэн цонхтой вэ?

Шинэ үгс: байр — apartment, хаалга — door, цонх — window, өрөө — room, аяга — cup, халбага — spoon, сэрээ — fork, хутга — knife, таваг — plate

Дасгал 5

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. I have one sister and two brothers.
2. My teacher has 125 books.
3. That ger has a good door.
4. Your brother has a bag.
5. That man has an apartment.
6. He doesn't have an apartment.
7. I have a good friend.
8. I don't have a bad friend.
9. That teacher has 20 students.
10. This restaurant has 50 good plates.
11. Do you have a brother?
12. How many brothers do you have?
13. Do you have a younger sibling?
14. How many siblings do you have?
15. Does your brother have a wife?
16. Do you have a book?
17. Do you have a notebook?
18. Do you have a Mongolian friend?
19. How old are you?
20. How old is your wife/husband?
21. Do you have a cup?
22. Do you have a spoon?

Дасгал 6

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Монгол хэл/англи хэл хэдэн үсэгтэй вэ? (35/26)
2. Таны нэр хэдэн үсэгтэй вэ?

3. Монгол хэдэн аймагтай вэ? (21)
4. "Манай өрөө дөрвөн цонхтой." Энэ өгүүлбэр хэдэн үгтэй байна вэ?

Шинэ үгс: хэл — language, үсэг — letter, англи — English, өгүүлбэр — sentence, аймаг — province, үг — word

Дасгал 7

Асуултыг уншаад хариулж бич. (Read the questions and answer them.)

Жишээ нь:
— Энэ таны ном уу? (Is this your book?) → — Тийм, энэ миний ном. (Yes, this is my book.)
— Үгүй, энэ миний ном биш. (No, this is not my book.)

1. Энэ таны дэвтэр үү? Is this your notebook?
2. Энэ таны харандаа юу? Is this your pencil?
3. Энэ таны ширээ юү? Is this your table?
4. Энэ таны цүнх үү? Is this your bag?
5. Тэр таны ах уу? Is he your brother?
6. Тэр таны эгч үү? Is she your sister?
7. Тэр таны дүү юү? Is he your younger sibling?
8. Тэр таны өвөө юү? Is he your grandfather?
9. Тэр таны найз уу? Is she your friend?
10. Тэр таны багш уу? Is he your teacher?

Дасгал 8

Асуух сул үгсийг нөхөж бич. (Add the correct question particle in the spaces.)

1. Энэ таны дэвтэр ..... ?
2. Энэ таны үзэг ..... ?
3. Энэ таны харандаа ..... ?
4. Энэ таны ширээ ..... ?
5. Энэ таны сандал ..... ?
6. Энэ таны цүнх ..... ?
7. Тэр чиний дэвтэр ..... ?
8. Тэр чиний үзэг ..... ?
9. Тэр чиний харандаа ..... ?
10. Тэр чиний ширээ ..... ?
11. Тэр чиний сандал ..... ?
12. Тэр чиний цүнх ..... ?
13. Тэр таны аав ..... ?
14. Тэр таны ээж ..... ?
15. Тэр таны ах ..... ?
16. Тэр таны эгч ..... ?
17. Тэр таны дүү ..... ?
18. Тэр таны эмээ ..... ?
19. Тэр таны өвөө ..... ?
20. Тэр таны найз ..... ?
21. Тэр таны багш ..... ?
22. Тэр таны хүүхэд ..... ?
23. Тэр таны хүү ..... ?
24. Тэр таны охин ..... ?
25. Энэ хэн ..... ?
26. Тэр юу ..... ?
27. Тэр ямар хүн ..... ?
28. Энэ ямар ном ..... ?
29. Энэ хэд ..... ?
30. Тэр ямар харандаа ..... ?

Дасгал 9

Асуух сул үгсийг нөхөж бич. (Add the correct question particle in the spaces.)

↑ ↓

Жишээ нь: Энэ таны ном уу, миний ном уу?[6] (Is this your book or my book?)

1. Тэр таны дэвтэр ....., миний дэвтэр ..... ?
2. Тэр таны үзэг ....., миний үзэг ..... ?
3. Тэр таны харандаа ....., миний харандаа ..... ?
4. Тэр таны ширээ ....., миний ширээ ..... ?
5. Тэр таны сандал ....., миний сандал ..... ?
6. Тэр таны хаалга ....., миний хаалга ..... ?
7. Тэр таны цүнх ....., миний цүнх ..... ?
8. Тэр Наранхүү ....., Дашхүү ..... ?
9. Тэр эмэгтэй Мөнхмаа ....., Болормаа ..... ?
10. Энэ эрэгтэй Батхүү ....., Сүххүү ..... ?

Дасгал 10

Асуултыг гүйцээж, хариул. (Complete the questions and answer them.)

Жишээ нь:

Энэ таны ном мөн[7] үү?	IS this your book?
— Тийм, энэ миний ном мөн.	— Yes, this IS my book.
— Үгүй, энэ миний ном биш.	— No, this is not my book.

1. Энэ таны дэвтэр ..... ?
2. Энэ таны үзэг ..... ?
3. Энэ таны харандаа ..... ?
4. Энэ таны ширээ ..... ?
5. Энэ таны цүнх ..... ?
6. Тэр таны ах ..... ?
7. Тэр таны эгч ..... ?
8. Тэр таны дүү ..... ?
9. Тэр таны эмээ ..... ?
10. Тэр таны өвөө ..... ?
11. Тэр таны найз ..... ?
12. Тэр таны багш ..... ?

Дасгал 11

А. Багш ширээн дээр бичгийн хэрэгслүүд тавьж, загварын дагуу асуулт асууж, ярилцана. (Your teacher will put stationery things on the table and ask questions as in examples below.)

1. Оюутан: — Энэ юу вэ?
   Багш: — Энэ үзэг.
2. Багш: — Тэр юу вэ?
   Оюутан: — Тэр ном.
3. Оюутан: — Энэ таны ном уу?
   Багш: — Тийм, миний ном. (— Үгүй, миний ном биш. Таны ном.)

6 When we say these sentences, the question particle of the first sentence is said with a higher tone and the question particle of the second sentence is said with a slightly lower tone.

7 "Мөн" is used after nouns to give emphasis.

Зургийг хараад багш оюутан хоёр бие биенээсээ доорх асуултуудыг асууж, ярилц. (Look at the cture. The teacher and student should ask each other the questions written below, then talk about the cture.)

1. Тэр хэн бэ?
2. Тэр хэдэн настай вэ?



Мэндчилгээ (Greetings)

Харилцаа яриа 1 (Conversation 1)

А: — Сайн уу?
Б: — Сайн, сайн уу?
А: — Юу байна?
Б: — Юмгүй дээ.
А: — Ажил төрөл сайн уу?
Б: — Сайн. Таны ажил төрөл сайн уу?
А: — Сайн.

A: — Hi.
B: — Hi.
A: — What's up?
B: — Nothing.
A: — How is your work? (Is your work good?)
B: — Good. How is your work?
A: — Good.

Харилцаа яриа 2 (Conversation 2)

А: — Амар байна уу?
Б: — Мэнд ээ, амар байна уу?
А: — Сайхан шинэлж байна уу?
Б: — Сайхан, сайхан шинэлж байна уу?
А: — Сайхан.

A: — How are you? (During Tsagaan Sar)
B: — I'm fine. How are you?
A: — Are you having a good New Year holiday?
B: — Yes, are you having a good holiday?
A: — Yes.

А: — Өглөөний мэнд.
Б: — Өглөөний мэнд.
А: — Өдрийн мэнд.
Б: — Өдрийн мэнд.
А: — Оройн мэнд.
А: — Оройн мэнд.
А: — Гэрэлмаад мэнд хүргээрэй.
Б: — Тэгнэ ээ.

A: — Good morning.
B: — Good morning.
A: — Good afternoon.
B: — Good afternoon.
A: — Good evening.
B: — Good evening.
A: — Please say "Hi!" to Gerelmaa.
B: — I will.

Давтлага хичээл (Review Lesson)

Дасгал 1

Үгсийг унш. (Read the words.)

сайн	хан	байгаа	хуруугаараа
хаана	хана	маргааш	зургаа
Хэн бэ?	сайн малгай	гэр	гүүр
сайн байр	улаан перц	баг	бага
он	олон	нэг	хог

Дасгал 2

Доорх сэдвийн үгсийг үеэр тасалж унш. (Divide the words of the text below into syllables and read.)

Инээмсэглэл[8]

Инээмсэглэл нь үнэ төлбөргүй атлаа ихийг бүтээдэг. Тэрээр авч байгаа хүнийг баяжуулдаг боловч өгч байгаа хүнийг ер үгүйрүүлж хоосруулдаггүй. Инээмсэглэл нь хоромхон зуур болж өнгөрөх авч заримдаа насан туршид мартагдахгүй. Инээмсэглэл нь орон гэрт аз жаргал авчирч, ажил хэрэгт тус дөхөм болдог ба ядрахад амралт, гуниглахад гэрэл гэгээ, өвдөж зовоход эм тан болдог. Инээмсэглэл нь өгөөмөр сэтгэлийн дотор байдаг зүйл бөгөөд хэн ч худалдан авч, эсвэл хулгайлж чадахгүй. Та хүмүүсийг баярлуулахыг хүсвэл инээмсэглэж бай.

Дасгал 3

Тоонуудыг чанга хэл. (Say the numbers out loud.)

А. 5, 10, 15, 20, 25, 30, 35, 40, 45, 50, 55, 60, 65, 70, 75, 80, 85, 90, 95, 100

Б. 1, 3, 5, 7, 9, 11, 13, 15, 17, 19, 21, 33, 55, 77, 99

В. 2, 4, 6, 8, 10, 12, 14, 16, 18, 20, 44, 66, 88

Дасгал 4

Гэр бүлийнхээ талаар "-тай[3]", "-гүй" нөхцөлүүдийг ашиглан ярь. (Talk about your family using the suffixes "-тай[3]" and "-гүй.")

Жишээ нь: Би нэг ахтай. Би эгчгүй.

Дасгал 5

Дараах өгүүлбэрүүдэд асуулт зохиож бич. (Make appropriate questions for the following sentences.)

Жишээ нь: Би дүүгүй. → Чи дүүтэй юү?

8 The literal translation of this text is in the exercise answers.

1. Би машингүй.
2. Би нэг багштай.
3. Би хоёр ахтай.
4. Би монгол номгүй.
5. Тэр эмэгтэй, нөхөргүй.
6. Миний дүү 10 настай.
7. Би хүүхэдтэй.
8. Би сайн найзтай.
9. Манай найз 20 настай.
10. Манай ээж эгчгүй.

Дасгал 6

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Энэ чиний ном уу?
2. Тэр таны харандаа юу?
3. Энэ танай гэр мөн үү?
4. Тэр танай машин уу?
5. Энэ танай аймаг уу?
6. Энэ таны ширээ мөн үү?
7. Энэ миний цүнх үү, чиний цүнх үү?
8. Тэр таны аяга уу, миний аяга уу?
9. Энэ үзэг үү, харандаа юу?
10. Та ахтай юу, эгчтэй юү?

Дасгал 7

Монгол, англи үгсийг зөв харгалзуулан холбож зур. (Match the Mongolian and English words by connecting them with lines.)

өгүүлбэр	English	үг	apartment	хаалга	son
үсэг	wife	хэл	person	цонх	cup
англи	plate	биш	table	өрөө	window
аймаг	province	байр	language	аяга	door
халбага	sentence	нөхөр	child	хүү	room
сэрээ	knife	хүн	age	охин	chair
хутга	letter	нас	word	жолооч	driver
таваг	spoon	ширээ	not	сандал	what kind of
эхнэр	fork	хүүхэд	husband	ямар	daughter

Тест (Test)

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Монгол хэл ... үсэгтэй.
   Mongolian has ... letters.
   А. 34
   Б. 33
   В. 35
2. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. сайн [saim]
   Б. сайн [saing]
   В. сайн [sain]
3. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. оно [ɵng]
   Б. оно [om]
   В. оно [on]
4. Аль нь эр үг вэ?
   Which one is a masculine word?
   А. өгүүлбэр
   Б. уугаарай
   В. ирнэ
5. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. уусэн
   Б. уусан
   В. уусөн
6. Алийг нь үеэр зөв тасалсан бэ?
   Which one is correctly divided into syllables?
   А. бай/гуул/ла/га
   Б. байг/уул/лага
   В. бай/гуул/лаг/а
7. Аль эгшиг балархай дуудагдах вэ?
   Which vowel is unstressed?
   А. х(а)рандаа
   Б. хар(а)ндаа
   В. харанд(аа)
8. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Би сайн өвөөтөй.
   Б. Би сайн өвөөтэй.
   В. Би сайн өвөөтай.
9. Аль нь зөв бэ?
   Which one is right?
   А. Энэ таны халбага юу?
   Б. Энэ таны халбага вэ?
   В. Энэ таны халбага уу?
10. Аль нь зөв бэ? Which one is right?
    А. Та хэдэн хүүхэдтэй вэ?
    Б. Та хэдэн хүүхэдтэй үү?
    В. Та хэдэн хүүхэдтэй юү?
11. Аль нь зөв бэ? Which one is right?
    А. Би арван хоёр дэвтэртэй.
    Б. Би арван хоёрон дэвтэртэй.
    В. Би арав хоёрон дэвтэртэй.
12. Асуулт (Question):
    Энэ таны ном уу?
    А. Үгүй, энэ миний ном.
    Б. Үгүй, энэ миний номгүй.
    В. Үгүй, энэ миний ном биш.
13. Асуулт (Question): Та хүүтэй юү?
    А. Үгүй, би хүү биш.
    Б. Үгүй, би хүү.
    В. Үгүй, би хүүгүй.
14. Асуулт (Question):
    Та хүүхэдгүй юү?
    А. Тийм, би хүүхэдгүй.
    Б. Тийм, би хүүхэдтэй.
    В. Үгүй, би хүүхэдгүй.
15. "Өгүүлбэр" гэж ..... гэсэн үг.
    "Өгүүлбэр" means .....
    А. sentence
    Б. word
    В. language
16. "Ямар" гэж ..... гэсэн үг. "Ямар" means .....
    А. why
    Б. what kind of
    В. where

Оноо (point): 16/.....

Зургадугаар хичээл

Тэмдэг нэр (Adjectives)

1. халуун	hot	16. хүйтэн	cold
2. дулаан	warm	17. сэрүүн	cool
3. олон	many	18. цөөн	few
4. сайн	good	19. муу	bad
5. сайхан	nice	20. муухай	ugly
6. том	big	21. жижиг	small
7. хуучин	old (inanimate things)	22. шинэ	new
8. хэцүү	difficult	23. амар(хан)	easy
9. амттай	tasty	24. амтгүй	not tasty
10. хол	far	25. ойр(хон)	near
11. үнэтэй	expensive	26. хямд	cheap
12. сонирхолтой	interesting	27. сонирхолгүй	uninteresting
13. адил(хан)	same	28. өөр	different
14. зөв	right	29. буруу	wrong
15. хурдан	fast	30. удаан	slow

Дасгал 1

Дээрх тэмдэг нэрсийг ашиглан өгүүлбэрийг гүйцээ. (Complete the sentences using the adjectives above.)

Жишээ нь: Манай гэр халуун. (My house is hot. (in general))
Манай гэр халуун биш. (My house is not hot. (in general))

1. Монгол (улс) .....
2. Америк .....
3. Канад (улс) .....
4. Англи .....
5. Франц (улс) .....
6. Африк .....
7. Сүүтэй цай .....
8. Итали хоол .....
9. Монгол хоол .....
10. Пицца .....
11. Монгол хэл .....
12. Англи хэл .....
13. Гадаа .....
14. Танай байр .....
15. Манай машин .....
16. Манай гэр .....
17. Миний ажил .....
18. Таны ажил .....
19. Манай найз .....
20. Миний хоол .....

Шинэ үгс: ажил — work, хоол — food, гэр — home/house, машин — car, улс — country, гадаа — outside, сүүтэй цай — milk tea

Дасгал 2

Тэмдэг нэр ашиглан өгүүлбэрийг гүйцээ. (Complete the sentences using the adjectives.)

Жишээ нь:
Манай гэр халуун байна. (My house is hot. (right now))

1. Монгол .....
2. Энэ хоол .....
3. Энэ өрөө .....
4. Тэр пицца .....
5. Энэ хичээл .....
6. Гадаа .....
7. Танай байр .....
8. Энэ хүн .....
9. Манай гэр .....
10. Миний ажил .....
11. Таны цай .....
12. Энэ ном .....

Дасгал 3

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь:
This food is very (much) delicious. → Энэ хоол маш (их) амттай байна.

1. It's very cold outside.
2. My house is very hot.
3. This work is very difficult.
4. This lesson is very easy.
5. My room is very big.
6. My school is very good.
7. This book is very interesting.
8. This car is very expensive.
9. My horse is very fast.
10. This table is very cheap.

Дасгал 4

Цэгийн оронд тэмдэг нэр, өнгө заасан үгсийг нөхөж бич. (Complete the sentences using adjectives and colors.)

Жишээ нь:
Манай найз ..... машинтай. → Манай найз том, хар машинтай.

1. Монгол улс ..... хүнтэй.
2. Америк ..... уултай.
3. Манай найз ..... хүүхэдтэй.
4. Манай аав ..... машинтай.
5. Тэр ресторан ..... хоолтой.
6. Би ..... найзтай.
7. Манай гэр ..... цонхтой.
8. Солонгос ..... цэцэгтэй.
9. Монгол улс ..... модтой.
10. Монгол ..... хоньтой.
11. Солонгос ..... үхэртэй.
12. Монгол улс ..... морьтой.

Шинэ үгс: цэцэг — flower, мод — tree, уул — mountain, хонь — sheep, үхэр — cow, Солонгос — Korea, морь — horse

Дасгал 5

Монгол, англи үгсийг зөв харгалзуулан холбож зур. (Match the Mongolian and English words by connecting them with lines.)

халуун	many	хүйтэн	few
дулаан	big	сэрүүн	bad
олон	hot	цөөн	small
сайн	warm	муу	near
сайхан	difficult	муухай	easy
том	old	жижиг	cold
хуучин	same	шинэ	uninteresting
хэцүү	good	амар(хан)	cheap
амттай	right	амтгүй	wrong
хол	interesting	ойр(хон)	different
үнэтэй	nice	хямд	not tasty
сонирхолтой	far	сонирхолгүй	new
адил(хан)	expensive	өөр	cool
зөв	tasty	буруу	ugly

Дасгал 6

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь:
I don't have a car. → Би машингүй.
That's not my car. → Тэр миний машин биш.

1. I don't have a child. I'm not a child.
2. She doesn't have a teacher. She is not a teacher.
3. You don't have horses. That's not your horse.
4. This is not my flower. I don't have flowers.
5. I don't have interesting books. This is not an interesting book.
6. I don't have a girlfriend. She is not my girlfriend.
7. She is not a student. She doesn't have any students.
8. That mountain has no trees. That's not a tree.
9. This tree doesn't have flowers. This is not a flower.
10. I don't have a car. That's not my car.
11. I don't have a red pen. It's not a red pen.
12. He doesn't have a cow. This is not his cow.

Долдугаар хичээл

Өнгө (Colors)

цагаан	white	улаан	red	цэнхэр	light blue
хар	black	хүрэн	dark red	саарал	gray
ногоон	green	шар	yellow	улбар шар	orange
бор	brown	хөх	blue	ягаан	pink

Хувцас (Clothes)

ороолт	scarf	зангиа	tie
гутал	boots	даашинз	dress
малгай	cap/hat	бээлий	glove
цамц	shirt	хүрэм	jacket
ботинк[9]	shoes	пальто	coat
шорт	shorts	өмд	pants
банзал	skirt	борооны цув	raincoat
оймс	sock	сандал	sandal

Дасгал 1

Багш оюутан хоёр зураг бүр дээр доорх асуултуудыг бие биенээсээ харилцан асууж, ярилц. (The teacher and student ask each other questions for every picture below, then talk about the pictures.)

1. Энэ юу вэ? — Энэ ороолт.
2. Энэ гутал уу? — Тийм, энэ гутал.
   — Үгүй, энэ гутал биш. Энэ ботинк.



9 The underlined words are Russian.

Дасгал 2

Хувцасны нэрсийг ашиглан өгүүлбэрийг гүйцээ. (Complete the sentences using names for clothes.)

Жишээ нь: Би 2 жижиг, хар гуталтай. (I have two small black boots.)

1. Би .....
2. Манай найз .....
3. Манай аав .....
4. Манай багш .....
5. Тэр хүүхэд .....
6. Манай дүү .....
7. Миний эгч .....
8. Миний ах .....
9. Тэр хүн .....
10. Манай нохой .....
11. Манай муур .....
12. Тэр эмэгтэй .....

Шинэ үгс: нохой — dog, муур — cat

Дасгал 3

Багш, оюутан хоёр яг одоо ямар хувцастай байгаагаа хэл. (Both teacher and student tell what clothes you have on right now.)

Жишээ нь: Би одоо улаан цамцтай байна. Багш ногоон цамцтай байна.

1. Би одоо ..... байна.
2. Манай багш/оюутан одоо ..... байна

Шинэ үг: одоо — now

Дасгал 4

Унш. (Read.)

Долоо хоног[10] (Week)

In official speech (Tibetan names)	**In everyday speech**	**English names**
Даваа гараг	Нэгдэх өдөр[11]	Monday
Мягмар гараг	Хоёрдахь өдөр	Tuesday
Лхагва гараг	Гуравдахь өдөр	Wednesday
Пүрэв гараг	Дөрөвдэх өдөр	Thursday
Баасан гараг	Тавдахь өдөр	Friday
Бямба гараг	Хагас сайн өдөр	Saturday
Ням гараг	Бүтэн сайн өдөр	Sunday
Бямба, ням гараг	Хагас, бүтэн сайн өдөр	Weekend

10 Хоног means one whole day (24 hours).
11 Өдөр means day time.

Сар (Months)

Mongolian names	In colloquial speech	English names
Нэгдүгээр сар	Нэг сар[12]	January
Хоёрдугаар сар	Хоёр сар	February
Гуравдугаар сар	Гурван сар	March
Дөрөвдүгээр сар	Дөрвөн сар	April
Тавдугаар сар	Таван сар	May
Зургадугаар сар	Зургаан сар	June
Долдугаар сар	Долоон сар	July
Наймдугаар сар	Найман сар	August
Есдүгээр сар	Есөн сар	September
Аравдугаар сар	Арван сар	October
Арван нэгдүгээр сар	Арван нэгэн сар	November
Арван хоёрдугаар сар	Арван хоёр сар	December

Дасгал 5

Өгүүлбэрийг уншаад цээжил. (Read the sentences and memorize them.)

Маргааш уулзъя.	See you tomorrow.
Дараа уулзъя.	See you later.
Нэгдэх өдөр уулзъя.	See you on Monday.
Хагас сайн өдөр уулзъя.	See you on Saturday.
Маргааш 2 цагт уулзъя.	See you tomorrow at 2 o'clock.
Ресторанд уулзъя.	See you at the restaurant.
Манай гэрт уулзъя.	See you at my house.
Танай гэрт уулзъя.	See you at your house.
Маргааш энд уулзъя.	See you here tomorrow.

Note: Suffixes **-д** and **-т** mean in, at, to and for. "**-т**" is used after words that end with letters **г**, **р**, **с** and some words that end with the letter **в**.

12 Нэг сар can also mean "for one month."

Наймдугаар хичээл

Харьяалахын тийн ялгал (Genitive case)

This suffix connects two nouns and it means **of** and **'s**.

For example:
аав**ын** ном — father**'s** book ээж**ийн** харандаа — mother**'s** pencil

Spelling rules:

	After words ending with short vowels or consonants	After words ending with diphthongs	After words ending with **н**	Masculine words ending with **ч, ж, ш, ь, и** or **г**	After words ending with long vowels or consonants (related to things)	After words ending with long vowels (related to people)
Masculine words (with **а, о** or **у**)	-ын	-н	-ы	-ийн	-(н)ы	-(г)ийн
Feminine words (with **э, ү, и** or **ө**)	-ийн	-н	-ий	-ийн	-(н)ий	-(г)ийн

For example:

эгчийн	жолоочийн	сургуулийн	даргын	хүний	модны
үхрийн	багшийн	ангийн	өрөөний	оюутны	усны
өвөөгийн	багийн	ахын	хашааны	гахайн	нарны

хүүхэд + ийн = хүүхдийн, сургууль + ийн = сургуулийн, дарга + ын = даргын

Note: Sometimes -ийн/-ын or -ний/-ны makes a different word. For example: цагийн нөхцөл (suffixes of tense) or цагны үнэ (a price of watch), Сүхийн ах (the brother of Sukh) or сүхний иш (an ax handle)
Few words ending with **н** like сан, байшин, ан and үзэсгэлэн use **г** before genetive case (сангийн, байшингийн, ангийн, үзэсгэлэнгийн).

Question pronouns and personal pronouns:

юу → юуны (of what)	та → таны (your)	бид → бидний[13] (манай)[14] (our)
хэн → хэний (whose)	чи → чиний (your)	та нар → та нарын (танай) (your)
би → миний (my)	тэр → түүний (his/her)	тэд → тэдний (their)

13 Бидний and та нарын are used for things we possess and do not share with anyone. For example, бидний нүд (our eyes), та нарын бодол (your thoughts), бид нарын машин (our cars).
14 Манай and танай are used for the things people share. For example, манай гэр (our house), манай багш (our teacher), танай сургууль (your school).

Дасгал 1

А. Харьяалахын тийн ялгалын нөхцөлүүдээс тохирохыг нь бич. (Add proper endings from the genitive case to each word.)
Б. Холбоо үгсийг бич. (Write down pairs of words.)

Жишээ нь: ном..... → А. номын → Б. номын нэр

1. ном.....
2. аав.....
3. найз.....
4. өдөр.....
5. дэвтэр.....
6. үхэр.....
7. гахай.....
8. эмээ.....
9. өглөө.....
10. ширээ.....
11. өрөө.....
12. ах.....
13. дүү.....
14. багш.....
15. эгч.....
16. жолооч.....
17. хүүхэд.....
18. сургууль.....
19. анги.....
20. сар.....
21. хоол.....
22. гутал.....
23. эхнэр.....
24. дэлгүүр.....
25. нөхөр.....
26. цэцэг.....
27. мод.....
28. хэл.....
29. хичээл.....
30. ажил.....

Шинэ үгс: гахай — pig, өглөө — morning, сургууль — school, анги — classroom, хэл — language

Дасгал 2

Цэгийн оронд харьяалахын тийн ялгалын нөхцөл нөхөж бич. (Add the genitive case in the spaces.)

1. Тэр эмэгтэй (би) ..... ах..... найз..... найз.
2. Та..... багш..... нохой гадаа байна.
3. Баярхүү..... сургууль..... нэр "Сант."
4. Дулмаа..... өвөө..... дүү..... цамц зурагтай.
5. (Би) ..... ах..... багш..... найз том, хар машинтай.
6. Тэр хүүхэд..... аав..... ажил сонирхолтой.
7. Энэ (би) ..... өдөр..... хоол, тэр та..... орой..... хоол.
8. (Би) ..... ээж..... дүү..... найз..... багш монгол хүн.
9. Тэр хүн..... дээл..... өнгө хөх.
10. Энэ анги..... ширээ..... өнгө цагаан.
11. Энэ өрөө..... цонх том.
12. Монгол хэл..... хичээл хэцүү юү, амархан уу?
13. Та ..... монгол хэл..... багш..... нэр хэн бэ?

Шинэ үгс: орой — evening, зураг — picture, байшин — house, өдөр — day, дээл — Mongolian national clothes

Дасгал 3

Асуултад хариулж бич. (Answer the questions.)

1. Таны утасны дугаар хэд вэ?
2. Таны ажлын утасны (гэрийн утасны) дугаар хэд вэ?
3. Таны гар утасны дугаар хэд вэ?
4. Таны нөхрийн ажлын утасны дугаар хэд вэ?
5. Таны найзын гар утасны (гэрийн утасны) дугаар хэд вэ?

Шинэ үгс: утас — phone, дугаар — number, гар — hand

Дасгал 4

Асуултыг орчуулаад хариул. (Translate the questions and answer them.)

1. What is your name?
2. What is his/her name?
3. What is your father's name?
4. What is your mother's name?
5. What is your teacher's name?
6. What is his father's name?
7. What is his mother's name?
8. What is our teacher's name?
9. What is their teacher's name?
10. What is your (plural) teacher's name?
11. Is his book interesting?
12. Is her work difficult?
13. Is our lesson easy?
14. Is their house big?

Дасгал 5

Асуултад хариул. (Answer the questions.)

Жишээ нь:
— Өнөөдөр хэдэн оны хэдэн сарын хэдэн бэ? (What is the date today?)
— Өнөөдөр 2009 оны таван сарын нэгэн. (Today is May 1, 2009.)

Өнөөдөр хэдэн оны хэдэн сарын хэдэн бэ?

а. 2008 он, 11 сар, 25
б. 2000 он, 2 сар, 3
в. 1999 он, 12 сар, 14
г. 1989 он, 1 сар, 30

Маргааш хэдэн оны хэдэн сарын хэдэн бэ?

а. 1991 он, 10 сар, 5
б. 2002 он, 3 сар, 9
в. 2001 он, 5 сар, 11
г. 1988 он, 2 сар, 2

Нөгөөдөр хэдэн оны хэдэн сарын хэдэн бэ?

а. 1995 он, 4 сар, 8
б. 1992 он, 7 сар, 6
в. 2010 он, 9 сар, 31
г. 2012 он, 6 сар, 23

Шинэ үгс: өнөөдөр — today, маргааш — tomorrow, нөгөөдөр — the day after tomorrow

Есдүгээр хичээл

Биед хамаатуулах нөхцөл (Possessive suffixes)

миний ах = ах **минь**
чиний ах = ах **чинь**
танай ах = ах **тань**
таны ах = ах **тань**
манай ах = ах **маань**
түүний/тэдний ах = ах **нь**

Дасгал 1

Харьяалахын тийн ялгалд байгаа биеийн төлөөний үгсийг биед хамаатуулах нөхцөлөөр сольж бич. (Replace personal pronouns that have genitive cases with possessive suffixes.)

Жишээ нь: миний ном = ном минь

1. манай ах = ...
2. миний найз = ...
3. чиний ээж = ...
4. танай найз = ...
5. таны морь = ...
6. манай аав = ...
7. чиний гэр = ...
8. тэдний цай = ...
9. манай хүүхэд = ...
10. тэдний анги = ...
11. чиний гутал = ...
12. чиний машин = ...
13. таны сургууль = ...
14. манай байр = ...
15. тэдний охин = ...
16. миний зураг = ...
17. танай гэр = ...
18. түүний багш = ...
19. түүний цамц = ...
20. таны гар = ...
21. танай охин = ...

Дасгал 2

Биед хамаатуулах нөхцөлийг харьяалахын тийн ялгалд байгаа биеийн төлөөний нэрээр сольж бич. (Replace possessive suffixes with personal pronouns that have genitive cases.)

Жишээ нь: ном минь = миний ном

1. найз тань = ...
2. ах маань = ...
3. гэр тань = ...
4. цай нь = ...
5. гар чинь = ...
6. анги чинь = ...
7. анги нь = ...
8. морь тань = ...
9. охин нь = ...
10. найз минь = ...
11. байр маань = ...
12. гэр чинь = ...
13. багш нь = ...
14. хүүхэд тань = ...
15. гутал чинь = ...
16. охин тань = ...
17. зураг минь = ...
18. аав маань = ...
19. цамц нь = ...
20. сургууль тань = ...
21. ээж чинь = ...

Дасгал 3

Гэр бүлийнхээ болон найзынхаа тухай биед хамаатуулах нөхцөлийг ашиглан ярь. (Talk about your family and a friend using the possessive suffixes.)

Дасгал 4

Харьяалахын тийн ялгалд байгаа биеийн төлөөний нэрийг биед хамаатуулах нөхцөлөөр сольж бич. (Replace personal pronouns that have genitive cases with possessive suffixes.)

Жишээ нь: Миний ах нэг хүүхэдтэй. → Ах минь нэг хүүхэдтэй.

1. Миний нохой их хөөрхөн.
2. Тэдний өвөө сайн хүн.
3. Чиний цэцэг шар.
4. Миний муур хар.
5. Түүний гэр их том.
6. Чиний машин үнэтэй.
7. Манай байр шинэ.
8. Манай хүү дулаан хувцастай.
9. Чиний нэр сонирхолтой.
10. Түүний ээж багш.
11. Түүний сургууль олон оюутантай.
12. Таны оюутан гадаа байна.
13. Танай хүү гэрт байна.
14. Тэдний машин хар.
15. Миний морь гадаа байна.
16. Танай муур өрөөнд байна.
17. Миний цүнх бор.
18. Түүний ном өрөөнд байна.
19. Манай аав сайн жолооч.
20. Чиний найз муу хүн биш.
21. Түүний гэр дулаан.
22. Түүний цамц шар.

Үндэс үүсгэх "-х" дагавар (Suffix "-х")

Suffix "-x" is used after genitive case and means " 's."

For example:

Энэ таны**х**.	This is your**s**.
Тэр **минийх**.	That's **mine**.
Энэ манай багшийн**х**.	This is our teacher**'s**.
Тэр үзэг Бурмаагийнх.	That pen is Burmaa's.
Энэ танай дүүгийнх.	This is your younger sibling's.
Энэ танай эгчийнх.	This is your sister's.

Дасгал 5

Нэр үгсийг хасч, "-х" дагаврыг харьяалахын тийн ялгалтай үгст залгаж бич.
(Take out nouns and add the suffix "-x" after the personal pronouns and nouns with genitive cases.)

Жишээ нь: Энэ манай аавын машин. → Энэ манай ааынх.

1. Энэ миний ном.
2. Тэр таны үзэг.
3. Тэр түүний дэвтэр.
4. Энэ бид нарын хоол.
5. Энэ та нарын ширээ.
6. Энэ тэд нарын бал.
7. Энэ танай компьютер.
8. Энэ манай багшийн малгай.
9. Энэ танай эгчийн гутал.
10. Тэр, Батхүүгийн ахын машин.
11. Энэ манай дүүгийн сандал.
12. Энэ манай өвөөгийн харандаа.

Дасгал 6

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. This is mine.
2. This is yours.
3. This is Bathuu's.
4. Mine is big. Yours is small.
5. Hers is nice.
6. His is new. Mine is old.
7. Mine is correct. Yours is wrong.
8. Ours is blue. Yours is white.
9. This is my mother's.
10. This is our mother's friend's.
11. This is our mother's friend's child's.
12. This is yours, not mine.
13. Whose is that?
14. Whose is this?
15. Is this mine or yours?
16. Is this yours or hers?
17. Is that our teacher's?
18. Is that your sister's or your brother's?

Шинэ үг: ball point pen — бал

Хүмүүстэй танилцах (To get to know people)

А: — Таны/чиний нэр хэн бэ?
Б: — Миний нэр .....
— Таныг хэн гэдэг вэ?
А: — Намайг ..... гэдэг.
Та хаанаас ирсэн бэ?
Б: — Би Америкаас ирсэн.
А: — Та энд хэр удаж байна (вэ)?
Б: — ..... сар/жил болж байна.
А: — Та Монголд хэр удах вэ?
Б: — ... сар/жил болно.
А: — Та Герман хэл мэдэх үү?
Б: — Мэдэхгүй. Харин та?
А: — Мэднэ.
Б: — Сайхан танилцлаа.
А: — Сайхан танилцлаа.

A: — What is your name?
B: — My name is .....
— What is your name?
A: — My name is .....
Where are you from?
B: — I'm from America.
A: — How long have you been staying here?
B: — I have been staying for ..... months/years.
A: — How long will you stay in Mongolia?
B: — I will stay for ... months/years.
A: — Do you know German?
B: — I don't know it. How about you?
A: — I know it.
B: — Nice to meet you.
A: — Nice to meet you.

Аравдугаар хичээл

Үйл үгийн зарим хэлбэр (Some verb forms)

In Mongolian language, different tense suffixes are added to the verb stem to express the different tenses. For example:

явах — to go
яв — verb stem (Verb stems express commands for second person. Яв! means Go!)

явсан — went
явна — will go
явдаг — go (in general)

Spelling rules:

	Please	Past tense	Future tense	Present tense
After verb stems with **а**, **у** or **я**	-аарай	-сан	-на	-даг
After verb stems with **э**, **ү** or **и**	-ээрэй	-сэн	-нэ	-дэг
After verb stems with **о**	-оорой	-сон	-но	-дог
After verb stems with **ө**	-өөрэй	-сөн	-нө	-дөг

Дасгал 1

Үйл үгийн үндсэнд тохирох нөхцөлийг залгаж бич. (Add the proper endings to the verb stems.)

	Infinitive verbs in English	Mongolian verbs	Stems of verbs	+аарай[4]	+сан[4]	+на[4]	+даг[4]
1.	to go	явах	яв	яваарай	явсан	явна	явдаг
2.	to come	ирэх	ир				
3.	to buy, to take	авах	ав				
4.	to read	унших	унш			унш(и)...	
5.	to write	бичих	бич				
6.	to play	тоглох	тогло	тоглоорой			
7.	to come (go) in	орох	ор				
8.	to eat	идэх	ид				
9.	to meet	уулзах	уулз			уулз(а)...	
10.	to drink	уух	уу	уу(г)...			
11.	to sit down	суух	суу	суу(г)...			
12.	to do, to make	хийх	хий	хий(г)...			

Дасгал 2

Дасгал 1-ийн үйл үгс болон өмнө сурсан нэр үг, тэмдэг нэрсээ ашиглан богино өгүүлбэр зохио. (Make short sentences using the verbs from Exercise 1 and nouns and adjectives learned before.)

Жишээ нь: Хоол идээрэй. (Please eat the food.) Би хоол идсэн. (I ate the food.)

Дасгал 3

1. Доорх өгүүлбэр бүрийг таваас доошгүй удаа унш. (Read each sentence below at least five times.)
2. Өгүүлбэрийн зохион байгуулалтыг алдагдуулалгүйгээр үгсийг нь өөрсдийн сурсан үгсээрээ сольж бич. (Replace words in the sentences with words that you have learned without changing the sentence structure.)

Examples of Mongolian sentence structure:

Хэн	**хэзээ**	**хэдэн цагт**	**хаана**	**хэнтэй**	**юу**	**яасан.**
Who	when	what time	where	with whom	what	did.
Би	өчигдөр	6 цагт	ресторанд	Баттай	хоол	идсэн.

I ate food yesterday at 6 o'clock at the restaurant with Bat.

Хэн	**хэзээ**	**хэдэн цагт**	**хаана**	**хэнтэй**	**юу**	**яана.**
Би	маргааш	10 цагт	ангид	багштай	хичээл	хийнэ.

I will do a lesson tomorrow at 10 o'clock in the classroom with the teacher.

Хэн	**хэзээ**	**хэдэн цагт**	**хаана**	**хэнтэй**	**юу**	**яадаг.**
Би	нэгдэх өдөр	10 цагт	гадаа	аавтай	теннис	тоглодог.

I play tennis on Monday at 10 o'clock outside with dad.

Дасгал 4

Үгсийг зөв дараалалд оруулж бич. (Put the words in the correct order.)

1. ангид, маргааш, би, хийнэ, багштай, 10 цагт, хичээл
2. идсэн, 6 цагт, өчигдөр, би, хоол, ресторанд, Батхүүтэй
3. би, 10 цагт, гадаа, аавтай, теннис, нэгдэх өдөр, тоглодог
4. маргааш, хоол, 1 цагт, хийгээрэй, гадаа, та, Батхүүтэй
5. хүүхдүүд, хичээл, 2 цагт, хийсэн, өчигдөр, гэрт
6. тавдахь өдөр, багш, хийдэг, хүүхдүүдтэй, 9 цагт, хичээл

Дасгал 5

Сурсан үгсээ ашиглан өчигдөр юу хийсэн болон маргааш юу хийхээ Дасгал 3-ын загвараар бич. (Write down what you did yesterday and what you will do tomorrow as in Exercise 3. Use words you have already learned.)

Үйл үгийн үндэс (Verb stems)

Infinitive verbs end with suffix "(vowel)+х." When we make verb stems out of infinitive verbs, we need to pay attention to the following:

- If the last three letters are **consonant+vowel+х**, then we take out last **vowel** and **х**. For example: явах → яв, ирэх → ир, харах → хар.

- If the last three letters are **long vowel+х or diphthong+х**, then we take out just **х**. For example: суух → суу, байх → бай.

- If the last three letters are **н+vowel+х**, then we take out just **х**. For example: хонох → хоно, онох → оно, санах → сана.

- If the last four letters are **7**[15]**+л+vowel+х**, then we take out just **х**. For example: тоглох → тогло, ажиллах → ажилла, баярлах → баярла.

- If the last four letters are **9**[16]**+л+vowel+х** or **consonants+р+vowel+х**, then we take out last **vowel** and **х** and add the vowel in front of **л** or **р**. For example: туслах → тусал, услах → усал, хурцлах → хурцал, амьдрах → амьдар, амрах → амар, хөмрөх → хөмөр.

- If the last four letters are **ж** (ч, ш) **+л+vowel+х** or **ж** (ч, ш)**+р+vowel+х**, then we insert **и** before **л** and **р**. For example: уучлах → уучил, хөгшрөх → хөгшир.

- If the last four letters are **consonant+г+vowel+х**, then we just take out **х**. For example: гаргах → гарга, олгох → олго, хүндэтгэх → хүндэтгэ.

- If the last four letters are **7+в/б+vowel+х**, then we just take out **х**. For example: холбох → холбо, харвах → харва.

- If an infinitive verb ends with **-ж**(ч, ш)**их**, then **и** and **х** are dropped. For example: бичих → бич, унших → унш, хожих → хож. But if infinitive verbs ending with **-их** (besides и after ж, ч and ш), then we drop **х** and **и** becomes **ь**. For example: барих → барь, болих → боль, ярих → ярь.

Note: If suffixes that start with consonants are added to verb stems that end with **vowel+consonant** or **all vowels**, they are added directly. For example: усал + сан = усалсан, усал + даг = усалдаг, тогло + сон = тоглосон, угаа + сан = угаасан, хай + сан = хайсан.

But if suffixes that start with long vowels are added to verb stems that end with **vowel+consonant** or **consonant+vowel**, then the last vowels which are before or after the consonant are dropped. For example: усал + аарай = услаарай, гарга + аарай = гаргаарай

If suffixes that start with long vowels are added to verb stems that end with long vowels or diphthongs, then **г** is inserted between the four vowels. For example: асуу + аарай = асуугаарай, хай + аарай = хайгаарай, нээ + ээрэй = нээгээрэй

15 The seven consonants in "**монгол баавар**" (м, н, г, л, б, в, р) always require a vowel in front of or behind them in words. If you want to see more about spelling rules, please look at the Appendix.

16 The nine consonants in "**Цоожоо засаад тушаачих**" (ц, ж, з, с, д, т, ш, ч, х) can be without vowels in words.

Дасгал 6

Өмнөх хуудсанд буй хэлзүйн тайлбарыг уншаад хавсралтад байгаа үйл үгсийн үндсийг тодорхойгүй төлөвт байгаа үйл үгтэй нь харьцуулж ажигла.
(Read the grammar explanations from the previous page, then look closely at verb stems in the appendix and compare them with their infinitive forms.)

Дасгал 7

Доорх үйл үгсийн үндсийг бич. (Write the stems of verbs below.)

1. Авах
2. Авчрах
3. Айх
4. Ажиллах
5. Алхах
6. Амрах
7. Амьдрах
8. Анхаарах
9. Асаах
10. Асгах
11. Асуух
12. Байх
13. Барих
14. Батлах
15. Бахархах
16. Баярлах
17. Босох
18. Буцах
19. Бэлдэх
20. Гайхах
21. Гүйх
22. Гэрлэх
23. Дуулах
24. Дэлгэх
25. Дэмжих
26. Дээшлэх
27. Заах
28. Загнах
29. Залгах
30. Идэх
31. Инээх
32. Итгэх
33. Магтах
34. Маллах
35. Мандах
36. Маргах
37. Мартах
38. Мэдрэх
39. Мэдэх
40. Нөхөх
41. Нугалах
42. Нүүх
43. Нүхлэх
44 Онгойх
45. Онох
46. Оролцох
47 Ойлгох
48. Өвдөх
49. Өгөх
50. Өлсөх
51. Өөрчлөх
52. Өргөх
53. Өшиглөх
54. Саах
55. Салах
56. Самнах
57. Санах
58. Солих
59. Сонгох
60. Сонсох
61. Судлах
62. Суллах
63. Суух
64. Тавих
65. Таглах
66. Танилцах
67. Таних
68. Тоглох
69. Тогтоох
70. Томрох
71. Торгох
72. Тослох
73. Туслах
74. Түлэх
75. Түүх
76. Тэврэх
77. Удах
78. Уйлах
79. Унах
80. Унтах
81. Унших
82. Урих
83. Уурлах
84. Уулзах
85. Уух
86. Уучлах
87. Үзэх
88. Хаах
89. Хавдах
90. Хариулах
91. Хаях
92. Хийх
93. Хонох
94. Хориглох
95. Хоцрох
96. Хуваах
97. Хугарах
98. Худалдах
99. Хүндлэх
100. Хүрэх
101. Хэвлэх
102. Хэлэх
103. Хэрэглэх
104. Хянах
105 Шийтгэх
106. Эвдрэх
107. Эмчлэх
108. Эхлэх
109. Ээлжлэх
110. Явах
111. Ядрах
112. Ярих

Давтлага хичээл

Дасгал 1

Өгүүлбэрийг гүйцээ. (Complete the sentences.)

1. ..... халуун.
2. ..... хүйтэн.
3. ..... дулаан.
4. ..... муу.
5. ..... сайн
6. ..... муухай.
7. ..... сайхан.
8. ..... жижиг.
9. ..... том.
10. ..... шинэ.
11. ..... хэцүү.
12. ..... амар(хан).
13. ..... амттай.
14. ..... амтгүй.
15. ..... үнэтэй.
16. ..... хямд.

Дасгал 2

Жишээ өгүүлбэрт бичсэний адилаар өгүүлбэр зохио. (Make sentences as in the example.)

Жишээ: Миний цамц улаан. → Би улаан цамцтай.

1. Баярхүүгийн гутал том.
2. Миний ороолт хар.
3. Миний малгай бор.
4. Манай аавын машин цагаан.
5. Танай хүүгийн цүнх шар.
6. Манай найзын өмд хөх.
7. Түүний хүүхдийн оймс ногос
8. Гэрэлмаагийн бээлий саарал.
9. Тэр охины хувцас ягаан.
10. Түүний хүрэм улбар шар.
11. Таны малгай жижиг.
12. Ахын сандал сайн.

Дасгал 3

Цэгийн оронд харьяалахын тийн ялгал нөхөж бич. (Add genitive cases in the spaces.)

1. багш..... ном
2. оюутан..... бал
3. сургууль..... зураг
4. анги..... цонх
5. ээж..... хувцас
6. та..... хичээл
7. аав..... ажил
8. хүүхэд..... нэр
9. машин..... дугаар
10. жолооч..... гэр
11. (би) ..... гутал
12. Гэрэлмаа..... найз
13. ямаа..... мах
14. үхэр..... мах
15. хонь..... мах
16. (тэр) ..... аав ээж
17. бид..... харандаа
18. тэд..... хүүхэд
19. хүн..... нэр
20. өвөө..... сандал
21. цэцэг..... өнгө
22. та нар..... хичээл

Дасгал 4

Хүснэгтийг бөглөж, үйл үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Fill out the table and make sentences using the verbs.)

Infinitive	Stem	Please	Past tense	Future tense	Present tense
ирэх					
уух					
хийх					
бичих					
явах					
идэх					

Дасгал 5

Харьяалахын тийн ялгалд байгаа биеийн төлөөний нэрийг биед хамаатуулах нөхцөлөөр сольж бич. (Replace personal pronouns that have genitive cases with possessive suffixes.)

Жишээ нь: таны ах = ах тань

1. миний эгч = ...
2. түүний найз = ...
3. танай сургууль = ...
4. манай анги = ...
5. чиний нэр = ...
6. таны гэр = ...
7. чиний хувцас = ...
8. танай аав ээж = ...
9. түүний эмээ өвөө = ...
10. манай багш = ...
11. миний гар = ...
12. таны ажил = ...

Дасгал 6

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. This is mine.
2. His is right.
3. Mine is big.
4. This table is theirs.
5. That's yours (singular).
6. That notebook is hers.
7. That's ours.
8. Yours is blue.
9. This is my brother's.
10. Whose is this?
11. My brother's is nice.
12. Is this mine or yours?
13. This car is my father's.
14. Is that his or mine?
15. That's yours (plural).
16. Is this ours or yours?
17. This cup is his.
18. Is this mother's or fathers?

Дасгал 7

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. See you on Monday.
2. See you on Saturday.
3. See you on Sunday.
4. See you later.
5. See you tomorrow at my house.
6. See you at your house at four o'clock.
7. See you at six o'clock at the restaurant.
8. See you outside.

Дасгал 8

Өнгөнүүдийг монголоор бич. (Write these colors in Mongolian.)

1. white
2. black
3. green
4. brown
5. red
6. dark red
7. yellow
8. blue
9. light blue
10. gray
11. orange
12. pink

Дасгал 9

Үгийн сүлжээг бөглө. (Fill out the crossword puzzle.)

Across

1. pants
2. shorts
3. glove
4. scarf
5. skirt
6. tie
7. hat/cap

Down

1. jacket
2. coat
3. dress
4. boots
5. shoes
6. shirt
7. socks



Тест

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Би малгай улаан.
   Б. Миний малгай улаан.
   В. Малгай миний улаан.

2. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Би хөх ороолтгүй.
   Б. Би хөх ороолттойгүй.
   В. Миний хөх ороолтгүй.

3. Аль нь зөв бэ?
   Which one is right?
   А. ээжгийн
   Б. ээжын
   В. ээжийн

4. Аль нь зөв бэ?
   Which one is right?
   А. багшын
   Б. багшийн
   В. багшны

5. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. өвөөгийн
   Б. өвөөний
   В. өвөөгын

6. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. ахийн
   Б. ахын
   В. ахны

7. His mother is a teacher.
   А. Ээж минь багш.
   Б. Ээж чинь багш.
   В. Ээж нь багш.

8. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. охин минь = миний охин
   Б. охин нь = охин маань
   В. охин тань = манай охин

9. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Энэ таны.
   Б. Энэ таных.
   В. Энэ тах.

10. This is that boy's.
   А. Энэ тэр хүүгийн.
   Б. Энэ тэр хүүгийнх.
   В. Тэр энэ хүүгийнх.

11. "хийх" гэдэг үгийн үндэс
   The stem of verb "хийх"
   А. хий
   Б. хи
   В. хийх

12. "идэх" гэдэг үгийн үндэс
   The stem of verb "идэх"
   А. идэх
   Б. ид
   В. идэ

13. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. бичээрэй
   Б. бичгээрэй
   В. бичаарай

14. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. уншсан
   Б. уншсэн
   В. уншсон

15. See you at your house.
   А. Чи гэрт уулзъя.
   Б. Чиний гэрт уулзъя.
   В. Чиний гэр уулзъя.

16. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. сууаарай
   Б. суухаарай
   В. суугаарай

Оноо (point): 16/.....

Арван нэгдүгээр хичээл

Өнгөрсөн цаг (Past tense)

Spelling rules:

	After verb stems with **а**, **у** or **я**	After verb stems with **э**, **ү** or **и**	After verb stems with **о**	After verb stems with **ө**
Affirmative form	-сан	-сэн	-сон	-сөн
Negative form	-аагүй	-ээгүй	-оогүй	-өөгүй
Question form	-сан уу/бэ?	-сэн үү/бэ?	-сон уу/бэ?	-сөн үү/бэ?

For example:

Би хоол **идсэн**.	I **ate** food.
Тэд теннис тоглосон.	They played tennis.
Би хүүд хоол өгсөн.	I gave food to the boy.
Би хоол **идээгүй**.	I **didn't eat** food.
Тэд теннис тоглоогүй.	They didn't play tennis.
Би хүүд хоол өгөөгүй.	I didn't give food to the boy.
Та хоол **идсэн үү**? [idsnüü]	**Did** you **eat** food?
Тэд теннис тоглосон уу? [toglsnuu]	Did they play tennis?
Та хүүд хоол өгсөн үү? [ögsnüü]	Did you give food to the boy.
Та хэнд хоол өгсөн бэ? [ögsömbe]	To whom did you give food?
Та ямар хоол **идсэн бэ**? [idsembe]	What kind of food **did** you **eat**?
Хэн теннис тоглосон бэ? [toglsombe]	Who played tennis?

Note:

- The suffix -**сан**[4] can be added directly to verb stems that end with a consonant, vowel or soft sign. For example: уншсан, хийсэн, тоглосон, барьсан
- But when last letters of the verb stem are -**хь**, the soft sign becomes **и**. For example: цохь+сон = цохисон.

For negative form -**аагүй**[4]:

- When this suffix is added to verb stems that end with long vowels and diphthongs, **г** is inserted between the four vowels. For example: уу+аагүй = уугаагүй.
- If the last letters of a stem are **cvc**, the vowel in between the two consonants is dropped when we add this suffix. For example: амар+аагүй = амраагүй.
- If the verb stem ends with a short vowel, the short vowel is dropped when we add -аагүй[4]. For example: ажилла+аагүй = ажиллаагүй, тогло+оогүй = тоглоогүй.
- If the verb stem ends with a soft sign, the soft sign becomes **и** and one of the long vowels is dropped when we add -аагүй[4]. For example: барь+аагүй = бариагүй, боль+оогүй = болиогүй.

Key words for past tense:

уржигдар	the day before yesterday	өнгөрсөн шөнө	last night
өчигдөр	yesterday	жилийн өмнө	year ago
өнгөрсөн жил (ноднин)	last year	сарын өмнө	month ago
өнгөрсөн сар(д)	last month	7 хоногийн өмнө	week ago
өнгөрсөн 7 хоног(т)	last week	цагийн өмнө	hour ago

Дасгал 1

Үйл үгийн үндсэнд хүснэгтийн дээд эгнээнд байгаа загварын дагуу нөхцөл залгаж, асуулт зохио. Дараа нь өгүүлбэр зохио. (Add the same endings to the verb stems as in the examples at the top of the table, then make short questions and sentences.)

	ирсэн	ирсэн үү?	хэзээ ирсэн бэ?	ирээгүй	ирээгүй юү?
1.	яв.....			яв.....	яваагүй юү?
2.	ав.....			ав.....	
3.	унш.....			унш.....	
4.	бич.....			бич.....	
5.	тогло.....			тогло.....	тоглоогүй юү?
6.	ойлго.....			ойлго.....	
7.	ид.....			ид.....	
8.	уулз.....			уулз.....	
9.	уу.....			уу.....	
10.	бай.....			бай.....	
11.	хий.....			хий.....	

Шинэ үгс: ойлгох — to understand, байх — to be

Жишээ нь:

Тэр манай гэрт ирсэн.
Тэр танай гэрт ирсэн үү?
Тэр хэзээ танай гэрт ирсэн бэ?

Тэр манай гэрт ирээгүй.
Тэр танай гэрт ирээгүй юү?
Тэр яагаад танай гэрт ирээгүй вэ?

Дасгал 2

Асуултуудыг сонсоод орчуул. (Listen to the questions and translate them.)

1. Та дэлгүүр лүү[17] явсан уу?
2. Та ном уншсан уу?
3. Та теннис тоглосон уу?
4. Та хоол идсэн үү?
5. Та ундаа уусан уу?
6. Та мах авсан уу?
7. Та имэйл бичсэн үү?
8. Та хоол хийсэн үү?
9. Та ажил хийсэн үү?
10. Чи хичээл хийсэн үү?
11. Чи гэрт байсан уу?
12. Чи хичээл ойлгосон уу?
13. Чи дэвтэр авсан уу?

Та хэзээ дэлгүүр лүү явсан бэ?
Та ямар ном уншсан бэ?
Та хаана теннис тоглосон бэ?
Та хэнтэй хоол идсэн бэ?
Та ямар ундаа уусан бэ?
Та хэдэн кило мах авсан бэ?
Та хэдэн имэйл бичсэн бэ?
Та ямар хоол хийсэн бэ?
Та хэдэн цаг(т) ажил хийсэн бэ?
Чи хаана хичээл хийсэн бэ?
Чи хэдэн цагт гэрт байсан бэ?
Хэн хичээл ойлгосон бэ?
Хэн дэвтэр авсан бэ?

Шинэ үгс: дэлгүүр — store, ундаа — soft drink, мах — meat

17 руу/рүү, луу/лүү — to, towards (If you want to know more about this, see Lesson 39.)

Дасгал 3

Хаалтанд байгаа үгсийг өмнөх өгүүлбэрт нь нэмж, өгүүлбэр зохио. (Add the words in parentheses to the sentences as in the example.)

Жишээ нь: Тэр ирсэн. (өчигдөр, 5 цаг, энд, багш, манай)
А. Тэр өчигдөр ирсэн.
Б. Тэр өчигдөр 5 цагт[18] ирсэн.
В. Тэр өчигдөр 5 цагт энд ирсэн.
Г. Тэр өчигдөр 5 цагт энд багштай ирсэн.
Д. Тэр өчигдөр 5 цагт энд манай багштай[19] ирсэн.

1. Би хоол хийсэн. (уржигдар, 7 цаг, гэр, амттай, үхрийн мах)
2. Манай найз явсан. (өчигдөр, хөдөө, сайн жолооч)
3. Би ном уншсан. (уржигдар, 3 цаг, гэр, сонирхолтой)
4. Төрхүү имэйл бичсэн. (өчигдөр, 1 цаг)
5. Хүүхэд тоглосон. (өнгөрсөн 7 хоногт, олон цаг, гадаа, теннис, Борхүү)
6. Ууганхүү пицца идсэн. (уржигдар, өглөө, 12 цаг, ресторан, итали)
7. Би кофе уусан. (өчигдөр, гэр, сүү, халуун)
8. Би Монголд байсан. (2 сар, гэр)

Дасгал 4

Доорх зургуудыг хараад Ганхүүгийн өчигдөр юу юу хийснийг бич. (Look at the pictures below and write down what Ganhuu did yesterday.)



[18] Suffixes -д/-т mean in, at, to and for. -Т is used for words ending with г, с, (р) and (в). -Д is used for words ending with vowels and consonants except for г, с, (р) and (в). For example: цагт, гэрт, хүмүүст, сэдэвт, ламд, хүнд, ээжид
Манай гэрт 2 цагт ирээрэй. (Please come to my house at two o'clock.) (If you want to know more about this, see Lesson 22.)

[19] "-тай" means with (If you want to know more about this, see Lesson 14.)

Би Гэрэлмаатай тоглосон.	I played with Gerelmaa.
Тэр найзтайгаа хоол хийсэн.	He made food with his friend.
Бид аав ээжтэйгээ хоол идсэн.	We ate food with our parents.
Би багштайгаа хичээл хийсэн.	I did lessons with my teacher.

Дасгал 5

Асуултыг уншаад хариул. (Read the questions and answer them.)

1. Та сайхан амарсан уу?
2. Та хичээлээ ойлгосон уу?
3. Та хөдөө амарсан уу?
4. Та өчигдөр ажил хийсэн үү?
5. Та өчигдөр юу юу[20] хийсэн бэ?
6. Та ном уншсан уу?
7. Та хэзээ Монголд ирсэн бэ?
8. Та ямар хоол идсэн бэ?
9. Та хүйтэн ус уусан уу?
10. Та дэлгүүрээс[21] юу авсан бэ?
11. Та Америкаас хэзээ ирсэн бэ?
12. Өчигдөр гадаа халуун байсан уу?
13. Та дэлгүүр лүү[22] явсан уу?
14. Та тоглоом тоглосон уу?
15. Та хичээл хийсэн үү?
16. Та 5 сард Монголд ирсэн үү?
17. Та хэдэн цагт банк руу явсан бэ?
18. Та өнгөрсөн жил энд байсан уу?

Шинэ үгс: ус — water, тоглоом — toy/game, амрах — to rest, гадаа — outside

Дасгал 6

Өгүүлбэрийг орчуулаад өмнөх дасгалаас харж, алдаагаа зас. (Translate the sentences, then look back to the previous exercise and check them.)

1. Did you sleep well?
2. Did you understand your lesson?
3. Did you rest in the countryside?
4. Did you do work yesterday?
5. What all did you do yesterday?
6. Did you read a book?
7. When did you come to Mongolia?
8. What kind of food did you eat?
9. Did you drink cold water?
10. What did you buy from the store?
11. When did you come from America?
12. Was it hot outside yesterday?
13. Did you go to the store?
14. Did you play a game?
15. Did you do the lesson?
16. Did you come to Mongolia in May?
17. What time did you go to the bank?
18. Were you here last year?

20 When a question pronoun is repeated twice, it expresses plurality.

21 -аас/-ээс/-оос/-өөс means from (If you want to know more about this, see Lesson 29.)

Би Америкаас ирсэн.	I came from America.
Би дэлгүүрээс мах авсан.	I bought meat from the store.
Та хаанаас ирсэн бэ?	Where did you come from?

22 The verb "явах" is always used with the suffix руу/рүү and луу/лүү. If a noun ends with "р," луу/лүү is used. (луу is for masculine words and лүү is for feminine words.) For example:

Тэр Улаанбаатар луу явсан.	He went to Ulaanbaatar.
Тэд банк руу явсан.	They went to the bank.
Та хаашаа явсан бэ?	Where did you go?

Дасгал 7

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь: (When, with whom, what time, why) Did you come here?

А. Чи энд ирсэн үү?
Б. Чи хэзээ энд ирсэн бэ?
В. Чи хэнтэй энд ирсэн бэ?
Г. Чи хэдэн цагт энд ирсэн бэ?
Д. Чи яагаад энд ирсэн бэ?

1. (When, which store, with whom) Did you go to the store?
2. (When, how many, what kind of) Did you buy a nice bag?
3. (What kind of, how many, when, where) Did you read a book?
4. (Where, when, with whom, what time, what kind of) Did you eat food?
5. (Where, when, with whom, what time, how many hours) Did you play tennis?
6. (What kind of, with whom, when, what time, how many hours) Did you cook?

Дасгал 8

Асуултыг орчуулаад хариул. (Translate the questions and answer them.)

1. What did you do yesterday?
2. Did you understand your lesson?
3. When did you come to Mongolia?
4. Did you come here yesterday?
5. Did you go to the store last week?
6. Did you read a book an hour ago?
7. How many books did you read?
8. Where did you eat last Sunday?
9. What kind of food did you eat?
10. With whom did you play volleyball?
11. Did you rest yesterday?
12. Did you come here last week?
13. When did you write an email?
14. With whom did you go to the store?
15. With whom did you cook?
16. When did you eat?

Ерөнхийлөн хамаатуулах нөхцөл (Possessive suffix)

Object + **аа, ээ, оо, өө** (This suffix shows that the object belongs to the subject.)

Би ном**оо** уншсан.	**I** read **my** book.
Тэр ном**оо** уншсан.	**He** read **his** book.
Та ном**оо** уншсан.	**You** read **your** book.
Би найзтайгаа уулзсан.	**I** met (with) **my** friend.

Note: If objects belong to someone else, not to the subject, then миний, чиний, таны are used. For example:

Би **таны** найзтай уулзсан.	I met **your** friend.
Тэр **миний** найзтай уулзсан.	She met **my** friend.

Spelling rules:

	Suffixes
After nouns with **а** or **у**	-аа
After nouns with **э, ү** or **и**	-ээ
After nouns with **о**	-оо
After nouns with **ө**	-өө

For example: усаа, аваа, ээжээ, цүнхээ, ишгээ, ороо, хөлөө

Note:

- If the last letters of the verb stem are **cvc**, then the vowel in between the two consonants is dropped when we add this suffix. For example: үзэг + ээ = үзгээ, нөхөр + өө = нөхрөө.
- If a verb stem ends with a short vowel, the short vowel is dropped when we add -**аа**[4]. For example: дарга + аа = даргаа.
- If a verb stem ends with a soft sign, the soft sign become **и** and one of the long vowels is dropped when we add -**аа**[4]. For example: морь + оо = морио.
- When -**аа**[4] is added after nouns that end with long vowels and diphthongs, **г** is inserted before it. For example: хүү + ээ = хүүгээ, өвөө + өө = өвөөгөө, цай + аа = цайгаа.

Дасгал 9

Цэгийн оронд загварын дагуу үг, нөхцөл бич. (Write down words or suffixes as in the example.)

А. Тэр хоолоо идсэн. (He ate his food.)

1. Би хичээл ..... хийсэн.
2. Тэд (нар) цай ..... уусан.
3. Бид (нар) дасгал ..... бичсэн.
4. Жаргалмаа гар ..... цэвэрлэсэн.
5. Баярхүү машин ..... угаасан.
6. Та ажил ..... хийсэн үү?

Шинэ үгс: дасгал — exercise, цэвэрлэх — to clean, угаах — to wash

Б. Тэр гэртээ хоолоо идсэн. (He ate his food at his house.)

1. Та гэр ..... хийсэн.
2. Баярхүү гэр ..... уншсан.
3. Тэд гэр ..... хийсэн.
4. Бид гэр ..... уусан.
5. Жаргалмаа гэр ..... цэвэрлэсэн.
6. Ганхүү гэр ..... угаасан.

В. Би найзтайгаа уулзсан. (I met (with) my friend.)

1. Тэр жолооч ..... уулзсан.
2. Та багш..... уулзсан.
3. Ганхүү эгч ..... уулзсан.
4. Тэд дүү..... уулзсан.
5. Жаргалмаа өвөө..... уулзсан.
6. Баярхүү ээж ..... уулзсан.
7. Алтмаа охин..... уулзсан.

Г. Би гэр лүүгээ явсан. (I went to my house.)

1. Та ажил..... явсан.
2. Би сургууль..... явсан.
3. Батхүү гэр..... явсан.
4. Тэд (нар) ресторан..... явсан.
5. Бид (нар) дэлгүүр..... явсан.
6. Жаргалмаа найз..... явсан.
7. Баярхүү ээж..... явсан.

Д. Би гэрээсээ энд ирсэн. (I came here from my house.)
Би ахаасаа бэлэг авсан. (I got a gift from my brother.)

1. Би сургууль..... ирсэн.
2. Батхүү гэр..... ирсэн.
3. Тэд (нар) ресторан..... ирсэн.
4. Тэр хичээл ..... ирсэн.
5. Та ажил..... ирсэн үү?
6. Жаргалмаа найз..... ном авсан.
7. Баярхүү ээж..... бэлэг авсан.
8. Чи ах..... цэцэг авсан уу?

Е. Би найздаа бэлэг өгсөн. (I gave a gift to my friend.)
Би ээждээ бэлэг авсан. (I bought a gift for my mother.)

1. Тэр жолооч..... бэлэг авсан.
2. Батхүү эгч..... ном өгсөн.
3. Тэд дүү ..... тоглоом өгсөн.

4. Бид эмээ ..... жимс өгсөн.
5. Жаргалмаа өвөө ..... харандаа авсан.
6. Баярхүү ээж ..... бууз хийсэн.
7. Манай найз хүү ..... машин авсан.
8. Манай охин дарга ..... бэлэг өгсөн.

Шинэ үг: дарга — boss, бэлэг — gift, жимс — fruit, бууз — steamed meat dumplings

Хүнтэй уулзаад явахдаа (When you meet someone and leave)

А: — Баяртай.
Б: — Баяртай.
А: — Түр баяртай.
Б: — Түр баяртай.
А: — За, би явлаа. Баяртай.
Б: — Баяртай.
А: — Сайхан амраарай.
Б: — Та бас сайхан амраарай.

А: — Дараа уулзъя.
Б: — За, дараа уулзъя.
А: — Маргааш уулзъя.
Б: — За, маргааш уулзъя.
А: — Баяртай, удахгүй уулзъя.
Б: — За, удахгүй уулзъя.
А: — Сайн яваарай.
Б: — Сайн сууж байгаарай.
А: — Сайн яваад ирээрэй.
Б: — Сайн сууж байгаарай.
А: — Сайхан баярлаарай.
Б: — Та бас сайхан баярлаарай.
А: — Сайхан шинэлээрэй.
Б: — Сайхан шинэлээрэй.

A: — Bye.
B: — Bye.
A: — Bye for now.
B: — Bye for now.
A: — Okay, I'm leaving. Bye.
B: — Bye.
A: — Have a good holiday/Good night.
B: — Have a good holiday, too/Good night to you, too.
A: — See you later. (in the same day)
B: — Okay, see you later.
A: — See you tomorrow.
B: — Okay, see you tomorrow.
A: — Bye, see you soon.
B: — Okay, see you soon.
A: — Have a good trip.
B: — Stay well.
A: — Have a good trip. (Both ways)
B: — Stay well.
A: — Have a good celebration.
B: — Have a good celebration too.
A: — Have a good Tsagaan sar.
B: — Have a good Tsagaan sar.

Арван хоёрдугаар хичээл

Баймж үг (дуртай, дургүй) (Modal verbs (like, don't like))

"Дуртай" and "дургүй" are used with infinitive verbs. For example:

Би ном **унших дуртай**.	I **like to read** books.
Би ном **унших дургүй**.	I **don't like to read** books.
Би ном **унших дуртай байсан**.	I **liked to read** books.
Би ном **унших дургүй байсан**.	I **didn't like to read** books.
Хүүхдүүд гадаа тоглох дуртай.	Children like to play outside.
Хүүхдүүд гадаа тоглох дургүй.	Children don't like to play outside.
Хүүхдүүд гадаа тоглох дуртай байсан.	Children liked to play outside.
Хүүхдүүд гадаа тоглох дургүй байсан.	Children didn't like to play outside.

Дасгал 1

Өгүүлбэрийг уншаад асуулт зохио. (Read the sentences and make questions.)

Жишээ нь: Би ном унших дуртай. → Та ном унших дуртай юу?

1. Би монгол хоол идэх дуртай.
2. Тэр ажил хийх дургүй.
3. Тэр хүүхдийн ном унших дургүй.
4. Бид хөгжим сонсох дуртай.
5. Зарим хүн зураг зурах дуртай.
6. Хүүхэд асуулт асуух дуртай.
7. Тэр гадаа тоглох дургүй.
8. Би хөдөө амьдрах дуртай.
9. Зарим хүн хөдөө явах дургүй.
10. Би хэл сурах дуртай.
11. Би морь унах дуртай.
12. Тэр гэрээ цэвэрлэх дуртай.
13. Тэр хүмүүст бэлэг өгөх дуртай.
14. Тэр телевиз үзэх дуртай.

Шинэ үгс: сонсох — to hear/to listen to, зурах — to draw, зарим — some, хөгжим — music, асуулт — question, асуух — to ask, амьдрах — to live, унах — to ride/to fall down, сурах — to study/to learn, үзэх — to watch

Дасгал 2

"Дуртай/дургүй" -г ашиглан өгүүлбэрийг гүйцээ. (Complete the sentences using "дуртай/дургүй.")

1. Монгол хүмүүс .....
2. Солонгос хүмүүс .....
3. Америк хүмүүс .....
4. Том хүмүүс .....
5. Хүүхэд .....
6. Би .....
7. Манай найз .....

Дасгал 3

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та юу хийх дуртай вэ?
2. Та юу идэх дуртай вэ?
3. Та ямар хөгжим сонсох дуртай вэ?
4. Та юу уух дуртай вэ?
5. Та хаана амрах дуртай вэ?
6. Та хаана амьдрах дуртай вэ?
7. Та хэзээ хөдөө явах дуртай вэ?
8. Та ямар кино үзэх дуртай вэ?
9. Та хаана хоол идэх дуртай вэ?
10. Та хаашаа явах дуртай вэ?

Дасгал 4

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. What do you like to do?
2. I like to ride horses.
3. I don't like to cook.
4. She likes to eat fruit.
5. He doesn't like to read books.
6. They don't like to go to that store.
7. I like to eat in that restaurant.
8. He doesn't like to do work.
9. Mongolians like to eat meat.
10. Americans like to play tennis.
11. Children like to ask questions.
12. Old people like to drink milk tea.
13. Young people like to drink water.
14. People like to listen to music.
15. People like to live in gers.
16. We like to learn new things.
17. I don't like to open windows.
18. She doesn't like to draw pictures.

Дасгал 5

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь: I liked to play tennis but now I don't like it.
Би теннис тоглох дуртай байсан. Харин/Гэхдээ одоо дургүй (болсон).

I didn't like to play tennis but now I like it.
Би теннис тоглох дургүй байсан. Харин/Гэхдээ одоо дуртай (болсон).

1. I liked to listen to music but now I don't like it.
2. She liked to ride horses but now she does not like it.
3. They liked to draw pictures but now they don't like it.
4. We liked to go to the countryside but now we don't like it.
5. He liked to ask questions but now he does not like it.
6. They liked to live in a Mongolian ger but now they don't like it.
7. They didn't like to clean their house but now they like it.
8. We didn't like to live in the countryside but now we like it.
9. She didn't like to eat vegetables but now she likes it.
10. I liked to drink cola but now I don't like it.
11. My friend didn't like to drink milk tea but now she likes it.

Баймж үг (хэрэгтэй, хэрэггүй) (need, don't need)

"Хэрэгтэй" and "хэрэггүй" are used with infinitive verbs. For example:

Та энд хоол идэх хэрэгтэй.	You need to eat food here.
Та хөдөө явах хэрэггүй.	You don't need to go to the countryside.
Та хоол идэх хэрэгтэй байсан.	You needed to eat food.
Та хөдөө явах хэрэггүй байсан.	You didn't need to go to the countryside.

Дасгал 6

Өгүүлбэрийг уншаад асуулт зохио. (Read the sentences and make questions.)

Жишээ нь: Би хоол хийх хэрэгтэй. → Та хоол хийх хэрэгтэй юү?

1. Батхүү ном унших хэрэгтэй.
2. Хүмүүс ногоо идэх хэрэгтэй.
3. Багш морь унах хэрэггүй.
4. Ганхүү захиа бичих хэрэггүй.
5. Би гадаа тоглох хэрэггүй.
6. Тэр хөдөө амьдрах хэрэгтэй.
7. Та монгол хэл сурах хэрэгтэй.
8. Тэр гэртээ амрах хэрэгтэй.
9. Малчин малаа маллах хэрэгтэй.
10. Тэд рок хөгжим сонсох хэрэггүй.
11. Та нар багштай уулзах хэрэгтэй.
12. Би зураг зурах хэрэггүй.
13. Тэд ус уух хэрэгтэй.
14. Би дэлгүүр лүү явах хэрэггүй.
15. Та нар хичээлээ эхлэх хэрэгтэй.
16. Та нар ажлаа дуусгах хэрэгтэй.
17. Та хаалга хаах хэрэгтэй.
18. Та цонхоо нээх хэрэгтэй.

Шинэ үгс: ногоо — vegetable, захиа — letter, мал — livestock, малчин — herdsman, маллах — to take care of livestock, эхлэх — to start, дуусгах — to finish, хаах — to close, нээх — to open

Дасгал 7

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та маргааш юу юу хийх хэрэгтэй/хэрэггүй вэ?
2. Та маргааш хаашаа явах хэрэгтэй/хэрэггүй вэ?
3. Та дэлгүүрээс юу авах хэрэгтэй/хэрэггүй вэ?
4. Хүмүүс юу идэх хэрэгтэй/хэрэггүй вэ?
5. Хүмүүс юу уух хэрэгтэй/хэрэггүй вэ?
6. Хүмүүс хаана амьдрах хэрэгтэй/хэрэггүй вэ?
7. Ээж аав юу хийх хэрэгтэй/хэрэггүй вэ?
8. Хүүхдүүд юу хийх хэрэгтэй/хэрэггүй вэ?
9. Багш юу хийх хэрэгтэй/хэрэггүй вэ?
10. Оюутан юу сурах хэрэгтэй/хэрэггүй вэ?
11. Малчин юу хийх хэрэгтэй/хэрэггүй вэ?

Дасгал 8

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь: He needs to study in a school. → Тэр сургуульд сурах хэрэгтэй.

1. What do children need to do?
2. What do men need to do?
3. What do women need to do?
4. What do you need to buy?
5. What do you need to do?
6. Where do you need to go?
7. Children need to live with their parents.
8. I need to learn Mongolian very well.
9. Parents need to love their children.
10. You don't need to come here.
11. They need to live in a warm house.
12. We need to eat good food.
13. People need to do work.
14. You don't need to sit outside.

Дасгал 9

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь:
I needed to stay home but now I don't need to.
Би гэртээ байх хэрэгтэй байсан. Харин одоо хэрэггүй (болсон).

I didn't need to stay home but now I need to.
Би гэртээ байх хэрэггүй байсан. Харин одоо хэрэгтэй (болсон).

1. I needed to go to the store yesterday but now I don't need to.
2. They needed to go to the countryside but now they don't need to.
3. We needed to learn Korean but now we don't need to.
4. He needed to meet his boss but now he doesn't need to.
5. She needed to cook but now she doesn't need to.
6. I didn't need to learn Mongolian but now I need to.
7. They didn't need to write their lessons but now they need to.
8. We didn't need to buy new clothes but now we need to.
9. You didn't need to start your lesson today but now you need to.
10. I didn't need to live here but now I need to.

Арван гуравдугаар хичээл

Ирээдүй цаг (Future tense)

Spelling rules:

	After verb stems with **а, у** or **я**	After verb stems with **э, ү** or **и**	After verb stems with **о**	After verb stems with **ө**
Affirmative form	-на	-нэ	-но	-нө
Negative form	-хгүй	-хгүй	-хгүй	-хгүй
Question form	-х уу/вэ?	-х үү/ вэ?	-х уу/ вэ?	-х үү/ вэ?

For example:

Би хоол хийнэ. I will cook.
Би хоол хийхгүй. I won't cook.
Та хоол хийх үү? [hiihüü] Will you cook?
Та хэзээ хоол хийх вэ? When will you cook?

- **-на**[4] is added directly to verb stems. For example: явна, хийнэ, байна, ажиллана.
- But if a verb stem ends with double consonants, vowels are inserted between them. For example: унш + на = уншина, уулз + на = уулзана.
- **-хгүй** is added directly to verb stems that end with vowels. For example: уухгүй, байхгүй.
- **-а**[4]хгүй is added to verb stems that end with consonants. For example: идэхгүй, авахгүй.

Key words for future tense:

маргааш	tomorrow	жилийн дараа	after a year
-өгөөдөр	the day after tomorrow	сарын дараа	after a month
ирэх жил	next year	7 хоногийн дараа	after a week
ирэх сар(д)	next month	удахгүй	soon
ирэх 7 хоног(т)	next week	маргааш үдээс хойш	tomorrow afternoon

Дасгал 1

Үйл үгсийн үндсэнд хүснэгтийн дээд мөрөнд байгаа загварын дагуу нөхцөл залга. (Add endings to the verb stems as in the first row.)

ирнэ	ирэх үү?	хэзээ ирэх вэ?	ирэхгүй	ирэхгүй юү?
яв.....			яв.....	
унш.....			унш.....	уншихгүй юү?
уз....			уз.....	
уулз.....			уулз.....	
уу.....			уу.....	
бай.....			бай.....	байхгүй юү?
хий.....			хий	
сур.....			сур.....	

Дасгал 2

Асуултуудыг сонсоод, хариулж бич. (Listen to the questions and answer them.)

1. Та маргааш энд ирэх үү? [ирхүү]
2. Та хаана номоо унших вэ?
3. Та хөгжим сонсох уу? [сонсхуу]
4. Та хэдэн цаг хичээлээ бичих вэ?
5. Та дэлгүүрээс мах авах уу?
6. Та хэзээ найзтайгаа ярих вэ?
7. Та хэдэн цагт гэртээ байх вэ?
8. Та үдээс хойш теннис тоглох уу?
9. Та ресторанд хоол идэх үү?
10. Та маргааш багштай уулзах уу?
11. Та нөгөөдөр гэртээ байх уу?
12. Та хэзээ хоол хийх вэ?
13. Та ямар хөгжим сонсох вэ?
14. Та хэнтэй хөдөө явах вэ?
15. Та кофе уух уу, цай уух уу?
16. Та хаанаас үхрийн мах авах вэ?

Шинэ үг: ярих — to speak

Дасгал 3

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Дэлгүүр хэдэн цагт нээх вэ?
2. Та хаана амрах вэ?
3. (Би) цонх нээх үү?
4. Та хэзээ кино үзэх вэ?
5. Банк 5 цагт хаах уу?
6. Банк хэдэн цагт хаах вэ?
7. Таны хичээл нэг цагт эхлэх үү?
8. Хичээл хэдэн цагт эхлэх вэ?
9. Та хаашаа явах вэ?
10. Таны ажил хэзээ эхлэх вэ?
11. Та хөдөө машинаар[23] явах уу?
12. Та удахгүй амрах уу?
13. Хичээл 12 цагт дуусах уу?
14. Хичээл хэдэн цагт дуусах вэ?

Шинэ үг: дуусах — to be finished

Дасгал 4

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. (What kind of, from where) Will you buy a car soon?
2. (Which, what time) Will you go to the store?
3. (When, what kind of food) Will you cook?
4. (When, what time) Will you be home?
5. (How many years) Will you stay here for many years?
6. (Where, what time) Will you meet with your friend?
7. (When) Will you rest?
8. (What time) Will you come here?
9. (With whom, where) Will you eat food?
10. (When) Will you live in the countryside?

23 -аар[4] — by (If you want to know more about this, see Lesson 40.)
For example: машинаар — by car, мориор — by horse, таксигаар — by taxi, автобусаар — by bus, онгоцоор — by airplane.

Дасгал 5

Доорх зургуудыг хараад маргааш Ганхүүгийн юу юу хийхийг бич. (Look at the pictures below and write down what Ganhuu will do tomorrow.)



Дасгал 6

Хүснэгтийг бөглөж, үг бүр дээр өгүүлбэр зохио. (Fill out the table and make sentences with each word.)

Жишээ нь: зурах → зур, зураарай, зурсан, зурна, зурах дуртай, зурах хэрэгтэй

Та цэцэг зур.
Та мод зураарай.
Би хувцас зурсан.
Тэр олон морь зурна.
Тэр зураг зурах дуртай.
Та гэр зурах хэрэгтэй.

Infinitive	Verb stem	Please	Past tense	Future tense	like	need
сурах						
дуулах						
бүжиглэх						
алхах						
гүйх						

Шинэ үг: дуулах — to sing, бүжиглэх — to dance, алхах — to walk, гүйх — to run

Дасгал 7

Хүснэгтийг бөглөж, үг бүр дээр өгүүлбэр зохио. (Fill out the table and make sentences with each word.)

Infinitive	didn't	won't	don't like to ...	don't need to ...
зурах				
сонсох				
сурах				
дуулах				
бүжиглэх				

Арван дөрөвдүгээр хичээл

Хамтрахын тийн ялгал (Comitative case)

-тай[3] (have, with), -гүй (don't have, without)

Би нэг ах**тай**.	I **have** one brother.
Би Бат**тай** хөдөө явсан.	I went to the countryside **with** Bat.
Тэр найз**тайгаа** хоол идсэн.	He ate food **with his** friend.

Spelling rules:

	Suffixes	**Examples**
After nouns with **а** or **у**	-тай	найзтай, устай
After nouns with **э**, **ү**, **ө** or **и**	-тэй	дүүтэй, өвөөтэй, эгчтэй
After nouns with **о**	-той	жолоочтой, хоолтой
After all nouns	-гүй	найзгүй, дүүгүй, эгчгүй

Note: When the possessive suffix -**аа**[4] is added after -**тай**[3], -**г** is inserted between them.
For example: ахтайгаа, дүүтэйгээ, өвөөтэйгөө, жолоочтойгоо.

Question pronouns and personal pronouns:

юу → юутай	та → тантай	бид → бидэнтэй
хэн → хэнтэй	чи → чамтай	та нар → та нартай
би → надтай	тэр → түүнтэй	тэд → тэдэнтэй

Дасгал 1

Нэр үгст хамтрахын тийн ялгалын болон биед хамаатуулах нөхцөл залгаж бич. (Add the comitative case and possessive suffixes to nouns.)

Жишээ нь: Би найз..... уулзсан. → Би найзтайгаа уулзсан.

1. Тэд аав ээж..... гадаа алхах дуртай.
2. Жаргалмаа ах..... монгол дуу дуулсан.
3. Оюутан багш..... хичээл хийх дуртай.
4. Тэр дүү..... гадаа тоглосон.
5. Тэд ээж..... гэртээ байсан.
6. Бид захирал..... ярих хэрэгтэй.
7. Багш охин..... гэрээ цэвэрлэсэн.
8. Би хүүхдүүд..... бүжиглэнэ.
9. Хүүхдүүд багш..... мэндэлдэг.

Шинэ үг: мэндлэх — to greet

Дасгал 2

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та хэнтэй Монголд ирсэн бэ?
2. Та хэнтэй гадаа алхдаг вэ?
3. Та хэн хэнтэй амьдардаг вэ?
4. Та өнгөрсөн сард хэнтэй хичээл хийсэн бэ?
5. Та ирэх сард хэнтэй кино үзэх вэ?
6. Та хэнтэй ажиллах дуртай вэ?
7. Та өнгөрсөн долоо хоногт хэнтэй хоол идсэн бэ?
8. Та ирэх долоо хоногт хэнтэй уулзах хэрэгтэй вэ?
9. Та ер нь хэнтэй тоглоом тоглодог вэ?
10. Та хэнтэй ярих дуртай вэ?
11. Та хэнтэй хөдөө явах дуртай вэ?
12. Хүүхдүүд хэн хэнтэй мэндэлдэг вэ?

Дасгал 3

Эхний хүснэгтэн дэх биеийн төлөөний үгсийг хамтрахын тийн ялгалын нөхцөлөөр хувирган, өмнөх хуудаснаас харж, алдаагаа зас. Өмнөх хүснэгтээ харалгүй дараагийн хүснэгтүүдээ бөглөж бичин, өөрийгөө шалгаарай. (Add comitative cases to personal pronouns in the first table, then look at the previous page and correct them. Fill out the last tables without looking at the first one, then check your answers.)

хэн	хэнтэй
Би	
Чи	
Та	
Тэр	
Бид (нар)	
Та нар	
Тэд (нар)	

хэн	хэнтэй
Тэд (нар)	
Та нар	
Бид (нар)	
Тэр	
Та	
Чи	
Би	

хэн	хэнтэй
Тэр	
Тэд (нар)	
Чи	
Би	
Бид (нар)	
Та нар	
Та	

Дасгал 4

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Би, тэр, мэндлэх
2. Тэр, би, ярих, хэрэгтэй
3. Тэд, та, тоглох
4. Та, тэр, бүжиглэх
5. Бид, тэд нар, хоол хийх, дуртай
6. Та, би, хичээл, хийх
7. Би, та, алхах
8. Би, та нар, амьдрах
9. Тэр, чи, байх
10. Би, чи, дуулах
11. Та нар, бид нар, хөдөө, явах
12. Та нар, би, ажил хийх
13. Тэр, чи, кино, үзэх
14. Тэр, та, уулзах

Дасгал 5

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. Whom will you meet with here next week?
   Next week I will meet my friend (doctor, director) here.
2. Whom did you do your lesson with?
   I did my lesson with my friend (sister, brother, mother, father).
3. Whom did you go to Terelj with last Sunday?
   I went to Terelj with my driver (wife/husband, dog, cat).
4. Whom will you run outside tomorrow morning with?
   I will run with my dog (child, son, daughter).
5. Whom do you like to sing with?
   I like to sing with Bayarhuu (John, Gerelmaa, Bolormaa).

Дасгал 6

Жишээ өгүүлбэрт бичсэний адилаар өгүүлбэр зохио. (Make sentences as in the examples.)

Жишээ:
Улаан малгайтай хүн миний ах. (The person with the red hat is my brother.)
Хар цамцтай эмэгтэй хоол хийнэ. (The woman with the black shirt will cook.)

1. ..... эрэгтэй хүн
2. ..... багш
3. ..... хүүхэд
4. ..... эмээ
5. ..... жолооч
6. ..... оюутан
7. ..... сурагч
8. ..... хүү
9. ..... өвөө

Талархал илэрхийлэх (To express thankfulness)

А: — Баярлалаа.
Б: — Зүгээр (зүгээр).
— Маш их баярлалаа.
— Ёстой их баярлалаа.
— Ирсэнд баярлалаа.
— (Надад) тусалсанд баярлалаа.
— Асуусанд баярлалаа.
— Надад) хэлсэнд баярлалаа.

A: — Thank you.
B: — You are welcome.
— Thank you very much.
— Thank you very, very much.
— Thank you for coming.
— Thank you for helping (me).
— Thank you for asking.
— Thank you for telling (me).

Арван тавдугаар хичээл

Одоо цаг (Present tense)

Spelling rules:

	After verb stems with **а, у** or **я**	After verb stems with **э, ү** or **и**	After verb stems with **о**	After verb stems with **ө**
Affirmative form	-даг	-дэг	-дог	-дөг
Negative form	-даггүй	-дэггүй	-доггүй	-дөггүй
Question form	-даг уу/вэ?	-дэг үү/вэ?	-дог уу/вэ?	-дөг үү/вэ?

For example:

Тэр сургуульд **сурдаг**.	He **studies** at a school.
Тэр сургуульд **сурдаггүй**.	He **doesn't study** at a school.
Тэр сургуульд сурдаг уу? (surdguu)	Does he study at a school?
Тэр ямар сургуульд сурдаг вэ?	In what school does he study?
Би дандаа нэг цагт өдрийн хоол иддэг.	I always eat lunch at one o'clock.
Тэд ер нь архи уудаггүй.	They don't drink vodka in general.
Би сард нэг удаа хөдөө явдаг.	I go to the countryside once a month.

This suffix can be added directly to verb stems that end with consonant, vowel or soft sign. For example:

Тэр монгол хэл мэддэг.	He knows Mongolian.
Би энд суудаг.	I sit here.
Би машин барьдаг*.	I drive a car.

*барих — to hold/to catch, машин барих — to drive a car, байшин барих — to build a house, загас барих — to catch a fish, цаг барих — to be on time

Key words for present tense:

өдөр бүр	every day	заримдаа	sometimes
сар бүр	every month	ер нь	in general
жил бүр	every year	хааяа	seldom
өглөө бүр	every morning	ховор	rarely
орой бүр	every evening	7 хоногт нэг удаа	once a week
шөнө бүр	every night	сард нэг удаа	once a month
дандаа	always	жилд нэг удаа	once a year
байнга	constantly	өдөрт 3 удаа	3 times a day
үргэлж	often		

Дасгал 1

Хүснэгтийн дээд талын эгнээнд байгаа загварын дагуу үйл үгийн үндсүүдэд одоо цагийн нөхцөлийг залгаж, асуулт зохио. Дараа нь өгүүлбэр зохио. (Add suffixes for present tense to the verb stems and make short questions as in the examples at the top of the table. Then make sentences with them.)

	эхэлдэг	эхэлдэг үү?	хэзээ эхэлдэг вэ?	эхэлдэггүй	эхэлдэггүй юү?
1.	яв.....			яв.....	
2.	сонс.....			сонс.....	
3.	унш.....			унш.....	
4.	амьдар.....			амьдар.....	
5.	тогло.....			тогло.....	
6.	сур.....			сур.....	
7.	ид			ид.....	
8.	уулз.....			уулз	
9.	уу.....			уу.....	
10.	бай.....			бай.....	
11.	хий.....			хий.....	
12.	амар.....			амар.....	

Жишээ нь:

Манай хичээл 9 цагт эхэлдэг.
Танай хичээл 9 цагт эхэлдэг үү?
Танай хичээл хэдэн цагт эхэлдэг вэ?

Манай хичээл 9 цагт эхэлдэггүй.
Танай хичээл 9 цагт эхэлдэггүй юү?
Танай хичээл яагаад 9 цагт эхэлдэггүй вэ?

Дасгал 2

Асуултуудыг сонсоод, хариулж бич. (Listen to the questions and answer them.)

1. Та өдөр бүр юу хийдэг вэ?
2. Та өглөө/орой юу иддэг вэ?
3. Танай гэр хаана байдаг вэ?
4. Та нар гэрт амьдардаг уу, байшинд амьдардаг уу?
5. Та нар Монголд ямар ажил хийдэг вэ?
6. Та ямар ямар хэл мэддэг вэ?
7. Та ер нь их алхдаг уу?
8. Та машин барьдаг уу?
9. Та нар архи уудаг уу?
10. Танай гэр бүл бүтэн сайн өдөр юу хийдэг вэ?
11. Та хүмүүстэй өдөрт хэдэн удаа мэндэлдэг вэ?
12. Та долоо хоногт хэдэн удаа хичээл хийдэг вэ?
13. Та жилд хэдэн удаа хөдөө явдаг вэ?
14. Та сард хэдэн удаа банк руу явдаг вэ?

Шинэ үгс: байшин — house, архи — vodka, гэр бүл — family

Дасгал 3

Жишээ өгүүлбэрт бичсэний адилаар асуулт зохио. (Make questions as in the example.)

Жишээ: Би хагас сайн өдөр найзтайгаа ресторанд хоол иддэг.
— Та хагас сайн өдөр найзтайгаа ресторанд хоол иддэг үү?
— **Хэн** хагас сайн өдөр найзтайгаа ресторанд хоол иддэг вэ?
— Та **хэзээ** найзтайгаа ресторанд хоол иддэг вэ?
— Та хагас сайн өдөр **хэнтэй** ресторанд хоол иддэг вэ?
— Та хагас сайн өдөр найзтайгаа **хаана** хоол иддэг вэ?

1. Би өглөө 9 цагт сургуульдаа ирдэг.
2. Манай ээж орой бүр гэртээ монгол хоол хийдэг.
3. Тэр бүтэн сайн өдөр бүр найзтайгаа Тэрэлж рүү явдаг.
4. Би өдөр бүр шинэ талх авдаг.
5. Би орой бүр нэг цаг өрөөндөө номоо уншдаг.
6. Баярхүү найздаа сайхан имэйл бичдэг.
7. Баярхүү үдээс хойш монгол хүүхэдтэй гадаа теннис тоглодог.
8. Би өглөө чихэртэй талх иддэг. Бас сүүтэй халуун цай уудаг.
9. Би заримдаа найзтайгаа ресторанд уулздаг.
10. Би найзтайгаа 15 дугаар хороололд, 14 дүгээр байранд амьдардаг.

Шинэ үгс: дугаар — -th, хороолол — district, байр — apartment

Дасгал 4

Бичвэрийг унш. (Read the text.)

Миний нэр Цэцэг. Би 15 настай. Би сургуулийн сурагч. Би аав ээжтэйгээ 13 дугаар хороололд амьдардаг. Би өдөр бүр 7 цагт босдог. Тэгээд усанд ордог. Өглөөний цайгаа уудаг. Тэгээд 8:30-д сургууль руугаа явдаг. Манай хичээл өглөө бүр 9 цагт эхэлдэг. Хичээл ер нь 12 цагт дуусдаг.

Би хичээлийн дараа гэртээ ирдэг. Өдрийн хоолоо иддэг. Дараа нь жаахан амардаг. Тэгээд гэрийн даалгавраа хийдэг. Би 7 хоногт хоёр удаа дэлгүүр лүү явдаг. Дэлгүүрээс мах, сүү, ногоо, жимс авдаг. 6 цагт оройн хоолоо хийдэг. Манай аав ээж хоёр, ажлаасаа 7 цагт ирдэг. Бид хамт оройн хоолоо иддэг. Дараа нь заримдаа зурагт үздэг, заримдаа тоглоом тоглодог. Би хаяа найзтайгаа театрт концерт үздэг. Бид ер нь 11 цагт унтдаг.

Шинэ үгс: босох — to get up/to stand up, усанд орох — to take a bath, сурагч — pupil, унтах — to sleep

Дасгал 5

Өдөр бүр юу хийдэг тухайгаа бич. (Write down what you do everyday.)

Дасгал 6

Доорх зургуудыг хараад Ганхүүгийн өдөр бүр юу хийдгийг бич. (Look at the pictures below and write down what Ganhuu does every day.)



Дасгал 7

Өгүүлбэрт асуулт зохио. (Make questions out of the sentences.)

1. Тэд ўржигдар энд ном авчирсан.
2. Ер нь хүүхэд сургуульдаа тоглоом авчрах дуртай.
3. Бид ангидаа монголоор ярьдаг.
4. Би өчигдөр үдээс хойш загас барьсан.
5. Ер нь монгол хүмүүс гэр сайн барьдаг.
6. Манай хүүхэд том болсон.
7. Гэр хүмүүстэй мэндэлдэггүй.
8. Машин энд зогсдог.
9. Би шинэ үгээ мартдаггүй.

Шинэ үг: авчрах — to bring, монголоор — in Mongolian, ярих — to speak/ to talk, болох — to become, зогсох — to stop/to stand, энд — here, мартах — to forget

Давтлага хичээл

Дасгал 1

Өгүүлбэр бүрт хоёр хоёр асуулт зохио. (Make two questions for each sentence.)

1. Би гэртээ цай уусан.
2. Тэр их сайхан бүжиглэдэг.
3. Баярхүү шинэ машин авсан.
4. Бид уржигдар энд хичээл хийсэн.
5. Та нар гадаа тоглох хэрэгтэй.
6. Манай хүү бүжиглэх дуртай.
7. Тэр маргааш ангид дуулна.
8. Жаргалмаа найзтайгаа тоглосон.
9. Тэд хөдөө явсан.
10. Би найзтайгаа удахгүй уулзана.
11. Би өдөр бүр хичээлээ хийдэг.
12. Би өнгөрсөн жил Америкаас ирсэн.
13. Тэд ирэх жил Монголд байна.
14. Хүүхдүүд монгол гэрт амьдардаг.

Дасгал 2

Асуултад үгүйсгэсэн хариулт бич. (Write negative answers to the questions.)

1. Чи дэлгүүр лүү явсан уу?
2. Та нар дэлгүүрээс мах авах уу?
3. Тэд нар ер нь ном уншдаг уу?
4. Та хичээлээ ойлгосон уу?
5. Та хоолоо идсэн үү?
6. Та кофе уух дуртай юу?
7. Чи дэвтрээ авчирсан уу?
8. Чи дуулах дуртай юу?
9. Тэд алхах хэрэгтэй юу?
10. Маргааш гадаа хүйтэн болох уу?
11. Чи шинэ үгээ амархан мартдаг уу?
12. Хүүхдүүд хичээл бичих дуртай юу?
13. Хүүхдүүд дандаа тоглох хэрэгтэй юу?
14. Чи орой эмээ өвөөтэйгөө уулзах уу?
15. Улаанбаатарт казино байдаг уу?
16. Чи өдөрт нэг удаа хоол хийдэг үү?
17. Та хагас, бүтэн сайн өдөр амрах уу?
18. Чи өнөө(дөр) өглөө гүйсэн үү?

Дасгал 3

"Хэрэгтэй" гэдэг үгийг ашиглан өгөгдсөн нөхцөл байдлуудад тохирсон зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation using the word "хэрэгтэй.")

Жишээ нь: Би өнөөдөр хоол идээгүй. → Чи хоол идэх хэрэгтэй.

1. Би 6 цаг гадаа тоглосон.
2. Би дандаа машинаар явдаг.
3. Би хичээл хийх их дургүй.
4. Би дандаа сүүтэй цай уудаг.
5. Би ажил хийдэггүй.
6. Би энэ жил амрахгүй.
7. Би кино их үздэг.
8. Би өглөө босох дургүй.
9. Би ус уух дургүй.
10. Би найзтайгаа ер нь их ярьдаггүй.
11. Би их жаахан хоол иддэг.
12. Би ном уншдаггүй.
13. Би хүмүүстэй мэндэлдэггүй.
14. Би монгол хэл сурахгүй.

Дасгал 4

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. They met their parents.
2. Children greet their teacher.
3. I live with my grandparents.
4. I will go to the countryside with him.
5. They danced with the children.
6. He will walk outside with me.
7. He always talks with his children.
8. They met me.
9. Children like to play with their parents.
10. You need to talk with your younger sister.
11. You need to work with your brother.
12. She likes to eat food with her friend.
13. I like to sing with Mongolian people.
14. You need to study with him.
15. They won't go with us.
16. I didn't meet them.

Дасгал 5

Доогуур нь зурсан үгст биед хамаатуулах (-аа[4]) нөхцөл залгаж, ялгааг нь багштайгаа ярилц. (Add possessive suffix -аа[4] to underlined words and talk about the differences with your teacher.)

1. Тэр <u>хичээл</u> хийсэн.
2. Бид <u>ээжтэй</u> уулзана.
3. Тэд <u>ангид</u> байсан.
4. Хүүхдүүд <u>багштай</u> дуулдаг.
5. Би <u>эгчтэй</u> уулзсан.
6. Би <u>сургуулиас</u> энд ирсэн.
7. Та нар <u>гэрт</u> байх хэрэгтэй.
8. Манай дүү <u>ном</u> унших их дуртай.
9. Ах чинь <u>гэр</u> цэвэрлэсэн.
10. Би <u>машин</u> угаана.

Дасгал 6

Монгол, англи үгсийг зөв харгалзуулан, холбож зур. (Match Mongolian and English words by connecting them with lines.)

дугаар	there	архи	family
хороолол	house	гэр бүл	soon
сурагч	district	ирэх жил	morning
усанд орох	to sleep	сарын дараа	after a month
босох	to get up	удахгүй	evening
унтах	pupil	өглөө	afternoon
тэнд	-th	орой	vodka
байшин	to take a bath	үдээс хойш	next year

Тест

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Та монгол гэрт амьдардаг үү?
   Б. Та монгол гэрт амьдардаг юу?
   В. Та монгол гэрт амьдардаг уу?

2. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Та өчигдөр хоол хийсэн үү?
   Б. Та өчигдөр хоол хийсэн уу?
   В. Та өчигдөр хоол хийсэн юу?

3. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Тэд хэзээ энд ирсэн вэ?
   Б. Тэд хэзээ энд ирсэн үү?
   В. Тэд хэзээ энд ирсэн бэ?

4. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Чи нөгөөдөр орой кино үзнэ үү?
   Б. Чи нөгөөдөр орой кино үзэх үү?
   В. Чи нөгөөдөр орой кино үзэх уу?

5. He didn't bring his book.
   А. Тэр номоо авчрахгүй.
   Б. Тэр номоо авчраагүй.
   В. Тэр номоо авчирдаггүй.

6. I don't run.
   А. Би гүйгээгүй.
   Б. Би гүйхгүй.
   В. Би гүйдэггүй.

7. They won't walk.
   А. Тэд алхахгүй.
   Б. Тэд алхаагүй.
   В. Тэд алхдаггүй.

8. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Бид ирэх жил сургуульд сурсан.
   Б. Бид ирэх жил сургуульд сурна.
   В. Бид ирэх жил сургуульд сурдаг.

9. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Би уржигдар хөдөө байсан.
   Б. Би уржигдар хөдөө байна.
   В. Би уржигдар хөдөө байдаг.

10. Аль нь зөв бэ? Which one is right?
    А. Тэр заримдаа архи уудаг.
    Б. Тэр заримдаа архи уусан.
    В. Тэр заримдаа архи ууна.

11. Аль нь зөв бэ? Which one is right?
    А. Хүүхдүүд гадаа тоглодог дуртай.
    Б. Хүүхдүүд гадаа тоглох дуртай.
    В. Хүүхдүүд гадаа тогло дуртай.

12. Аль нь зөв бэ? Which one is right?
    А. Хүмүүс амрах хэрэгтэй.
    Б. Хүмүүс амар хэрэгтэй.
    В. Хүмүүс амарсан хэрэгтэй.

13. I did my lesson.
    А. Би хичээлээ хийсэн.
    Б. Би хичээл минь хийсэн.
    В. Би миний хичээл хийсэн.

14. You need to talk with your friend.
    А. Чи чиний найзтай ярих хэрэгтэй.
    Б. Чи найзаатай ярих хэрэгтэй.
    В. Чи найзтайгаа ярих хэрэгтэй.

15. I was at my house last night.
    А. Би өчигдөр орой гэртээ байсан.
    Б. Би өчигдөр орой гэрт байсан.
    В. Би өчигдөр орой гэртэй байсан.

16. She bought a bag from the store.
    А. Тэр, дэлгүүрээсээ цүнх авсан.
    Б. Тэр, дэлгүүрээс цүнх авсан.
    В. Тэр, дэлгүүр цүнх авсан.

Оноо (point): 16/.....

Арван зургадугаар хичээл

Үйл үгийн -маар⁴ нөхцөл (Verb suffix -маар⁴)

-маар⁴ байна/-маар⁴гүй байна (want to/don't want to)
-маар⁴ байсан/-маар⁴гүй байсан (wanted to/didn't want to)

Spelling rules:

	After verb stems with **а, у** or **я**	After verb stems with **э, ү** or **и**	After verb stems with **о**	After verb stems with **ө**
Affirmative form	-маар байна	-мээр байна	-моор байна	-мөөр байна
Negative form	-маргүй байна	-мээргүй байна	-мооргүй байна	-мөөргүй байна
Question form	-маар байна уу?	-мээр байна уу?	-моор байна уу?	-мөөр байна уу?

For example:

Би шинэ дуу **сурмаар байна**.	I **want to learn** a new song.
Би шинэ дуу с**урмааргүй байна**.	I **don't want to learn** a new song.
Та шинэ дуу сурмаар байна уу?	Do you want to learn a new song?
Та ямар дуу сурмаар байна вэ?	What song do you want to learn?

This suffix can be added directly to verb stems that end with consonants or vowels.
For example: уншмаар байна, хиймээр байна, тогломоор байна.

But when we add this suffix to verb stems that end with a soft sign, the soft sign becomes **и**. For example: барь + маар байна = баримаар байна.

Дасгал 1

Эхлээд үйл үгийн үндсэн дээр "-маар⁴ байна" нөхцөлийг залгаж, дараа нь өгүүлбэр зохио. (First add "-маар⁴ байна" to verb stems, then make sentences.)

Жишээ нь: тогло → А. тогломоор байна. Б. Би одоо гадаа тогломоор байна.

1. амар
2. бай
3. ид
4. хаа
5. нээ
6. авчир
7. барь
8. мэд
9. бол
10. ярь
11. унт
12. бос
13. дуул
14. алх
15. бүжиглэ
16. ав
17. яв
18. хий
19. сур
20. март
21. өг

Шинэ үгс: мэдэх — to know, өгөх — to give

Дасгал 2

Доорх нөхцөл байдлуудад тохируулан юу хийхийг хүсэж байгаа болон хүсэхгүй байгаагаа бич.
(Write down what you want to do or what you don't want to do in each situation below.)

А. *Жишээ нь*: Та дандаа бууз иддэг. → Би бууз идмээргүй байна. Хуушуур идмээр байна.

1. Та өдөр бүр сүүтэй цай уудаг.
2. Та олон цаг ажилласан.
3. Та ном унших их дуртай.
4. Та шөнө сайн унтаагүй.
5. Та юм мартдаггүй.
6. Та Монголд байна.
7. Гэрт их халуун байна.
8. Та гадаа олон цаг байсан.
9. Та дандаа машинаар явдаг.
10. Та зүгээр суух дургүй.
11. Та дандаа алхдаг.
12. Та өглөө бүр 5 цагт босдог.

Б. *Жишээ нь*: Цай уугаарай. → Би цай уумааргүй байна. Ус уумаар байна.

1. Номоо уншаарай.
2. Гэрээ цэвэрлээрэй.
3. Хичээлээ хийгээрэй.
4. Чи гадаа суугаарай.
5. Чи гэртээ байгаарай.
6. Гадаа тоглоорой.
7. Миний хүү, унтаарай.
8. Одоо машин бариарай.
9. Чи хөдөө явах хэрэгтэй.
10. Чи номоо авчрах хэрэгтэй.
11. Чи эмч болох хэрэгтэй.
12. Та одоо дуулаарай.
13. Та одоо бүжиглээрэй.
14. Бүтэн сайн өдөр ажиллаарай.

Шинэ үг: зүгээр — just

Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь: Би, гадаа, тоглох
А. Би гадаа тогломоор байсан. Гэхдээ хүйтэн байсан. Тэгээд би тоглоогүй.
I wanted to play outside. But it was cold outside, so I didn't play.)
Б. Би гадаа тогломооргүй байсан. Гэхдээ найзтайгаа тоглосон.
I didn't want to play outside but I played with my friend.)

1. Би, амрах
2. Тэр, ажиллах
3. Би, дуулах
4. Би, бүжиглэх
5. Тэд нар, босох
6. Тэр, усанд орох
7. Хүү, гараа угаах
8. Тэр, монголоор ярих
9. Бид, автобусаар явах
10. Хүмүүс, амрах

Шинэ үг: ажиллах — to work

Дасгал 4

Доорх зургуудыг хараад Ганхүүгийн юу хийхийг хүсэж байгааг бич. (Look at the pictures below and write down what Ganhuu wants to do.)



Зөөлний тэмдэгтэй холбоотой дүрэм (Rules related to the soft sign)

Монгол баавар — 7
Цоожоо засаад тушаачих — 9
vowel — v
я, ё — (let me ...)

7ь + 9 = 7ь9	**7ь + 7 = 7и7**	**9ь + 9 = 9и9**	**9ь + 7 = 9и7**	**7ь + vv = 7иv** **9ь + vv = 9иv**	**7ь + я = 7ья** **9ь + ё = 9ьё**
барьсан	барина	захисан	захина	бариарай	барья
барьдаг	бариг	захидаг	захиг	болиод	больё
барьжээ	барилаа	захижээ	захилаа	цохиорой	цохьё
барьчих	барив	захичи́х	захив	цохиод	захья

Шинэ үгс: барь — hold, захь — order, цохь —hit, боль — stop

Дасгал 5

Үйлдэхцөлүүдийг зөв залгаж бич. (Add the suffixes correctly.)

1. холь + сон = ...
2. холь + оорой = ...
3. холь + г = ...
4. холь + но = ...
5. холь + моор = ...
6. холь + чих = ...
7. холь + ё = ...
8. холь + лоо = ...
9. холь + дог = ...
10. холь + ж = ...
11. холь + в = ...
12. холь + ood = ...
13. урь + сан = ...
14. урь + аарай = ...
15. урь + г = ...
16. урь + на = ...
17. урь + маар = ...
18. урь + чих = ...
19. урь + я = ...
20. урь + лаа = ...
21. урь + даг = ...
22. урь + ж = ...
23. урь + в = ...
24. урь + аад = ...
25. дахь + сан = ...
26. дахь + аарай = ...
27. дахь + г = ...
28. дахь + на = ...
29. дахь + маар = ...
30. дахь + чих = ...
31. дахь + я = ...
32. дахь + лаа = ...
33. дахь + даг = ...
34. дахь + ж = ...
35. дахь + в = ...
36. дахь + аад = ...

Шинэ үгс: холь — mix, урь — invite, дахь — recur

Дасгал 6

Доорх өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences below.)

Хэрхэн цаг хэлэх (How to say time)

— Хэдэн цаг болж байна (вэ)? → [tsagvoljiin] → [tsagoljiin]	What time is it?
— 10 цаг болж байна. → [boljiin]	It's 10 o'clock.
— Цаг хэд болж байна (вэ)? → [hedvoljiin] → [hedoljiin]	What time is it?
— 10 болж байна.	It's 10.

10:00	10 цаг болж байна.	Арав болж байна.
10:15	10 цаг 15 минут болж байна.	Арав, арван тав болж байна.
10:30	10 цаг 30 минут болж байна.	Арав, гуч (хагас) болж байна.
10:45	10 цаг 45 минут болж байна.	Арав, дөчин тав болж байна.
9:55	9 цаг 55 минут болж байна.	Ес, тавин тав болж байна.
	10 цагт 5 минут дутуу байна.	Аравт тав дутуу байна (5 to 10.)
10:05	10 цаг 5 минут болж байна.	Арав, тав болж байна.
	10 (цаг)аас 5 минут өнгөрч байна.	(5 minutes after 10 (o'clock.))

Дасгал 7

Цаг хэд болж байгааг бич. (Write down what time it is.)



Дасгал 8

Багш, оюутан хоёр загварын дагуу бие биенээсээ харилцан асууж, хариул. (Teacher and student, ask each other questions and answer them as in the examples.)

Оюутан: — Цаг хэд болж байна (вэ)?
Багш: — ..... болж байна.

Багш: — Цаг хэд болж байна (вэ)?
Оюутан: — ..... болж байна.

11:20.....	20:03.....	13:24 .....
12:10.....	10:55	20:09.....
01:45.....	17:30.....	9:15 .....
08:50.....	19:28	04:00.....
06:00.....	22:30.....	15:30 .....
11:11.....	07:35	17:05 .....

Note: 9 am → өглөөний 9 цаг, 9 pm → оройн 9 цаг

Дасгал 9

Асуултад хариул. (Answer the questions.)

Жишээ нь: Та хэдэн цагт (хэдэд) ажил руугаа явдаг вэ? → Би 8 цагт (8-д) ажил руугаа явдаг.

1. Та хэдэн цагт (хэдэд) босдог вэ?
2. Та хэдэн цагт (хэдэд) өглөөний цайгаа уудаг вэ?
3. Та хэдэн цагт (хэдэд) өдрийн хоолоо иддэг вэ?
4. Та хэдэн цагт (хэдэд) оройн хоолоо иддэг вэ?
5. Таны ажил хэдэн цагт (хэдэд) эхэлдэг вэ?
6. Таны ажил хэдэн цагт (хэдэд) дуусдаг вэ?
7. Таны монгол хэлний хичээл хэдэн цагт (хэдэд) эхэлдэг вэ?
8. Таны монгол хэлний хичээл хэдэн цагт (хэдэд) дуусдаг вэ?
9. Та хэдэн цагт (хэдэд) унтдаг вэ?

Арван долдугаар хичээл

Байгаль, цаг агаар (Nature and weather)

улирал	season	цэцэг	flower
өвөл	winter	жимс	fruit
хавар	spring	солонго	rainbow
зун	summer	цахилгаан	lightening, electricity, zipper
намар	fall	хэм (градус)	degree
агаар	air	салхитай	windy
гол	river	нартай	sunny
далай	sea	бороотой	rainy
дэлхий	world	цастай	snowy
салхи	wind	нэмэх	plus (to add)
сансар	space	хасах	minus (to subtract)
од	star	(нар) мандах	(sun) to rise
нар	sun	(нар) жаргах	(sun) to set
сар	moon	(нар) гарах	(sun) to rise
тэнгэр	sky	(нар) орох	(sun) to set
газар	earth, land, place	бороо орох	to rain
уул	mountain	цас орох	to snow
үүл	cloud	(хавар) болох	(spring) to come
мод	tree, wood	ургах	to grow

Дасгал 1

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Монгол орон/танай орон хэдэн улиралтай вэ?
2. Улаанбаатар хотын агаар цэвэр үү, хөдөөний агаар цэвэр үү? Яагаад?
3. Улаанбаатар хотод хэдэн гол байдаг вэ? Танай хотод гол байдаг уу?
4. Та далай руу явах дуртай юу? Та далайн хоол идэх дуртай юу?
5. Монголд/танай оронд хэзээ их салхитай байдаг вэ?
6. Улаанбаатар/танай хотод дандаа нартай байдаг уу?
7. Монгол/Солонгос/Америк том газартай юу?
8. Монгол/Америк/Солонгос олон өндөр уултай юу?
9. Монголд/танай оронд хэзээ их бороо ордог вэ?
10. Монголд/танай оронд хэзээ их цас ордог вэ?
11. Монголд/Солонгост/Америкт өвөл хэдэн градус хүйтэн байдаг вэ?
12. Монголд/Солонгост/Америкт зун хэдэн градус дулаан байдаг вэ?

Шинэ үгс: орон — country, хот — city

Дасгал 2

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Өнөөдөр гадаа ямар байна (вэ)?
2. Өчигдөр гадаа ямар байсан бэ?
3. Монголд/танай оронд өвөл цаг агаар ямар байдаг вэ?
4. Монголд/танай оронд хавар цаг агаар ямар байдаг вэ?
5. Монголд/танай оронд зун цаг агаар ямар байдаг вэ?
6. Монголд/танай оронд намар цаг агаар ямар байдаг вэ?

Дасгал 3

Зургуудыг хараад улирал, цаг агаарын талаар багштайгаа ярилц. (Look at the picture and talk with your teacher about the season and weather.)



Дасгал 4

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Энэ ямар улирал вэ?

   А. Гадаа нартай, халуун, жаахан салхитай байна.

   Б. Гадаа их салхитай, жаахан цастай, хүйтэн байна.

   В. Гадаа их хүйтэн, наргүй, цастай байна.

   Г. Гадаа бороотой, халуун байна.

Д. Гадаа хасах 25 хэм, нартай байна.

Е. Гадаа нэмэх 10 хэм, их салхитай байна.

Ё. Гадаа дулаан, тэнгэрт солонго байна.

Ж. Гадаа мод ногоон байна. Бас олон цэцэг байна.

2. Энэ ямар улирал вэ?

А. Их бороо ордог.

Б. Их цас ордог.

В. Бороо ордоггүй.

Г. Цас ордоггүй.

Д. Бороо, цас хамт ордог.

Е. Нар өглөө 6 цагт манддаг.

Ё. Нар өглөө 8 цагт манддаг.

Ж. Нар орой 5 цагт жаргадаг.

3. Нар орой 9:30-д жаргадаг.

И. Жимс ургадаг.

Хоол хүнс (Foods)

хоол	**food**
шөл	soup
бууз	buuz
хуушуур	huushuur
банш	dumpling
цуйван	noodles+meat+vegetables
өглөөний цай	breakfast
өдрийн хоол	lunch
оройн хоол	dinner
мах	**meat**
үхрийн мах	beef
хонины мах	mutton
тахианы мах	chicken
гахайн мах	pork
ямааны мах	goat meat
хиам	sausage
уух зүйлс	**things to drink**
ус	water
кофе	coffee
ундаа	soft drink
сүү	milk
цай	tea
сүүтэй цай	milk tea
шүүс	juice
тараг	yoghurt
ногоо	**vegetables**
төмс	potato
сармис	garlic
лууван	carrot
сонгино	onion
байцаа	cabbage
манжин	turnip
улаан лооль	tomato
жимс	**fruit**
алим	apple
гадил	banana
хан боргоцой	pineapple
жүрж	orange
интоор	cherry
тоор	peach
киви	kiwi
нимбэг	lemon
үзэм	raisin
усан үзэм	grape
тарвас	watermelon
гүзээлзгэнэ	strawberry
бусад	**other things**
цагаан будаа	rice
гурил	flour
зайрмаг	ice cream
өндөг	egg
гоймон	noodles
бяслаг	cheese
элсэн чихэр	sugar
чихэр	candy
ёотон	lump sugar
давс	salt
талх	bread
бялуу	cake
тос	oil

Арван наймдугаар хичээл

Захирах хүсэх төлөв (2-р бие) (Imperative mood (for second person))

Verb stems are used as a command for second person and **-аар⁴ай³** is used for please.

For example:

Яв.	Go.	Суу.	Sit.
Яв**аарай**.	**Please** go.	Суу**гаарай**.	**Please** sit.

"Битгий" (don't) is used in everyday speech.

Битгий яв.	**Don't** go.
Битгий яваарай.	Please don't go.

"Бүү" (don't) is used in formal speech.

Тамхи **бүү** тат!	**Don't** smoke! (No smoking!)
Хог бүү хая!	Don't throw garbage!
Шилэнд бүү хүр!	Don't touch the glass!

Spelling rules:

	After verb stems ending with consonant or short vowels	After verb stems ending with long vowels or diphthongs
Verb stems with **а** or **у**	-аарай	-(г)аарай
Verb stems with **э**, **ү** or **и**	-ээрэй	-(г)ээрэй
Verb stems with **о**	-оорой	-(г)оорой
Verb stems with **ө**	-өөрэй	-(г)өөрэй

For example: яваарай, уугаарай, хэлээрэй, ороорой, өгөөрэй.

Note:
If the last letters of a stem are **cvc**, the vowel in between the two consonants is dropped when we add this suffix. For example: амар + аарай = амраарай, эхэл + ээрэй = эхлээрэй.

If a verb stem ends with a short vowel, the short vowel is dropped when we add -аар⁴ай³.
For example: ажилла + аарай = ажиллаарай, тогло + оорой = тоглоорой.

If a verb stem ends with a soft sign, the soft sign become и and one of the long vowels in the suffix is dropped when we add -аар⁴ай³. For example: барь + аарай = бариарай, боль + оорой = болиорой.

Дасгал 1

Үйл үгийн үндсэн дээр -аар[4]ай[3] нөхцөлийг залгаж, өгүүлбэр зохио. (Add the suffix -аар[4]ай[3] to the verb stems and make sentences.)

1. гар
2. нээ
3. хаа
4. дуусга
5. сур
6. уулз
7. хий
8. үз
9. бод
10. яв
11. гүй
12. амар
13. өг
14. тогло
15. ярь
16. хэл
17. шар
18. чана
19. тоол
20. тат

Шинэ үгс: гарах — to go out, бодох — to think, хэлэх — to say/to tell, шарах — to fry, чанах — to boil, тоолох — to count, татах — to pull

Дасгал 2

Өгөгдсөн үгсээр өгүүлбэр зохио. (Make sentences with the given words.)

Жишээ нь: хийх, идэх → Эхлээд хичээлээ хийгээрэй, дараа нь хоолоо идээрэй.
(Please do your lesson first, then eat your food.)

1. идэх, ажиллах
2. амрах, ажиллах
3. хийх, тоглох
4. цэвэрлэх, унтах
5. явах, амрах
6. асуух, бичих
7. сурах, ярих
8. бодох, хэлэх
9. бодох, хийх
10. бодох, ярих
11. дуулах, бүжиглэх
12. зурах, өгөх
13. мэндлэх, асуух
14. мэндлэх, суух
15. тоолох, өгөх
16. тоолох, хэлэх
17. тоолох, чанах
18. ажиллах, авах
19. цэвэрлэх, шарах
20. чанах, шарах

Дасгал 3

Хориглон чимэх үг "битгий" -г ашиглан доорх байдлуудад тохирсон зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation using the word "битгий.")

1. Би дандаа муухай үг хэлдэг.
2. Би найзаасаа их мөнгө авдаг.
3. Би өдөрт 6 аяга кофе уудаг.
4. Би тамхи татдаг.
5. Би их санаа зовдог.
6. Би дулаан цамцгүй гадаа гарна.
7. Би дандаа амардаг.
8. Би түүний нэрийг[24] мартдаг.
9. Би орой 10 цагт их хоол иддэг.
10. Би ер нь их олон цаг ажилладаг.

Шинэ үгс: мөнгө — money, тамхи татах — to smoke, санаа зовох — to worry

[24] The suffixes -ийг, -ыг and -г are used for specific direct object. For example: Би тэр хоолыг хийсэн. (I cooked that food.) (If you want to know more, please see Lesson 41.)

Дасгал 4

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. Don't go outside. Stay home.
2. Don't smoke.
3. Please cook tonight.
4. Don't work. Please rest now.
5. Please don't buy food!
6. Do house work. Don't just sit.
7. Don't go to the countryside.
8. Don't meet that bad person.
9. Don't be there for many hours.
10. Do your lesson now! Don't play.
11. Don't work many hours. Rest now.
12. Don't eat bad food. Eat good food.
13. Ask many questions. Don't worry.
14. Don't sit here! Please sit there!
15. Please work now, then rest.
16. Please don't play outside.

Дасгал 5

Үзсэн хэлзүйгээ ашиглан, өгөгдсөн нөхцөл байдлуудад тохирох зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation using the grammar you have just learned.)

1. Би хөдөө явна.
2. Би ирэх сард Африк руу явна. Тэнд хоёр жил амьдарна.
3. Би шинэ машин авна.
4. Би ирэх сараас монгол хэл сурна.
5. Би монгол хоол хийнэ.
6. Би Улаанбаатарт машин барина.
7. Би монгол гэрт амьдарна.
8. Би дэлгүүрээс юм авна.
9. Би ажил хийхгүй.
10. Би хүмүүстэй уулзахгүй.

Арван есдүгээр хичээл

Холбоос үгс (Conjunctions)

Яагаад гэвэл ...	**Because ...**
Тийм учраас ...	**That's why ...**
... учраас ...	**Because .../That's why ...**

Би монгол хэл сурах хэрэгтэй. **Яагаад гэвэл** би Монголд амьдардаг.
I need to learn Mongolian **because** I live in Mongolia.

Би Монголд амьдардаг. **Тийм учраас** монгол хэл сурах хэрэгтэй.
I live in Mongolia. **That's why** I need to learn Mongolian.

Би Монголд амьдардаг **учраас** монгол хэл сурах хэрэгтэй.
I live in Mongolia, **that's why** I need to learn Mongolian.

Дасгал 1

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь: Тэр хүйтэн ус уух, тэр их халууцах
Тэр хүйтэн ус уусан. Яагаад гэвэл тэр их халууцсан.
Тэр их халууцсан. Тийм учраас хүйтэн ус уусан.
Тэр их халууцсан учраас хүйтэн ус уусан.

1. Та, их хэцүү, ажил, хийх; та, их ядрах
2. Хүүхдүүд, гадаа, тоглох(гүй); гадаа, их, бороо орох
3. Гадаа, их хүйтэн, байх; би, гэр, байх
4. Миний найз, өвдөх; тэр, муу хоол, идэх
5. Би, завгүй, байх; би, хичээл, хийх(гүй)
6. Жаргалмаа, олон цаг, хичээл хийх; тэр, хэл, сайн, сурах
7. Тэр эрэгтэй, дандаа, архи уух; эхнэр, санаа зовох
8. Тэр, цөөн цаг, ажиллах; бага мөнгө, авах
9. Манай найз, шинэ цүнх, авах; тэр, их, баяртай байх
10. Хүүхэд, хоол, идэх(гүй); хүүхэд, өвдөх
11. Тэр, монгол, сайн ярих; тэр, олон жил, монгол хэл, сурах
12. Баярхүү, олон найзтай; тэр, сайн хүн
13. Хүмүүс, сайн хоол, идэх хэрэгтэй; хүмүүс, эрүүл, байх хэрэгтэй
14. Гадаа, халуун, байх; би, их, халууцах
15. Тэр, хичээл, ирэх(гүй); тэр, сонирхолтой юм, сурах(гүй)

Шинэ үгс: халууцах — to feel hot, ядрах — to be tired, завгүй — busy, өвдөх — to be sick, эрүүл — healthy

Дасгал 2

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та өчигдөр ядарсан уу? Яагаад?
2. Та өнгөрсөн жил өвдсөн үү? Яагаад?
3. Та яагаад Монголд ирсэн бэ?
4. Монголд ямар байна вэ? Яагаад?
5. Монгол хүмүүс хатуу хүмүүс үү? Яагаад?
6. Америк хүмүүс цөөн хүүхэдтэй юү? Яагаад?
7. Америкт хуучин юм (машин, хувцас) зардаг уу? Яагаад?
8. Америк хүмүүс хуучин юм авдаг уу? Яагаад?
9. Туранхай хүн амархан өвддөг үү? Яагаад?
10. Та ер нь завгүй байдаг уу? Яагаад?
11. Гэрийн даалгавар хэцүү байсан уу? Яагаад?

Шинэ үгс: хатуу — hard, зарах — to sell

Дасгал 3

Доорх зургууд дээр үзсэн холбоос үгсээ ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences about the pictures below using the conjunctions you have learned.)



Дасгал 4

Доорх нөхцөл байдлуудад өөрийн бодлоо илэрхийлж бич. (Write an expression for each situation below.)

Жишээ нь: Том нохой байна. (There is a big dog.) → Ямар том нохой вэ? (What a big dog.)

1. Их гоё цүнх байна.
2. Их гоё хувцас байна.
3. Их гоё пицца байна.
4. Их амттай пицца байна.
5. Их том өрөө байна.
6. Их завгүй хүн байна.
7. Их үнэтэй цаг байна.
8. Их хүйтэн өрөө байна.
9. Халуун цай байна.
10. Их сайн хүн байна.
11. Тарган хонь байна.
12. Их туранхай морь байна.
13. Их муу хүүхэд байна.
14. Их хуучин байр байна.
15. Дэлгүүрт их хатуу талх байна.
16. Их өөхтэй хоол байна.
17. Хөөрхөн хүүхэд байна.
18. Өндөр байшин байна.

Шинэ үгс: тарган — fat (adjective), туранхай — thin, өөх — fat (noun), хөөрхөн — cute, өндөр — tall

Дасгал 5

Нөхцөл байдлуудад тохируулан нэр үгийн оронд "юм" гэдэг үгийг ашиглан өгүүлбэр зохио. (Replace nouns with the word "юм" and make sentences.)

Жишээлбэл: Гэрт их халуун байна. (It's very hot in the house.) → Ямар халуун юм бэ? (How hot is it (here)?)

1. Ажил хэцүү байна.
2. Тарган нохой байна.
3. Туранхай морь байна.
4. Хатуу мах байна.
5. Бага хоол байна.
6. Гоё цүнх байна.
7. Жижиг машин байна.
8. Сайхан байр байна.
9. Сайхан үнэртэй цэцэг байна.
10. Амттай хоол байна.
11. Олон ном байна.
12. Халуун цай байна.
13. Хүйтэн ус байна.
14. Үнэтэй цүнх байна.
15. Хямд цамц байна.
16. Сонирхолтой ном байна.

Хорьдугаар хичээл

Одоо үргэлжлэх цаг (Present continuous tense)

Verb stem + ж/-ч байна	am/is/are ...-ing (Action is being seen or heard)
байгаа	am/is/are ...-ing (Action is not being seen)
байдаг	am/is/are ...-ing (Action is always happening)

For example:
Тэр дуулж байна. (He is singing. (You see or hear him singing.))
Тэр дуулж байгаа. (He is singing. (You don't see.)/(He has been singing.))
Тэр дуулж байдаг. (He is (always) singing.)

Өнгөрөн үргэлжлэх цаг (Past continuous tense)

Verb stem + ж/-ч байсан was/were ...-ing
For example: Тэр дуулж байсан. (He was singing.)

Spelling rules:

	After verb stems ending with vowels or soft sign	After verb stems ending with **г, с, (в)** or **(р)**	After verb stems ending with **ц, з, д, т** or **х**	After verb stems ending with **ш, ч** or **ж**	After verb stems ending with consonants **л, м, (в)** or **(р)**
-ч байна		√			
-ж байна	√				√
-(а[4])ж байна			√		
-(и)ж байна				√	

For example:

ажиллаж байна	явж[25] байна	гарч байна	будаж байна
хааж байна	орж байна	авч[25] байна	буцаж байна
барьж байна	өгч байна	уулзаж байна	уншиж байна

хийж байна	[hiijiin]	авч байна	[avchiin]
хийж байгаа	[hiijaigaa]	авч байгаа	[avchaigaa]
хийж байсан	[hiijaisan]	авч байсан	[avchaisan]

Negatives:
1. Verb stem **+аагүй[4] байна** (When speaker found out the action is not happening.)
2. Verb stem **+хгүй байна** (Speaker knows the action is not happening.)

For example:
Тэр хоолоо идээгүй байна. He is not eating his food. (Speaker just found out.)
Тэр хоолоо идэхгүй байна. He is not eating his food. (Speaker tried to make him eat but he is not eating.)

25 In the old Mongolian script, words like яв and ор end with vowels, so **-ж** is used; words like ав and гар end with consonants, so **-ч** is used. In Cyrillic, we can't see this difference, but we retain the old Mongolian spelling. (Please look at the verb list in the Appendix to see verb stems with -ж/-ч.)

Дасгал 1

Үйл үгийн үндсэнд үргэлжлэх цагийн нөхцөлүүдийг залгаж бич. (Add suffixes of the continuous tense to the verb stems.)

Жишээ нь: эхэл → эхэлж байна, эхэлж байгаа, эхэлж байсан

1. дуус.....
2. нээ.....
3. хаа.....
4. амьдар .....
5. сур.....
6. хий .....
7. үз .....
8. ав .....
9. асуу.....
10. амар .....
11. тогло .....
12. ядар.....
13. халууц.....
14. барь.....
15. тат.....
16. хэл.....
17. шар .....
18. чана .....
19. тоол .....
20. даар.....
21. өлс.....
22. цанга .....
23. яар .....
24. яв .....

Шинэ үгс: даарах — to feel cold, өлсөх — to be hungry, цангах — to be thirsty, яарах — to be in a hurry

Дасгал 2

Үргэлжлэх цагийн нөхцөлүүдийг залгаж бич. (Add suffixes of continuous tense.)

1. Олон хүн гадаа суу.....
2. Хүүхдүүд гудамжинд яв.....
3. Хүүхдүүд гудамжинд тогло.....
4. Мөнгөнхүү хичээлээ хий.....
5. Манай ах имэйл бич.....
6. Отгонхүү теннис тогло.....
7. Монгол хүмүүс гэрт ор.....
8. Тэр монгол хоол ид.....
9. Оюутан хүйтэн кола уу.....
10. Багш ангидаа найзтайгаа суу.....
11. Эмэгтэй хүмүүс хоол хий.....
12. Манай найз захаас ир.....

Шинэ үгс: гудамж — street, хамт — together

Дасгал 3

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та нар юу хийж байна (вэ)?
2. Та Монголд юу хийж байна (вэ)?
3. Та өглөө 9 цагт юу хийж байсан бэ?
4. Хүүхдүүд гадаа юу хийж байна (вэ)?
5. Хүүхдүүд хаана сууж байна (вэ)?
6. Хүүхдүүд хэнтэй тоглож байна (вэ)?
7. Та ямар хоол идэж байна (вэ)?
8. Та юу бичиж байна (вэ)?
9. Та юу бодож байна (вэ)?
10. Та одоо юу юу харж байна (вэ)?
11. Та хаана ажиллаж байна (вэ)?
12. Та хаана амьдарч байна (вэ)?

Дасгал 4

Асуултуудыг сонсоод боломжтой хариултуудыг бич. (Listen to the questions and then write down possible answers.)

Жишээ нь: Та даарч байна уу? [daarchiinuu]	Are you cold (right now)?
А. (Би) даарч байна.	I'm cold.
Б. (Би) жаахан даарч байна.	I'm a little cold.
В. (Би) даарахгүй байна.	I'm not cold.
Г. (Би) ерөөсөө/огт даарахгүй байна.	I'm not cold at all.

1. Та халууцаж байна уу? [haluutsjiinuu]
2. Та өлсөж байна уу? [ölsjiinüü]
3. Та цангаж байна уу? [tsangajiinuu]
4. Та яарч байна уу? [yarchiinuu]
5. Та ядарч байна уу? [yadarchiinuu]
6. Та энийг ойлгож байна уу? [oilgojiinuu]
7. Та энийг санаж байна уу? [sanjiinuu]
8. Таны монгол хэл сайжирч байна уу? [saijirchiinuu]

Шинэ үг: сайжрах — to get better

Дасгал 5

Доорх үгсийг бичгийн хэлбэрт оруулж бич. (Write the written forms of the phrases.)

Жишээ нь: [hiijiin] → хийж байна

1. [irjaisan]
2. [yadarchaigaa]
3. [irjiin]
4. [haluutsjaisan]
5. [yadarchiin]
6. [irjaigaa]
7. [haluutsjiin]
8. [tsangajaigaa]
9. [yavjiin]
10. [haluutsjaigaa]
11. [tsangajiin]
12. [yavjaigaa]
13. [daarchaigaa]
14. [tsangajaisan]
15. [yavjaisan]
16. [daarchiin]
17. [suujaisan]
18. [ölsjiin]
19. [suujiin]
20. [daarchaisan]
21. [ölsjaisan]
22. [suujaigaa]
23. [yadarchaisan]
24. [ölsjaigaa]

Дасгал 6

Өгүүлбэрийг унш. (Read the sentences.)

1. Одмаа тэр өрөөнд сууж байгаа.
2. Тэд одоо кино үзэж байгаа.
3. Тэр одоо гэрээ цэвэрлэж байгаа.
4. Хүүхдүүд одоо ирж байгаа.
5. Би монгол хэл сурч байгаа.
6. Тэр манайд дандаа ирж байгаа.
7. Би их сургуульд ажиллаж байгаа.
8. Та найзтайгаа уулзаж байгаа юу?

Дасгал 7

Асуултад хариул. (Answer the questions.)

Жишээ нь:
Та өмнө нь аль сургуульд сурч байсан бэ? (At which school were you studying before?)
Би өмнө нь Сантис сургуульд сурч байсан. (I was studying at Santis school before.)

1. Та өмнө нь хаана амьдарч байсан бэ?
2. Та өмнө нь хаана ажиллаж байсан бэ?
3. Та өмнө нь ямар хэл сурч байсан бэ?
4. Та өмнө нь аль ресторанд хоол идэж байсан бэ?
5. Та өмнө нь ямар машин барьж байсан бэ?
6. Хэн өмнө нь таны багш байсан бэ?
7. Танай гэр өмнө нь ямар байсан бэ?
8. Таны үс өмнө нь ямар байсан бэ?
9. Та өмнө нь хэнтэй амьдарч байсан бэ?
10. Та өмнө нь юу идэх дуртай байсан бэ?
11. Та өмнө нь юу уух дуртай байсан бэ?

Дасгал 8

Доорх зургуудыг хараад хэн юу хийж байгааг бич. (Look at the pictures below and write who is doing what.)



Дасгал 9

Өгүүлбэрийг унш. (Read the sentences.)

1. Та Монголд хэр удаж байна (вэ)? (How long have you been staying in Mongolia?)
2. Би Монголд нэг жил болж байна. (I have been staying in Mongolia for one year.)
3. Та Монголд хэр удах вэ? (How long will you stay in Mongolia?)
4. Би Монголд 10 жил болно. (I will stay in Mongolia for 10 years.)
5. Та Монголд хэр удсан бэ? (How long did you stay in Mongolia?)
6. Би Монголд 2 жил болсон. (I stayed in Mongolia for 2 years.)

Гудамжны зарим хаяг (Some signs on the street)

Хүнсний дэлгүүр/Хүнсний бараа	Food store
Барааны дэлгүүр	Good's store
Бичиг хэргийн дэлгүүр	Stationery store
Бэлэг дурсгалын дэлгүүр	Souvenir shop
Номын дэлгүүр	Book store
Нээлттэй	Open
Хаалттай	Closed
Тат	Pull
Түлх	Push
Номын сан	Library
Эмийн сан	Pharmacy
Ломбард	Pawn shop
Үсчин	Hairdresser
Гоо сайхан	Beauty salon
Цайны газар	Tea place (cafe)
Зоогийн газар	Restaurant
Ресторан	Restaurant
Түргэн хоолны газар	Fast food
Зочид буудал	Hotel
Төв шуудан	Central post office
Банк	Bank
Зах	Market
Сургууль	School
Эмнэлэг	Hospital
Цэцэрлэг	Kindergarden
Алт мөнгөний дархан	Gold and silver smith
Гутал засвар	Shoe repair place
Цаг засвар	Watch repair place
Дугуй засвар	Tire repair place
Авто засвар	Auto repair place
Кино театр	Cinema
Гэрээт борлуулагч	Distributor
Түлхүүр олшруулна	Will make copies of keys
Хуурай хими цэвэрлэгээ	Dry cleaning
Зарна	Going to be sold

Давтлага хичээл

Дасгал 1

Хүснэгтийг бөглө. (Fill out the tables.)

Infinitive	Verb stem	Present continuous tense	Past continuous tense	Past tense	Future tense	want
хэлэх						
шарах						
чанах						
тоолох						
явах						
дуулах						
алхах						
гүйх						
ярих						
зарах						
өвдөх						—
ядрах						—

Infinitive	Don't	didn't	won't	don't (in general)	don't want to
хэлэх					
шарах					
чанах					
тоолох					
тамхи татах					
санаа зовох					
алхах					
гүйх					
ярих					
зарах					
өвдөх					
ядрах					

Дасгал 2

Хориглон чимэх үг "битгий" -г ашиглан өгөгдсөн нөхцөл байдлуудад тохирсон зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation using the word "битгий.")

1. Гадаа их хүйтэн байна. Гэхдээ би гадаа тоглоно.
2. Манай найз тамхи татдаг учраас би тамхи татна.
3. Би их олон юманд санаа зовдог.
4. Би дандаа муухай үг хэлдэг.
5. Би өөх идэх их дуртай. Тэгээд дандаа өөх иддэг.
6. Хүмүүс архи уудаг учраас би архи ууна.
7. Би өдөр бүр үнэтэй ресторанд хоол иддэг.
8. Би өдөрт 15 цаг унтдаг.

Дасгал 3

"Яагаад гэвэл, тийм учраас, учраас"-ыг ашиглан гинжин хэлхээ үүсгэн өгүүлбэр зохио. (Make sentences in sequence using "яагаад гэвэл, тийм учраас, учраас.")

Жишээ нь: Тэр их бага хоол иддэг. Тийм учраас тэр их туранхай.
Тэр их туранхай. Тийм учраас амархан өвддөг.
Тэр их амархан өвддөг. Тийм учраас ажил хийдэггүй.

1. Тэр хүн ажил хийдэггүй. Яагаад гэвэл .....
2. Гадаа их халуун байсан. Тийм учраас .....
3. Тэр сурагч хичээлдээ ирээгүй. Яагаад гэвэл .....
4. Их бороо орсон учраас .....

Шинэ үг: бага — little

Дасгал 4

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. What a nice day!
2. What a tall building!
3. What a hot room!
4. What delicious food!
5. What a good person!
6. What a bad person!
7. What a cute baby!
8. What a big car!
9. What an ugly thing!
10. How hot it is!
11. How cold it is!
12. What a nice thing it is!

Дасгал 5

Цонхоороо гадагшаа хараад хэн юу хийж байгааг бич. (Look out your window and write down what people are doing.)

Тест

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Би халуун юм уухмаар байна.
   Б. Би халуун юм уумаар байна.
   В. Би халуун юм уумаар.

2. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Та хаашаа явмаар байна уу?
   Б. Та хаашаа явмаар байна бэ?
   В. Та хаашаа явмаар байна вэ?

3. Don't go outside.
   А. Гадаа битгий гар.
   Б. Гадаа битгий гараарай.
   В. Гадаа гардаггүй.

4. Please rest now.
   А. Одоо амрахаарай.
   Б. Одоо амар.
   В. Одоо амраарай.

5. What time is it now?
   А. Одоо цаг хэд болох байна (вэ)?
   Б. Одоо цаг хэд болж байна (вэ)?
   В. Одоо цаг хэдэн болж байна (вэ)?

6. It's 10:30 now.
   А. Одоо арав, гуч болж байна.
   Б. Одоо арав, гучин цаг болж байна.
   В. Одоо арван, гуч болж байна.

7. Children are playing. (You see them.)
   А. Хүүхдүүд тоглож байгаа.
   Б. Хүүхдүүд тоглож байна.
   В. Хүүхдүүд тоглож байдаг.

8. They are playing. (You don't see them.)
   А. Тэд тоглож байгаа.
   Б. Тэд тоглож байна.
   В. Тэд тоглож байдаг.

9. How long have you been staying here?
   А. Та энд хэр удаж байдаг вэ?
   Б. Та энд хэр удаж байна (вэ)?
   В. Та энд хэр удаж байсан бэ?

10. I was studying French before.
   А. Би өмнө нь франц хэл сурч байсан.
   Б. Би өмнө нь франц хэл сурч байгаа.
   В. Би өмнө нь франц хэл сурсан.

11. Which sentence is true in meaning?
   А. Монголд өвөл цас ордог.
   Б. Монголд зун их цас ордог.
   В. Монголд намар их цас ордог.

12. Which sentence is true in meaning?
   А. Монголд хавар их салхитай байдаг.
   Б. Монголд зун их салхитай байдаг.
   В. Монголд өвөл их салхитай байдаг.

13. What a pretty bag!
   А. Ямар гоё юм бэ?
   Б. Ямар гоё цүнх!
   В. Ямар гоё цүнх вэ?

14. How hot it is!
   А. Ямар халуун бэ?
   Б. Ямар халуун өдөр вэ?
   В. Ямар халуун юм бэ?

15. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. тоглож байна [тогложийн]
   Б. тоглож байна [тогложайгаа]
   В. тоглож байна [тогложайсан]

16. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. тоглож байгаа [тогложийн]
   Б. тоглож байгаа [тогложайгаа]
   В. тоглож байгаа [тогложайсан]

Оноо (point): 16/.....

Хорин нэгдүгээр хичээл

Орон заасан үгс (Positional words)

(noun + (а)[4]н)+following prepositions

дээр	on
доор	under
дотор	inside

(noun + -ын[2], -ы[2], -н)+ following prepositions

хажууд	next to
дэргэд	beside
урд, өмнө	in front of
ард, хойно	behind
наана	this side of
цаана	that side of

дээд тал(д)	(on) the top
доод тал(д)	(on) the bottom
дотор тал(д)	(on) the inside
баруун тал(д)	(on) the right side
зүүн тал(д)	(on) the left side
урд тал(д)	(in) the front
ар тал(д)	(in) the back
урд зүг(т)	(to) the south
хойд зүг(т)	(to) the north
баруун зүг(т)	(to) the west
зүүн зүг(т)	(to) the east

For example: цүнхэн дээр, цүнхэн доор, цүнхэн дотор, цүнхний хажууд, цүнхний наана, цүнхний цаана, дэлгүүрийн урд, дэлгүүрийн ард.

Дасгал 1

Өгүүлбэрийг унш. (Read the sentences.)

1. Ширээн дээр олон монгол ном байна.
2. Ширээн доор хар нохой байна.
3. Миний цүнхэн дотор харандаа байгаа.
4. Манай гэрийн хажууд нэг том дэлгүүр байдаг.
5. Хоёр хүүхэд замын наана байсан.
6. Олон хүүхэд замын цаана байсан.
7. Их дэлгүүрийн ард шүдний эмнэлэг байдаг.
8. Сүхбаатарын талбайн хажууд театр байдаг.
9. Ширээний хажууд зогсоорой. Ширээний хажууд битгий зогсоорой.
10. Сандлын ард зогсоорой. Сандлын ард битгий зогсоорой.
11. Миний хажууд зогс. Миний хажууд битгий зогс.
12. Гутлаа ширээн дээр биш, ширээн доор тавиарай.

Шинэ үгс: зам — road, шүдний эмнэлэг — dental clinic, талбай — square, тавих — to put (on)

Note:

Ном ширээн дээр байна.	The book is on the table. (You see right now.)
Ном ширээн дээр байгаа.	The book is on the table. (It's in the other room and you don't see it.)
Ном ширээн дээр байдаг.	The book is on the table. (Book is always there.)

Дасгал 2

Ганхүүд юу тохиолдсон болон зураг бүр дээр Ганхүүгийн хаана байгааг бич. (Write about what happened to Ganhuu and where he is in each picture.)



Дасгал 3

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. There is one white notebook on your table.
2. There is a good restaurant next to the bank.
3. There is a central post office next to Sukhbaatar Square.
4. The wide road is in front of Sukhbaatar Square.
5. People are sitting in front of (behind) that store.
6. She sat next to (behind, in front of, on the right/left side of) me.
7. See you at 10 o'clock in front of (on the right side of) the State Department Store.
8. Children are playing on this side of (that side of) the store.
9. Please put your book on (under) that big book.
10. Don't stand behind (in front of) a car.

Дасгал 4

Улаанбаатарын хаана хаана, юу юу байдаг талаар багштайгаа ярилц. (Talk with your teacher about where these places are in Ulaanbaatar.)

1. Сүхбаатарын талбайн эргэн тойронд юу юу байдаг вэ?
2. Их дэлгүүрийн эргэн тойронд юу юу байдаг вэ?
3. Чингис зочид буудлын эргэн тойронд юу юу байдаг вэ?
4. Гуравдугаар хороололд юу юу байдаг вэ?

Шинэ үг: эргэн тойронд — around

Байх (to be)

If a sentence ends with a noun or an adjective and if it tells about general things, we don't need to use the verb "байх." For example:

Тэр манай багш.	She is our teacher.
Монгол хоол амттай.	Mongolian food is delicious.
Энэ байр хүйтэн.	This apartment is cold.

But if a sentence ends with a noun or an adjective and if we just found out about it, then we use "байна." For example:

Тэр манай багш байна.	(I just found out that) she is our teacher.
Монгол хоол амттай байна.	Mongolian food is delicious. (I'm tasting it now.)
Энэ байр хүйтэн байна.	This apartment is cold. (I'm feeling it now.)

If we describe the position of something, we must to use the verbs "байна, байгаа, байдаг."

For example:

Аяга ширээн дээр байна.	The cup is on the table. (I see it now.)
Аяга ширээн дээр байгаа.	The cup is on the table. (I don't see it now.)
Аяга ширээн дээр байдаг.	The cup is on the table. (It's always there.)

Дасгал 5

"Байна, байгаа, байдаг" гэдэг үгсийг доорх өгүүлбэрүүдэд бичих хэрэгтэй юу?
(Do we need to use verbs "байна, байгаа, байдаг" in the sentences below?)

1. Хүүхдүүд сургуулийн гадаа .....
2. Би сургуулийн сурагч .....
3. Цонхоо хаагаарай. Энэ өрөө их хүйтэн .....
4. Африк их халуун .....
5. Монгол улс Азид .....
6. Чиний ном цүнхэн дотор .....
7. Энэ миний хүү .....
8. Энэ их сайн сургууль .....
9. Долгормаа ангидаа .....
10. Их дэлгүүрийн урд цирк .....
11. Хөөх! Энэ хоол их амттай .....
12. Жаахан хүлээгээрэй. Цай их халуун .....
13. Энэ ном ер нь их сонирхолтой .....
14. Монгол улс ер нь хүйтэн .....
15. Яана аа! Гадаа их халуун .....

Шинэ үгс: Ази — Asia, хүлээх — to wait

Хорин хоёрдугаар хичээл

Тодорхой тийн ялгалтай хэрэглэгддэг зарим үйл үг (Some verbs which are used with specific cases)

Object + д/-т → verbs below

авах	to buy … for
баярлах	to be happy, to be thankful
бэлдэх	to prepare for
дасах	to get used to
заах	to teach
итгэх	to believe in, to trust
өгөх	to give
туслах	to help to
таарах	to fit
санаа зовох	to worry
очих	to get to, to visit
орох	to go in
нөлөөлөх	to influence
оролцох	to participate in
үзүүлэх	to show
сануулах	to remind
хүрэх	to touch, to reach
хариулах	to answer
хэлэх	to say, to tell

Direct object + ыг²/-г → verbs below

гомдоох	to offend
дуудах	to call
загнах	to scold
магтах	to praise
мартах	to forget
ойлгох	to understand
санах	to remember, to miss
сонсох	to hear, to listen to
таних	to know, to recognize
урих	to invite
мэдэх	to know
уучлах	to forgive
харах	to see
хайрлах	to love
хооллох	to eat food, to feed
хүлээх	to wait
хүндлэх	to respect
эмчлэх	to treat
эрэх	to look for

Object + аас⁴ → verbs below

авах	to take … from/buy … from
айх	to be afraid of
асуух	to ask
буух	to get off
гарах	to go out of
гуйх	to ask for, to beg
залхах	to get tired of
ичих	to be embarrassed
ирэх	to come from
оцрох	to be late
хамаалах	to depend on
хамаарах	to depend on
хүндэх	to have a fear of respect

Object + тай³ → verbs below

тааралдах	to run into
танилцах	to get to know
уулзах	to meet
мэндлэх	to greet

Object + руу²/луу² → verbs below

заах	to point at
утасдах	to call
шидэх	to throw ... at
харах	to look at
явах	to go to
явуулах	to send

Object + аар⁴ → verbs below

бахархах	to be proud of

Өгөх оршихын тийн ялгал (Dative and locative case)

-д/-т (in, at, for, to)

Би ресторан**д** хоол идсэн.	I ate food **at** the restaurant.
Би таван цаг**т** гэр**т**ээ ирсэн.	I came **to** my house **at** five o'clock.
Би ээж**д**ээ бэлэг авсан.	I bought the gift **for** my mother.
Би Дашхүү**д** бэлэг өгсөн.	I gave a gift **to** Dashhuu.

	After words ending with **г, с, р** or (**в**)	After words ending with long, short vowel or diphthong	After words ending with **ь, н, м, л** or (**в**)	After words ending with **з, т, х** or **д**	After words ending with **ш, ч** or **ж**
After words related to people, place	-т	-д	-д	-(а^4)д	-(и)д
After words related to things	-т -(н)д	-(н)д	-д -(а^{4}н)д	-(а^{4}н)д	-(ин)д

For example:

эхнэрт	ламд	хичээлд	өрөөнд
хүмүүст	аавд	ахад	маханд
цагт	Гэрэлд	хүүхдэд	хоолонд
өвөөд	байшинд	багшид	байранд
даргад	сургуульд	эмчид	толинд

Question pronouns and personal pronouns:

юу → юунд	та → танд	бид → бидэнд
хэн → хэнд	чи → чамд	та нар → та нарт
би → надад	тэр → түүнд	тэд → тэдэнд

Дасгал 1

Өгүүлбэрийг уншаад асуулт зохио. (Read the sentences and make questions.)

Жишээ нь: Би найздаа үзэг авсан. (I bought a pen for my friend.)
Та найздаа үзэг авсан уу? (Did you buy a pen for your friend?)
Та хэнд үзэг авсан бэ? (For whom did you buy a pen?)

1. Тэр эхнэртээ бэлэг авсан.
2. Бид дүүдээ бэлэг авсан.
3. Тэр найздаа хоол хийсэн.
4. Би нөхөртөө хоол хийсэн.
5. Жаргалмаа багшдаа хоол хийсэн.
6. Тэд манай багшид хоол хийсэн.
7. Тэр найздаа бэлэг өгсөн.
8. Тэр бидний найзад бэлэг өгсөн.
9. Би гэртээ байсан.
10. Би түүний гэрт байсан.

Дасгал 2

Нэр үгст өгөх оршихын тийн ялгалын нөхцөл залгаж, өгөгдсөн үйл үгсийг ашиглан өгүүлбэрийг гүйцээ. (Add the dative locative cases to nouns and complete the sentences using the verbs below.)

1. Би таны нөхөр.....
2. Би таны эхнэр.....
3. Тэр манай захирал.....
4. Бид хүмүүс.....
5. Тэр таны хүү.....
6. Би тэдний аав.....
7. Би Галхүүгийн эгч.....
8. Галхүү миний ээж.....
9. Гэрэлмаа Төрхүүгийн дүү.....
10. Багш манай өвөө.....
11. Хүүхдүүд таны найз.....
12. Би танай нохой.....
13. Хүүхдүүд манай оюутан.....
14. Оюутнууд багш.....

Үйл үгс (Verbs): хэлэх, хийх, авах, бичих, өгөх, туслах (to help), итгэх (to trust/to believe), заах (to teach)

Дасгал 3

Эгөх оршихын тийн ялгал болон ерөнхийлөн хамаатуулах нөхцөл "-аа⁴"-г ашиглан өгүүлбэрийг гүйцээ. (Complete the sentences using the dative locative case and the possessive suffix "-аа⁴.")

Жишээ нь: Би найз ..... → Би найздаа тусалсан. (I helped my friend.)

1. Тэр, нөхөр .....
2. Бид захирал .....
3. Тэд хүү.....
4. Би охин .....
5. Хүүхдүүд аав .....
6. Энхмаа ах.....
7. Тэд ээж.....
8. Би дүү .....
9. Баатархүү өвөө .....
10. Тэр, найз .....
11. Та нар багш.....
12. Хүүхдүүд нохой.....
13. Би оюутан .....
14. Аав жолооч .....

Дасгал 4

Нэр үгс дээр өгөх оршихын тийн ялгалын нөхцөл залгаж бичээд асуулт зохио. (Add the dative locative case to nouns and make questions.)

1. Аяга... цай байна.
2. Миний цүнх... дэвтэр байгаа.
3. Миний ам... эм байгаа.
4. Манай гэр... том цэцэг байдаг.
5. Манай сургууль... гуанз байдаг.
6. Анги... олон зураг байсан.
7. Миний өрөө... ор байгаа.
8. Танай байр... жижүүр байдаг.
9. Энэ хайрцаг... ном байгаа.
10. Тэр лааз... жимс байсан.
11. Энэ уут... талх байсан.
12. Тэр тор... мах байсан

Шинэ үгс: ам — mouth, гуанз — little restaurant, анги — classroom, хайрцаг — box, лааз — can, уут — bag (with handle), тор — bag (with handle), жижүүр — doorman

Дасгал 5

Биеийн төлөөний үгсийг өгөх оршихын тийн ялгалын нөхцөлөөр хувирга. Өмнөх хүснэгтээсээ харалгүй дараагийн хүснэгтээ бөглөж бич. Дараа нь биеийн төлөөний болон өгөгдсөн үйл үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Add the dative locative case to personal pronouns. Fill out the next table without looking at the previous table. Then make sentences using the personal pronouns and the verbs below.)

хэн	хэнд
Би	
Чи	
Та	
Тэр	
Бид (нар)	
Та нар	
Тэд (нар)	

хэн	хэнд
Тэд (нар)	
Та нар	
Бид (нар)	
Тэр	
Та	
Чи	
Би	

хэн	хэнд
Тэр	
Тэд (нар)	
Чи	
Би	
Бид (нар)	
Та нар	
Та	

Үйл үгс: өгөх, авах, итгэх, туслах, хийх, үзүүлэх (to show), уурлах (to get angry)

Дасгал 6

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Би, нөхөр (эхнэр, охин, хүү, найз), шинэ ном, өгөх
2. Жаргалмаа, өглөө, найз (багш, хөрш, эмч, дүү), бэлэг, авах
3. Та, тэр (би, бид нар, тэд нар, найз), итгэх?
4. Та, хүүхдүүд (ах, эгч, хөрш, оюутан, амьтан, хүмүүс), туслах хэрэгтэй
5. Би, том хүн (хүүхдүүд, оюутан, эмч, багш нар), англи хэл, заах
6. Би, гэр (байр, байшин, оюутны байр, 3 дугаар хороолол) амьдрах
7. Тэр, манай гэр (сургууль, байр, театр, байшин), очих
8. Хүүхдүүд, гэр (өрөө, байр, анги, сургууль, майхан, гуанз), орох
9. Хүмүүс, хичээл (хувцас, ажил, хоол), анхаарах

Шинэ үгс: хөрш — neighbor, эмч — doctor, амьтан — animal, майхан — tent, очих — to visit/to get to, анхаарах — to pay attention

Дасгал 7

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. Please give this candy to your son (daughter, brother, sister).
2. Please buy one notebook for me (them, her, us).
3. I cooked Mongolian food for my husband (family, friend, neighbor).
4. You need to trust your friend (mother, father, teacher, neighbor)
5. She likes to help people (children, old people, sick people).
6. I don't trust him (them, your friend).

Дасгал 8

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Аав ээж хүүхдэдээ амьдралын тухай заах хэрэгтэй юү?
2. Та хүмүүст хичээл заадаг уу?
3. Та хүмүүст итгэдэг үү? Яагаад?
4. Хүмүүс юунд итгэдэг вэ?
5. Та хүмүүст туслах дуртай юу? Яагаад?
6. Ээж чинь танд юу гэж хэлдэг вэ?
7. Та хэний гэрт (хэнийд) очих дуртай вэ?
8. Юу юу хүүхдэд сайнаар (муугаар) нөлөөлдөг вэ?
9. Хүүхдүүд бүх юмаа аав ээждээ ярьдаг уу?
10. Хүмүүс юу юунд бэлдэх хэрэгтэй вэ?
11. Та заримдаа аав ээж, найз нөхөд, ах дүүдээ уурладаг уу?
12. Аав ээж, хүүхдүүддээ олон юмны тухай тайлбарлаж ярьдаг уу?

Шинэ үгс: нөлөөлөх — to influence, бэлдэх — to prepare, найз нөхөд — friends, тухай — about, тайлбарлах — to explain

Дасгал 9

Сүүлд болсан шинэ үгсээ ашиглан Ганхүүд юу тохиолдсоныг бич. (Write about what happened to Ganhuu recently using the words you have learned.)



Хорин гуравдугаар хичээл

Хөндлөнгийн үг (Direct speech)

The boy said to his mother, "Thank you mom!"

1. **Хүү ээждээ** "Ээж ээ, баярлалаа!" гэж **хэлсэн.**
2. **Хүү** "Ээж ээ, баярлалаа!" гэж **ээждээ хэлсэн.**
3. "Ээж ээ, баярлалаа!" гэж **хүү ээждээ хэлсэн.**

Дасгал 1

Харилцаа яриаг ашиглан хөндлөнгийн үгтэй өгүүлбэр зохиож бич. (Change the following conversations into direct speech.)

1. Жаргалмаа: — Би чамд итгэдэг.
   Баярхүү: — Баярлалаа. Би бас чамд итгэдэг.
2. Хүү: — Ээж ээ, би ангидаа хичээлээ сайн хийнэ.
   Ээж: — Миний хүү, чи хичээлээ сайн хийх хэрэгтэй.
3. Нөхөр: — Охин надад тусалсан.
   Эхнэр: — Тийм үү, надад ч гэсэн тусалсан.
4. Аав: — Чи найздаа номоо өгөх хэрэгтэй.
   Охин: — Би түүнд номоо өгөхгүй.
5. Наранхүү: — Чи надад дуу заагаарай.
   Гэрэлмаа: — Ээ, би дуу мэдэхгүй шүү дээ.
6. Багш: — Хүүхдүүд ээ, маргааш 9 цагт ирээрэй. Битгий хоцроорой.
   Сурагч: — Багш аа, бид хоцрохгүй ээ.
7. Эгч: — Миний дүү, цүнхэндээ номоо хийгээрэй.
   Дүү: — Эгч ээ, та миний номыг цүнхэнд хий.

Шинэ үгс: ч гэсэн — too/also, хоцрох — to be late, шүү дээ — gives emphasis to a sentence, -д/-т хийх — to put in

Дасгал 2

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Аав ээж хүүхдүүддээ юу гэж хэлдэг вэ?
2. Та дүүдээ/хүүхдэдээ юу гэж хэлдэг вэ?
3. Багш сурагчдадаа/оюутнуудаа юу гэж хэлдэг вэ?
4. Та найзуудаа юу гэж хэлдэг вэ?
5. Том хүмүүс хүүхдүүдэд юу гэж хэлдэг вэ?

Дасгал 3

Доорх зураг бүр дээр хөндлөнгийн үгтэй өгүүлбэр хоёр хоёрыг зохиож бич. (Write two sentences with direct speech for each picture below.)



Дасгал 4

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохиож, багш оюутан хоёр харилцан бие биенээсээ асуулт асуух ярилц. (Make sentences using the given words, then teacher and student should ask each other questions.)

Жишээ нь: Би, 1970 он, 6 сар, 1, төрөх

Хэзээ онд төрсөн бэ? — Би 1970 онд төрсөн.
Хэзээ оны хэдэн сард төрсөн бэ? — Би 1970 оны 6 сард төрсөн.
Хэзээ оны хэдэн сарын хэдэнд төрсөн бэ? — Би 1970 оны 6 сарын 1-нд төрсөн.

1. Жаргалмаа, 1990 он, 7 сар, 8, төрөх
2. Тэд, 2010 он, 6 сар, 5, Солонгос явах
3. Би, 2002 он, 1 сар, 25, Монгол, ирэх
4. Бид, өнгөрсөн сар, 2, концерт, үзэх
5. Би, 1991 он, 9 сар, 1, сургууль, орох
6. Тэд, ирэх сар, 15, кино, үзэх
7. Найз, 1999 он, 7 сар, 20, сургууль, төгсөх
8. Би, 2001 он, 12 сар, 3, хөдөө, байх
9. Тэр, 1990 он, 8 сар, 7, Америк, гэрлэх
10. Би, 2007 он, 10 сар, 30, Герман, сургууль, сурах
11. Монгол, 7 сар, 11, наадам болох
12. Монгол, 2 сар, цагаан сарын баяр, болох
13. 12 сар, 31, шинэ жилийн баяр, болох

Шинэ үгс: төрөх — to be born, төгсөх — to graduate, болох — to become/to take a place

Дэлгүүрт (At the store)

— Худалдагч аа!	— Excuse me! (Literally: Seller!)
— Энэ хэд юм бэ? [hedii?]	— How much is this?
— Энэ ямар үнэтэй юм бэ? [üneteiii]	— How much is this?
— Энэ хаанахынх юм бэ? [haanahiihii]	— Where is this from?
— Алим байгаа юу?	— Do you have apples?
— Нэг кило алим ямар үнэтэй юм бэ?	— How much is one kilo of apples?
— Нэг кило алим авъя.	— I want to buy one kilo of apples.
— Энийг авъя. [avii]	— I want to buy this.
— Нэгийг авъя.	— I want to buy one of those.
— Очерлоорой.	— Please stay in line.
— Тор байгаа юу?	— Do you have a bag? (with handle)
— Гялгар уут байгаа юу?	— Do you have a plastic bag? (no handle)

Хорин дөрөвдүгээр хичээл

Баймж үг (дуртай, дургүй) (Modal verbs (like, don't like))

When verbs are used with дуртай/дургүй, we don't need to use any suffixes on subjects or objects. For example:
Би монгол хоол **идэх дуртай**. (I **like to eat** Mongolian food.)
Би өөхтэй хоол **идэх дургүй**. (I **don't like to eat** food with fat in it.)

But when verbs are not used with дуртай/дургүй, we need to use the dative locative case on objects. For example:
Би монгол хоол**онд** дуртай. (I like Mongolian food.)
Би өөхтэй хоол**онд** дургүй. (I don't like food with fat in it.)

Дасгал 1

Өгүүлбэрийг үйл үггүй болгон бичиж, асуулт зохио. (Write each sentence without the verb and make questions.)

Жишээ нь: Би бууз идэх дуртай. → Та бууз идэх дуртай юу? Би буузанд дуртай. → Та буузанд дуртай юу?

1. Энхмаа ном унших дургүй.
2. Тэд тоглоом тоглох дургүй.
3. Би морь унах дуртай.
4. Би бэлэг авах дуртай.
5. Алтмаа кино үзэх дуртай.
6. Бид жимс идэх дуртай.
7. Тэр, хэлний хичээл хийх дуртай.
8. Тэр, ажил хийх дургүй.
9. Би машинаар явах дургүй.
10. Тэр, сүүтэй цай уух дургүй.

Дасгал 2

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь: I like to eat bread. → Би талх идэх дуртай. I like bread. → Би талханд дуртай.

1. What do you like to do?	What do you like?
2. I like to ride horses.	I like horses.
3. They don't like to cook.	They don't like huushuur.
4. She likes to eat fruit.	She likes fruit.
5. He doesn't like to read books.	He doesn't like books.
6. They don't like to go to that store.	They don't like that store.
7. I like to eat in that restaurant.	I like the food in that restaurant.
8. He doesn't like to work.	He doesn't like work.
9. Mongolians like to eat meat.	Mongolians like meat.
10. Americans like to play football.	Americans like football.

Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь: Би, өөх, идэх, дуртай/дургүй байсан

А. Би өөх идэх дуртай байсан. Харин одоо дургүй болсон.
(I liked to eat fat. But now I have started not liking it.)
Б. Би өөх идэх дургүй байсан. Харин одоо дуртай болсон.
(I didn't like to eat fat. But now I have started liking it.)
В. Би өөхөнд дуртай байсан. Харин одоо дургүй болсон.
(I liked fat. But now I have started not liking it.)
Г. Би өөхөнд дургүй байсан. Харин одоо дуртай болсон.
(I didn't like fat. But now I have started liking it.)

1. Манай найз, мах, идэх, дуртай/дургүй, байсан
2. Томчууд, тоглоом, тоглох, дуртай/дургүй, байсан
3. Монгол хүмүүс, ногоо, идэх, дуртай/дургүй, байсан
4. Америк хүмүүс, кола, уух, дуртай/дургүй, байсан
5. Тэр, монгол хэл, сурах, дуртай/дургүй, байсан
6. Тэд, хот, амьдрах, дуртай/дургүй, байсан

Дасгал 4

Та өмнө нь юунд/юу хийх дуртай байгаад одоо дургүй болсон болон юунд/юу хийх дургүй байгаад одоо дуртай болсноо бич. (Write about what you liked (to do) and now don't like (to do) and what you didn't like (to do) and now like (to do).)

1. Таны дуртай байсан, одоо дургүй болсон юмс.
2. Таны хийх дуртай байсан, одоо дургүй болсон юмс.
3. Таны дургүй байсан, одоо дуртай болсон юмс.
4. Таны хийх дургүй байсан, одоо дуртай болсон юмс.

Дасгал 5

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь:

I love my parents.	Би аав ээждээ хайртай.
I love you.	Би чамд хайртай.
I love you.	Би танд хайртай.
I don't love her.	Би түүнд хайргүй.
He does not love animals.	Тэр амьтанд хайргүй.

1. I love my mother (father, brother, sister, son, daughter, children, dog, friend).
2. I love him (you, them).
3. She loves them (you, him, horses, cats, flowers).
4. He doesn't love people (children, animals, dogs, cats).

Хорин тавдугаар хичээл

Нэр үгийн олон тоо (Plural form for nouns)

	After words related to people	After words related to things	After nouns	After adjectives	After names	After words related to relatives or professions	After words ending with **-гч, -ч, аач, -чин** or **-н**	After some words with hidden **н** and words ending with long vowels or diphthongs	After some words ending with **н**(г)
1. **-ууд**[2]	√	√	√						
2. **-(н)ууд**[2]		√	√					√	
3. **-(г)ууд**[2]		√	√						√
4. **нар**	√		√			√			
5. **-д**	√						√		
6. **-с**	√	√	√	√					
7. **-чууд**[2] **-чуул**[2]	√			√	√				

For example:

-ууд[2]	**-(н)ууд**[2]	**нар**	**-д**	**-с**	**-чууд**[2]/**-чуул**[2]
дэвтрүүд	хуруунууд	та нар	охин + д =	үгс	монголчууд
дэлгүүрүүд	хашаанууд	бид нар[26]	охид	нэрс	германчууд
голууд	гахайнууд	ах нар	дуучин + д =	үүлс	америкчууд
номууд	бээлийнүүд	эгч нар	дуучид	уулс	японччууд
оюутнууд	сэрээнүүд	дүү нар	бүжигчин + д =	залуус	солонгосчууд
найзууд	ширээнүүд	эмээ нар	бүжигчид	хүмүүс	эмэгтэйчүүд
нүүхдүүд	малгайнууд	өвөө нар	зураач + д =	эмс	эрэгтэйчүүд
хамаатнууд	толгойнууд	ач нар	зураачид	эрс	томчууд
эхнэрүүд	тахианууд	багш нар	уншигч + д =	юмс	(томчуул)
нөхрүүд	шүднүүд	дарга нар	уншигчид		багачууд
дэцгүүд	үзэгнүүд	эмч нар	хөгжимчин + д =		(багачуул)
асуултууд	сумнууд	лам нар	хөгжимчид		хөгшчүүд

Note: When we add the suffix **-ууд**[2] to some words ending with **н**, the letter **г** is inserted. For example: сан**г**ууд, байшин**г**ууд

Шинэ үгс: хамаатан — relative, сум — bullet, ач — grandchild, дуучин — singer, томчууд — adults, багачууд — kids, бүжигчин — dancer, зураач — artist

[26] Sometimes in the Mongolian language you see double plural suffixes in one word. For example, бид нар (-д and нар are both plural suffixes) and охидууд (-д and -ууд are plural suffixes). This is grammatically incorrect but this is commonly used in colloquial speech.

Олон тооны нөхцөл хэрэглэдэггүй зарим тохиолдол
(Some cases where plural suffixes are not used)

1. When people talk about general things — Би номонд дуртай. (I like books.)
2. When nouns are preceded by plural adjectives — олон/зарим хүн (many/some people)
3. When nouns are with numbers — 10 ном (10 books), 2 үзэг (2 pens)
4. When nouns are abstract things — бидний ухаан/сэтгэл (our mind/heart)
5. When nouns are uncountable things — элс (sand), будаа (rice)
6. When nouns describe things in pairs — миний нүд/гутал (my eyes/boots)
7. When nouns with repeated words express the plural — урт урт мод (long woods)

Note: Би ном унших дуртай. (I like to read books.) In this sentence I'm talking generally about the idea of books. But, if we talk about specific books, then we will use a plural suffix. For example: Таны номууд ширээн дээр байна. (Your books are on the table.)

Дасгал 1

Доорх үгст олон тооны нөхцөл залгаж бичээд өмнөх хуудаснаас харж, алдаагаа зас.
(Add plural suffixes to the words below, then look at the previous page and correct them.)

монгол	үзэг	үг	охин	та	дэвтэр
америк	шүд	нэр	дуучин	бид	гол
солонгос	хуруу	үүл	бүжигчин	эгч	ном
эмэгтэй	хашаа	уул	зураач	дүү	оюутан
эрэгтэй	бээлий	хүн	уншигч	багш	найз
том	сэрээ	эм	хөгжимчин	дарга	хүүхэд
хөгшин	гахай	эр	зурагчин	эмч	нөхөр

Дасгал 2

Доорх үгст олон тооны нөхцөл залгаж бич. (Add plural suffixes to the words below.)

1. малчин
2. та
3. багш
4. харандаа
5. малгай
6. хөгжимчин
7. эмэгтэй
8. эмээ
9. ах
10. эрэгтэй
11. дэвтэр
12. найз
13. бүжигчин
14. өвөө
15. нөхөр
16. хашаа
17. дуучин
18. австрали
19. сандал
20. эмч
21. монгол
22. жолооч
23. ном
24. захирал
25. бээлий
26. зурагчин
27. дэлгүүр
28. хүүхэд
29. герман
30. үзэг
31. хамаатан
32. америк
33. ямаа
34. цэцэг
35. эхнэр
36. солонгос
37. хүн
38. оюутан
39. машин
40. ширээ

Шинэ үг: зурагчин — photographer

Дасгал 3

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Монголчууд америкчуудтай адилхан уу?
2. Монголчууд ямар хүмүүс вэ?
3. Америкчууд ямар хүмүүс вэ?
4. Эрэгтэйчүүд ажил хийх хэрэгтэй юу, эмэгтэйчүүд ажил хийх хэрэгтэй юу?
5. Багш нар ямар байх хэрэгтэй вэ?
6. Малчдын амьдрал хэцүү юу?
7. Эцэг эхчүүд юу хийх хэрэгтэй вэ?
8. Томчууд хүүхдүүдэд итгэдэг үү?
9. Та хамаатнуудтайгаа дотно байдаг уу?
10. Америк дуучид, бүжигчдийн амьдралын талаар та юу гэж боддог вэ?
11. Америкт машин ямар ямар өнгөтэй байдаг вэ?
12. Ах эгч нар, дүү нартаа тусалдаг уу?
13. Америкт оюутнууд өдөрт хэдэн цаг сурдаг вэ?
14. Танай ангийн сандал, ширээнүүд ямар өнгөтэй вэ?

Шинэ үгс: дотно — close, эцэг эх — parents

Дасгал 4

Өгүүлбэрийг орчуул. Орчуулахдаа нэр үгс олон тооны нөхцөл авах эсэхэд анхаараарай. (Translate the sentences. When you translate the sentences, pay attention to whether the nouns need plural suffixes or not.)

1. Teachers came. Few teachers came.
2. Many fruits are on the table. Fruits are on the table.
3. I like to read books. I read many books last year.
4. His eyes are good.
5. There are chairs in that classroom. Bring five chairs here.
6. People ate food. Some people ate food.
7. They like to watch movies. They watched very many movies.
8. Mongolians like to eat meat. Koreans like to eat rice.
9. He trusts his friends. His many friends trust him.
10. Ten students are learning Mongolian now. Students need to study many hours.

Дасгал 5

Бичгийн хэрэгслүүдийн нэрийг цээжилж, зургуудыг харж, юу юу байгааг нэрлэ. (Memorize the stationery vocabulary, then look at the pictures and tell what things are there.)

Бичгийн хэрэгсэл (Stationery items)

үзэг	pen	шугам	ruler
бал	ballpoint pen	цүнх	purse
харандаа	pencil	хайч	scissors
баллуур	eraser	ширээ	table
цэрд/шохой	chalk	сандал	chair
дэвтэр	notebook	цаас	paper
самбар	chalkboard	бичгийн хавчаар	paperclip
тооны машин	calculator	үдээсний машин	stapler



Дасгал 6

Ангид болон багш, оюутнуудын ширээн дээр юу юу байж болохыг олон тооны нөхцөл ашиглан хэл. (Using the plural suffixes, tell about what things can be found in a classroom and on the teacher's and students' tables.)



Давтлага хичээл

Дасгал 1

Зана хэн, юу байгааг хэл. (Tell about where things and children are using the dative locative case.)



Дасгал 2

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Их дэлгүүр хаана байдаг вэ?
2. Цирк хаана байдаг вэ?
3. "Kempinski" зочид буудал хаана байдаг вэ?
4. Сүхбаатарын талбайн хойно юу юу байдаг вэ?
5. Танай гэрийн баруун/зүүн талд юу юу байдаг вэ?
6. "Линго Лаб" төвийн эргэн тойронд юу юу байдаг вэ?

Дасгал 3

Доор өгөх оршихын тийн ялгалын нөхцөлөөр хувиргаж, үг тус бүрийг оролцуулан өгүүлбэр зохио. (Add the dative locative case to the words and make sentences with each word.)

багш	5. нохой	9. та	13. бид
2. аав	6. би	10. сургууль	14. сурагч
3. найз	7. хүүхдүүд	11. чи	15. хашаа
4. тэр	8. анги	12. гэр	16. тэд

Дасгал 4

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та хэн хэнд итгэдэг вэ? Яагаад?
2. Та одоо хэн хэнд тусалмаар байна вэ? Яагаад?
3. Та хүмүүст хичээл заадаг уу?
4. Та хэн хэнд бэлэг өгдөг вэ?
5. Та хэн хэнд юу юу гэж хэлдэг вэ?
6. Та хэдэн оны хэдэн сарын хэдэнд төрсөн бэ?
7. Та хэдэн оны хэдэн сарын хэдэнд сургуулиа төгссөн бэ?
8. Та юунд дуртай вэ?
9. Та хэн хэнд хайртай вэ?

Дасгал 5

Хүснэгтийг бөглөж, үг бүр дээр өгүүлбэр зохио. (Fill out the table and make sentences with each word.)

хэн	**хэний** **(-ын²хаа⁴)**	**хэнтэй** **(-тай³гаа⁴)**	**хэнд** **(-даа⁴/-таа⁴)**
багш			
эмч			
найз			
өвөө			
эцэг эх			
хамаатан			
та			

Note: In the Mongolian language, the possessive suffix -аа⁴ can be used with personal pronouns to mean closeness. For example: Би чамдаа хайртай, I love you (who is my dear).

Дасгал 6

Доорх үгст олон тооны нөхцөл залгаж бич. (Add plural suffixes to the words below.)

1. хүүхэд
2. монгол
3. ном
4. эцэг эх
5. ах дүү
6. машин
7. том
8. эхнэр
9. багш
10. дуучин
11. малчин
12. найз
13. шугам
14. эгч
15. эмч
16. солонгос
17. харандаа
18. бал
19. нэр
20. үг
21. та
22. дарга
23. эмэгтэй
24. хүн

Тест

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Би найзандаа тусалсан.
   Б. Би найзаад тусалсан.
   В. Би найздаа тусалсан.

2. I will give flowers to your mother.
   А. Би танай ээжид цэцэг өгнө.
   Б. Би танай ээжэд цэцэг өгнө.
   В. Би танай ээжд цэцэг өгнө.

3. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Тэр Оросод амьдардаг.
   Б. Тэр Орост амьдардаг.
   В. Тэр Оросонд амьдардаг.

4. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Тэд маханд дуртай.
   Б. Тэд махад дуртай.
   В. Тэд мах дуртай.

5. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Монголчууд бууз дуртай.
   Б. Монголчууд буузанд идэх дуртай.
   В. Монголчууд бууз идэх дуртай.

6. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Галхүү ээжээ хайртай.
   Б. Галхүү ээждээ хайртай.
   В. Галхүү түүний ээж хайртай.

7. I was in Erdenet in June.
   А. Би Эрдэнэтэд 6 сар байсан.
   Б. Би Эрдэнэтэд 6 сарын байсан.
   В. Би Эрдэнэтэд 6 сард байсан.

8. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Тэр охин 2005 онд төрсөн.
   Б. Тэр охин 2005 онт төрсөн.
   В. Тэр охин 2005 он төрсөн.

9. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Япон нар хар үстэй.
   Б. Японууд хар үстэй.
   В. Японс хар үстэй.

10. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Багшууд ирж байна.
   Б. Багшчууд ирж байна.
   В. Багш нар ирж байна.

11. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Дэлгүүрүүд одоо хаасан.
   Б. Дэлгүүр нар одоо хаасан.
   В. Дэлгүүрчүүд одоо хаасан.

12. The child is standing on the fence.
   А. Хүүхэд хашааны дээр зогсож байна.
   Б. Хүүхэд хашаа дээр зогсож байна.
   В. Хүүхэд хашаан дээр зогсож байна.

13. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Манай гэрийн хажууд мод байдаг.
   Б. Манай гэр хажууд мод байдаг.
   В. Манай гэрэн хажууд мод байдаг.

14. People are in front of the store.
   А. Хүмүүс дэлгүүрийн ард байна.
   Б. Хүмүүс дэлгүүрийн наана байна.
   В. Хүмүүс дэлгүүрийн урд байна.

15. What is in my hand? (Guess.)
   А. Миний гарт юу байдаг вэ?
   Б. Миний гарт юу байна вэ?
   В. Миний гарт юу байгаа вэ?

16. Wow, this is a pretty shirt.
   А. Хөөх, энэ гоё цамц байна.
   Б. Хөөх, энэ гоё цамц байдаг.
   В. Хөөх, энэ гоё цамц байгаа.

Оноо (point): 16/.....

Хорин зургадугаар хичээл

Хүний бие, эрүүл мэнд (People's body and health)

бие	body	гэдэс	stomach
толгой	head	нуруу	back
нүүр	face	эмнэлэг	hospital
ам	mouth	өвдөх	to be sick, to have a pain
хамар	nose	эмч	doctor
шүд	teeth	эмчид үзүүлэх	to go to see a doctor
нүд	eye	эм уух	to take medicine
чих	ear	халуурах	to have a fever
гар	hand, arm	ханиах	to cough
хөл	leg, feet	ханиад хүрэх	to catch cold
хуруу	finger	эмчлэх	to treat
хөлийн хуруу	toes	эдгэх	to be healed
үс	hair	үхэх	to die
хэл	tongue	нас барах	to die (for people)

Дасгал 1

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та жил бүр эмчид үзүүлдэг үү?
2. Та их эм уудаг уу?
3. Таны бие (толгой, шүд, нүд, хөл, гар, гэдэс, нуруу) өвддөг үү?
4. Шүдний эмнэлэг хаана хаана байдаг вэ?
5. Америк хүмүүс урт үстэй юу? Та үсчин явдаг уу?
6. Ази (европ) хүмүүс том нүдтэй юу, жижиг нүдтэй юу?
7. Хүн яагаад нэг ам, хоёр чихтэй байдаг вэ?
8. Шүдэнд (нүдэнд, биенд) юу юу сайн бэ?
9. Шүдэнд (нүдэнд, биенд) юу юу муу вэ?

Дасгал 2

Доорх нөхцөл байдлуудад юу өвдөж болохыг бич. (Write about what sicknesses can be caused in the situations below.)

1. Би муу хоол иднэ.
2. Би гадаа, дулаан хувцасгүй тоглоно.
3. Би компьютер тоглоом тоглоно.
4. Би олон цаг гар бөмбөг тоглоно.
5. Би олон цаг хичээлээ хийнэ.
6. Би хоолгүй олон цаг ажиллана.
7. Би суухгүй, олон цаг зогсоно.
8. Би ярих их дуртай. Их ярина.
9. Би ус уухгүй.
10. Би амралгүй их ажил хийнэ.

Дасгал 3

Өгөгдсөн нөхцөл байдлуудад тохирсон зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation.)

Жишээ нь: Миний чих өвдөж байна. → Эмчид үзүүлээрэй.

1. Миний толгой өвдөж байна.
2. Миний гэдэс өвдөж байна.
3. Би халуурч байна.
4. Миний нуруу өвдөж байна.
5. Миний бие олон хоног өвдөж байна.
6. Би гадаа олон цаг тоглосон. Тэгээд ханиад хүрсэн.
7. Би их чихэр идсэн. Тэгээд одоо миний шүд өвдөж байна.
8. Би их ажил хийсэн. Тэгээд одоо миний гар өвдөж байна.
9. Би олон цаг суугаагүй. Тэгээд миний хөл өвдөж байна.

Дасгал 4

Доорх зургуудыг хараад тэдэнд юу юу тохиолдсоныг бич. (Look at the pictures below and write what happened to the people.)



Хичээлд хэрэглэгддэг үгс (Words that are used in a lesson)

үсэг	letter	сурах	to study, to learn
үг	word	асуулт	question
эгшиг	vowel	асуух	to ask
гийгүүлэгч	consonant	хариулт	answer
өгүүлбэр	sentence	хариулах	to answer
үйл үг	verb	давтлага	review
нэр үг	noun	давтах	to review
тэмдэг нэр	adjective	жишээ	example
хэлзүй	grammar	асуултын тэмдэг	question mark
дуудлага	pronunciation	анхаарлын тэмдэг	exclamation mark
тоо	number	цэг	full stop
олон тоо	plural	таслал	comma
дасгал	exercise	хаалт	parenthesis
хичээл	lesson	шалгалт	exam
завсарлага	break	шалгалт өгөх	to take an exam
заах	to teach	шалгалт авах	to give an exam

Хичээл дээр

— Багш аа, (надад) нэг асуулт байна.
— Танаас юм асуух гэсэн юм. [asuuhgsii]
— "Chair"-ийг монголоор юу гэдэг юм бэ? [yugdii]
— "Chair"-ийг монголоор "сандал" гэдэг.
— "Сүх" гэж юу гэсэн үг юм бэ? [yugsügii]
— "Сүх" гэж "ах" гэсэн үг.
— Зүрх, сэтгэл гэдэг хоёр үг ямар ялгаатай юм бэ? [yalgaataiii]
— "Зүрх" гэдэг үгийг яаж бичдэг юм бэ? [bichdii]

At the lesson

— Teacher, I have one question.
— I would like to ask you something.
— How do you say "chair" in Mongolian?
— Chair is called сандал in Mongolian.
— What does "сүх" mean?
— Сүх means ax.
— What is the difference between зүрх and сэтгэл?
("Зүрх" is physical heart and "сэтгэл" is emotional heart.)
— How do you spell "зүрх"?

Хорин долдугаар хичээл

Баймж үг (хэрэгтэй, хэрэггүй (need, don't need))

When verbs are used with хэрэгтэй/хэрэггүй, we don't need to add any suffixes to subjects.
For example:
Хүмүүс хоол **идэх хэрэгтэй**. (People **need to eat** food.)
Би үнэтэй машин **авах хэрэггүй**. (I **don't need to buy** an expensive car.)

But when verbs are not used with хэрэгтэй/хэрэггүй, we need to add the dative locative case to subjects. For example:
Хүмүүс**т** хоол хэрэгтэй. (People need food.)
Надад үнэтэй машин хэрэггүй. (I don't need an expensive car.)

Дасгал 1

Өгүүлбэр бүрийг үйл үггүй болгон бичиж, асуулт зохио. (Write each sentence without verbs and make questions out of them.)

Жишээ нь: Би машин авах хэрэгтэй. → Надад машин хэрэгтэй. → Танд машин хэрэгтэй юү?

1. Баярхүү ном унших хэрэгтэй.
2. Хүмүүс хоол идэх хэрэгтэй.
3. Би тоглоом тоглох хэрэггүй.
4. Чи ус уух хэрэгтэй.
5. Та монгол хэл сурах хэрэгтэй.
6. Мөнхмаа хөдөө амрах хэрэгтэй.
7. Бид сайн найз байх хэрэгтэй.
8. Тэд хөгжим сурах хэрэгтэй.
9. Та багштай уулзах хэрэгтэй.
10. Багш шинэ дэвтэр авах хэрэггүй.
11. Алтмаа дасгал хийх хэрэггүй.
12. Би машин барих хэрэгтэй.

Дасгал 2

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. Children need to live with their parents.	Children need parents.
2. Children need to live in a warm house.	They need a warm house.
3. Parents need to love their children.	Children need love.
4. I need to learn Mongolian very well.	I need Mongolian.
5. We need to eat good food.	We need good food.
6. I don't need to go to the store tomorrow.	I don't need meat tomorrow.
7. People need to do work.	People need work.
8. What do children need to do?	What do children need?
9. What do men need to do?	What do men need?
10. What do women need to do?	What do women need?
11. What do you need to do?	What do you need?

Дасгал 3

Шинэ үгсийг цээжилж, доорх асуултад хариул. (Memorize new words and answer the questions below.)

хайрцаг	box	сав	container
(гялгар) уут	(plastic) bag without handle	аяга	cup
тор	bag with handle	халаас	pocket
цүнх	purse	түрийвч	wallet
хөргөгч	refrigerator	шүүгээ	cupboard/closet
дугтуй	envelope	–д/–т хийх	to put in

Жишээ нь: Та юунд дэвтрээ хийдэг вэ? → Би цүнхэндээ дэвтрээ хийдэг.

1. Та юунд номоо хийдэг(гүй) вэ?
2. Та юунд хоол хийдэг вэ?
3. Та юунд мөнгөө хийдэг(гүй) вэ?
4. Та юунд мах хийдэг(гүй) вэ?
5. Та юунд хувцаа хийдэг вэ?
6. Та хайрцагт юу юу хийдэг вэ?
7. Та торонд юу юу хийдэг вэ?
8. Та цүнхэндээ юу юу хийдэг вэ?
9. Та хөргөгчинд юу хийдэг(гүй) вэ?
10. Та саванд юу юу хийдэг(гүй) вэ?
11. Та халаасандаа юу хийдэг(гүй) вэ?
12. Та түрийвчиндээ юу хийдэг вэ?

Дасгал 4

Доорх зүйлсийг нэрлэж, дотор нь юу юу хийж болохыг бич. (Tell the names of the objects below and write what things can be put in them.)



Дасгал 5

Доорх нөхцөл байдлуудад тохирсон зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation below.)

Жишээ нь: Би мөнгөө оймсондоо хийдэг. → Мөнгөө оймсондоо битгий хий. Түрийвчиндээ хий.

1. Би гутлаа цүнхэндээ хийдэг.
2. Би мөнгөө торонд хийдэг.
3. Би хоолоо хайрцаганд хийдэг.
4. Би захиагаа гялгар уутанд хийдэг.
5. Би номоо саванд хийдэг.
6. Би балаа амандаа хийдэг.
7. Би гар утсаа аяганд хийдэг.
8. Би нохойгоо шүүгээнд хийдэг.
9. Би мууpаа уутанд хийдэг.
10. Би үзгээ хөргөгчинд хийдэг.
11. Би цагаа усанд хийдэг.
12. Би цагаа халаасандаа хийдэг.

Хорин наймдугаар хичээл

Байх (To have)

S+д/-т ... байна. (байгаа = бий, байдаг, байсан) S+д/-т ... байхгүй.

Надад үзэг **байна**.	**I have** a pen.	**Надад** үзэг **байхгүй**.	**I don't have** a pen.
Надад үзэг байгаа/бий.	I have a pen.	Надад үзэг байдаггүй.	I don't have a pen.
Надад үзэг байсан.	I had a pen.	Надад үзэг байгаагүй.	I didn't have a pen.

	To have things	To have (people)
-тай[3]	√	√
S+**д/-т ..... байна**.	√	

Дасгал 1

Өгүүлэгдэхүүнүүдийг өгөх оршихын тийн ялгалын нөхцөлөөр хувиргаж бич. (Add the dative locative case to the subjects.)

Жишээ нь: Цэцэгмаа..... олон тоглоом байгаа. → Цэцэгмаад олон тоглоом байгаа.

1. Баярхүү..... ном байна.
2. Аав..... мөнгө байгаа.
3. (Би) ..... асуулт байна.
4. Бид..... том цүнх байсан.
5. Тэд..... тоглоом байгаа.
6. Та нар..... цэцэг бий юү?
7. Хүүхдүүд..... тэр ном байгаа.
8. Багш..... бичгийн цаас бий.
9. Ээж..... шинэ үзэг байсан.
10. Та..... хар бал байна уу?
11. (Тэр) ..... жижиг дэвтэр байдаг.
12. Тэр оюутан..... тооны машин байна.

Дасгал 2

Өгөгдсөн үгсийг ашиглан асуулт зохиож, хариул. (Make questions using the given words and answer them.)

Жишээ нь: Та, бичих юм, байх → Танд бичих юм байгаа юу/бий юү? (Do you have something to write with?)
Надад бичих юм байхгүй. (I don't have anything to write with.)

1. Та, идэх юм, байх?
2. Та, идэх хоол, байх?
3. Чи, хэлэх юм, байх?
4. Тэр, уух юм, байх?
5. Та, асуух асуулт, байх?
6. Тэр, уух ус, байх?
7. Тэд, орчуулах текст, байх?
8. Чи, унших ном, байх?
9. Чи, хэрэглэх цаас, байх?
10. Чи, бичих үзэг, байх?

Шинэ үгс: орчуулах — to translate, хэрэглэх — to use

... -сан[4]д баярлалаа (Thank you for ...-ing)

Манайд ирсэнд баярлалаа.	Thank you for coming to my house.
Надад тусалсанд баярлалаа.	Thank you for helping me.
Гэр бүлийн минь талаар асуусанд баярлалаа.	Thank you for asking about my family.
Надад тэр тухай сануулсанд баярлалаа.	Thank you for reminding me about that.
Надад энэ талаар урьдчилж хэлсэнд баярлалаа.	Thank you for telling me about this in advance.
Утсаар ярьсанд баярлалаа.	Thank you for calling.

Дасгал 3

Өгөгдсөн нөхцөл байдалд тохируулан талархлаа илэрхийл. (Express thankfulness for each situation.)

Жишээ нь: Найз тань танай гэрт ирсэн. → Ирсэнд баярлалаа. (Thank you for coming.)

1. Найз тань танд бэлэг өгсөн.
2. Найз тань тантай хамт зах явсан.
3. Найз тань тан руу утсаар ярьсан.
4. Найз тань танд бүжиглэж үзүүлсэн.
5. Найз тань танд тусалсан.
6. Найз тань танд шинэ дуу зааж өгсөн.
7. Найз тань таныг баярт урьсан.
8. Найз тань танд дуу дуулж өгсөн.
9. Найз тань таныг хоолонд урьсан.
10. Найз тань танд сайхан кино үзүүлсэн.
11. Найз тань танд шинэ номын тухай хэлсэн.
12. Найз тань танд имэйл бичсэн.
13. Найз тань танд гоё зураг өгсөн.
14. Найз тань танд сайхан үг хэлсэн.
15. Найз тань тантай хамт ажилласан.

Шинэ үгс: утасдах — to call on the phone, урих — to invite

Дасгал 4

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. Thank you for asking.
2. Thank you for telling me this.
3. Thank you for helping me.
4. Thank you for inviting me.
5. Thank you for cooking.
6. Thank you for teaching the lesson.
7. Thank you for being with me.
8. Thank you for playing with me.
9. Thank you for trusting me.
10. Thank you for bringing the fruit.

Хорин есдүгээр хичээл

Гарахын тийн ялгал (Ablative case)

-аас[4] (from, of, than)

Би **Америкаас** ирсэн.	I came **from America**.
Хүүхдүүд **гэрээсээ** ирсэн.	The children came **from their house**.
Би **ээжээсээ** үзэг авсан.	I got a pen **from my mother**.
Би **дэлгүүрээс** дэвтэр авна.	I will buy a book **from the store**.
Тэр багшаас асуулт асуух дуртай.	He likes to ask the teacher questions.
Би нохойн**оос** айдаг.	I'm afraid **of** dogs.
Тэр найзаасаа тусламж гуйгаагүй.	She didn't ask her friend for help.
Америк **Монголоос** том.	America is bigger **than Mongolia**.
Монгол **Америкаас** жижиг.	Mongolia is smaller **than America**.

Spelling rules:

	After words with **а** or **у**	After words with **э, ү** or **и**	After words with **о**	After words with **ө**
After words ending with consonants or short vowels	**-аас**	**-ээс**	**-оос**	**-өөс**
After words ending with long vowels or diphthongs (related to people)	**-(г)аас**	**-(г)ээс**	**-(г)оос**	**-(г)өөс**
After words ending with long vowels or diphthongs (related to things)	**-(н)аас**	**-(н)ээс**	**-(н)оос**	**-(н)өөс**

For example:

ахаас	гараас	эмэгтэйгээс	модноос
эгчээс	эмээгээс	хашаанаас	ботгоноос-
охиноос	өвөөгөөс	хөдөөнөөс	жимснээс
газраас	дүүгээс	гахайнаас	үүлнээс

Note:

гөхөр + өөс = нөхрөөс	дарга + аас = даргаас	хорь + оос = хориос
хамар + аас = хамраас	бага + аас = багаас	тавь + аас = тавиас

Question pronouns and personal pronouns:

юу → юунаас	та → танаас	бид → биднээс
хэн → хэнээс	чи → чамаас	та нар → та нараас
би → надаас	тэр → түүнээс	тэд → тэднээс

Дасгал 1

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Хүүхдүүд, аав (ээж, багш, ах, эгч), олон асуулт, асуух
2. Тэд, найз (хөрш, дарга, захирал, эмээ, өвөө), тусламж, гуйх
3. Бид нар, багш (аав ээж, ах, эгч, хүүхдүүд, дарга), эмээх хэрэгтэй
4. Би, хүмүүс (найз, хүүхдүүд, хичээл, ажил, монгол хоол), залхах
5. Тэр, нохой (муур, морь, хонь, ямаа, тэмээ, үхэр), айх
6. Би, энд, ажил (гэр, байр, сургууль, ресторан, дэлгүүр), ирэх
7. Хүүхдүүд, өрөө (анги, сургууль, гэр, байшин(г), байр), гарах
8. Та, битгий, ажил (хичээл, хурал, уулзалт), хоцрох
9. Хүүхэд, машин (автобус, морь, микроавтобус), буух

Шинэ үгс: гуйх — to ask for, эмээх — to fear (out of respect), залхах — to get tired of, айх — to be afraid, хурал — official meeting, уулзалт — meeting, хоцрох — to be late for, буух — to get off

Дасгал 2

Асуултад хариул. (Answer the questions.)

Жишээ нь: Хэн хэнээс юуны тухай асуудаг вэ? (Who asks whom about what?)
Хүүхдүүд багшаасаа хичээлийн тухай асуудаг. (Children ask their teacher about lessons.)

1. Хэн хэнээс юу авдаг вэ?
2. Хэн хаанаас юу авдаг вэ?
3. Хэн хэнээс юу гуйдаг вэ?
4. Хэн хэнээс/юунаас залхдаг вэ?
5. Хэн хэнээс/юунаас айдаг вэ?
6. Хэн хэнээс эмээх хэрэгтэй вэ?
7. Хэн юунаас хоцордог вэ?
8. Хэн хаанаас ирсэн бэ?
9. Хэн юунаас болгоомжлох хэрэгтэй вэ?
10. Хэн хэнээс болгоомжлох хэрэгтэй вэ?

Шинэ үг: болгоомжлох — to be careful

Дасгал 3

Биеийн төлөөний үгсийг гарахын тийн ялгалын нөхцөлөөр хувирга. Өмнөх хүснэгтээсээ харалгүй дараагийн хүснэгтээ бөглөж бич. (Add the ablative case to the personal pronouns. Fill out the next table without looking at the previous table.)

хэн	хэнээс
Би	
Чи	
Та	
Тэр	
Бид (нар)	
Та нар	
Тэд (нар)	

хэн	хэнээс
Тэд (нар)	
Та нар	
Бид (нар)	
Тэр	
Та	
Чи	
Би	

хэн	хэнээс
Тэр	
Тэд (нар)	
Чи	
Би	
Бид (нар)	
Та нар	
Та	

Дасгал 4

Эгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. I came from America (Mongolia, my home, my work, the store, the restaurant).
2. I got the paper from my teacher (my neighbor, my parents, her, store).
3. Children are afraid of bad people (dogs, cats, goats, them).
4. Did you ask your friend (him) about that new book?
5. What time did you come from your work (your lesson) to your house?
6. I heard about Mongolia from my friend (the teacher, you).

... -аас[4] ... хүртэл (from ... to (until) ...)

Та **хэдэн цагаас** хэдэн цаг хүртэл хичээл хийдэг вэ? (**From what time** to what time do you do lessons?)
Бид 9 цагаас 12 цаг 15 минут хүртэл хичээл хийдэг. (We do lessons from 9 o'clock to 12:15.)
Бид 9-өөс 12:15 хүртэл хичээл хийдэг. (We do lessons from 9 to 12:15.)
Би эндээс Дархан хүртэл машинаар явсан. (I went from here to Darkhan by car.)

Дасгал 5

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та хэдэн цагаас хэдэн цаг хүртэл ажилладаг вэ?
2. Та хэдээс хэд хүртэл сургууль дээрээ байдаг вэ?
3. Та хэдэн сараас хэдэн сар хүртэл монгол хэл сурах вэ?
4. Та хэдэн оноос хэдэн он хүртэл сургуульд сурсан бэ?
5. Та хаанаас хаа хүртэл онгоцоор явдаг вэ?

Шинэ үг: дээрээ — at your

Дасгал 6

Эгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. I slept from 10 pm to 10 am.
2. They go to school from fall to summer.
3. That boy works from morning to night.
4. I lived in the countryside from 2003 to 2008.
5. He did his lesson from evening to morning.
6. Please translate the sentences from one to ten.
7. Please count from one to one hundred.

Шинэ үгс: 10 pm — оройн 10 цаг, 10 am — өглөөний 10 цаг

Гучдугаар хичээл

Хөндлөнгийн үг (Direct speech)

"Та багш уу?" гэж тэр надаас асуусан.	He asked me, "Are you a teacher?"
Тэр надаас "Та багш уу?" гэж асуусан.	He asked me, "Are you a teacher?"
"Тийм ээ, би багш" гэж би хариулсан.	"Yes, I'm a teacher," I replied.

Дасгал 1

Харилцаа яриа бүрт доорх загварын дагуу хөндлөнгийн үгтэй өгүүлбэр бич. (Write sentences with direct speech for each conversation as in the example.)

А. "....." гэж ..... асуух
Б. "....." гэж ..... хэлэх
В. ..... гэж ..... бодох

Жишээ нь:
Аав: — Миний хүү, хичээлээ хийсэн үү?
Хүү: — Хийсэн, аав аа.

А. "Миний хүү, хичээлээ хийсэн үү?" гэж аав хүүгээсээ асуусан.
Б. "Хийсэн, аав аа" гэж хүү аавдаа хэлсэн.
В. Энэ их сайн хүү гэж би бодож байна.

1. Ээж: — Миний хүү, өнөөдөр гэртээ эрт ирж чадах уу?
   Хүү: — Чадахгүй ээ, ээж ээ.
2. Дүү: — Эгч ээ, миний цүнх хаана байна (вэ)?
   Эгч: — Ширээн доор байна.
3. Багш: — Чи яагаад гэрийн даалгавраа хийгээгүй юм бэ?
   Оюутан: — Багш аа, би хийсэн. Харин дэвтрээ гэртээ мартчихжээ.
4. Жолооч: — Та хаашаа явах вэ?
   Жон: — Их дэлгүүр лүү явна аа.
5. Худалдагч: — Та хэдэн талх авах вэ?
   Үйлчлүүлэгч: — Хоёр хар талх авъя.
6. Охин: — Аав аа, та хэзээ надтай тоглох юм бэ?
   Аав: — Маргааш тоглоно оо.
7. Батхүү: — Чи юу идэх дуртай вэ?
   Энхмаа: — Мэдэхгүй ээ, мэдэхгүй.
8. Жаргалмаа: — Гадаа ямар байна (вэ)?
   Доржмаа: — Гадаа нартай, дулаахан байна.

Шинэ үгс: эрт — early, худалдагч — seller, үйлчлүүлэгч — customer

Дасгал 2

Эгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. My friend asked me, "Where were you?"
   I said to my friend, "I was outside."
2. My teacher asked me, "Why didn't you write your lesson?"
   I said to my teacher, "I forgot my pen at my house."
3. Bayarhuu asked Enhmaa, "Where did you play tennis?"
   Enhmaa said to Bayarhuu, "I played tennis at the school."
4. I asked her, "When did you come from the countryside?"
   She said to me, "I came from the countryside last week."
5. I asked you, "What time will you be here tomorrow?"
   You said me, "I will be here at 10 am tomorrow."

Дасгал 3

Асуултад хариул. (Answer the questions.)

-аас[4] шалтгаалах — to depend on

Жишээлбэл: Та өдөр бүр гадаа алхдаг уу?	Do you walk outside everyday?
— **Цаг агаараас** шалтгаалдаг.	— It depends **on the weather**.
— Сэтгэл санаанаас шалтгаалдаг.	— It depends on how I feel.

Яаг яагаад заримдаа удаан, заримдаа хурдан өнгөрдөг вэ?
Why does time sometimes go fast and sometimes go slow?

— Юу хийж байгаагаас шалтгаалдаг.	— It depends on what we are doing.
— Хаана байгаагаас шалтгаалдаг.	— It depends on where we are.

1. Хүүхдүүд өдөр бүр гадаа тоглодог уу?
2. Бүх хүн хэл хурдан сурдаг уу?
3. Та шөнө бүр сайн унтдаг уу?
4. Та бүх хоолыг идэж чадах уу?
5. Танай улсад бүх хоол үнэтэй юү?
6. Та өдөр бүр завгүй байдаг уу?
7. Гадаад улсад амьдрах амархан уу?
8. Та бүх мөнгөл хүний яриаг ойлгодог уу?
9. Та дандаа сайхан зүйл боддог уу?
10. Та ер нь баяр хөөртэй байдаг уу?
11. Хүмүүс дандаа хөдөө явдаг уу?
12. Зарим хүүхэд яагаад сайн, зарим хүүхэд яагаад муу байдаг вэ?
13. Ямар нэг шашинд итгэдэг бүх хүн сайн зүйл хийдэг үү?

Шинэ үгс: улс — country, яриа — speech/talking, баяр хөөртэй — joyful, шашин — religion, зүйл — thing

Давтлага хичээл

Дасгал 1

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Томчууд яагаад ажил хийх хэрэгтэй вэ?
2. Хүмүүс яагаад хоол идэх хэрэгтэй вэ?
3. Хүүхдүүд яагаад сургуульд сурах хэрэгтэй вэ?
4. Та юу хийх хэрэгтэй вэ? Танд юу юу хэрэгтэй/хэрэггүй вэ?
5. Хүүхдүүдэд юу юу хэрэгтэй/хэрэггүй вэ?
6. Оюутнуудад юу хэрэгтэй вэ?
7. Эрэгтэйчүүдэд юу юу хэрэгтэй/хэрэггүй вэ?
8. Эмэгтэйчүүдэд юу юу хэрэгтэй/хэрэггүй вэ?

Дасгал 2

"Хийх" гэдэг үйл үгийг ашиглан өгөгдсөн нөхцөл байдалд тохирсон зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation using the verb "хийх.")

Жишээ нь: Надад мах байна. → Махаа хөргөгчинд хий.

1. Миний гарт мөнгө байна.
2. Надад ном, дэвтэр байна.
3. Түүнд гар утас байна.
4. Тэд нарт чихэр байна.
5. Надад талх байна.
6. Надад үзэг, харандаа, бал байна.
7. Ширээн дээр аяга, таваг байна.
8. Хүүхэд хувцаснуудаа барьж байна.
9. Сандал дээр тоглоом байна.
10. Би дэлгүүрээс олон юм авч байна.

Дасгал 3

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Гэрт чинь ирсэн найздаа та юу гэж хэлэх вэ?
2. Хичээл заасан багшдаа та юу гэж хэлэх вэ?
3. Өөрт чинь тусалсан найздаа (та) юу гэж хэлэх вэ?
4. Өөрт чинь хоол хийж өгсөн найздаа та юу гэж хэлэх вэ?
5. Таныг гэртээ урьсан найздаа (та) юу гэж хэлэх вэ?
6. Өөртэй чинь хамт ажилласан найздаа (та) юу гэж хэлэх вэ?
7. Тантай хамт дэлгүүр лүү явсан найздаа юу гэж хэлэх вэ?
8. Гэр бүлийн тань талаар асуусан найздаа юу гэж хэлэх вэ?
9. Өөрт чинь бэлэг өгсөн найздаа та юу гэж хэлэх вэ?

Шинэ үгс: өөрт чинь — to you, өөртэй чинь — with you

Дасгал 4

Өгөгдсөн нөхцөл байдлуудад тохирсон зөвлөгөөг өг. (Give advice that suits each situation.)

1. Би дандаа найзаасаа мөнгө, тусламж гуйдаг.
2. Би хүмүүсээс тусламж гуйх дургүй. Бүх юмыг ганцаараа хийдэг.
3. Би хүмүүсээс ерөөсөө уучлалт гуйдаггүй.
4. Би хүмүүсээс айдаг учраас хүмүүстэй байх дургүй.
5. Би бүх юмнаас залхаж байна.
6. Би ер нь хичээл, хурал, уулзалтаад тав, арван минут хоцордог.
7. Би машинаас айдаггүй.

Дасгал 5

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та хэдэн цагаас хэдэн цаг хүртэл хичээл хийдэг вэ?
2. Та хэдэн цагаас хэдэн цаг хүртэл унтдаг вэ?
3. Та хэдэн сараас хэдэн сар хүртэл монгол хэл сурах вэ?
4. Та гэрээсээ сургууль хүртэл хэдэн минут явдаг вэ?
5. Та өглөөнөөс орой хүртэл хичээлээ хийдэг үү?

Дасгал 6

Харилцаа яриа бүрт хөндлөнгийн үгтэй өгүүлбэр бич. Мөн харилцаа яриа бүр дээр тэр хүмүүсийн талаар юу бодож байгаагаа бич. (Write sentences with direct speech for each conversation. Also write what you think about the people in each conversation.)

1. Анхмаа: — Чи надаас уучлалт гуйхгүй юм уу?
   Базархүү: — Үгүй. Чи надаас уучлалт гуйдаггүй.
2. Галхүү: — Чи надад хоол хийсэн үү?
   Одмаа: — Хийсэн. Миний найз, хоолоо ид.
3. Хүү: — Ээж ээ, надтай хамт тоглоорой.
   Ээж: — Ээж нь завгүй байна.
4. Нөхөр: — Өнөөдөр ядарсан уу? Би хоол хийсэн.
   Эхнэр: — Баярлалаа, би их ядарсан.
5. Эмээ: — Миний хүү, энэ автобус хаашаа явах вэ?
   Хүү: — Мэдэхгүй ээ, мэдэхгүй.
6. Ах: — Чи тэр хүнээс айгаад байгаа юм уу?
   Дүү: — Харин тийм ээ.
7. Гэрэлмаа: — Чи гэрийн даалгавраа хийсэн үү?
   Болдхүү: — Чамд хамаагүй.

Шинэ үг: Чамд хамаагүй. — You don't care. (It is not your business.)

Дасгал 7

Асуух төлөөний үгсийн оронд тохирох үгийг бичиж, асуултад хариул. (Answer the questions by replacing question pronouns with appropriate words.)

Жишээлбэл: Хэн хэний хэнтэй юу үзсэн бэ?
Би таны эгчтэй кино үзсэн.

1. Хэн хэзээ хэдэн цагт хэнтэй хаана юу идсэн бэ?
2. Хэн хэдэн удаа юу хийх хэрэгтэй вэ?
3. Хэнд юу хэрэгтэй вэ?
4. Хэн хэнтэй хаана хэдэн цаг юуны тухай ярьсан бэ?
5. Хэн юунд дуртай вэ?
6. Хэн хэнээс юу гуйсан бэ?
7. Хэн хэнтэй хэдэн удаа юу тоглодог вэ?
8. Хэн хэдэн оны хэдэн сарын хэдэнд төрсөн бэ?
9. Хэн хэзээ юунаас айсан бэ?
10. Хэн хэзээ хаанаас ирсэн бэ?
11. Хэн хэнд ямар юу авсан бэ?
12. Хэн хэнд ямар юу заадаг вэ?

Дасгал 8

Үгийн сүлжээг бөглө. (Fill out the crossword puzzle.)



Across

1. to die
2. hospital
3. hand
4. stomach
5. ear
6. mouth
7. body
8. to have a fever
9. doctor
10. finger
11. to get sick

Down

1. head
2. face
3. tongue
4. back
5. to be healed
6. eye
7. to treat
8. to cough
9. leg
10. hair
11. nose

Тест

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. People need food.
   А. Хүмүүс хоол хэрэгтэй.
   Б. Хүмүүст хоол хэрэгтэй.
   В. Хүмүүс хоолонд хэрэгтэй.

2. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Хүүхдүүд амрах хэрэгтэй.
   Б. Хүүхдүүдэд амрах хэрэгтэй.
   В. Хүүхдүүдэнд амрах хэрэгтэй.

3. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Эрэгтэйчүүдэд тамхи хэрэггүй.
   Б. Эрэгтэйчүүд тамхи хэрэггүй.
   В. Эрэгтэйчүүд тамхинд хэрэггүй.

4. I have a book.
   А. Би ном байгаа.
   Б. Би номонд байгаа.
   В. Надад ном байгаа.

5. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Ирсэнд баярлалаа.
   Б. Ирсэн баярлалаа.
   В. Ирэх баярлалаа.

6. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Туслах баярлалаа.
   Б. Тусалсанд баярлалаа.
   В. Тусалсан баярлалаа.

7. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Би нохой айдаг.
   Б. Би нохойнд айдаг.
   В. Би нохойноос айдаг.

8. He asked his friend for help.
   А. Тэр найзаасаа тусламж гуйсан.
   Б. Тэр найздаа тусламж гуйсан.
   В. Тэр найзтайгаа тусламж гуйсан.

9. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Сурагч багшдаа асуулт асуудаг.
   Б. Сурагч багшаа асуулт асуудаг.
   В. Сурагч багшаасаа асуулт асуудаг.

10. Аль нь зөв бэ? Which one is right?
    А. "Баярлалаа" гэж охин ээждээ хэлсэн.
    Б. "Баярлалаа" охин гэж ээждээ хэлсэн.
    В. Охин "Баярлалаа" ээждээ гэж хэлсэн.

11. Аль нь зөв бэ? Which one is right?
    А. Тэр сайн хүн би гэж бодож байна.
    Б. Тэр сайн хүн гэж би бодож байна.
    В. Тэр сайн хүн гэж бодож би байна.

12. Аль нь зөв бэ? Which one is right?
    А. Би багшаас "Энэ юу вэ?" гэж асуусан.
    Б. Би "Энэ юу вэ?" багшаас гэж асуусан.
    В. Багшаас "Энэ юу вэ?" би гэж асуусан.

13. Enhmaa put her hand phone in her purse.
    А. Энхмаа гар утсаа цүнхэнд нь хийсэн.
    Б. Энхмаа гар утсаа цүнхэндээ хийсэн.
    В. Энхмаа гар утсаа цүнхээ хийсэн.

14. Put your money in your wallet.
    А. Мөнгөө түрийвчинд хий.
    Б. Мөнгөө таны түрийвчинд хий.
    В. Мөнгөө түрийвчиндээ хий.

15. She has a pen.
    А. Түүнд үзэг байна.
    Б. Тэр үзэг байна.
    В. Түүнд үзэгтэй байна.

16. It depends on the weather.
    А. Цаг агаарт шалтгаалдаг.
    Б. Цаг агаараас шалтгаалдаг.
    В. Цаг агаар дээр шалтгаалдаг.

Оноо (point): 16/.....

Гучин нэгдүгээр хичээл

Харьцуулсан зэрэг (Comparative)

өндөр (tall)	нам(хан) (short)
хөгшин (old (people and living things))	залуу (young)
тарган (fat)	туранхай (thin)
өргөн (wide)	нарийн (narrow)
хол (far)	ойр(хон) (near)
сонирхолтой (interesting)	сонирхолгүй (uninteresting)
адил(хан) (same)	өөр (different)
зөв (right)	буруу (wrong)
үнэн (true)	худал (not true/false)
хурдан (fast)	удаан (slow)
урт (long)	богино (short)
хүчтэй (strong)	сул (weak)
хатуу (hard)	зөөлөн (soft)

Жаргалмаа **Ганхүүгээс** өндөр.	Jargalmaa is taller **than Ganhuu**.
Ганхүү **Жаргалмаагаас** намхан.	Ganhuu is shorter **than Jargalmaa**.

Дасгал 1

Өгөгдсөн тэмдэг нэрсийг ашиглан хүн, мал, юмсыг хооронд нь харьцуул. (Compare people, livestock, and things using the given adjectives.)

1. Гахай, ямаа (тарган, туранхай)
2. Аав, ээж (хатуу, зөөлөн)
3. Тэмээ, ямаа (өндөр, намхан)
4. Миний ном, таны ном (хуучин, шинэ)
5. Монгол хэл, англи хэл (хэцүү, амархан)
6. Онгоц, машин (хурдан, удаан)
7. Даавуу, цаас (зөөлөн, хатуу)
8. Монгол хоол, солонгос хоол (үнэтэй, хямд)
9. Миний үс, таны үс (урт, богино)
10. Гэр, байшин (дулаан, сэрүүн)
11. Ази хүмүүс, европ хүмүүс (жижиг, том)
12. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд (хүчтэй, сул)

Шинэ үг: даавуу — cotton

Дасгал 2

Доорх жишээ өгүүлбэрт бичсэний адилаар хүн болон юмсыг харьцуул. (Compare people and things as in the examples given below.)

Жишээ:
Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс өөр. (Men are different than women.)
Монголчууд японучуудтай адилхан хар үстэй. (Mongolians have black hair same as Japanese.)
Монголчууд солонгосчууд шиг хар үстэй. (Mongolians have black hair like Koreans do.)

1. Ази хүмүүс, европ хүмүүс
2. Монголчууд, америкчууд
3. Томчууд, хүүхдүүд
4. Хонины мах, үхрийн мах
5. Монгол гэр, байр
6. Пицца, талх
7. Өдөр, шөнө
8. Шоколад, чихэр
9. Чихэр, давс
10. Цамц, өмд
11. Хар цай, сүүтэй цай
12. Англи хэл, монгол хэл

Дасгал 3

Доорх зургуудыг хараад хүн, юм, амьтдыг харьцуулж бич. (Look at the pictures below and compare people, things, and animals.)



Давуу зэрэг (Superlative)

Хамгийн (~est/most)

хамгийн сайн	best	хамгийн хүйтэн	coldest
хамгийн муу	worst	хамгийн үнэтэй	most expensive
хамгийн том	biggest	хамгийн чухал	most important
хамгийн жижиг	smallest	хамгийн дуртай	like the most (favorite)

Дасгал 4

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Танай улсын хамгийн өндөр байшин хэдэн давхар вэ?
2. Танай улсын хамгийн өндөр уул ямар уул вэ?
3. Танай улсын хамгийн алдартай хүмүүс хэн хэн бэ?
4. Хамгийн үнэтэй (чухал, муу) юм юу вэ?
5. Ямар хүн хамгийн сайн (муу) хүн бэ?
6. Хамгийн амттай (муухай) хоол юу вэ?
7. Америкт хамгийн үнэтэй юм юу вэ?
8. Хамгийн хэрэггүй юм юу вэ?

Шинэ үгс: алдартай — famous, чухал — important

Дасгал 5

Асуултад хариул. (Answer the questions.)

Жишээ нь: Таны хамгийн дуртай хоол ямар хоол вэ? → Миний хамгийн дуртай хоол пицца.

1. Таны хамгийн дуртай хоол ямар хоол вэ?
2. Таны хамгийн дуртай спорт ямар спорт вэ?
3. Таны хамгийн дуртай юм юу вэ?
4. Таны хамгийн дургүй хоол ямар хоол вэ?
5. Таны хамгийн дуртай ундаа ямар ундаа вэ?
6. Таны хамгийн дургүй юм юу вэ?
7. Таны хамгийн дуртай улирал ямар улирал вэ?
8. Таны хамгийн дуртай ном ямар ном бэ?
9. Таны хамгийн дургүй кино ямар кино вэ?
10. Таны хамгийн дуртай кино ямар кино вэ?
11. Таны хамгийн дургүй улирал ямар улирал вэ?

Гучин хоёрдугаар хичээл

-ж/-ч чадах (to be able to)

— Та морь унаж чадах уу?
— Тийм, (би морь унаж) чадна.
— Үгүй, (би морь унаж) чадахгүй.

— Та морь унаж чаддаг уу?
— Тийм, (би морь унаж) чаддаг.
— Үгүй, (би морь унаж) чаддаггүй.

— Can you ride a horse?
— Yes, I can (ride a horse).
— No, I can't (ride a horse).

— Can you ride a horse?
— Yes, I can (ride a horse).
— No, I can't (ride a horse).

Дасгал 1

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та теннис тоглож чадах уу?
2. Та усанд сэлж чаддаг уу?
3. Та монгол хэл зааж чадах уу?
4. Та ганцаараа харьж чадах уу?
5. Та найздаа тусалж чадах уу?
6. Та хаана амьдарч чадахгүй вэ?
7. Та юу юу хийж чаддаг вэ?
8. Та юу юу хийж чаддаггүй вэ?
9. Та монгол хоол хийж чадах уу?
10. Та солонгос хоол идэж чаддаг уу?
11. Та олон үг нэг дор цээжилж чадах уу?
12. Тэр монгол текст орчуулж чадах уу?
13. Та ямар ямар хоол хийж чаддаг вэ?
14. Та таван цагт энд ирж чадах уу?
15. Та надтай хамт хөдөө явж чадах уу?
16. Та хүүхдүүдэд юу юу зааж чадах вэ?
17. Та 10 хоног хоолгүй байж чадах уу?
18. Та 4 хоног усгүй байж чадах уу?

Шинэ үгс: сэлэх — to swim, харих — to go home, нэг дор — at once, цээжлэх — to memorize

Дасгал 2

Өгүүлбэрийг орчуулаад асуулт зохио. (Translate the sentences, then make questions.)

1. I can cook Mongolian food.
2. They can sing very well.
3. She can't dance very well.
4. I can ride a horse.
5. We can drive a car.
6. He can build a house.
7. I can catch a fish.
8. I can't eat Mongolian food.
9. She can meet you tomorrow.
10. She can make a Mongolian deel.
11. I can live here.
12. She can come tomorrow.
13. I can't help him.
14. They can't come here at 8 o'clock.
15. I can't meet him tomorrow.
16. They can eat Mongolian food.
17. You can learn Mongolian very well.
18. She can help you.

Дасгал 3

Асуулт бүрт гурваас доошгүй хариулт бич. (Write at least three answers for each question.)

	... юу юу хийж чаддаг вэ?	... юу юу хийж чаддаггүй вэ?
6 сартай хүүхэд		
3 настай хүүхэд		
7 настай хүүхэд		
18 настай хүүхэд		
Том хүн		
Нохой		
Шувуу		
Морь		
Монголчууд		
Америкчууд		

Шинэ үг: шувуу — bird

Уучлал гуйх (To ask for forgiveness)

А: — Уучлаарай.
Б: — Зүгээр (зүгээр).

— Намайг уучлаарай.
— Ёстой уучлаарай.
— Үнэхээр уучлаарай.
— Хоцорсонд уучлаарай.
— Ирж чадаагүйд уучлаарай.
— Уучлаарай, мартчихжээ.

A: — Excuse me/Sorry.
B: — No problem.

— Please forgive me.
— I'm very sorry.
— I'm really sorry.
— Sorry for being late.
— Sorry for not being able to come.
— Sorry, I forgot about it.

Гучин гуравдугаар хичээл

-ж/-ч болох (May)

— Танаас асуулт асууж болох уу?
— Тийм, (та асуулт асууж) болно.
— Үгүй, (та асуулт асууж) болохгүй.
— Энд сууж болох уу?
— Болно оо, болно.

— May I ask you a question?
— Yes, you may (ask question).
— No, you may not (ask question).
— May I sit here?
— Yes, you may.

Дасгал 1

Асуултад хариул. (Answer the questions.)

1. (Би)[27] орж болох уу?
2. (Би) ангид орж болох уу?
3. Би энд байж болох уу?
4. Би өнөөдөр амарч болох уу?
5. (Би) энэ цайг ууж болох уу?
6. (Би) энэ номыг авч болох уу?
7. (Би) энэ хоолыг идэж болох уу?
8. (Би) танд нэг юм хэлж болох уу?
9. Танаас нэг юм асууж болох уу?
10. Бид нар ангиас гарч болох уу?
11. Би одоо гэр лүүгээ явж болох уу?
12. Хүүхдүүд ангид унтаж болох уу?
13. Би танай нохойг хооллож болох уу?
14. Би сургуульд хоол авчирч болох уу?
15. (Би) энэ сандал дээр сууж болох уу?
16. Би ангид нохой авчирч болох уу?
17. (Би) танайд дахиад ирж болох уу?
18. Би өнөөдөр хоол хийж болох уу?
19. Би танай гэрт амьдарч болох уу?
20. Би тантай хөдөө явж болох уу?

Шинэ үгс: хонох — to spend a night, хооллох — to feed

Дасгал 2

Эгүүлбэрийг орчуулж, асуулт зохио. (Translate the sentences and make questions.)

1. You may come in.
2. You may ask questions.
3. You may sit here.
4. You may leave now.
5. You may play now.
6. She may come tomorrow.
7. You may trust him.
8. You may teach Mongolian.
9. They may live here.
10. You may open the window.
11. You may close the door.
12. He may go with us.
13. She may cook tonight.
14. They may rest now.
15. They may eat now.
16. They may ride a horse tomorrow.

[27] If it is clear from context that you are going to do something, then we don't have to say "Би."

Дасгал 3

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. Can you ride a horse?
2. Can you drive a car?
3. May I ask you a question?
4. Can you build a house?
5. Can you catch a fish?
6. May I come in?
7. He can work next week.
8. I can't help her.
9. May I leave now?
10. "I can wait for you" she said to me.
11. Can you call me tomorrow?
12. May she play now?
13. I can't come to my lesson tomorrow.
14. May I sit here?
15. Can you hold this piece of wood?
16. May I speak in Mongolian now?
17. "I can't cook Mongolian food," she said.
18. She can play games with us tomorrow.

Дасгал 4

Асуулт бүрт гурваас доошгүй хариулт бич. (Write at least three answers for each question.)

	... юу юу өгч болох вэ?	... юу юу өгч болохгүй вэ?
6 сартай хүүхдэд		
3 настай хүүхдэд		
7 настай хүүхдэд		
18 настай хүүхдэд		
Том хүнд		

Дасгал 5

Асуулт бүрт гурваас доошгүй хариулт бич. (Write at least three answers for each question.)

	... юу юу хийж болох вэ?	... юу юу хийж болохгүй вэ?
Гэрт		
Эмнэлэгт		
Ангид		
Автобусанд		
Гадаа		
Гадаад хүмүүс Монголд		

Гучин дөрөвдүгээр хичээл

байх аа — probably, I think
магадгүй — maybe
юм шиг байна — It looks (seems, sounds, feels) like

Энхмаа хоол	хийх **байх аа**.	**Probably** Enhmaa	will cook.
	хийдэг байх аа.		cooks.
	хийж байгаа байх аа.		is cooking.
	хийх дуртай байх аа.		likes to cook.
	хийсэн байх аа.		cooked.
	хийгээгүй байх аа.		didn't cook.
Энхмаа хоол	хийх **юм шиг байна**.	**It looks like** Enhmaa	will cook.
	хийдэг юм шиг байна.		cooks.
	хийж байгаа юм шиг байна.		is cooking.
	хийх дуртай юм шиг байна.		likes to cook.
	хийсэн юм шиг байна.		cooked.
	хийгээгүй юм шиг байна.		didn't cook.
Энхмаа хоол	хийж **магадгүй**.	**Maybe** Enhmaa	will cook.
	хийдэг байж магадгүй.		cooks.
	хийж байгаа байж магадгүй.		is cooking.
	хийх дуртай байж магадгүй.		likes to cook.
	хийсэн байж магадгүй.		cooked.
	хийгээгүй байж магадгүй.		didn't cook.

Тийм байх аа.	I think so/Probably so.
Үгүй байх аа.	I don't think so/Probably not.
Тийм юм шиг байна.	It seems/looks so.
Үгүй юм шиг байна.	It seems/looks not.
Тийм байж магадгүй.	Maybe so.
Үгүй байж магадгүй.	Maybe not.

Тийм ч байж магадгүй, үгүй ч байж магадгүй. — Maybe so, maybe not.

Тэр ирсэн ч байж магадгүй, үгүй ч байж магадгүй. — Maybe he came, maybe not.
Тэр ирсэн ч байж магадгүй, ирээгүй ч байж магадгүй. — Maybe he came, maybe not.

Дасгал 1

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохиож, "байх аа, магадгүй, юм шиг байна"-ыг ашиглан өгүүлбэр бүрийг гурван янзаар бич. (Make sentences using the given words and write down three different sentences for each sentence using "байх аа, магадгүй, юм шиг байна.")

1. Гадаа, бороо орох
2. Гадаа, хүйтэн байх
3. Гадаа, халуун байх
4. Найз, жимс, идэх дуртай
5. Тэр хүн, сайн хүн
6. Тэр, монгол хүн
7. Тэр, гадаад хэл, хурдан сурах
8. Тэр, өвдөх
9. Та, Монгол, хурдан дасах
10. Тэр хүн, 50 настай
11. Та, амрах хэрэгтэй
12. Хүүхэд, ядрах
13. Тэр багш, их уурлах
14. Тэр, их инээх
15. Хүүхдүүд, гайхах
16. Тэр хүн, тэр, итгэх

Шинэ үгс: дасах — to get used to, инээх — to laugh, гайхах — to be suprised

Дасгал 2

Өгүүлбэрийг уншаад юуны тухай өгүүлж байгааг тааж, багштайгаа ярилц. (Read the sentences and guess what is being talked about, then discuss with your teacher.)

Жишээ нь: Тэр юм том, дотор нь хүмүүс амьдардаг.
Гэр байх аа. Эсвэл байшин байж магадгүй. (Байр юм шиг байна.)

1. Тэр юм их халуун, маш их том, шар өнгөтэй, гадаа байдаг.
2. Тэр амьтан том, их сүүтэй, гадаа амьдардаг.
3. Тэр юмыг модоор, төмрөөр хийдэг. Тэр юмаар хүмүүс хоол иддэг.
4. Хүмүүст тэр юм их хэрэгтэй. Тэр юм байхгүй бол хүн амьдарч чадахгүй.
5. Хүмүүс тэр амьтанд хайртай. Тэр амьтан хүний сайн найз байж чаддаг.
6. Тэр юм явдаг. Хүмүүс тэр юмаар ийшээ тийшээ явдаг.
7. Бүх хүнд тэр юм байдаг. Тэр юм янз янзын өнгөтэй.
8. Тэр юмыг цаасаар хийдэг. Хүмүүс тэр юмнаас олон юмыг мэдэж авдаг.

Шинэ үгс: амьтан — animal, янз янзын — different kinds of

Дасгал 3

Багш нэг уутанд янз бүрийн юм (амьтны дүрстэй хүүхдийн жижиг тоглоомууд, бичгийн хэрэгсэл гэх мэт) хийгээд оюутанд өгнө. Оюутан харалгүй уутанд гараа оруулж, нэг нэгээр барьж үзээд юу болохыг нь таана. (The teacher will put different things (maybe children's small animal toys, stationery items, etc.) in a bag and will give the bag to the student. The student will put his/her hand into the bag without looking, feel the objects one by one and guess what each one.)

Дасгал 4

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Маргааш цаг агаар ямар байх вэ?
2. Ирэх өвөл хүйтэн болох уу?
3. Гучин жилийн дараа дэлхийн цаг агаар ямар байх вэ?
4. Та таван жилийн дараа ямар ажил хийж байх вэ?
5. Та арван жилийн дараа хаана байх вэ?
6. Таны амьдрал хорин жилийн дараа ямар байх вэ?
7. Таны хамгийн сайн найз яг одоо хаана байгаа вэ?
8. Багшийн цүнхэнд яг одоо юу юу байгаа вэ?

Дасгал 5

Багштэйгээ үгсийг (байх аа, магадгүй, юм шиг байна) ашиглан доорх зурган дээр байгаа хүмүүсийн талаар багштайгаа ярилц. (Talk with your teacher about the people who are in the pictures below using "байх аа, магадгүй, юм шиг байна.")

Ресторанд (At the restaurant)

— Зөөгч өө!
— Энэ ширээ хүнтэй юү?
— Пицца байгаа юу?
— Сайхан хооллоорой.
— Тооцоогоо хийе.
— Хариулт хэрэггүй.
— Танай ноль хаана байдаг юм бэ?

— Waiter!
— Is this table free?
— Do you have pizza?
— Good appetite.
— Bill please.
— Keep the change.
— Where is your toilet?

Гучин тавдугаар хичээл

Үйл үгийн -аад[4] нөхцөл (Verb suffix -аад[4])

Verb stem +аад[4] (then, and)

Би хоол идсэн. **Дараа нь** жаахан амарсан.	I ate food. Then I rested a little bit.
Би хоол идээд жаахан амарсан.	I ate food, then I rested a little bit.
Би гэртээ очоод гэрээ цэвэрлэнэ.	I will go home and clean my house.

Sentences which are connected with the suffix "-аад[4]" in compound sentences have to have the same subjects and tenses. For example:

Би хоол идээд жаахан амарна.	I will eat food, then I will rest a little bit.
Би хоол идээд жаахан амардаг.	I eat food, then I rest a little bit.
Чи хоол идээд жаахан амраарай.	Please eat food, then rest a little bit.
Би хоол идээд жаахан амармаар байна.	I want to eat food, then rest a little bit.

Spelling rules:

	After verb stems with **а, у** or **я**	After verb stems with **э, ү** or **и**	After verb stems with **о**	After verb stems with **ө**
After verb stems ending with consonant or short vowels	**-аад**	**-ээд**	**-оод**	**-өөд**
After verb stems ending with long vowels or diphthongs	**-(г)аад**	**-(г)ээд**	**-(г)оод**	**-(г)өөд**

For example: яваад, аваад, уугаад, хэлээд, ирээд, үзээд, ороод, өгөөд

Note:

- If the last letters of a stem are **cvc**, the vowel in between the two consonants is dropped when we add this suffix. For example: амар + аад = амраад, эхэл + ээд = эхлээд.
- If a verb stem ends with a short vowel, the short vowels are dropped when we add -аад[4]. For example: ажилла + аад = ажиллаад, тогло + оод = тоглоод.
- If a verb stem ends with the soft sign, the soft sign become и and one of the long vowel is dropped when we add -аад[4]. For example: барь + аад = бариад, боль + оод = болиод.

Дасгал 1

Доорх үйл үгст -аад[4] нөхцөл залгаж бич. (Add the suffix -аад[4] to the verbs below.)

1. хар
2. үз
3. ав
4. нээ
5. хаа
6. хоолло
7. ажилла
8. барь
9. хий
10. мэд
11. гуй
12. өвд

Дасгал 2

Өгүүлбэрүүдийг "-аад⁴" нөхцөлийг ашиглан нийлмэл өгүүлбэр болго. (Make compound sentences using the suffix "-аад⁴.")

Жишээ нь:
Би гэртээ номоо хайсан. Би номоо олоогүй. I looked for my book at my house. I didn't find my book.
Би гэртээ номоо хайгаад олоогүй. I looked for my book at my house and couldn't find it.

1. Хүүхдүүд сургуулиас гарсан. Хүүхдүүд гүйсэн.
2. Хүүхдүүд гэрт орно. Хүүхдүүд халууцна.
3. Та нэг монгол үлгэр уншаарай. Та монголоор яриарай.
4. Та өгүүлбэр бичих хэрэгтэй. Та өгүүлбэрээ орчуулах хэрэгтэй.
5. Оюутан гэрийн даалгавраа хийсэн. Оюутан унтсан.
6. Тэр ээжийгээ харсан. Тэр уйлсан.
7. Тэр захиа бичмээр байна. Тэр захиагаа найздаа өгмөөр байна.
8. Тэр их уурласан. Тэр надтай яриагүй.
9. Тэр найздаа уурласан. Тэр ангидаа хичээлээ хийгээгүй.
10. Би түүний захиаг уншсан. Би их инээсэн.
11. Би нөгөөдөр үдээс хойш сургууль дээр ирнэ. Би багштай уулзана.
12. Тэр хөдөө явна. Тэр олон сонирхолтой юм үзнэ.
13. Чи манай гэрт ирж болно. Чи надтай хамт хичээл хийж болно.
14. Чи одоо текстээ орчуулж болно. Чи одоо амарч болно.
15. Чи найзынхаа гэр лүү явж чадна. Чи найздаа тусалж чадна.

Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан нийлмэл өгүүлбэр зохио. (Make compound sentences using the given words.)

Жишээ нь:
Багш, анги, орох; хүүхдүүд, уулзах; олон, сонирхолтой юм, ярих
Багш ангид ороод хүүхдүүдтэй уулзаад сонирхолтой юм ярьсан.

1. Тэр, манай гэр, ирэх; манай ах, уулзах; нэг ном, өгөх; явах
2. Би, өчигдөр, өглөө, босох; нүүр гар, угаах; өглөөний цай, уух; банк, явах
3. Тэд, гэр, ирэх; хоол, хийх; идэх; аяга таваг, угаах; зурагт, үзэх
4. Чи, маргааш, энд, ирэх; ном, авах; сургууль, явах; багш, өгөх
5. Чи, сургууль, төгсөх; ажил хийх; мөнгө, олох; машин, авах
6. Би, зах, явах; мах авах; гэр, ирэх; хоол хийх; идэх
7. Чи, найз, гэр, очих; уучлалт гуйх; найз, ярих
8. Тэр, энэ, сав, угаах; арчих; ширээ, дээр, тавих
9. Сурагчид, анги, орох; ширээ, суух; хичээл, хийх
10. Долгормаа, гэр, ирэх; найз, уулзах; их, баярлах

Шинэ үг: арчих — to wipe

Дасгал 4

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь:
When she saw her mother, she was happy. → Тэр ээжийгээ хараад баярласан.
She saw her mother and was happy. → Тэр ээжийгээ хараад баярласан.

1. She found her pen and she was happy. (When she found her pen, she was happy.)
2. He met his friend and he was surprised.
3. When he comes home, he will be surprised.
4. When I found out about that, I got angry.
5. When they heard about their friend, they got angry.
6. When she sees this, she will laugh.
7. When I watched the movie, I didn't laugh.
8. When the little boy fell down, he cried.
9. When she gets the gift, she will be happy.
10. I read the book and laughed.
11. When you go in the house, please don't get angry.
12. When you go in the house, please don't be suprised.
13. When you go in the house, please don't laugh.

Шинэ үгс: to find — олох, to cry — уйлах, dishes (cup and plate) — аяга таваг, to find out — олж мэдэх

Note: In complex sentences using "when" or "and" and with words that express emotions, first verbs use -аад[4].

Дасгал 5

Доорх зургуудыг хараад Ганхүүд юу тохиолдсоныг -аад[4] нөхцөлийг ашиглан бич. (Look at the pictures below and write what happened to Ganhuu using the suffix -аад[4].)

Дасгал 6

Доорх өгүүлбэрүүдийн дугаарыг тохирох зургийнх нь доор тавь. Дараа нь тэр хүн яагаад инээж байгааг -аад[4] нөхцөлийг ашиглан бич. (Write the numbers of the sentences below under the appropriate pictures. Then write why he is acting this way using the suffix -аад[4].)



1. Энэ хүн баярлаж байна.
2. Энэ хүн айж байна.
3. Энэ хүн гайхаж байна.
4. Энэ хүн сайхан юм бодож байна.
5. Энэ хүний нэг юм нь өвдөж байна.
6. Энэ хүн уйлж байна.
7. Энэ хүн уурлаж байна.
8. Энэ хүн нэг юманд анхаарч байна.
9. Энэ хүн архи их уусан байна.
10. Энэ хүн инээмсэглэж байна.

Шинэ үгс: анхаарах — to pay attention, инээмсэглэх — to smile

Автобусанд (In the bus)

А: — Энэ автобус зах руу явах уу?
Б: — Явна аа.
А: — (Автобус) одоо хаана ирж байна?
Б: — Багшийн дээд сургууль дээр.
А: — Та ийшээ суу.
Б: — Баярлалаа.
А: — Дараагийн буудал дээр бууна шүү.
— Та одоо буух уу?
Б: — Буухгүй.
А: — Зөрчихье. [zörchii]
Б: — За.

A: — Does this bus go to the open market?
B: — Yes, it does.
A: — What bus stop are we coming to?
B: — At the Teacher's University.
A: — You (please) sit here.
B: — Thank you.
A: — I want to get off at the next stop.
— Are you going to get off now?
B: — I won't get off.
A: — Let me pass.
B: — Okay.

Давтлага хичээл

Дасгал 1

Хүн, юмсыг харьцуулж бич. (Compare people and things, then write about them.)

1. монголчууд, америкчууд
2. эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд
3. өвөл, хавар
4. үхрийн мах, хонины мах
5. такси, автобус
6. монгол гэр, байр
7. монгол хэл, англи хэл
8. өчигдөр, өнөөдөр
9. өнгөрсөн жил, энэ жил
10. өдөр, шөнө
11. концерт, кино
12. Улаанбаатар, Дархан

Дасгал 2

Асуултыг орчуулж, хариул. (Translate the questions and answer them.)

1. What is the most important thing?
2. What is the most interesting thing?
3. What is the most expensive thing?
4. What is the most difficult thing?
5. What is the worst thing?
6. What is your favorite season?
7. What is your favorite sport game?
8. What are your favorite clothes?
9. What thing don't you like the most?
10. What food don't you like the most?

Дасгал 3

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та юу юу хийж чаддаг/чаддаггүй вэ?
2. Танай эхнэр/нөхөр/найз юу хийж чаддаг вэ?
3. Таван настай хүүхэд юу юу хийж чаддаг вэ?
4. Ерэн таван настай хүн юу юу хийж чаддаггүй вэ?

Дасгал 4

"Болох" үйл үгийг ашиглан өгөгдсөн нөхцөл байдлуудад тохируулан асуулт асуу. (Ask questions suitable to each situation using the verb "болох.")

1. Та өрөөнд орох хэрэгтэй байна.
2. Та ус уумаар байна. Гэрийн эзнээс гуйгаарай.
3. Банкинд нэг хүний хажууд сандал байна. Та тэр сандал дээр суумаар байна.
4. Та одоо ажил дээрээ байна. Тэгээд гэр лүүгээ явах хэрэгтэй байна.
5. Та хүүхдүүдтэй хамт тогломоор байна.
6. Та багшаасаа юм асуух хэрэгтэй байна.
7. Та юм бичих хэрэгтэй байна. Танд бал байхгүй, харин найзад чинь бал байна.

Дасгал 5

Хүснэгтүүдийг бөглө. (Fill out the tables.)

Infinitive	Is/am/are ... -ing	need to	like to	want to	can	may
хонох						
гуйх						
буух						
хэрэглэх						
орчуулах						
урих						
утасдах						
бодох						

Infinitive	Is/am/are not ... -ing	don't need to	don't like to	don't want to	can't	may not
хонох						
гуйх						
буух						
хэрэглэх						
орчуулах						
урих						
утасдах						
бодох						

Дасгал 6

Эгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. Maybe it will rain.
2. It looks like it will rain.
3. I think it will rain.
4. Maybe he is a good person.
5. Probably he is a good person.
6. It looks like he is a good person.
7. Maybe she will be surprised.
8. Probably she will be surprised.
9. Maybe they will laugh.
10. Probably they will laugh.
11. Maybe he will learn it soon.
12. It feels like he will learn it soon.
13. Probably he will learn it soon.
14. It looks like he is sick.
15. Maybe he is sick.
16. Probably he is sick.

Дасгал 7

Өгүүлэл үгийн "-аад⁴" нөхцөлийг ашиглан асуултад хариул. (Answer the questions using the suffix "-аад⁴.")

1. Та өчигдөр юу юу хийсэн бэ?
2. Та маргааш юу юу хийх вэ?
3. Эндээс их дэлгүүр лүү яаж явах вэ?
4. Хуушуур яаж хийдэг вэ?

Тест

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Mongolia is bigger than Korea.
   А. Монгол Солонгосоос том.
   Б. Монголоос Солонгос том.
   В. Монгол Солонгос том.

2. My favorite thing is a book.
   А. Миний их дуртай юм ном.
   Б. Миний дуртай юм ном.
   В. Миний хамгийн дуртай юм ном.

3. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Та хэл сайн сурч чадна.
   Б. Та хэл сайн сураж чадна.
   В. Та хэл сайн сурж чадна.

4. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Тэд машин сайн барьж чадна.
   Б. Тэд машин сайн барих чадна.
   В. Тэд машин сайн барьч чадна.

5. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Та монгол хоол хийч чадах уу?
   Б. Та монгол хоол хийж чадах уу?
   В. Та монгол хоол хийх чадах уу?

6. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Та ямар хоол хийж чадах уу?
   Б. Та ямар хоол хийж чадна вэ?
   В. Та ямар хоол хийж чадах вэ?

7. May I sit here?
   А. Энд сууж болох уу?
   Б. Энд суух болох уу?
   В. Энд сууж болох вэ?

8. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Би яагаад амарч болохгүй юу?
   Б. Би яагаад амарч болохгүй вэ?
   В. Би яагаад амарч болохгүй уу?

9. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Тэр гэртээ байсан байж магадгүй.
   Б. Тэр гэртээ байсан магадгүй.
   В. Тэр гэртээ байсан байх магадгүй.

10. That person looks like he is a teacher.
   А. Тэр хүн багш юм шиг байна.
   Б. Тэр хүн багш шиг байна.
   В. Тэр хүн багш юм байна.

11. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Хүүхдүүд дуу сайн сурна байх аа.
   Б. Хүүхдүүд дуу сайн сурах байх аа.
   В. Хүүхдүүд дуу сайн сурч байх аа.

12. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Тэр энд ирээд явсан байх аа.
   Б. Тэр энд ирэхээд явсан байх аа.
   В. Тэр энд иргээд явсан байх аа.

13. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Ээж захаас мах аваад хоол хийсэн.
   Б. Ээж захаас мах авгаад хоол хийсэн.
   В. Ээж захаас мах авахаад хоол хийсэн.

14. "Хайх" гэж ... гэсэн үг. "Хайх" means ...
   А. to find
   Б. to loose
   В. to look for

15. "Олох" гэж ... гэсэн үг. "Олох" means ...
   А. to find
   Б. to loose
   В. to look for

16. "To cry" гэж ... гэсэн үг. "To cry" means ...
   А. гайхах
   Б. инээх
   В. уйлах

Оноо (point): 16/.....

Гучин зургадугаар хичээл

Үйл үгийн -ж/-ч нөхцөл (Verb suffix -ж/-ч)

Verb stem + ж/-ч (and)

Би өглөө талх идэ**ж**, цай уусан. I ate bread **and** drank tea in the morning.
Би өглөө талх идэж, цай ууна. I will eat bread and drink tea in the morning.
Би өглөө талх идэж, цай уудаг. I eat bread and drink tea in the morning.
Та өглөө талх идэж, цай уугаарай. Please eat bread and drink tea in the morning.

In complex sentences with -ж/-ч, sentences have to have the same tenses as the sentences above. Complex sentences can have same subject or different subjects.

Би дуулж, бүжиглэсэн. I sang **and** danced.
Би дуулж, Гэрэлмаа бүжиглэсэн. I sang and Gerelmaa danced.

Spelling rules:

	After verb stems ending with vowels or soft sign	After verb stems ending with **г**, **с**, (**в**) or (**р**)	After verb stems ending with **ц**, **з**, **д**, **т** or **х**	After verb stems ending with **ш**, **ч** or **ж**	After verb stems ending with consonants **л**, **м**, (**в**) or (**р**)
-ч		√			
-ж	√				√
-(а[4])ж			√		
-(и)ж				√	

For example:

зүүллаж	явж	гарч[28]	будаж
хаж	орж[28]	уулзаж	бичиж
барьж	өгч	шахаж	хожиж
алж	босч	буцаж	очиж

Дасгал 1

Энгийн өгүүлбэрийг "-ж/-ч" нөхцөлүүдийг ашиглан нийлмэл өгүүлбэр болго. (Make compound sentences out of simple sentences using the suffixes "-ж/-ч.")

Жишээ нь: Би дэлгүүр лүү явна. Би мах авна. → Би дэлгүүр лүү явж, мах авна.
I will go to the store. I will buy meat. I will go to the store and buy meat.

1. Бид гуанз руу явдаг. Бид хоол иддэг.

[28] In the old Mongolian script, words like ᠶᠠᠪ and ᠣᠷᠠ end with vowels, so **-ж** is used and words like ᠠᠪ and ᠭᠠᠷ end with consonants, so **-ч** is used. In Cyrillic, we can't see this difference, but we retain the old Mongolian spelling. (Please look at the verb list in the appendix to see verb stems with -ж/-ч.)

2. Би найзтайгаа уулзана. Би уучлалт гуйна.
3. Би найзтайгаа уулзах дуртай. Би ярих дуртай.
4. Би хөдөө явмаар байна. Би амармаар байна.
5. Би гэртээ очих хэрэгтэй. Би гэрийн даалгавраа хийх хэрэгтэй.
6. Чи гэрэл асаа. Чи үзгээ хай. Чи үзгээ ол.
7. Ганхүү машин жолоодсон. Би зам заасан.
8. Чи өрөөндөө ор. Чи гэрлээ унтраа. Чи унт.
9. Мөнхмаа уншина. Би бичнэ. Долгормаа орчуулна.
10. Тэр миний хажууд суусан. Тэр цай уусан. Тэр хоол идсэн.

Шинэ үгс: гэрэл — light, асаах — to turn on, жолоодох — to drive, унтраах — to turn off

Дасгал 2

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. I went to the store and bought flowers for my mother.
2. Yesterday I rested and she worked.
3. I cooked and my younger sister washed dishes.
4. I like to cook and clean my house.
5. In the house, the young people stood up and the old people sat.
6. They went out and played basketball.
7. Now the teacher is talking and her students are writing.
8. The teacher is asking questions and the students are answering.
9. I will go to the countryside and have a vacation.

Дасгал 3

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь:
Go and rest. → Явж амар.
Come and rest. → Ирж амар.

1. Go and play.	Come and play.
2. Go and ask.	Come and ask.
3. Go and take pictures.	Come and take pictures.
4. Go and buy food.	Come and buy food.
5. Go home and sleep.	Come here and sleep.
6. Go and cook.	Come here and cook.
7. Go and clean your room.	Come and clean your room.
8. Go and drink water.	Come and drink water.
9. Go and help your friend.	Come and help your friend.
10. Go and do your lesson.	Come and do your lesson.

Дасгал 4

Доорх зурган дээр байгаа хүмүүст нэр өгч, юу хийж байгааг нь "-ж/-ч" нөхцөлийг ашиглан бич. Give names to people in the pictures below and write what they are doing using the suffixes "-ж/-ч.")

Жишээ нь: Галхүү зураг зурж, Баярхүү зургийг нь үзэж байна.



Дасгал 5

Асуултад хариул. (Answer the questions.)

Жишээ нь: Та бууз идэж үзсэн үү? (Have you ever tried buuz?)
Би бууз идэж үзсэн. (I have tried buuz.)
Би бууз идэж үзээгүй. (I have not tried buuz.)

1. Та монгол хоол идэж үзсэн үү?
2. Та монгол хоол хийж үзсэн үү?
3. Та монгол гэрт амьдарч үзсэн үү?
4. Та монгол хөгжим тоглож үзсэн үү?
5. Та монгол дээл өмсөж үзсэн үү?
6. Та монгол тоглоом тоглож үзсэн үү?

Шинэ үг: өмсөх — to put on

Таксинд (In the taxi)

А: — Явах уу?
Б: — Хаашаа явах вэ?/Хаа хүрэх вэ?
А: — Их дэлгүүр (лүү явна аа).
— Чигээрээ (яваарай).
— Баруун гар тийшээ (эргээрэй).
— Зүүн гар тийшээ (эргээрэй).
— За, энгэсхийгээд зогсчих.
— Хэд гарав?
Б: — 2500.

A: — Are you free? (Are you going?)
B: — Where do you want to go?
A: — I want to go to the Department store.
— (Please go) directly.
— (Please turn) to the right hand side.
— (Please turn) to the left hand side.
— Okay, please stop here.
— How much is it?
B: — 2500.

Гучин долдугаар хичээл

Зарим мал, амьтан г.м. (Some livestock, animals, etc.)

хонь	sheep	бар	tiger
ямаа	goat	заан	elephant
үхэр	cow	ялаа	fly
адуу	horse	шумуул	mosquito
тэмээ	camel	мал	livestock
гахай	pig	амьтан	animal
нохой	dog	шувуу	bird
муур	cat	загас	fish
тахиа	chicken	хооллох	to feed
чоно	wolf	тэжээх	to nourish, to feed
үнэг	fox	агнах	to hunt
баавгай	bear	алах	to kill
туулай	rabbit	сургах	to train
могой	snake	барих	to catch

Дасгал 1

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Монголд/танай оронд ямар ямар мал байдаг вэ?
2. Хүмүүс гэртээ ямар ямар амьтан тэжээдэг вэ? Яагаад?
3. Монголчууд ямар мал, амьтны махыг идэж, сүүг нь уух дуртай вэ?
4. Танай оронд хүмүүс ямар мал, амьтны махыг их иддэг вэ? Яагаад?
5. Аль улсад их могой/заан/үхэр/муур байдаг вэ? Яагаад?
6. Та амьтан агнаж (алж) байсан уу?

Дасгал 2

Өгөгдсөн нөхцөл байдлыг уншаад тэр хүнийг ямар амьтантай зүйрлүүлж болохыг бич. (Read each situation and write what animal the person is.)

Жишээлбэл: Тэр хүн маш их хоол иддэг. → Тэр хүн гахай шиг.

1. Тэр хүн маш их ус уудаг.
2. Тэр хүн их муухай хувцастай.
3. Тэр хүн их хурдан явдаг.
4. Тэр хүн их удаан явдаг.
5. Тэр хүн их юм мэддэг.
6. Тэр хүн дандаа юм мартдаг.
7. Тэр хүн ярих дургүй.
8. Тэр хүн өглөө дандаа 5 цагт босдог.
9. Тэр хүн ууланд авирах их дуртай.
10. Тэр хүн их том.

Шинэ үг: авирах — to climb

Дасгал 3

Доорх амьтдын нэр болон ямар онцлогтой болохыг нь бич. (Write the names and characteristics of the animals below.)



Дасгал 4

Өгөгдсөн үгсийг ашиглан асуултад хариул. (Answer the questions using the given words.)

1. Та юуны мах идэх дуртай/дургүй вэ?
   (хонь, ямаа, үхэр, адуу, тэмээ, гахай, нохой, могой)
2. Та ямар мал, амьтнаас айдаг/айдаггүй вэ?
   (ямаа, үхэр, адуу, тэмээ, нохой, муур, баавгай, могой, бар)
3. Та ямар мал, амьтанд хоол өгч байсан/өгч байгаагүй вэ?
   (заан, ямаа, үхэр, адуу, тэмээ, гахай, нохой, үнэг, чоно, туулай)
4. Хонь, нохой, тахиа, баавгай, могой, заан, шувуу, загас, тэмээ, муур хаана амьдардаг вэ?
   (Хашаа, гадаа, уул, газар доор, гэр, байшин, мод, ус)

Гучин наймдугаар хичээл

"Тэгэх" үйл үг (Verb "to do so")

— Та хоол хийсэн үү?	— Did you cook?
— **Тэгсэн.**	— **Yes, I did.** (I did what you said.)
— Та хоол хийх үү?	— Will you cook?
— **Тэгнэ.**	— **Yes, I will.** (I will do what you said.)
— Та хоол хийдэг үү?	— Do you cook?
— **Тэгдэг.**	— **Yes, I do.** (I do what you said.)
— Та цай уух уу?	— Do you want to drink a tea?
— **Тэгье, тэгье.**	— **Okay.** (Let me do what you said.)
— Би танайд очно оо.	— I will visit your home.
— **Тэгээрэй.**	— **Please.** (Please do what you said.)

Дасгал 1

Харилцаа яриаг унш. (Read the conversation.)

Ээж: — Миний хүү, хоолоо идсэн үү?
Хүү: — Тэгсэн, ээж ээ.
Ээж: — Анги дээрээ хичээлээ сайн хийгээрэй.
Хүү: — Тэгнэ ээ.
Ээж: — Чи битгий муу хүүхдүүдтэй тоглоорой.
Хүү: — Тэгэхгүй ээ, ээж ээ.
Ээж: — Чи надтай ярих дургүй байгаа юм уу?
Хүү: — Үгүй ээ, зүгээр ядраад байна. Ээж ээ, та надад гоё тоглоом аваарай.
Ээж: — Тэгнэ ээ.
Хүү: — Та одоо надтай хамт сургууль руу яваарай.
Ээж: — Тэгье ээ, миний хүү.
Хүү: — Ээж ээ, та надтай ярих дургүй байгаа юм уу?

Дасгал 2

Хариултад тохирох өгүүлбэрийг бич. (Write sentences which are suitable for the answers.)

1. Тэгнэ ээ.
2. Тэгсэн.
3. Тэгдэг.
4. Тэгмээр байна.
5. Тэгэх хэрэгтэй.
6. Тэгж байна.
7. Тэгж болно.
8. Тэг, тэг.
9. Тэгж чадахгүй.
10. Тэгээрэй.
11. Тэгье, тэгье
12. Тэгэх хэрэггүй.

Дасгал 3

Эгүүлбэрт богино хариултуудаас тохирохыг нь бич. (Write a suitable short answer for each question or statement.)

А. Тэгсэн, тэгнэ, тэгдэг, тэгж чадна, тэгж болно

1. Та энэ хоолыг хийсэн үү?
2. Та ирэх сард манайд ирээрэй.
3. Чи миний өрөөг цэвэрлэсэн үү?
4. Та маргааш надад туслаарай.
5. Тэр маргааш хөдөө явах уу?
6. Та монгол хэл сайн сураарай.
7. Чи ирэх сард амрах уу?
8. Та ингэж чадах уу?
9. Та өглөө бүр гүйдэг үү?
10. Би энийг хийж болох уу?
11. Та найзтайгаа уулзсан уу?
12. Та маргааш хичээл заагаарай.
13. Хүү тань хоол хийдэг үү?
14. Та их сургууль төгссөн үү?
15. Та цагтаа хичээлдээ ирдэг үү?
16. Та надад хоол хийж өгөөрэй.

Б. Тэгье, тэг, тэг тэг, тэгээрэй

1. Та цай уух уу?
2. Та над руу утсаар яриарай.
3. Би цай аваад ирэх үү?
4. Та энд суугаарай.
5. Та одоо дуу дуулаарай.
6. Би танд тусална аа.
7. Би одоо тогломоор байна.
8. Та надад туслаарай.
9. Би энэ номыг авъя.
10. Би танайд дахиад ирнэ ээ.
11. Та энэ номыг ав.
12. Та энэ нохойг аваад гараарай.
13. Би тан руу утсаар ярина аа.
14. Чи энийг идээрэй.

Шинэ үгс: гүйх — to run, ингэх — to do this way

Аялага үгс (Interjections)

Аа.	Oh!
Ай?	Hm?
Өө! Ээ!	Oophs!
Хүүе! Хөөе! Хүүш!	Hey!
Хөөх!	Wow!
Ёо!	Ouch!
Ёох!	Ah! (relaxing)
Паах! Пөөх!	Pooh!
Халхай, халхай!	Phew! (When it's hot.)
Тий, тий!	Phew! (When it's cold.)

Гучин есдүгээр хичээл

Чиглэхийн тийн ялгал (Directive case)

руу²/луу² (to (towards), at)

Тэд дэлгүүр **луу** явсан.	They went **to** the store.
Хүүхдүүд багш **руу** харж байна.	Children are looking **at** the teacher.
Та хаа**шаа** явсан бэ?	Where did you go?

Spelling rules:

	After words ending with all vowels or consonants besides **р**	After words ending with **р**
After words with **а**, **у** or **о**	**руу**	**луу**
After words with **э**, **ө**, **ү** or **и**	**рүү**	**лүү**

For example:

гэр лүү	банк руу	ширээ рүү
Улаанбаатар луу	аав руу	хүн рүү

Question pronouns and personal pronouns:

юу → юу руу	та → тан руу	бид → бидэн рүү
хэн → хэн рүү	чи → чам руу	та нар → та нар луу
би → над руу	тэр → түүн рүү	тэд → тэдэн рүү

Дасгал 1

Нэр үгсийн ард чиглэхийн тийн ялгалын нөхцөлийг бич. (Write the directive cases after the nouns.)

Жишээ нь: Би сургууль ..... явна. → Би сургууль руугаа явна. (I will go to my school.)

1. Би ажил ..... явах хэрэгтэй.
2. Та Дархан ..... нүү.
3. Та сургууль ..... гүй.
4. Тэр дэлгүүр ..... явж болно.
5. Бид банк ..... явж чадна.
6. Тэд өрөө ..... гүйгээгүй.
7. Та нар гуанз ..... явахгүй.
8. Би байр ..... гүймээр байна.
9. Бурмаа ресторан ..... гүйсэн.
10. Долгормаа цирк ..... алхсан.
11. Би Америк ..... буцна.
12. Тэр гэр ..... явж байна.
13. Тэд хот ..... явж болохгүй.
14. Та ах ..... хар.

Шинэ үгс: нүүх — to move (house), буцах — to go back, харах — to see, to look at

Дасгал 2

Жишээ өгүүлбэрт бичсэнчлэн гарах, чиглэхийн тийн ялгал болон тохирох цагийн нөхцөлүүдийг дэгийн оронд бич. (Write down the ablative case, directive case and proper tense in the spaces as in the example.)

	Би дандаа	ажлаасаа	байр луугаа	явдаг.
1.	Тэр уржигдар орой	ажил	гэр	яв .....
2.	Тэд нар маргааш өглөө	байшин(г)	зах	яв .....
3.	Бид өчигдөр үдээс хойш	сургууль	банк	яв .....
4.	Оюутан ер нь	гэр	сургууль	яв .....
5.	Худалдагч өглөө	гэр	дэлгүүр	яв .....
6.	Дуучин өглөө бүр	гэр	театр	яв .....
7.	Жолооч уржигдар	зах	кино театр	яв .....
8.	Би хоёр хоногийн өмнө	дэлгүүр	гуанз	яв .....
9.	Хүүхэд өчигдөр хоёр удаа	гэр	цирк	яв .....
10.	Эмч нөгөөдөр орой	эмнэлэг	байр	яв .....

Дасгал 3

Дэгийн оронд чиглэхийн тийн ялгалын нөхцөлүүдээс тохирохыг нь бич. (Add the proper directive case in the spaces.)

Жишээ нь: Та жолооч ..... утасдаж болно
Та жолооч руугаа утасдаж болно. (You may call your driver.)

1. Та манай гэр ..... утасдаарай.
2. Чи сургууль ..... утасдаарай.
3. Багш (би) ..... утсаар ярьсан.
4. Та (тэр) ..... утасдах хэрэггүй.
5. Чи тэд ..... утасдаж чадахгүй.
6. Хүүхдүүд бид ..... утсаар яримаар байна.
7. Би (чи) ..... утсаар ярих дуртай.
8. Ажилчин банк ..... утасдана.
9. Тогооч ресторан ..... утасдаж болно.
10. Би тэр хүн ..... (утсаар) яримааргүй байсан.
11. Би найз ..... (утсаар) яримаар байна.
12. Та ээж ..... утсаар ярьсан уу?

Дасгал 4

Биеийн төлөөний үгсийг чиглэхийн тийн ялгалын нөхцөлөөр хувирга. Өмнөх хүснэгтээсээ харалгүй дараагийн хүснэгтээ бөглөж бичээд биеийн төлөөний үгс болон өгөгдсөн үйл үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Add the directive case to the personal pronouns. Fill out the next table without looking at the previous table. Then make sentences with the personal pronouns and given verbs.)

хэн	хэн рүү
Би	
Чи	
Та	
Тэр	
Бид (нар)	
Та нар	
Тэд (нар)	

хэн	хэн рүү
Тэд (нар)	
Та нар	
Бид (нар)	
Тэр	
Та	
Чи	
Би	

хэн	хэн рүү
Тэр	
Тэд (нар)	
Чи	
Би	
Бид (нар)	
Та нар	
Та	

Үйл үгс: гүйх, харах, утсаар ярих, алхах

Дасгал 5

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Make sentences using the given words.)

Жишээ нь:
Тэд, ном, монгол хэл, англи хэл, орчуулах → Тэд номоо монгол хэл(н)ээс англи хэл рүү орчуулна.
Тэд номоо монголоос англи руу орчуулна. (They will translate their book from Mongolian to English.)

1. Оюутан, хичээл, орос хэл, хятад хэл, орчуулах
2. Тэр, захиа, франц хэл, испани хэл, орчуулах
3. Бид, текст, грек хэл, еврэй хэл, орчуулах
4. Хүүхдүүд, дуу, монгол хэл, япон хэл, орчуулах
5. Багш, шүлэг, япон, монгол хэл, орчуулах
6. Би, өгүүлбэр, испани хэл, орос хэл, орчуулах
7. Тэд, захиа, монгол хэл, англи хэл, орчуулах
8. Сурагч, үг, хятад хэл, герман хэл, орчуулах
9. Би, ном, англи хэл, монгол хэл, орчуулах

Шинэ үгс: захиа — letter, шүлэг — poem

Дасгал 6

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. I will call you later.
2. Please call my house.
3. Please call me tomorrow afternoon.
4. Why didn't you call your teacher?
5. Call him now.
6. He is not able to call me from there.
7. You need to call his office.
8. She likes very much to call her friend.
9. You may not call me.
10. You can't call your friend many times.
11. I called him. But he didn't answer.
12. Did you call your mother?
13. Do you want to call them?
14. Generally, my friend doesn't call me.

Шинэ үг: to answer a phone — утас авах

Дөчдүгээр хичээл

Үйлдэхийн тийн ялгал (Instrumental case)

-аар[4] (by, out of, with, during, as, for, at)

Spelling rules:

	After words ending with short vowels or consonants	After words ending with long vowels or diphthongs
After words with **а** or **у**	**-аар**	**-(г)аар**
After words with **э, ү** or **и**	**-ээр**	**-(г)ээр**
After words with **о**	**-оор**	**-(г)оор**
After words with **ө**	**-өөр**	**-(г)өөр**

For example:

машинаар	онгоцоор	харандаагаар
өвгөөр	монголоор	малгайгаар
бөмбөгөөр	мөнгөөр	хүнээр

Question pronouns and personal pronouns:

юу → юугаар	та → танаар	бид → биднээр
хэн → хэнээр	чи → чамаар	та нар → та нараар
би → надаар	тэр → түүнээр	тэд → тэднээр

Note:

бага + аар = багаар	нөхөр + өөр = нөхрөөр	морь + оор = мориор
торго + оор = торгоор	хамар + аар = хамраар	амь + аар = амиар

Үйлдэхийн тийн ялгалын нөхцөлийн хэрэглээ (The usages of the instrumental case)

Transportation (by)

Бид хөдөөнөөс машин**аар** ирсэн.	I came from the countryside **by** car.
Би онгоцоор явах дуртай.	I like to go by airplane.

Material (out of, with)

Та мод**оор** юу юу хийж чадах вэ?	What all can you do **with** wood?
Би цаас**аар** цэцэг хийнэ.	I will make flowers **out of** paper.

Object (with)

Туяа харандаа**гаар** бичих дуртай.	Tuya likes to write **with** a pencil.
Энэ халбагаар хоолоо ид.	Eat your food with this spoon.

Language

Та монгол**оор** ярьж чадах уу?	Can you speak Mongolian?
Тэр англиар их сайн ярьдаг.	He speaks English very well.

Money and prices (for)

Та хэдэн **төгрөгөөр** ном авсан бэ?	**For** how many **togrog** did you buy the book?
Би 100 доллароор гутал авсан.	I bought boots for 100 dollars.

During (for time)

Би **наадмаар** танайд очно.	I will visit your house **during Naadam**.
Амралтаараа манайд ир.	Come to my house during your vacation.

Division (...by ...)

Чи энийг нэг **нэгээр** нь идээрэй.	You please eat it one **by one**.
Чи хоолоо бага багаар ид.	You eat your food little by little.

As

Би сургуульд **багшаар** ажилладаг.	I work in the school **as a teacher**.
Би Монголд эмчээр ирсэн.	I came to Mongolia as a doctor.

Asking news (what, at, in)

— **Танаар** сонин юу байна (вэ)?	— What is new **with you**?
— Надаар юмгүй.	— Nothing (is new) with me.

Time (at)

Би 5-р сарын **эхээр** Америк явна.	I will go to America **at the beginning** of May.
Би 2-р сарын дундуур явна.	I will leave in the middle of February.
Тэд 6-р сарын сүүлээр гэрлэнэ.	They will be married at the end of June.

to paint, to dye

Зарим хүүхэд үсээ **шараар** буддаг.	Some kids dye their hair **yellow**.
Би сандлаа бороор будсан.	I painted my chair brown.

Purpose (to/in order to)

Би хэл **сурахаар** энд ирсэн.	I came here **to learn** the language.
Тэд хичээлээ хийхээр суулаа.	They sat to do their lesson.
Би хоол **идэхээр** явж байна.	I'm going **to eat**.

Дасгал 1

Нэр үгсийг үйлдэхийн тийн ялгалын нөхцөлөөр хувирга. (Add the instrumental case to the nouns.)

1. машин...
2. онгоц...
3. усан онгоц...
4. автобус...
5. троллейбус...
6. галт тэрэг...
7. такси(г)...
8. морь...
9. мотоцикл...
10. унадаг дугуй....
11. нисдэг тэрэг...
12. морин/үхэр тэрэг...
13. тэмээ...
14. микроавтобус...
15. завь...

Шинэ үгс: усан онгоц — ship, троллейбус — trolleybus, галт тэрэг — train, мотоцикл — motorcycle, унадаг дугуй — bicycle, нисдэг тэрэг — helicopter, морин тэрэг — horse cart, үхэр тэрэг — cow cart, тэмээ — camel, завь — boat

Дасгал 2

Доорх тээврийн хэрэгсэл болон малын нэрсийг хэлж, зураг бүр дээр өгүүлбэр зохиож бич. (Say the names of the animals and modes of transportation below and write sentences for each picture.)



Дасгал 3

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та юугаар явах дуртай/дургүй вэ?
2. Та дэлгүүр лүү (сургууль руугаа, ажил руугаа, гэр лүүгээ) юугаар явдаг вэ?
3. Та хөдөө (Америк руу) юу юугаар явдаг вэ?
4. Та онгоцны буудал руу (галт тэрэгний буудал руу) юугаар явдаг вэ?

Шинэ үгс: галт тэрэгний буудал — train station, онгоцны буудал — airport, автобусны буудал — bus stop

Дасгал 4

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words .)

Жишээ нь: Би, гэр, ажил, эхнэр, машин, явах
Би гэрээсээ ажил руугаа эхнэртэйгээ машинаараа явна.
I will go from my house to my office with my wife by my car.

1. Тэр, ажил, гэр, нөхөр, такси, явах
2. Гэрэлмаа, сургууль, ажил, багш, машин, явах
3. Бид, сургууль, гэр, найз, автобус, явах
4. Би, сургууль, дэлгүүр, оюутан, унадаг дугуй, явах
5. Ганхүү, гэр, сургууль, ээж, троллейбус, явах

Дасгал 5

Өгөгдсөн үгсийг ашиглан асуулт зохиож, хариул. (Make questions using the given words and answer them.)

Жишээ нь:
Их дэлгүүрээс танай гэр лүү таксигаар хэдэн минут явдаг вэ?
Их дэлгүүрээс манай гэр лүү таксигаар 20 минут явдаг.

How long does it take from the Department Store to get to your house by taxi?
It takes 20 minutes from the Department Store to get to my house by taxi.

1. Дархан, Эрдэнэт, машин, хэдэн цаг, явах?
2. Улаанбаатар, Сөүл, онгоц, хэдэн цаг, нисэх?
3. Улаанбаатар, Ховд, машин, хэдэн хоног, явах?
4. Танай гэр, онгоцны буудал, такси, хэдэн минут, явах?
5. Танай сургууль, танай гэр, такси, хэдэн минут, явах?
6. Танай ажил, танай гэр, автобус, хэдэн минут, явах?
7. Зах, гуравдугаар хороолол, микроавтобус, хэдэн минут, явах?

Дасгал 6

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь:
We went from Ulaanbaatar to Darkhan by bicycle, then from Darkhan to Erdenet by car. → Бид нар Улаанбаатараас Дархан хүртэл унадаг дугуйгаар яваад Дарханаас Эрдэнэт хүртэл машинаар явсан.

1. They will go from Ulaanbaatar to Hovsgol aimag by airplane, then from Hovsgol aimag to Uvs aimag by microbus.
2. I walked from my house to the bus stop, then I went from there to the school by bus.
3. You need to go from your house to the mountain by horse, then you need to walk from there to that house.
4. Please run from here to that tree, then walk fast from there to here.

Дасгал 7

Асуултад хариул. (Answer the questions.)

Жишээлбэл:
— Та хэдэн цагаас хэдэн цаг хүртэл хичээлтэй вэ?
— Би 9 цагаас 12 цаг хүртэл хичээлтэй.

— Та хэдээс хэд хүртэл хичээлтэй вэ?
— Би 9-өөс 12 хүртэл хичээлтэй.

1. Та хэдэн цагаас хэдэн цаг хүртэл (хэдээс хэд хүртэл) ажилладаг вэ?
2. Америкт хүмүүс хэдэн цагаас хэдэн цаг хүртэл (хэдээс хэд хүртэл) ажилладаг вэ?
3. Дэлгүүр хэдэн цагаас хэдэн цаг хүртэл (хэдээс хэд хүртэл) ажилладаг вэ?

4. Та хэдэн оноос хэдэн он хүртэл сургуульд сурсан бэ?
5. Та зун хэдэн сараас хэдэн сар хүртэл амардаг вэ?

Дасгал 8

Нэр үгсийг үйлдэхийн тийн ялгалын нөхцөлөөр хувирга. (Add the instumental case to the nouns.)

1. Би халбага ..... хоол идэх дуртай.
2. Хүүхдүүд сэрээ ..... бууз идсэн.
3. Монгол хүмүүс хутга ..... мах идэх дуртай.
4. Та гар ..... хуушуур барьж идэж болно.
5. Ази хүмүүс савх ..... хоол идэх дуртай.
6. Оюутнууд хар харандаа ..... бичих дуртай.

Шинэ үгс: халбага — spoon, сэрээ — fork, хутга — knife, савх — chopstick

Дасгал 9

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та юу юугаар хоол идэх дуртай вэ?
2. Та юу юугаар бууз идэх дуртай вэ?
3. Та юугаар юм бичих дургүй вэ?
4. Та юу юугаар тоглох дуртай вэ?
5. Хүмүүс юу юугаар тоглож болохгүй вэ?
6. Хүмүүс юугаараа юм хардаг вэ?
7. Хүмүүс юугаараа юм сонсдог вэ?
8. Хүмүүс юугаараа юм үнэрлэдэг вэ?

Шинэ үг: үнэрлэх — to smell

Дасгал 10

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Хүмүүс модоор (цаасаар, шилээр, даавуугаар, чулуугаар, төмрөөр, мөнгөөр) юу хийдэг вэ?
2. Хүмүүс юугаар цонх (цүнх, дэвтэр, харандаа, аяга, ширээ, хувцас) хийдэг вэ?

Шинэ үгс: шил — glass, чулуу — stone, төмөр — iron

Дасгал 11

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. I can go by this bicycle.
2. Can you go fast by horse?
3. Don't go by plane. Go by train.
4. How will you go to the countryside? Will you go by car or airplane?
5. Don't go by that horse, because that horse is difficult.

6. Don't come by taxi. Come by bus.
7. Please don't play with fire. Play with a ball.
8. Don't eat buuz with a spoon. To eat buuz with a spoon is difficult.
9. Don't buy one shirt with 100 dollar. Buy books with 100 dollar.
10. Don't write with a red ballpoint pen. To write with red is bad for your eyes.
11. Don't eat your food with your hands, because your hands are not clean.
12. My mother always says "Don't play with your food."
13. My mother always says "Don't play with a dog."
14. My mother always says "Don't play with your friend."
15. My mother always says "Don't play with fire."
16. To eat food with chopstick is difficult.
17. To go by train is nice.

Дасгал 12

Биеийн төлөөний үгсийг үйлдэхийн тийн ялгалын нөхцөлөөр хувирга. Өмнөх хүснэгтээсээ харалгүй дараагийн хүснэгтээ бөглөж бич. Дараа нь биеийн төлөөний үгс болон өгөгдсөн үйл үгийг ашиглан өгүүлбэр зохио. (Add the instrumental case to the personal pronouns. Fill out the next table without looking at the previous table. Then make sentences with the personal pronouns and given verb.)

хэн	хэнээр
Би	
Чи	
Та	
Тэр	
Бид (нар)	
Та нар	
Тэд (нар)	

хэн	хэнээр
Тэд (нар)	
Та нар	
Бид (нар)	
Тэр	
Та	
Чи	
Би	

хэн	хэнээр
Тэр	
Тэд (нар)	
Чи	
Би	
Бид (нар)	
Та нар	
Та	

Үйл үг: бахархах (to be proud of)

Жишээ нь: Би түүнээр бахархдаг. Тэр надаар бахархдаг.

Дасгал 13

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та ямар ямар хэлээр ярьж чаддаг вэ?
2. Та ангид ямар хэлээр ярих хэрэгтэй вэ?
3. Та ямар ямар хэлээр бичиж чаддаг вэ?
4. Та хэдэн хэлээр "Сайн байна уу?" гэж хэлж чаддаг вэ?
5. Та монголоор (англиар, германаар, оросоор, хятадаар, францаар) сайн ярьж чадах уу?
6. Та найзтайгаа (ахтайгаа, багштайгаа, хүүхэдтэйгээ, монгол хүмүүстэй, хөрштэйгөө, нохойтойгоо) ямар хэлээр ярьдаг вэ?
7. Та ямар хэлээр хүмүүст имэйл бичдэг вэ?

Дасгал 14

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Танай оронд хүмүүс шинэ жилийн баяраар юу хийдэг вэ?
2. Монголчууд цагаан сараар юу хийдэг вэ?
3. Монгол хүмүүс наадмаар юу хийдэг вэ?
4. Хүүхдүүд зуны амралтаараа юу хийдэг вэ?
5. Та өвлийн амралтаараа юу хийдэг вэ?
6. Танай оронд хүмүүс баяраар хэдэн хоног амардаг вэ?
7. Та зуны амралтаараа хаана хаана амардаг вэ?
8. Та шинэ жилийн баяраар эхнэртээ/нөхөртөө ямар бэлэг өгдөг вэ?

Дасгал 15

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. Don't speak in English. Speak in Mongolian.
2. You need to talk in Mongolian in the classroom.
3. You don't need to talk in English with her. She doesn't know English.
4. She wrote her email in Mongolian to me.
5. He said one word in Mongolian to me. I didn't understand it.
6. Say one word in Mongolian. Then I will say one word in English.
7. I can count from one to one hundred in Mongolian.
8. In general what do you do during the New Year Holiday?
9. My friends came to my house for my birthday and sang a song for me.
10. During Tsagaan Sar old people give a gift to young people.
11. Boldhuu and Dulmaa like to cook nice food for their parents during the holidays.

Утсаар ярих (To talk on the phone)

А: — Байна уу?
Б: — Байна.
А: — Та Батхүү юү?
Б: — Тийм байна.
А: — Сайн байна уу? Би Гэрэлмаа байна.

— Та хэнтэй ярих гэсэн юм бэ?
— Батхүүтэй ярих гэсэн юм.
— За, одоохон.
— Тийм хүн байдаггүй.
— Та буруу залгачихжээ.

A: — Hello?
B: — Hello.
A: — Are you Bathuu?
B: — Yes.
A: — Hi, I'm Gerelmaa.

— Who do you want to talk to?
— I would like to talk to Bathuu.
— Okay, wait a minute.
— Such (that) person isn't (generally) here.
— You dialed the wrong number.

Давтлага хичээл

Дасгал 1

Үйл үгийн "-ж/-ч" нөхцөлийг ашиглан өгөгдсөн үгсээр өгүүлбэр зохио. (Make sentences with the given words using the suffixes "-ж/-ч.")

Жишээлбэл: явах, үзэх → Тэд гадагшаа (out) явж кино үзсэн.

1. ирэх, авах
2. ирэх, уулзах
3. орох, амрах
4. орох, унших
5. унтраах, унтах
6. асаах, хайх
7. гарах, тоглох
8. гарах, гүйх
9. явах, идэх
10. явах, амрах
11. асуух, бичих
12. цэвэрлэх, хийх
13. унших, орчуулах
14. зурах, бэлэглэх
15. олох, өгөх
16. идэх, ажиллах
17. асуух, хэрэглэх
18. хайх, олох

Дасгал 2

"Тэгэх" гэдэг үгийг ашиглан асуултад хариул. (Answer the questions using the verb "тэгэх.")

1. Чи найзтайгаа уулзсан уу?
2. Чи энэ балаар бичих үү?
3. Та манайд очоорой.
4. Чи найз руугаа одоо утасдах уу?
5. Та дандаа машинаар явдаг уу?
6. Над руу утасдаарай.
7. Би тан руу утасдана аа.
8. Та ингэж чадах уу?
9. Чи өчигдөр энд ирсэн үү?
10. Та цай уух уу?
11. Та зун манай гэрт ирж амраарай.
12. Би танайд дахиад ирнэ ээ.
13. Та таван цагт ирээрэй.
14. Та тамхи татдаг уу?

Дасгал 3

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. Call your mother tonight. She will be happy.
2. I will call you in the afternoon because I will be busy in the morning.
3. I will go to my school tomorrow morning and I will get some books.
4. The child saw his mother and he ran to her very fast.
5. He was very afraid of my big dog and ran to the door.
6. "My family will move to Erdenet soon," she said to me.
7. The teacher told students, "Look at this picture. Don't look at the window."
8. Do children look at their parents' eyes and talk?
9. Look at me and talk. Don't look that way.
10. Where are you going? Are you going to the store?

Дасгал 4

Зөв газрийн оронд "-ын²хаа⁴, -нхаа⁴, -ны²хаа⁴" нөхцөлүүдээс аль тохирохыг нь нөхөж бич. (Add the proper suffixes from "-ын²хаа⁴, -нхаа⁴, -ны²хаа⁴" in the spaces.)

Жишээ нь: Би найз..... гэр лүү явсан. → Би найзынхаа гэр лүү явсан. (I went to my friend's house.)

1. Тэр, өвөө..... гэрээс энд ирнэ.
2. Би найз..... зуслан руу явмаар байна.
3. Галхүү дүү..... багштай уулзах хэрэгтэй.
4. Алимаа эгч..... гэр лүү утасдах хэрэгтэй.
5. Тэд хөрш..... нохойноос айдаг.
6. Тэр, ах..... гэрт хөзөр тоглох дуртай.
7. Баярхүү нохой..... тухай ярих дуртай.
8. Чи надад гэр бүл..... тухай яриарай.
9. Тэр чамд ажил..... тухай ярихгүй.
10. Би найз..... аав ээжид туслах хэрэгтэй.
11. Та нар хүүхэд..... үгэнд итгэх хэрэгтэй.
12. Би эгч..... охинд цэцэг бэлэглэсэн.
13. Ангирмаа шинэ өрөө..... тухай түүнд ярьсан.
14. Би найз..... гэрт очоогүй.

Шинэ үг: бэлэглэх — to give as a gift

Дасгал 5

Хүснэгтийг бөглөж, үг тус бүр дээр өгүүлбэр зохио. (Fill out the table and make sentences with each word.)

хэн	хэний	хэнтэй	хэнд	хэнээс	хэн рүү
эмээ					
оюутан					
найз					
эгч					
ах					
дарга					
би					
тэр					
та					
бид (бид нар)					
чи					
тэд (тэд нар)					
та нар					

Дасгал 6

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та үхэр тэргээр явж үзсэн үү?
2. Та хөдөө морин тэргээр явж үзсэн үү?
3. Та галт тэргээр явах дуртай юу?
4. Та ер нь онгоцоор ийш(ээ) тийш(ээ) их явдаг уу?
5. Та юугаар хичээлээ бичдэг вэ? Яагаад?
6. Та юугаар бууз иддэг вэ?
7. Та юугаар шөл уудаг вэ?
8. Хүмүүс төмрөөр юу юу хийдэг вэ?
9. Та цаасаар юу юу хийж чадах вэ?
10. Та ямар ямар хэлээр сайн ярьж чаддаг вэ?
11. Та монгол хүмүүстэй англиар ярьдаг уу, монголоор ярьдаг уу?
12. Та зуны, өвлийн амралтаараа юу юу хийдэг вэ?
13. Танай оронд хүмүүс баяраар ер нь юу хийдэг вэ?

Дасгал 7

Монгол, англи үгсийг зөв харгалзуулан холбож зур. (Match Mongolian and English words by connecting them with lines.)

үнэрлэх	to be cut off	гүйх	glass
харагдах	cotton	бэлэглэх	to fly
тасрах	chopstick	шил	to run
савх	spoon	чулуу	bus stop
даавуу	knife	нисэх	to give as a gift
халбага	to smell	онгоцны буудал	bicycle
хутга	to walk	унадаг дугуй	stone
алхах	to look	автобусны буудал	airport

Тест

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Тэр зах руу явч, ногоо авсан.
   Б. Тэр зах руу явж, ногоо авсан.
   В. Тэр зах руу яваж, ногоо авсан.

2. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Би найздаа номоо өгч тусалсан.
   Б. Би найздаа номоо өгөж тусалсан.
   В. Би найздаа номоо өгж тусалсан.

3. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Охин аяга угаач, би амарсан.
   Б. Охин аяга угааж, би амарсан.
   В. Охин аяга угаахж, би амарсан.

4. Та над руу утсаар ярьсан уу?
   А. Тэгнэ.
   Б. Тэгье.
   В. Тэгсэн.

5. Чи одоо хоол хийгээрэй.
   А. Тэгье.
   Б. Тэгээрэй.
   В. Тэгнэ.

6. Би танд тусална.
   А. Тэгье.
   Б. Тэгнэ.
   В. Тэгээрэй.

7. Та цай уух уу?
   А. Тэгье.
   Б. Тэгнэ.
   В. Тэгээрэй.

8. I went to my friend's house.
   А. Би найзын гэр лүүгээ явсан.
   Б. Би найзынхаа гэр лүү явсан.
   В. Би миний найзын гэр лүү явсан.

9. I met my teacher's mother.
   А. Би манай багшийн ээжтэй уулзсан.
   Б. Би багшийн ээжтэйгээ уулзсан.
   В. Би багшийнхаа ээжтэй уулзсан.

10. He will make a toy out of stone.
   А. Тэр, чулуунаас тоглоом хийнэ.
   Б. Тэр, чулуугаар тоглоом хийнэ.
   В. Тэр, чулуутай тоглоом хийнэ.

11. She speaks in Mongolian very well.
   А. Тэр монголоор их сайн ярьдаг.
   Б. Тэр монголд их сайн ярьдаг.
   В. Тэр монгол их сайн ярьдаг.

12. What do you do for your holidays?
   А. Та амралтдаа юу хийдэг вэ?
   Б. Та таны амралтаар юу хийдэг вэ?
   В. Та амралтаараа юу хийдэг вэ?

13. Don't eat your food with your hand.
   А. Хоолоо гараараа битгий ид.
   Б. Хоолоо гартайгаа битгий ид.
   В. Хоолоо чиний гараар битгий ид.

14. That pupil doesn't look at his teacher.
   А. Тэр сурагч багшдаа хардаггүй.
   Б. Тэр сурагч багш руугаа хардаггүй.
   В. Тэр сурагч багшаа хардаггүй.

15. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Чи хаашаа явсан бэ?
   Б. Чи хаана явсан бэ?
   В. Чи хаана руу явсан бэ?

16. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Тэд гэр рүүгээ явмаар байна.
   Б. Тэд гэр лүүгээ явмаар байна.
   В. Тэд гэрээ рүү явмаар байна.

Оноо (point): 16/.....

Дөчин нэгдүгээр хичээл

Заахын тийн ялгал (Accusative case)

The accusative case (-**ыг**[2], **г**) is used to determine definite and indefinite nouns. Indefinite direct objects have no accusative case ending, but when direct objects are used with pronouns like **энэ**, **тэр**, **аль** or words with the genitive case, then the accusative case is used. This suffix is also used with peoples' names, personal pronouns, or names related to people when they are used as direct objects. For example:

Би ном уншсан.	I read a book.
Би **энэ** (тэр, таны) ном**ыг** уншсан.	I read this (that, your) book.
Та **аль** ном**ыг** уншсан бэ?	Which book did you read?
Би Баярхүү**г** харсан.	I saw Bayarhuu.
Би тан**ыг** харсан.	I saw you.
Би ээж**ийг**ээ хүлээж байна.	I'm waiting for my mother.

	After words ending with short vowels or consonants	Masculine words ending with **ч, ж, ш, ь, и** or **г**	After words ending with long vowels or diphthongs
Masculine words (with **а, о** or **у**)	**-ыг**	**-ийг**	**-г**
Feminine words (with **э, ү, и** or **ө**)	**-ийг**	**-ийг**	**-г**

For example:

эгчийг	багшийг	ангийг	дүүг
үхрийг	Доржийг	ахыг	гахайг
үзгийг	багийг	уулыг	санг
жолоочийг	сургуулийг	өвөөг	байшинг

Note: үхэр + ийг = үхрийг, дарга + ыг = даргыг, анги + ийг = ангийг, сургууль + ийг = сургуулийг

Question pronouns and personal pronouns:

юу → юуг	та → таныг	бид → биднийг
хэн → хэнийг	чи → чамайг	та нар → та нарыг
би → намайг	тэр → түүнийг	тэд → тэднийг

When pronouns, adjectives and numbers are used as direct objects in place of nouns, they are used with the accusative case. For example:

аль номыг → алийг (which one)	улаан дэвтэр → улааныг (the red one)
энэ номыг → энийг (this one)	том дэвтэр → томыг (the big one)
тэр номыг → тэрийг (that one)	олон дэвтэр → олныг (many of it)
ахын номыг → ахынхыг (the brothers)	хоёр дэвтэр → хоёрыг (two of it)

Дасгал 1

Нэр үгст заахын тийн ялгалын нөхцөл залгаж бич. (Add the accusative case to the nouns.)

1. ширээ
2. сандал
3. аав
4. дүү
5. машин
6. хашаа
7. малгай
8. анги
9. байр
10. толь
11. багш
12. нөхөр
13. эмийн сан
14. бал
15. манаач
16. эхнэр
17. цоож
18. мод
19. байшин
20. дэвтэр
21. баг

Шинэ үгс: толь — mirror, эмийн сан — pharmacy, манаач — watchman, цоож — lock, баг — team

Дасгал 2

Харилцаа яриаг унш. (Read the conversation.)

Дэлгүүрт

Худалдагч: — Та юу авах вэ?
Үйлчлүүлэгч: — Тэр цамцыг үзэж болох уу?
Худалдагч: — Болно, болно. Алийг?
Үйлчлүүлэгч: — Тэрийг.
Худалдагч: — Энийг үү?
Үйлчлүүлэгч: — Үгүй, тэр улааныг. Хэд юм бэ?
Худалдагч: — 10 000.
Үйлчлүүлэгч: — Энэ хаанахын цамц юм бэ?
Худалдагч: — Германых
Үйлчлүүлэгч: — Өмсөж үзэж болох уу?
Худалдагч: — Болно. Тэнд толь байгаа.
Үйлчлүүлэгч: — Энэ надад томдож (багадаж, уртдаж, богинодож) байна. Танд арай жижиг (том, богино, урт) байгаа юу?
Худалдагч: — Байгаа, байгаа. Май.
Үйлчлүүлэгч: — Энэ надад таарч байна. Авъя.
Худалдагч: — Танд зохиж байна.

Шинэ үгс: худалдагч — seller, үйлчлүүлэгч — customer, өмсөх — to put on/to wear, томдох — to be big, **арай** жижиг — small**er**, таарах — to fit, зохих — to suit

Дасгал 3

Шаардлагатай газар нь заахын тийн ялгалын нөхцөл бич. (Add the accusative case if necessary.)

1. Би ном ..... авсан. Би энэ ном ..... авсан.

2. Манай нөхөр тэр ширээ ..... хийсэн. Маңай нөхөр ширээ ..... хийсэн.
3. Би олон монгол нэр ..... мэднэ. Би түүний нэр ..... мэднэ.
4. Багш тэдэнд хичээл ..... заасан. Багш энэ хичээл ..... заасан.
5. Би өчигдөр олон шинэ үг ..... сурсан. Харин тэр үг ..... сураагүй.
6. Сүрэнхүү зураг ..... зурах их дуртай. Тэр аль зураг ..... зурсан бэ?
7. Дулмаа надад багшийн ном ..... өгсөн. Дулмаа надад ном ..... өгсөн.
8. Хэн өнөө орой хоол ..... хийх вэ? Хэн өнөөдрийн хоол ..... хийх вэ?
9. Чи миний цай ..... битгий уу. Тэр цай ..... уугаарай.
10. Чи тэр харандаа ..... авсан уу? Чи дэлгүүрээс харандаа ..... авсан уу?
11. Та аль цаасан шувуу ..... хийсэн бэ? Та шувуу ..... хийх дуртай юу?
12. Ах надад энэ зураг ..... өгсөн. Ах надад олон зураг ..... өгсөн.
13. Чи Батхүү ..... зурж байна уу? Чи хэн ..... зурж байна вэ?
14. Би ах ..... хүлээж байна. Чи хэн ..... хүлээж байна вэ?
15. Би та ..... ойлгож байна. Чи (би) ..... ойлгож байна уу?
16. Би тэд ..... сайн мэднэ. Чи тэд ..... мэдэх үү?
17. Та (би) ..... битгий хүлээгээрэй. Та (тэр) ..... хүлээгээрэй.
18. Хүүхэд ээж аав ..... санадаг. Хүүхэд хэн ..... санадаг вэ?

Шинэ үгс: хүлээх — to wait, санах — to miss, to remember

Дасгал 4

Биеийн төлөөний үгсийг заахын тийн ялгалын нөхцөлөөр хувирга. Өмнөх хүснэгтээсээ харалгүй дараагийн хүснэгтээ бөглөж бичээд биеийн төлөөний үгс болон өгөгдсөн үйл үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Add the accusative case to the personal pronouns. Fill out the next table without looking at the previous table. Then make sentences with the personal pronouns and the given verbs.)

хэн	хэнийг
Би	
Чи	
Та	
Тэр	
Бид (нар)	
Та нар	
Тэд (нар)	

хэн	хэнийг
Тэд (нар)	
Та нар	
Бид (нар)	
Тэр	
Та	
Чи	
Би	

хэн	хэнийг
Тэр	
Тэд (нар)	
Чи	
Би	
Бид (нар)	
Та нар	
Та	

Үйл үгс: мэдэх, санах, хүлээх, ойлгох

Дасгал 5

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь: I waited for you. → Би таныг хүлээсэн.

1. She waited for me.
2. Please wait for Bayarhuu.
3. Did you wait for me?
4. Wait for your brother.
5. Who are you waiting for?
6. I can't wait for them.
7. I waited for you many hours.
8. I don't like to wait for people.
9. I didn't wait for him yesterday.
10. I need to wait for that person.
11. I will wait for my mother.
12. They won't wait for students.

Дасгал 6

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь: I understand you. → Би таныг ойлгож байна.

1. She didn't understand me (the teacher, her, them, her friend, her mother).
2. Did you understand me (that woman, him, your teacher)?
3. Please understand your friend (your father, them, her).
4. Please don't misunderstand me (us, your friend, your sister, him).
5. He needs to understand his parents. He will understand his parents one day.

Шинэ үгс: to understand — ойлгох, to misunderstand — буруу ойлгох

Дасгал 7

Доогуур нь зурсан болон хаалтанд байгаа үгст -ыг²/-г нөхцөл залгаж, өгүүлбэрийг орчуул. Add -ыг²/-г to the underlined words and words in parentheses, then translate the sentences.)

1. Та тэр (тэд, би, багш, охин) дуудсан уу?
2. Би уржигдар дэлгүүрт оюутан (та нар, ах, найз) таниагүй.
3. Тэр би (та, эмээ, найз, багш) хараагүй.
4. Тэр өчигдөр Сүхүү (Батхүү, Доржмаа) сонсоогүй.
5. Би өдөр бүр ээж (найз, аав, дүү, эмээ өвөө) санадаг.
6. Та би (тэр, тэд, сайн найз, бид) битгий мартаарай.

Шинэ үгс: дуудах — to call, харах — to see, таних — to recognize, сонсох — to hear/to listen to

Дасгал 8

Эгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. You need to forgive your friend.
2. She praises her child a lot.
3. I forgave them.
4. Don't praise your son too much.
5. "I can't forgive her" she said.
6. Don't offend people.
7. We need to forgive people.
8. Did I offend you?
9. Do parents need to praise their son?
10. I don't want to offend my friend.

Шинэ үгс: to forgive — **уучлах**, to praise — магтах, to offend — гомдоох, хэтэрхий — too

Дасгал 9

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Би, энэ, ном, унших, их, дуртай
2. Би, энэ өрөө, цэвэрлэх; та, тэр өрөө, цэвэрлэх
3. Та, энэ гутал, хэн, авах?
4. Чи, яагаад энэ сандал, засах(гүй)?
5. Мөнхмаа, багшийн ном, ширээн дээр, тавих
6. Чи, миний цүнх, харах?
7. Та нар, ангийн хаалга, түгжих?
8. Та, би (найз, багш, ах, эгч), их, хүлээх?
9. Та, би (тэд нар, хүүхдүүд, багш, захирал), ойлгох?
10. Чи, тэр (би, Батхүү, бид нар, тэд нар, жижиг охин), харах?
11. Би, гадаа, найз (дүү, тэр, чи, та, Гэрэлмаа, багш), таних(гүй)
12. Би, төрсөн өдрийн баяр, тэр (найз нар, гэр бүл, Баярхүү), урих

Шинэ үгс: засах — to fix, түгжих — to lock, урих — to invite

Дасгал 10

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь: Тэр, <u>ээж</u>, <u>хувцас</u>, угаах → Тэр <u>ээжийнхээ хувцсыг</u> угаасан.

1. Би, дандаа, <u>хүү</u> (охин, эхнэр/нөхөр), <u>хувцас</u>, угаах
2. Тэр, <u>өрөө</u> (анги, машин), <u>цонх</u>, сайн цэвэрлэх хэрэгтэй
3. Би, шинэ, <u>багш</u> (сургууль, оюутан), <u>нэр</u>, мартах
4. Төмөрхүү, <u>өрөө</u> (шүүгээ, анги, сургууль), <u>хаалга</u>, засах хэрэгтэй
5. Та, <u>нөхөр</u> (хүү, охин, дүү, эгч, ах), <u>мөрөөдөл</u>, сайн мэдэх?
6. Та, <u>ажил</u> (зуны амралт, хичээл), <u>төлөвлөгөө</u>, хийх
7. Та, энэ цаас, дээр, <u>гэр</u> (сургууль, ажил), <u>хаяг</u>, бичих
8. Та, энэ цаас, дээр, <u>ажил</u> (аав, гэр, сургууль), <u>утасны дугаар</u>, бичих
9. Би, <u>машин</u> (гэр, өрөө, цүнх), <u>тулхүүр</u>, ширээ, дээр, мартах
10. Та, <u>байр</u> (утас), <u>мөнгө</u>, төлөх?
11. Чи, <u>хашаа</u> (анги, шүүгээ, гэр, өрөө), <u>хаалга</u>, хаах?
12. Би, <u>найз</u> (нохой, муур, гэр, цэцэрлэг), <u>зураг</u> авах

Шинэ үгс: мөрөөдөл — day dream, төлөвлөгөө — plan, хаяг — address, төлөх — to pay

Дасгал 11

Асуултад хариул. (Answer the questions.)

Жишээ нь: Хэн хэнийг хүлээж байна вэ? → Би найзыгаа хүлээж байна.

1. Хэн хэнийг гомдоодог вэ?
2. Хэн хэнийг хайрлах ёстой вэ?
3. Хэн хэнийг магтдаг вэ?
4. Хэн хэнийг өрөвддөг вэ?
5. Хэн хэнийг хэзээ, юунд урьсан бэ?
6. Хэн хэнийг уучлах ёстой вэ?
7. Хэн хэнийг хүндлэх хэрэгтэй вэ?
8. Хэн хэнийг сонсох хэрэгтэй вэ?

Шинэ үгс: хайрлах — to love, өрөвдөх — to feel sorry for, хүндлэх — to respect

Дасгал 12

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та ер нь монгол хүмүүсийг ойлгодог уу?
2. Хүмүүс найз нөхөд, аав ээжийгээ дандаа ойлгодог уу?
3. Та хүмүүсийг олон цаг хүлээж чадах уу?
4. Та хүмүүсийн хувцсыг анзаардаг уу?
5. Аав ээж хүүхдүүдээ магтах хэрэгтэй юү?
6. Та найз нарыгаа санаж байна уу?
7. Та хүүхэд насаа санаж байна уу?
8. Та олон жилийн дараа найз нарыгаа харвал таних уу?
9. Та хүмүүсийг уучилж чаддаг уу?
10. Хүмүүс аав ээж, найз нөхөд, ах дүүгээ хайрлах ёстой юу?
11. Хүүхдүүд настай хүмүүсийг хүндлэх ёстой юу?
12. Хүмүүсийг юу өөрчилдөг вэ?
13. Хүмүүс найз нөхдийгөө ямар үед мартдаг вэ?

Шинэ үгс: анзаарах — to notice, хүүхэд нас — childhood, өөрчлөх — to change

Дөчин хоёрдугаар хичээл

Захирах хүсэх төлөв (1-р бие) (Imperative mood (First person))

Би тийшээ явъя.	Let me go there.	Би цонх нээе.	Let me open it.
Би гэрт оръё.	Let me go in the house.	Би энийг өргөе.	Let me lift this.

Spelling rules:

	After verb stems ending with vowels or soft sign	After verb stems ending with consonants
After verb stems with **а, у** or **я**	**-я**	**-ъя**
After verb stems with **э, ү, и** or **ө**	**-е**	**-ье**
After verb stems with **о**	**-ё**	**-ъё**

For example:

Би хаая.	Би нүүе.	Би авъя.	Би үзье.
Би ууя.	Би хийе.	Би уулзъя.	Би идье.
Би барья.	Би өргөе.	Би харъя.	Би өгье.
Би нээе.	Би тоглоё.	Би хэлье.	Би олъё.
Би эргэе.	Би бооё.	Би эрье.	Би оръё.

Дасгал 1

Үйл үгийн үндсүүд дээр "-я, -е, -ё (-ъя, -ье, -ъё)" нөхцөлүүдээс тохирохыг нь бичиж, өгүүлбэр зохио. (Add the appropriate suffixes "-я, -е or -ё (-ъя, -ье or -ъё)" to the verb stems and make sentences with them.)

1. авчир	14. гуй	27. сонс	40. уучил
2. ажилла	15. гүй	28. сур	41. хаа
3. амар	16. заа	29. суу	42. хар
4. амьдар	17. зар	30. тавь	43. хий
5. асуу	18. зогс	31. танилц	44. хүлээ
6. бай	19. зур	32. тоол	45. хэл
7. барь	20. соль	33. тогло	46. хэрэглэ
8. тайл	21. ир	34. тусал	47. цэвэрлэ
9. бод	22. мэд	35. угаа	48. эхэл
10. бос	23. нээ	36. уна	49. эргэ
11. бол	24. ор	37. унш	50. яв
12. буу	25. оч	38. уулз	51. ярь
13. гар	26. өг	39. уу	52. зүү

Шинэ үгс: тайлах — to take off, солих — to exchange, танилцах — to get to know, эргэх — to turn, зүүх — to wear

Дасгал 2

Дасгал 1-ийн үйл үгийн үндсүүдэд "-цгаая, -цгээе, -цгөөе, -цгооё" нөхцөлүүдээс тохирохыг нь залга. (Add the appropriate suffixes "-цгаая, -цгээе, -цгөөе or -цгооё" to the verb stems from Exercise 1.)

-цгаая → Явцгаая. (Let's go.)
-цгээе → Идэцгээе. (Let's eat.)
-цгөөе → Өгцгөөе. (Let's give.)
-цгооё → Тоглоцгооё. (Let's play.)

Дасгал 3

Эгөгдсөн үйл үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given verbs.)

Жишээ нь: ажилла, амар → А. Би ажиллая, чи амраарай. Б. Би амаръя, чи ажиллаарай.

1. ажилла, амар
2. онгойлго, хаа
3. суу, зогс
4. хэл, бич
5. ор, хүлээ
6. тогло, хар
7. заа, сонс
8. сонс, унш
9. яв, амар
10. ид, хий
11. сур, заа
12. ярь, орчуул

Дасгал 4

Эгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь: А. Би цай аваад ирье. (Let me go and get some tea.) Б. Чи цай аваад ир. (Go and get some tea.)

1. хоол авах, ирэх
2. ном авах, ирэх
3. үзэг авах, ирэх
4. аяга угаах, ирэх
5. гар угаах, ирэх
6. хувцас цэвэрлэх, ирэх
7. хоол хийх, ирэх
8. дэлгүүр явах, ирэх
9. хаалга хаах, ирэх
10. цонх онгойлгох, ирэх

Шинэ үг: онгойлгох — to open

Дасгал 5

Өгүүлбэрийг гүйцээ. (Complete the sentences.)

1. ..... учраас та битгий муу хоол идээрэй.
2. .....учраас та битгий гадаа гараарай.
3. .....учраас та битгий хөдөө яваарай.
4. ..... учраас та битгий шил хагалаарай.
5. ..... учраас та битгий мод хугалаарай.
6. ..... учраас та битгий их тостой хоол идээрэй.
7. ..... учраас та битгий олон цаг ажиллаарай.

Шинэ үг: хагалах — to break (glass), хугалах — to break (into two pieces)

Үндэс үүсгэх -хан⁴ дагавар (Suffix -хан⁴)

нэр үг+хтя+хан⁴ (noun+genitive case+хан⁴)

англиийн**хан**	classmates	гэрийн**хэн**	family members
сургуулийн**хан**	schoolmates	өрөөний**хөн**	roommates
ажлын**хан**	co-workers	байрны**хан**	people who live in same apartment building
хотын**хон**	city people		
хөдөөний**хөн**	countryside people	цуглааны**хан**	assembly people, church people
гэр бүлийн**хэн**	family members		

Дасгал 6

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Хотынхон ажилсаг уу, залхуу юу?
2. Хөдөөнийхөн өдөрт хэдэн цаг ажилладаг вэ?
3. Танай сургуулийнхан зуны амралтаараа юу хийдэг вэ?
4. Танай гэр бүлийнхэн хагас, бүтэн сайн өдөр юу хийдэг вэ?
5. Танай өрөөнийхөн сайн оюутнууд байсан уу?
6. Танай байрныхан бие биенийгээ сайн мэдэх үү?
7. Танай ажлынхан бие биендээ тусалдаг уу?
8. Та ажлынхантайгаа хөдөө явдаг уу?
9. Та англиийнхантайгаа уулздаг уу?
10. Танай цуглааныхан долоо хоногт хэдэн удаа уулздаг вэ?

Шинэ үгс: ажилсаг — hard working, залхуу — lazy, бие биенийгээ — each other

Дасгал 7

Өгүүлбэрийн өгүүлэгдэхүүнийг "-хан⁴" дагаврыг ашиглан өөрчилж бич. (Change the subjects of the sentences using the suffix "-хан⁴.")

Жишээлбэл:
Манай англиийн сурагчид шинэ бүжиг сурсан. → Манай англиийнхан шинэ бүжиг сурсан.

1. Манай ажлын хүмүүс бие биенийгээ сайн ойлгодог.
2. Хөдөөний хүмүүс сайхан сэтгэлтэй.
3. Хотын хүмүүс мал сайн мэдэх үү?
4. Манай сургуулийн багш, сурагчид их сайхан харилцаатай байдаг.
5. Манай өрөөний охид надад их юм зааж өгдөг.
6. Базархүү цуглаанд явдаг. Тэр цуглааны хүмүүс бие биедээ дандаа тусалдаг.
7. Манай байрны хүмүүс байрныхаа урд сууж, ярих дуртай.
8. Манай багийн тамирчид сайн тоглосон.

Шинэ үгс: сэтгэл — heart, харилцаа — relationship, тамирчид — athletes

Дасгал 8

Өгүүлбэрийг гүйцээ. (Complete the sentences.)

1. Би ангийнхантайгаа .....
2. Энхмаа ангийнхнаасаа .....
3. Тэр, ангийнхандаа .....
4. Батсүх ажлынхандаа .....
5. Чи ажлынхан руугаа .....
6. Та ажлынхныгаа .....
7. Би өрөөнийхөнтэйгөө .....
8. Тэр, байрныхандаа .....
9. Хотынхон хөдөөнийхнөөс .....
10. Манай ангийнхан манай ажлынхантай .....

Хүмүүсийг ерөөх (To say a blessing to people)

— Сайн сайхан бүхнийг хүсье!
— Аз жаргал хүсье!
— Амжилт хүсье!
— Бурхан (таныг) өршөөг!
— Эрүүл мэндийн төлөө!
— Ажлын амжилтын төлөө!

— Wish you all the best!
— Wish you the happiness!
— Good luck!
— God bless you!
— For health! (When cheering)
— For work success! (When cheering)

Дөчин гуравдугаар хичээл

Баймж уг (ёстой (have to, must, to be supposed to))

"Ёстой/ёсгүй" is used with infinitive verb. For example:

Тэр хүү сургуульд **сурах ёстой**.	That boy **has to study** at a school.
Тэр хүү ажил **хийх ёсгүй**.	That boy **doesn't have to do** work.
Тэр хүү сургуульд **сурах ёстой байсан**.	That boy **had to study** at a school.
Энхмаа одоо энд ирэх ёстой.	Enhmaa is supposed to come here now.
Энхмаа энд ирэх ёстой байсан.	Enhmaa was supposed to come here.

Дасгал 1

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Хүүхдүүд юу хийх ёстой вэ?
2. Эцэг эх юу хийх ёстой вэ?
3. Багш ямар байх ёстой вэ?
4. Эмэгтэй хүн ямар байх ёстой вэ?
5. Эрэгтэй хүн ямар байх ёстой вэ?
6. Та юу хийх ёстой вэ?

Дасгал 2

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. They have to be here at 9 o'clock.
2. I have to learn Mongolian.
3. I have to take medicine.
4. You have to rest now.
5. You have to trust your friend.
6. She has to talk with her friend.
7. You have to do work.
8. I have to know the truth.
9. I have to tell you the truth.
10. I have to ask my friend about that.
11. You have to forgive him.
12. He has to help his parents.

Дасгал 3

"Ёстой, ёсгүй"-г ашиглан нөхцөл байдлуудад тохирсон гурав гурван өгүүлбэр бич. (Write three sentences for each situation using "ёстой, ёсгүй.")

Жишээ нь: Жон 20 жил Монголд амьдарсан. (John lived in Mongolia for 20 years.)
А. Тэр монгол хэл сайн мэдэх ёстой. (He is supposed to know Mongolian well.)
Б. Тэр бууз хийж чадах ёстой. (He is supposed to be able to make buuz.)
В. Тэр Монголд дургүй байх ёсгүй. (He is not supposed to dislike Mongolia.)

1. Жон америк хүн.
2. Аав ээж хүүхдүүддээ хайртай.
3. Төрхүү олон жил машин барьсан.
4. Гэрэлхүү эмч.
5. Дэлгэрмаа эмэгтэй хүн.
6. Галхүү монгол хүн.

Дасгал 4

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. He was supposed to come here yesterday but he didn't come.
2. My book is supposed to be here.
3. You were not supposed to do this work.
4. He is not supposed to talk about this.
5. They are supposed to be having a lesson now.
6. They are not supposed to be playing outside.
7. It is supposed to work.
8. You were supposed to teach a lesson yesterday. Why didn't you come?
9. I was supposed to ask him for forgiveness but I couldn't.
10. You are supposed to be able to do this.
11. We are supposed to be there at 10 o'clock.
12. The lesson was supposed to start at 9.

удахгүй	soon	(future affirmative sentence)
мөд	soon	(future negative sentence)
удалгүй	soon after/after a little while	(past and present tenses)

Тэр удахгүй ирнэ.	She will come soon.
Тэр мөд ирэхгүй.	She won't come soon.
Тэр дэлгүүр яваад удалгүй ирсэн.	She went to the store and came after a little while.

Дасгал 5

Эгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

Жишээ нь: Хөдөө, явах

1. Би **удахгүй** хөдөө явна. — I will go to the countryside soon.
2. Би **мөд** хөдөө явахгүй. — I won't go to the countryside soon.
3. Би сургуулиа төгсөөд **удалгүй** хөдөө явсан. — Soon after I graduated from my school, I went to the countryside.

1. Хичээл, дуусах
2. Тэд, гэрлэх
3. Хурал, эхлэх
4. Бороо, зогсох
5. Хүүхдүүд, хоол идэх
6. Бид, уулзах
7. Машин, ирэх
8. Гадаа, дулаан болох
9. Би, амрах
10. Мод, ногоорох

Шинэ үг: ногоорох — to become green

Дасгал 6

Багшдаа тухай "удахгүй, мөд, удалгүй"-г ашиглан багшдаа ярьж өг. (Tell your teacher about yourself using the words "удахгүй, мөд, удалгүй.")

Дасгал 7

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. I just came from my homeland, so I won't go back soon.
2. My friend went to the store. She will come soon. Please wait inside.
3. Soon after you left, the electricity came on.
4. They will graduate from their school soon.
5. I have work to do here at my office, so I will probably not go to my home soon.
6. She got sick and soon after she took the medicine, she was ok.
7. Soon after they got married, they moved to Erdenet.
8. She called me yesterday on the phone. She won't call me again soon.
9. He just left for his lesson. He won't come soon.
10. Soon after it snowed, it started melting.
11. She got angry but soon after, she became calm.
12. She is angry. She won't be calm soon.
13. He started working soon after he graduated from his university.

Шинэ үгс: нутаг — homeland, хайлах — to melt, тайвшрах — to become calm

Ямар нэгэн асуудал гарсан үед (When there is a problem)

— Яасан бэ?
— Та зүгээр үү?
— Танд тусламж хэрэгтэй юү?
— Яана аа, тийм үү?
— Зүгээр ээ, битгий санаа зовоорой.
— За, тэр яах вэ. [yahuu]
— Яах вэ, яах вэ. [yahuu, yahuu]
— Яах юм бэ, яах юм бэ? [yahii, yahii]

— What happened?
— Are you okay?
— Do you need help?
— Oh no, really?
— It's okay. Please don't worry.
— Okay, that's not a big deal.
— It's okay, please don't worry about it.
— It's okay, you don't have to do it.

Дөчин дөрөвдүгээр хичээл

Энгийн өнгөрсөн цагууд (Simple past tenses)

	Personally witnessed	Not personally witnessed	General	Recent	In spoken language	In written language
-сан[4]	√		√		√	√
-лаа[4]	√			√	√	√
-в	√					√
-жээ/-чээ		√			√	√

When someone gives information to people:

Батхүү хөдөө явсан.	Bathuu went to the countryside.
Батхүү сая хөдөө явлаа.	Bathuu just went to the countryside.
Батхүү хөдөө явав.	Bathuu went to the countryside.
Батхүү хөдөө явжээ.	(I found out that) Bat went to the countryside.

In **direct conversation in everyday life**:

Батхүү хөдөө явчихсан.	[yavtsan]
Батхүү сая хөдөө явчихлаа.	[yavchlaa]
Батхүү хөдөө явчихжээ.	[yavchij]

Саяхан өнгөрсөн цаг (Recent past tense)

	After verb stems with **а, у** or **я**	After verb stems with **э, ү** or **и**	After verb stems with **о**	After verb stems with **ө**
Affirmative form	-лаа	-лээ	-лоо	-лөө
Negative form	-сангүй -аагүй	-сэнгүй -ээгүй	-сонгүй -оогүй	-сөнгүй -өөгүй
Question form	-(а)в уу? -в?	-(э)в үү? -в?	-(о)в уу? -в?	-(ө)в үү? -в?

Key words for recent past:

саяхан	recently	дөнгөж сая	just now
сая	just	арван минутын өмнө	ten minutes ago

For example:

Хүү маань сая унтлаа.	My son just slept.
Багш дөнгөж сая ангид орлоо.	The teacher went into the classroom just now.
Чи сая ирэв үү?	Did you just come?
Чи хэзээ ирэв?	When did you come?

Note: -лаа[4] can also be used for near future tense.

Би явлаа.	I'm leaving.
Та явлаа юу?	Are you leaving?

Дасгал 1

Харилцаа яриануудыг унш. (Read the conversations.)

Харилцаа яриа 1

А: — Сайхан амрав уу?

Б: — Сайхан амарлаа. Их олон юмны тухай зүүдэллээ.

А: — Сайхан зүүд байв уу, муухай зүүд байв уу?

Б: — Сайхан зүүд байлаа.

А: — Юу юуны тухай зүүдлэв?

Б: — Монголын тухай, ажлынхаа тухай, гэр бүлийнхээ тухай зүүдэллээ.

Харилцаа яриа 2

А: — Хүүе, чи хаана байв аа?

Б: — Найзынхаа гэрт.

А: — Тэнд юу хийв?

Б: — Нэг сайхан кино үзлээ. Тоглоом тоглолоо.

А: — Хэн хэн тэнд байв?

Б: — Гэрэлмаа, Дугармаа, Энхмаа бид дөрөв байлаа.

А: — Хэр удаан тоглоом тоглов?

Б: — Хоёр цаг тоглолоо.

А: — Хөгжилтэй байв уу?

Б: — Хөгжилтэй байлаа.

Харилцаа яриа 3

А: — Чи хэзээ ирэв?

Б: — 20 минутын өмнө ирлээ.

А: — Юугаар ирэв?

Б: — Таксигаар ирлээ.

А: — Хэнтэй ирэв?

Б: — Багш нартай.

А: — Жаргалмаа багш ирэв үү?

Б: — Ирлээ, ирлээ.

Харилцаа яриа 4

Б: — Энийг хэнд авав?

А: — Чамд.

Б: — Маш их баярлалаа.

А: — Зүгээр ээ.

Б: — Хаанаас авав? Их дэлгүүрээс авав уу?

А: — Тийм.

Шинэ үгс: зүүдлэх — to dream, зүүд — dream, хөгжилтэй — with fun

Дасгал 2

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Чи найз руугаа утсаар ярив уу?
2. Чи хоолоо идэв үү?
3. Чи ажлаа хийж дуусгав уу?
4. Чи амарч чадав уу?
5. Чи мах авав уу?
6. Чи гэрийн даалгавраа хийв үү?
7. Та тэр хүнийг харав уу?
8. Чи сая гарсан чимээг сонсов уу?
9. Цахилгаан ирэв үү?
10. Сая хэн ирэв?
11. Чи хаанаас ирэв?
12. Тэд ямар тоглоом тоглов?
13. Цахилгаан хэзээ тасрав?
14. Ус хэзээ тасрав?
15. Чи яагаад хичээлээс хоцров?
16. Хүүхэд яагаад уйлав?
17. Та өглөө юу хийв?
18. Та ямар хоол хийв?

Дасгал 3

Өгөгдсөн үгсийг ашиглан өнгөрсөн цагаар төгссөн батлах болон асуух өгүүлбэр зохио. (Make affirmative and interrogative sentences with the past tense using the given words.)

Жишээ нь: Ээж, сая, ирэх
А. Ээж сая ирэв үү?
Б. Ээж сая ирлээ.
В. Ээж хэзээ ирэв?

1. Та, би, ойлгох
2. Та, сурсан үг, санах
3. Чи, найз, урих
4. Чи, хаалга, түгжих
5. Тэд, сандал, засах
6. Чи, хүүхдүүд, дуудах
7. Та, Бурмаа, харах
8. Тэр, та, утасдах
9. Та, би, их, хүлээх
10. Хүүхэд, нохой, айх
11. Чи, ангийнхан, туслах
12. Та, ажлынхан, хэлэх
13. Та нар, хичээл, бичих
14. Чи, энэ дуу, сурах

Шинэ үг: түгжих — to lock

Дөчин тавдугаар хичээл

Мэдэгдэлгүй өнгөрсөн цаг (Past tense (not personally witnessed))

	Affirmative form	Negative form	Question form	
After verb stems ending with vowel, soft sign or consonants other than **г**, **с**, (**в**) or (**р**)	-жээ/-ж	-аа[4]гүй байна	without question pronoun	-ж уу/үү?
			with question pronoun	-ж?
After verb stems ending with **г, с**, (**в**) or (**р**)	-чээ/-ч	-аа[4]гүй байна	without question pronoun	-ч уу/үү?
			with question pronoun	-ч?

When people didn't personally witness an action, then find out (by hearing somone or seeing results) about it, this tense can be used. For example:

Тэр сая явжээ.	(I found out that) he has just left.
Морьд энд байжээ.	Horses were here. (We see footprints.)

Also when people make up stories, this tense can be used. For example:

Чи нэг машинтай байжээ. Тэгсэн чинь ...	(Let's say) you had one car. But ...
Эрт урьд цагт нэгэн охин байжээ.	Once upon a time, there was one girl.

When speaking, when people find out something happened, they can use -чихжээ/-чиж.
For example: Жаргалмаа явчихжээ. [yavchij] (I found out that) Jargalmaa has left. (Her coat and bag weren't there.)

Key words for this past tense:
аль хэдийн (already), нэг мэдсэн чинь (all of a sudden)

Дасгал 1

Улгэрийг унш. (Read the story.)

Үнэг, чоно, зараа гурав

Эрт урьд цагт үнэг, чоно, зараа гурав амьдарч байжээ. Нэг өдөр тэд чавга олж, хэн нь тэр чавгыг идэх талаар хэлэлцжээ. Чоно "Архинд хэн амархан согтдог маань идье" гэв. Энэ саналыг бүгдээрээ зөвшөөрөв. Чоно "Би амсаад согтдог" гэлээ. Үнэг "Би үнэрлээд согтдог" гэлээ. Зараа "Би сонсоод согтдог" гээд гуйвж байжээ. Ингээд чавгыг зараа идэхээр болжээ.

Шинэ үгс: үнэг — fox, чоно — wolf, зараа — hedgehog, чавга — plum, хэлэлцэх — to discuss, согтох — to get drunk, зөвшөөрөх — to agree, амсах — to taste, үнэрлэх — to smell, гуйвах — to sway

Дасгал 2

Үйл үгст өнгөрсөн цагийн нөхцөл залгаж, асуулт зохио. (Add the past tense suffix to the verbs and make questions.)

Жишээ нь: Хоол дуус.....
А. Хоол дуусчихжээ. [duuschij]
Б. Хоол дуусчихаж уу? [duuschijuu]
В. Аль хоол дуусчихаж? [duuschij]

1. Гадаа цас ор.....
2. Багш ир.....
3. Ах яв.....
4. Ус буцал.....
5. Хоол бол.....
6. Цахилгаан тасар.....
7. Цахилгаан ир.....
8. Ус тасар.....
9. Ус ир.....
10. Кино эхэл.....
11. Хүүхэд унт.....
12. Мах дуус.....
13. Тэр хөгшир.....
14. Цаг эвдэр.....
15. Зам эвдэр.....
16. Би шинэ үгээ март.....
17. Би номоо март.....
18. Ус чинь цагаан бол.....
19. Нүүр чинь хар бол.....
20. Хувцас чинь муухай бол.....
21. Үсэн дээр чинь будаа наалд.....
22. Хувцсан дээр чинь цаас наалд.....
23. Шүдэн дээр чинь ногоо наалд.....
24. Нүүрэн дээр чинь хоол наалд.....

Шинэ үгс: буцлах — to boil, цахилгаан — electricity, хөгшрөх — to become old, эвдрэх — to be broken, наалдах — to be stuck

Дасгал 3

Нөхцөл байдлуудыг уншаад өнгөрсөн цагийн доорх 3 нөхцөлөөс тохирохыг нь бич. (Read the situations and add the proper past tense (one of the three past tenses below) after the verbs.)

-чихсан[4] [-tsan[4]] -чихлаа[4] [-chlaa[4]] -чихжээ [-chij]

Тэр явчихсан. (I know) he left.
Тэр явчихлаа. He just left.
Тэр явчихжээ. (I found out that) he has left.

1. Багш ирээгүй байна. Найз чинь "Багш ирсэн үү?" гэж танаас асуусан. Та "Ирээгүй" гэж хэлсэн. Харин 10 минутын дараа багш ирсэн. Та найздаа "Багш ир....." гэж хэлсэн.
2. Багш 30 минутын өмнө ирсэн. Та багшийг харсан. Найз чинь "Багш ирсэн үү?" гэж танаас асуусан. Та "Багш ир....." гэж хэлсэн.
3. Найз чинь "Багш ирсэн үү?" гэж танаас асуусан. Та "Мэдэхгүй. Би үзээд ирье" гэж хэлсэн. Тэгээд нөгөө өрөөнд орж үзсэн. Багш байсан. Та "Багш ир....." гэж хэлсэн.
4. Та нэг цагийн өмнө хоол хийсэн. Найз чинь "Хоол болсон уу?" гэж асуусан. Та "Хоол бол....." гэж хэлсэн.
5. Та хоол хийж байна. Найз чинь "Хоол болсон уу?" гэж асуусан. Та "Болоогүй байна" гэж

хэлсэн. Харин хоол дөнгөж сая боллоо. Та найздаа "Хоол бол....." гэж хэлсэн.

6. Та хоол хийж байна. Харин яг одоо та зурагт үзэж байна. Ах чинь "Хоол болсон уу?" гэж асуусан. Та "Үзээд ирье" гэж хэлсэн. Тэгээд хоол идэж үзсэн. Хоол болсон байсан. Та ахдаа "Хоол бол....." гэж хэлсэн.
7. Өрөө харанхуй байсан. Та унтраалга дарсан. Харин цахилгаан байхгүй байсан. Та "Өө, цахилгаан тасар....." гэж хэлсэн.
8. Цахилгаан тасраад нэг цаг өнгөрсөн. Найз чинь "Яагаад хоолоо хийгээгүй юм бэ?" гэж асуусан. Та "Цахилгаан тасар....." гэж хэлсэн.
9. Та найзтайгаа утсаар ярьж байсан. Яг тэр үед цахилгаан тасарсан. Та "Өө, цахилгаан тасар....." гэж найздаа хэлсэн.
10. Та 10 минутын өмнө дүүгээ унтуулсан. Ээж чинь "Дүү чинь унтсан уу?" гэж асуухад та "Дүү унт....." гэж хэлсэн.
11. Та дүүгээ унтуулаад өрөөнөөс гарч ирж байна. Ээж чинь "Дүү чинь унтсан уу?" гэж асуусан. Та "Дүү унт....." гэж хэлсэн.
12. Та дүүгээ хайгаад өрөөнд нь орсон. Харин дүү чинь унтаж байсан. Та "Дүү унт....." гэж ээждээ хэлсэн.

Шинэ үгс: унтраалга — switch, өнгөрөх — to pass

Дасгал 4

Үйл үг бүр дээр "-чихсан[4], -чихлаа[4], -чихжээ" нөхцөлүүдийг ашиглан гурав гурван өгүүлбэр зохиож, ямар нөхцөлд уг өгүүлбэрийг хэлж болохыг бич. (Make three sentences for each verb using "-чихсан[4], -чихлаа[4], -чихжээ" and write down in which situations you can use each sentence.)

1. яв
2. бол
3. эвдэр
4. өмс
5. ав
6. ир
7. тасар
8. март
9. зас
10. мэд
11. буцал
12. дуус
13. наалд
14. хий
15. сур
16. эхэл

Дасгал 5

Өгүүлбэрийг орчуулаад уг нөхцөл байдалд тохирсон зөвлөгөөг өг. (Translate the sentences, then give advice that is appropriate to the situation.)

1. Let's say your friend was sick. But she never saw a doctor. What would you say to her?
2. Let's say your friend had ten thousand togrogs. His friend needed ten thousand togrog. But he wouldn't give it to his friend. What would you say to your friend?
3. Let's say it was snowing outside. Your daughter was playing outside without a coat. What would you say to your daughter?
4. Let's say your friend bought a new computer. But his new computer was not turned on. What would you say to your friend?
5. Let's say your brother offended his friend. He didn't want to ask his friend for forgiveness. What would you say to him?

Давтлага хичээл

Дасгал 1

Заахын тийн ялгалын нөхцөлийг шаардлагатай газар нь бич. (Add the accusative case where needed.)

1. Ээж хоол..... хийсэн.
2. Би энэ хоол..... хийсэн.
3. Чи амттай хоол..... хийсэн үү?
4. Чи аль хоол..... хийсэн бэ?
5. Би энэ..... үзэж болох уу?
6. Би энэ ном..... үзэж болох уу?
7. Би ном..... үзэж болох уу?
8. Худалдагч аа, нэг талх..... авъя.
9. Худалдагч аа, нэг..... авъя.
10. Худалдагч аа, тэр..... авъя.
11. Би та..... хүлээж байсан.
12. Би автобус..... хүлээж байсан.
13. Би гоё зураг..... харсан.
14. Би Гэрэлмаа..... харсан.

Дасгал 2

Үйл үгийн үндсэнд "я, е, ё" нөхцөлүүдээс тохирохыг нь зөв залгаж бич. (Add the appropriate suffix "я, е, ё" to the verb stems.)

1. авчир
2. ажилла
3. асуу
4. барь
5. бод
6. гүй
7. зогс
8. зур
9. соль
10. ир
11. мэд
12. нээ
13. оч
14. өг
15. суу
16. танилц
17. тогло
18. тусал
19. унш
20. хий
21. хэрэглэ
22. эхэл
23. яв
24. ярь

Дасгал 3

Эгөгдсөн үгст нөхцөлүүдийг залгаж, үг тус бүрийг оролцуулан өгүүлбэр зохио. (Add the suffixes to the words and make sentences with each of them.)

хэн	**хэний** **-ын²хаа⁴**	**хэнтэй** **-тай³гаа⁴**	**хэнд** **-даа⁴**	**хэнээс** **-аасаа⁴**	**хэн рүү** **руу²гаа⁴**	**хэнийг** **-ыг²аа⁴**
найз						
дүү						
хөрш						
хүү						
охин						
хамаатан						

Дасгал 4

Өгүүлбэрийг ямар нөхцөл байдалд хэрэглэж болохыг бич. (Write down in which situations these sentences can be used.)

1. Хүүхдүүд явчихлаа.
2. Хүүхдүүд явчихсан.
3. Хүүхдүүд явчихжээ.
4. Цахилгаан тасарчихжээ.
5. Цахилгаан тасарчихлаа.
6. Цахилгаан тасарчихсан.
7. Ус ирчихлээ.
8. Ус ирчихжээ.
9. Ус ирчихсэн.
10. Хоол дуусчихжээ.
11. Хоол дуусчихлаа.
12. Хоол дуусчихсан.
13. Хоол болчихлоо.
14. Хоол болчихжээ.
15. Хоол болчихсон.
16. Хичээл эхэлчихсэн.
17. Хичээл эхэлчихжээ.
18. Хичээл эхэлчихлээ.

Дасгал 5

Өгөгдсөн үгсийг ашиглан өгүүлбэр зохио. (Make sentences using the given words.)

1. Би, том хүмүүс, англи хэл, заах
2. Та, хүмүүс, туслах, хэрэгтэй
3. Тэд, Будда, итгэх, гэж, би, сонсох
4. Та нар, анги, орох, ширээ, суух
5. Би, найз, гэр, очих, дуртай
6. Чи, тэр тухай, аав, хэлэх, болох
7. Би, оюутан, гэж, тэр, би, хэлэх
8. Тэр, энэ ном, би, авах
9. Хүүхэд, ээж, олон, асуулт, асуух
10. Бурмаа, нохой, их, айх
11. Би, гудамж, найз, тааралдах
12. Та, би, ойлгох?
13. Та, би, олон, цаг, хүлээх?
14. Багш, хүүхдүүд, дуудах
15. Би, театр, Ганхүү, харах
16. Та, би, дуудах? Би, та, сонсох(гүй)
17. Хүү, аав ээж, их, санах
18. Ээж, хүү, загнах, болох?
19. Та, би, утасдах?
20. Тэр, та, утасдах

Шинэ үгс: тааралдах — to run into, загнах — to scold

Дасгал 6

Үгсийг орчуулж, үг тус бүр дээр өгүүлбэр зохио. (Translate the words and make sentences with each of them.)

1. classmates
2. schoolmates
3. co-workers
4. city people
5. countryside people
6. family members
7. roommates
8. assembly people, church people

Дасгал 7

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Хүмүүс юу юу хийх (яах) ёстой вэ?
2. Хүүхдүүд юу хийх (яах) ёстой вэ?
3. Хүмүүс бие биенийгээ хайрлах ёстой юу?
4. Хүмүүс бие биенийгээ хүндлэх ёстой юу?
5. Хүмүүс бие биенийгээ уучлах ёстой юу?

Дасгал 8

Эхний баганан дахь жишээний адилаар баганууды дээрээс доош бөглө. Тэгэхдээ өмнөх бөглөсөн баганаа цаасаар дараад дараагийн баганаа бөглө. Ямар нөхцөл бичихээ мэдэхгүй бол цаасаа сөхөж хараад үргэлжлүүлэн бичээд бичсэн өгүүлбэрээ чанга унш. (Fill out the columns from top to bottom. Each time, cover the completed columns with paper and fill out the next one. If you are not sure which suffix to use, you may look at the example from the first column and keep going. Read out loud the sentences you wrote. The first column has been completed for you.)

Би ээж...	**Би** багш...	**Би** нөхөр...	**Би** хүүхдүүд...	**Би** монгол хүмүүс...	**Би** ах...	
ээжтэйгээ						**яримаар байна.**
ээжийгээ						**хүлээж байна.**
ээжтэйгээ						**мэндэлдэг.**
ээжийгээ						**урьсан.**
ээждээ						**дуу заана.**
ээжээсээ						**айдаггүй.**
ээжийгээ						**санана.**
ээждээ						**хэлсэн.**
ээжийгээ						**гомдоохгүй.**
ээжээсээ						**асууна.**
ээж рүүгээ						**утасдах хэрэгтэй.**
ээжтэйгээ						**уулзаагүй.**
ээждээ						**баярладаг.**
ээжийгээ						**таниагүй.**
ээжээсээ						**уучлалт гуйна.**
ээжийгээ						**харсан.**
ээждээ						**тусалдаг.**
ээжийгээ						**дуудмаар байна.**

Дасгал 9

Бичсэн жишээний адилаар хүснэгтийг эгнээ эгнээгээр нь бөглө. Ямар нөхцөл бичихээ мэдэхгүй бо. Дасгал 8-аас хараарай. (Fill out the table row by row as in the example. If you don't know which suffix to use, please look at Exercise 8.)

Би нөхөр/ эхнэр...	**Би** багш...	**Би** ээж...	**Би** хүүхдүүд...	**Би** монгол хүмүүс...	
					яримаар байна.
					хүлээж байна.
нөхөртэйгөө	багштайгаа	ээжтэйгээ	хүүхдүүдтэйгээ	хүмүүстэй	**мэндэлсэн.**
					урьсан.
					дуу заана.
					айдаггүй.
					санана.
					хэлсэн.
					гомдоохгүй.
					асууна.
					утасдах хэрэгтэй.
					уулзаагүй.
					баярладаг.
					таниагүй.
					уучлалт гуйна.
					харсан.
					тусалдаг.
					дуудмаар байна.

Тест 1

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Та аль цэцгийг авчирсан бэ?
   Б. Та аль цэцэг авчирсан бэ?
   В. Та алийг цэцэг авчирсан бэ?

2. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Багш надад дууг заасан.
   Б. Багш надад дуугийг заасан.
   В. Багш надад дуу заасан.

3. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Та энэ авч болно.
   Б. Та энийг авч болно.
   В. Та энэг авч болно.

4. This woman is a good person.
   А. Энэ эмэгтэй сайн хүн.
   Б. Энэ эмэгтэйг сайн хүн.
   В. Энэ эмэгтэйгийг сайн хүн.

5. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Би тантай дэлгүүр луу явъя.
   Б. Би тантай дэлгүүр луу явъе.
   В. Би тантай дэлгүүр луу явъё.

6. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Би одоо тоглоя.
   Б. Би одоо тоглоё.
   В. Би одоо тоглое.

7. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Би маргааш 6 цагт ирья.
   Б. Би маргааш 6 цагт ирье.
   В. Би маргааш 6 цагт ирьё.

8. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Нэг талх авя.
   Б. Нэг талх авая.
   В. Нэг талх авъя.

9. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Би цонх хаая.
   Б. Би цонх хааъя.
   В. Би цонх хаахя.

10. I won't go to the countryside soon.
   А. Би удахгүй хөдөө явахгүй.
   Б. Би мөд хөдөө явахгүй.
   В. Би удалгүй хөдөө явахгүй.

11. It will get cooler outside soon.
   А. Удахгүй гадаа хүйтэрнэ.
   Б. Удалгүй гадаа хүйтэрнэ.
   В. Мөд гадаа хүйтэрнэ.

12. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Тэд удалгүй явсан.
   Б. Тэд удахгүй явсан.
   В. Тэд мөд явсан.

13. Аль нь зөв бэ? Which one is right?
   А. Хүүхдүүд сургуульд сурдаг ёстой.
   Б. Хүүхдүүд сургуульд сурч ёстой.
   В. Хүүхдүүд сургуульд сурах ёстой.

14. Oh, no! My watch is broken.
   А. Өө, яана аа! Миний цаг эвдэрчихсэн.
   Б. Өө, яана аа! Миний цаг эвдэрчихжээ.
   В. Өө, яана аа! Миний цаг эвдэрлээ.

15. They just left. (I just sent them off.)
   А. Тэд дөнгөж сая явчихлаа.
   Б. Тэд дөнгөж сая явчихсан.
   В. Тэд дөнгөж сая явчихжээ.

16. (I know) she already went to America.
   А. Тэр Америк руу явчихлаа.
   Б. Тэр Америк руу явчихсан.
   В. Тэр Америк руу явчихжээ.

Оноо (point): 16/.....

Тест 2

7-р багананд байгаа үйл үгсийг аль багананд бичиж болохыг 3-р эгнээнд тэмдэглэсний адилаар тэмдэглэ. Үйл үг бүрт тэмдэглэсэн зөв хариулт бүрт нэг оноо өгнө. (Put a check mark in the column with the correct phrase to use with the words in column 7. See the example in row three. Every correct answer for verbs is worth one point.)

1	2	3	4	5	6	7
Би найзтайгаа	Би найздаа	Би найзаасаа	Би найз руугаа	Би найзаараа	Би найзыгаа	
					√	хүлээж байна.
						яримаар байна.
						мэндлээгүй.
						урьсан.
						дуу заана.
						айдаггүй.
						санахгүй.
						ном авсан.
						хэлэх үү?
						гомдоохгүй.
						асуухгүй.
						утасдах хэрэгтэй.
						уулзаагүй.
						баярладаг.
						таниагүй.
						уучлалт гуйна.
						харсан.
						туслахгүй.
						ойлгохгүй байна.
						итгэдэг.
						хүндлэх хэрэгтэй.

Оноо (point): 20/.....

Дөчин зургадугаар хичээл

Ярианд зарим үг хэрхэн хураагдан хэлэгдэх нь (How some words are shortened in spoken language)

Нийлмэл цагууд (Compound tenses)

-ж/-ч байна	[-jiin/-chiin]	am/is/are ...-ing
-ж/-ч байгаа	[-jaigaa/-chaigaa]	am/is/are ...-ing/have been ...-ing
-ж/-ч байсан	[-jaisan/-chaisan]	was/were ...-ing
-х гэж байна	[-hgjiin]	am/is/are about to
-х гэж байгаа	[-hgjaigaa]	am/is/are going to
-х гэж байсан	[-hgjaisan]	was/were going to

Жишээ:

явж байна	[yavjiin]	явах гэж байна	[yavahgjiin]
явж байгаа	[yavjaigaa]	явах гэж байгаа	[yavahgjaigaa]
явж байсан	[yavjaisan]	явах гэж байсан	[yavahgjaisan]

Асуух сул үгс (Question particles)

Question particles "**бэ**" and "**вэ**" are used:

- In official speech. For example: Та ямар ажил хийдэг вэ?
- When the questioner knows the answers but is asking someone questions as a test. For example: Энэ юу вэ? (Teacher asks students.)
- When the speaker is surprised. For example: Энэ юу вэ? [Ene yuuu veee?]

Question particle "**юм бэ**" is used in everyday speech, when asking people about themselves or things that they definitely know. It sounds like [ii]. For example:

Та хэдэн цагт ирэх юм бэ? [irhii]	What time will you come?
Энэ юу юм бэ? [yuii]	What is this?

.When people pronounce every word, it gives emphasis to the question. For example:

Та хэдэн цагт ирэх юм бэ? [ireh yum be] WHAT TIME WILL YOU COME?

Энэ миний ном уу?	Is this my book? (regular question)
Энэ миний ном юм уу?	A. Is this my book? (regular question)
	Б. IS THIS MY BOOK?

–сан[4] юм бэ?	[–sii]	–ж байгаа юм бэ?	[–jaigaaii]
–сан[4] юм уу?	[–siimuu]	–ж байгаа юм уу?	[–jaigaamuu]
–х юм бэ?	[–hii]	дуртай юм бэ?	[durtaiii]
–х юм уу?	[–hiimuu]	дуртай юм уу?	[durtaimuu]
–даг[4] юм бэ?	[–dii]	хэрэгтэй юм бэ?	[heregteiii]
–даг[4] юм уу?	[–diimuu]	хэрэгтэй юм уу?	[heregteimuu]

Дасгал 1

Үгсийг сонсоод дагаж хэл. (Listen to the words and then repeat them.)

авсан юм бэ?	идсэн юм бэ?	уусан юм бэ?
авах юм бэ?	идэх юм бэ?	уух юм бэ?
авдаг юм бэ?	иддэг юм бэ?	уудаг юм бэ?
авч байгаа юм бэ?	идэж байгаа юм бэ?	ууж байгаа юм бэ?
авч байсан юм бэ?	идэж байсан юм бэ?	ууж байсан юм бэ?
авах дуртай юм бэ?	идэх дуртай юм бэ?	уух дуртай юм бэ?
авсан юм уу?	идсэн юм уу?	уусан юм уу?
авах юм уу?	идэх юм уу?	уух юм уу?
авдаг юм уу?	иддэг юм уу?	уудаг юм уу?
авч байгаа юм уу?	идэж байгаа юм уу?	ууж байгаа юм уу?
авч байсан юм уу?	идэж байсан юм уу?	ууж байсан юм уу?
авах дуртай юм уу?	идэх дуртай юм уу?	уух дуртай юм уу?

Дасгал 2

Асуултуудыг сонсоод цээжил. (Listen to the questions and then memorize them.)

1. Энэ хэд юм бэ? [hedii] (Энэ ямар үнэтэй юм бэ? [üneteiii])
2. Чамайг хэн гэдэг юм бэ? [gedii]
3. Чи юу хийж байгаа юм бэ? Хичээлээ хийж байгаа юм уу?
4. Чи хаашаа явж байгаа юм бэ? Сургууль руугаа явж байгаа юм уу?
5. Чи хаана байсан юм бэ? Гэртээ байсан юм уу?
6. Та юу уух юм бэ? Кофе уух юм уу, цай уух юм уу?
7. Та юу идэх юм бэ? Бууз идэх юм уу, хуушуур идэх юм уу?

Дасгал 3

Багшаасаа хаана амьдардаг, юу хийх дуртай, юу хийсэн, юу хийх талаар асууж ярилц. (Ask your teacher about where he/she lives, what he/she likes to do, what he/she did or what he/she will do.)

Жишээ нь: Та хаана амьдардаг юм бэ?

Дасгал 4

Үгсийг сонсоод, бичгийн хэлбэрт оруулж бичээд, дараа нь тэдгээр үгсээ оролцуулан асуух өгүүлбэр зохио. (Listen to the words and change them into their proper written forms and then make interrogative sentences with them.)

Жишээ нь: [baisii]? → байсан юм бэ? → Та хаана байсан юм бэ?

1. [baisii]?
2. [baidiimuu]?
3. [yavhiimuu]?
4. [baihii]?
5. [yavsii]?
6. [yavhii]?
7. [baihiimuu]?
8. [yavdiimuu]?
9. [yavjaigaamuu]?
10. [baidii]?
11. [yavjaigaaii]?
12. [toglhii]?
13. [baigaamuu]?
14. [yavdii]?
15. [togldii]?
16. [baigaaii]?
17. [yavsiimuu]?
18. [togldiimuu]?
19. [toglsii]?
20. [irhii]?
21. [asuudii]?
22. [toglhiimuu]?
23. [irsii]?
24. [asuuhii]?
25. [togljaigaaii]?
26. [irdiimuu]?
27. [asuudiimuu]?
28. [toglsiimuu]?
29. [irgaigaaii]?
30. [asuusii]?
31. [togljaigaamuu]?
32. [irhiimuu]?
33. [asuujaigaamuu]?
34. [irjaigaamuu]?
35. [irdii]?
36. [asuuhiimuu]?
37. [irsiimuu]?
38. [asuusiimuu]?
39. [asuujaigaaii]

Дасгал 5

Асуултыг орчуулж, хариул. (Translate the questions and answer them.)

1. What is your name?
2. How old are you?
3. What do you do?
4. Where do you live?
5. Who do you live with?
6. What do you like to do?
7. What do you need to do?
8. What did you do yesterday?
9. What will you do tomorrow?
10. Where will you be at 6 o'clock?
11. What do you do everyday?
12. Who are you waiting for?
13. What are you eating?
14. What are you drinking?

Баяр хүргэх (To give congratulations)

— Баяр хүргэе!
— Баярын мэнд хүргэе!
— Төрсөн өдрийн мэнд хүргэе!
— Шинэ жилийн баярын мэнд хүргэе!
— Хүүхэдтэй болсонд тань баяр хүргэе!

— Congratulations!
— Happy holiday!
— Happy birthday!
— Happy New Year!
— Congratulations for having a new baby!

Дөчин долдугаар хичээл

билээ?/билүү? (again? (I forgot/I can't remember.))

The word "билээ" is used for sentences that have question pronouns. For example:

Та хаана амьдардаг **билээ**?	Where do you live, **again**?
Та хэзээ хичээлтэй билээ?	When do you have a lesson, again?
Та ямар ажил хийдэг билээ?	(I forgot.) What kind of work do you do?
Тэр юу билээ? [yuvilee]	What is that, again?

The word "билүү" is used for affirmative sentences that have no question pronouns. For example:

Та хөдөө амьдардаг **билүү**?	(**I forgot.**) Do you live in the countryside?
Та маргааш хичээлтэй билүү?	(I forgot.) Do you have a lesson tomorrow?
Та багш билүү?	Again, are you a teacher?

Дасгал 1

Доорх асуултуудыг олон дахин давтан хэлж, цээжил. (Repeat the questions below many times and memorize them.)

1. Өнөөдөр хэдэн билээ? Нэгэн билүү?
2. Өнөөдөр хэддэх (өдөр) билээ? Нэгдэх (өдөр) билүү?
3. Таны нэр хэн билээ? Гэрэлмаа билүү?
4. Чи хэдэн настай билээ? Арван настай билүү?
5. Чи юу идэх дуртай билээ? Жимс идэх дуртай билүү?
6. Танай гэр хаана байдаг билээ? Гуравдугаар хороололд байдаг билүү?

Дасгал 2

Өгөгдсөн нөхцөл байдлуудад тохирсон асуулт зохио. (Ask questions that are suitable for each situation.)

Жишээ нь: Та найзынхаа хүүгийн насыг санахгүй байна.
Танай хүү хэдэн настай билээ? 10 настай билүү?

1. Та нэг хүнтэй хаана уулзсанаа санахгүй байна.
2. Та төв шуудан хаана байдгийг санахгүй байна.
3. Та ном уншиж байгаад хаана зогссоноо санахгүй байна.
4. Та номоо хаана тавьснаа санахгүй байна.
5. Та хэдэн онд Монголд ирснээ санахгүй байна.
6. Та хэдэн цагт хичээл хийхээ санахгүй байна.
7. Та аль ангид хичээл хийхээ санахгүй байна.

Дасгал 3

Доорх асуултуудыг бие биенээсээ асууж, ярилц. Хариултаа бодож байхдаа "билээ, билүү"-г ашиглан өөрөөсөө асуу. (Ask each other the questions below and talk. Ask yourself questions using "билээ and билүү" to find the answers.)

Жишээ нь:
А: — Та хэзээ энэ цамцаа авсан бэ?
Б: — (Хэзээ авсан билээ? Хоёр жилийн өмнө авсан билүү, гурван жилийн өмнө авсан билүү?) Өө, тийм. Гурван жилийн өмнө авсан.

1. Та бугуйн цагаа (wrist watch) хэзээ, хаанаас, хэдэн төгрөгөөр авсан бэ?
2. Та уржигдар өглөө 10 цагт хаана байсан бэ?
3. Та өнгөрсөн амралтын өдрүүдээр юу хийсэн бэ?
4. Та уржигдар оройн хоолондоо юу идсэн бэ?
5. Та ирэх амралтын өдрүүдээр юу хийх вэ?
6. Таны хамгийн сайн найз юу идэх дуртай вэ?

биз дээ? (isn't it?/is it?, didn't you?/did you? etc.)

Та багш **биз дээ**?	You **are** a teacher, **aren't you**?
Та хоолоо **идсэн биз дээ**?	You **ate** your food, **didn't you**?
Та хоолоо идээгүй биз дээ?	You didn't eat your food, did you?
Ийм гутал үнэтэй биз дээ?	This type of boot is expensive, isn't it?
Монгол хоол амттай биз дээ?	Mongolian food is delicious, isn't it?
Чи ирнэ биз дээ? [irnizdee]	You will come, won't you?

When "биз дээ" is used after verb байгаа, sometimes just "биз" is used.

Гадаа халуун байгаа биз? [baigaaiz]	It's hot outside, isn't it?
Энэ цамц гоё байгаа биз? [goyaigaaiz]	This shirt is pretty, isn't it?
Энэ хоол амттай байгаа биз?	This food is tasty, isn't it?

Дасгал 4

Асуух сул үгс "уу/үү/юу/юү"-г "биз дээ"-гээр сольж, утгыг нь ярилц. Дараа нь асуултуудыг багшаасаа асууж, ярилц. (Replace the question particles "уу/үү/юу/юү" with "биз дээ" and discuss its meanings. Then ask your teacher the questions and talk about them.)

1. Америкт байр хямд уу?
2. Энэ таны ном уу?
3. Маргааш бороо орохгүй юү?
4. Та ирэх сард хичээл хийх үү?
5. Та хоолоо идсэн үү?
6. Та америк хүн үү?
7. Та надад туслах уу?
8. Та шөнө сайн амарсан уу?
9. Та өөх идэх дуртай юу?
10. Та шоколад идэх дургүй юү?
11. Та монгол дуу дуулж чадах уу?
12. Та гэрийнхээ бүх ажлыг хийдэг үү?
13. Монголын өвөл дулаан уу?
14. Та монгол гэрт амьдарч чадах уу?

Дасгал 5

Доорх өгүүбэрүүдийг орчуулаад өгүүлбэр болгоныг гурваас доошгүй удаа давтаж хэл. (Translate the sentences below and repeat each sentence at least three times.)

1. It's cold outside, isn't it?
2. It's nice outside, isn't it?
3. This bag is pretty, isn't it?
4. They are very tall, aren't they?
5. They are good people, aren't they?
6. My bag is heavy, isn't it?
7. City life is difficult, isn't it?
8. My house is far away, isn't it?
9. Fruit is cheap here, isn't it?
10. This work is easy, isn't it?
11. This car is expensive, isn't it?
12. This food is not delicious, is it?
13. This store is big, isn't it?
14. That man is a bad man, isn't he?

Шинэ үг: heavy — хүнд

тийм ээ? → т(ийм) ээ? → [тээ?] (right?)

Та багш, **тийм ээ**?
Та энэ сургуульд сурдаг, тийм ээ?
Танай нутаг их хүйтэн, тийм ээ?
Би номыг чинь өгсөн, тийм ээ?
Чи монгол хэл сурч байгаа, тийм ээ?
Хүү чинь дуулах дуртай, тийм ээ?
Энэ чинийх, тийм ээ?
Танайх 3-р хороололд байдаг, тийм ээ?
Бид нар маргааш хичээлтэй, тийм ээ?
Та хорин настай, тийм ээ?

You are a teacher, **right**?
You study in this school, right?
Your homeland is very cold, right?
I gave you your book, right?
You are learning Mongolian, right?
Your son likes to sing, right?
This is yours, right?
Your house is in third district, right?
We have a lesson tomorrow, right?
You are twenty years old, right?

Дасгал 6

Доорх өгүүлбэрийг "тийм ээ?" -г ашиглан асуух өгүүлбэр болго. Дараа нь өгүүлбэрээ чанга унш. (Make interrogative sentences out of the sentences below using "тийм ээ?", then read them out loud.)

Жишээлбэл: Та өнөөдөр хичээл заана. → Та өнөөдөр хичээл заана, тийм ээ?

1. Бид хоёр өмнө нь уулзсан.
2. Чи өнөөдөр хоол хийнэ.
3. Чи хичээлээс хоцордоггүй.
4. Өчигдөр цахилгаан тасарсан.
5. Та энийг зассан.
6. Чи өчигдөр энд байсан.
7. Чи ногоо идэх дургүй.
8. Та энийг хийж чадна.
9. Та нохойноос айдаггүй.
10. Бид нар маргааш хичээлгүй.
11. Би энд сууж болно.
12. Би маргааш энд ирэх хэрэггүй.
13. Та миний балыг авсан.
14. Маргааш дулаан болно.
15. Таны хичээл 6 сард дуусна.
16. Та хөдөө явах дуртай.
17. Танай ээж нөгөөдөр ирнэ.
18. Бид өмнө нь хамт сурч байсан.

Дасгал 7

Өгүүлбэрийг орчуулж, жишээ өгүүлбэрт бичсэний дагуу асуух сул үгсийг сольж бич. (Translate the sentences and change interrogative particles as in the example.)

Жишээ нь:
When did Burmaa come?
Бурмаа хэзээ ирсэн бэ?

Did she come yesterday?
Бурмаа өчигдөр ирсэн үү?

Бурмаа хэзээ ирсэн юм бэ?
Бурмаа хэзээ ирсэн билээ?
Бурмаа өчигдөр ирсэн биз дээ?

Бурмаа өчигдөр ирсэн юм уу?
Бурмаа өчигдөр ирсэн билүү?
Бурмаа өчигдөр ирсэн, тийм ээ?

1. What is your name?
2. Where were you born?
3. How old are you?
4. What do you do?
5. What time will our lesson start?
6. Which school are you studying at?
7. What language were you learning?
8. What do you like to eat?
9. Who do you need to meet now?
10. What was the homework?
11. What kind of food can you cook?
12. To whom do you teach English?

Is your name Saranhuu?
Were you born in Ulaanbaatar?
Are you 18 years old?
Are you a teacher?
Will it start at 9 o'clock?
Are you studying at this school?
Were you learning French?
Do you like to eat food with hot peppers?
Do you need to meet your director?
Was this the homework?
Can you cook Mongolian food?
Do you teach adults?

Дөчин наймдугаар хичээл

Ойрын ирээдүй цаг (Near future tense)

-х гэж байна	[-hgjiin]	am/is/are about to
-х гэж байгаа	[-hgjaigaa]	am/is/are going to
-х гэж байсан	[-hgjaisan]	was (were) about to/ was (were) going to

Тэд **хоол хийх гэж байна**.	They **are about to cook**.
Тэд **хоол хийх гэж байгаа**.	They **are going to cook**.
Тэд **хоол хийх гэж байсан**.	They **were about to** (were going to) **cook**.

Дасгал 1

Өгүүлбэрийг унш. (Read the sentences.)

1. Багш ангидаа ороод хичээлээ эхлэх гэж байна. [ehlehgjiin]
2. Тэд машиндаа суугаад явах гэж байна. [yavahgjiin]
3. Оюутнууд ширээнд суугаад хоолоо идэх гэж байна. [idehgjiin]
4. Би ирэх жил их сургуульд орох гэж байгаа. [orohgjaigaa]
5. Хүүхдүүд тэмцээнд оролцох гэж байгаа. [oroltsohgjaigaa]
6. Багш нар оюутнуудаас ирэх сард шалгалт авах гэж байгаа. [avahgjaigaa]
7. Манай ангийн хүүхдүүд хамт хичээлээ давтах гэж байгаа. [davtahgjaigaa]
8. Тэд хөдөө явах гэж байсан. [yavahgjaisan]
9. Би 10 цагт унтсан. Тэр үед ээж маань юм оёх гэж байсан. [oyohgjaisan]
10. Би орой найзынхаа гэрт очсон. Тэр хоол хийх гэж байсан. [hiihgjaisan]

Шинэ үгс: тэмцээн — competition, оролцох — to participate, шалгалт — exam, давтах — to review/to repeat, тэр үед — at that time, оёх — to sew

Дасгал 2

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. Please be quiet. My son is about to sleep.
2. Our lesson is about finished.
3. The children are about to play football outside.
4. It's about to rain. Put up your tent.
5. Please be quiet. They are about to sing.
6. Next month I'm going to the countryside.
7. She is going to enter the university next year.
8. I'm going to buy a car next week.

9. I was going to go to the store but it rained and I couldn't go.
10. He was going to cook but the electricity went off and he couldn't cook.
11. I was going to ask you something but I just forgot it.
12. She came. That time, I was about to eat dinner.

Шинэ үгс: quiet — чимээгүй, tent — майхан, at that time — тэгэхэд

Дасгал 3

Зургуудыг хараад доорх асуултуудад хариул. (Look at the pictures and answer the questions below.)

1. Хэн юу хийх гэж байна (вэ)?
2. Хэн юу хийх гэж байсан бэ? Тэгээд яасан бэ?



Эрүүл мэндтэй холбоотой хэллэг (Some expressions related to health)

— Эмчид үзүүлээрэй.
— Эм уусан уу?
— (Таны) бие сайн уу?
— Бие чинь яаж байна?
— Бие чинь гайгүй юү?
— Юу чинь өвдөж байна?
— Түргэн эдгээрэй.
— Биеэ сайн бодоорой.
— Сайн амраарай.

— Please go see a doctor.
— Did you take any medicine?
— How are you?
— How are you feeling?
— Are you feeling better?
— What is hurting?
— Please get well quickly.
— Please take good care of yourself.
— Please rest well.

Дөчин есдүгээр хичээл

"нь" нөхцөлийн хэрэглээ (Usages of "нь")

1. **нь = his/her/it's/their**
   Гэр нь хөдөө байдаг. (His/their house is in the countryside.)
2. **нь = something mentioned earlier**
   Би кино үзсэн. Дараа нь унтсан. (I watched the movie. After that (I watched the movie) I went to bed.)
3. **нь = of them (of a group)**
   Тэнд таван ном байгаа. Нэг нь минийх. (There are five books. One of them is mine.)
4. **verb + нь = verb+ing (Subjective clause)**
   Их сургуульд сурсан нь дээр. (Studying in a university is better.) Also it is used a lot in titles.
   Улаанбаатарт ирсэн нь (Coming to Ulaanbaatar)
5. **нь = your (It shows closeness.)**
   Ээж нь чамд цүнх авсан. (I (who am your mother) bought you a bag.)
6. **нь (ээ) = I found out that ... (From some reason)**
   Би танайд очиж чадахгүй нь ээ. (I found out that I can't come to your house.)

Дасгал 1

Өгүүлбэрийг "нь" нөхцөлийг ашиглан орчуул. (Translate the sentences using the suffix "нь.")

Жишээ нь: I know his friend well. → Би найзыг нь сайн мэднэ.
I bought boots and they (their colors) are brown. → Би гутал авсан. Өнгө нь бор.

1. My friend's name is Enhmaa. Her house is in the third district. Her mother is a teacher and her father is a singer. She has three brothers. Her oldest brother lives in Korea. Her middle brother lives in Japan and her youngest brother lives in China.
2. I stayed in my friend's house for one week. His apartment has four rooms. Its biggest room has three windows. Its smallest room has one window.
3. I went to one country. Its people are very nice. The food is very delicious. Its weather is very beautiful.
4. I like to go to that restaurant. Its owner is my friend. The food at that restaurant is delicious and inexpensive. Its waiters are very fast.

Дасгал 2

Өгүүлбэр болгонд "нь"-тэй гурваас доошгүй өгүүлбэр бич. (Write at least three sentences with "нь" for each sentence.)

1. Хамгийн сайн найзынхаа талаар бич.
2. Очих дуртай рестораныхаа тухай бич.
3. Өөрийн сайн мэддэг нэг улсын талаар бич.

Дасгал 3

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь: I cooked, then I read a book yesterday. → Би өчигдөр хоол хийсэн. Дараа нь ном уншсан.

1. They will sing, then they will dance.
2. We do our lesson in the afternoon, then we play football outside.
3. Clean the house, then cook. Don't sleep.
4. Help your mother, then do your homework. Don't just sit.
5. Tomorrow I will have my lesson, then come home, then I will have my lunch, then I will go to the store.
6. First read, then translate.
7. First wash your hands, then eat your food.
8. First work, then ask for money.
9. First sit, then write.
10. First rest, then work.
11. First talk to him, then talk to his parents.
12. First take this medicine, then take that medicine.
13. First ask your friend, then take her book.
14. First ask your friend for forgiveness, then ask for help.

Дасгал 4

Асуулт болгонд "Дараа нь"-г ашиглан таваас доошгүй хариулт бич. (Write at least five answers with "Дараа нь" for each question.)

1. Та өчигдөр юу юу хийсэн бэ?
2. Та маргааш юу юу хийх вэ?
3. Та сургууль дээрээ юу юу хийдэг вэ?
4. Бууз яаж хийдэг вэ?
5. Би байр авах хэрэгтэй байна. Би юу юу хийх хэрэгтэй вэ?

Дасгал 5

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

Жишээ нь:
There are three children. One of them is my child and two of them are my friend's children.
Тэнд гурван хүүхэд байна. Нэг нь манай хүүхэд, хоёр нь манай найзын хүүхэд.

1. There are many people outside of the school. Some of them are students, some of them are teachers. Some of them are sitting and some of them are standing.
2. There are books on the table. Three of them are blue and four of them are white. One of them is red. The biggest one (of them) is mine. The smallest one (of them) is my friend's. The red

one (of them) is the Mongolian language book.

3. There are ten children in that room. Five of them are girls and five of them are boys. Some of them are Mongolian, some of them are American. The boy (of them) with the red shirt will sing. The tall girl (of them) will dance. Three of them will play music.
4. There are four paper birds. I made one of them and she made three of them.
5. There were three apples on the table. I ate one of them and my sister ate two of them.
6. There are some shirts. I want to buy the yellow one. That man wants to buy two of them. That woman wants to buy the big one.
7. There are my friends. I bought notebooks for two of them and pens for three of them. I asked one of them about the movie.

Дасгал 6

Доорх зургуудыг хараад "нь" нөхцөлийг ашиглан өгүүлбэр зохиож бич. (Look at the pictures below and make sentences using the suffix "нь.")

Жишээ нь: Нэг нь дуулж байна.



Дасгал 7

Өгүүлбэрийг унш. (Read the sentences.)

1. Би энэ ажлыг хийж чадахгүй нь ээ. ((I found out that) I can't do this work.)
2. Би энийг орчуулж чадахгүй нь ээ. ((I found out that) I can't translate this.)
3. Найз маань ирэхгүй нь ээ. ((I found out that) my friend won't come.)
4. Энэ ажиллахгүй нь ээ. ((I found out that) this won't work.)
5. Бороо мөд зогсохгүй нь ээ. ((I found out that) rain won't stop soon.)
6. Ээж ээ, охин нь байна аа. (Mom, this is me (who is your daughter).)
7. Найз нь чамд тусална. (I (who am your friend) will help you.)
8. Ах нь завгүй байна. Ахыгаа битгий хүлээгээрэй. (I (who am your brother) am busy. Please don't wait for me (who am your brother).)
9. Хүү нь удахгүй ирнэ ээ. (I (who am your son) will come soon.)

Тавьдугаар хичээл

л = зөвхөн (only)
ч = бас (also)

Туяа л англиар сайн ярьж чадна.	**Only Tuya** can speak English well.
Зөвхөн Туяа англиар сайн ярьж чадна.	**Only Tuya** can speak English well.
Туяа **англиар л** сайн ярьж чадна.	Tuya can speak well **only in English**.
Туяа **зөвхөн англиар** сайн ярьж чадна.	Tuya can speak well **only in English**.
Туяа англиар **ярьж л** чадна.	Tuya can **only speak** in English well.
Туяа англиар **зөвхөн ярьж** чадна.	Tuya can **only speak** in English well.
Туяа ч англиар сайн ярьж чадна.	**Also Tuya** can speak well in English.
Туяа бас, англиар сайн ярьж чадна.	**Also Tuya** can speak well in English.
Туяа **англиар ч** сайн ярьж чадна.	Tuya can speak well **in English also**.
Туяа **англиар бас** сайн ярьж чадна.	Tuya can speak well **in English also**.

Дасгал 1

Дээрх өгүүлбэрүүдийн адилаар "л, ч, зөвхөн, бас" гэсэн чимэх үгсийг боломжтой газар нь тавьж, утгыг нь багштайгаа ярилц. (Add "л, ч, зөвхөн, бас" in all possible places as in the sentences above and talk about the different meanings with your teacher.)

1. Баатархүүгийн ах Монгол Улсын Их Сургуулийг төгссөн.
2. Бид монгол гэрт амьдрах дуртай.
3. Та энэ ажлыг хийж чадна.
4. Их дэлгүүрийн ард солонгос ресторан байдаг.
5. Би өчигдөр дэлгүүрээс нэг ном авсан.
6. Би Америкт таван жил ажил хийсэн.
7. Монголчууд энэ заншлыг сайн мэднэ.
8. Би дүүтэйгээ машинаар явна.
9. Хүүхдүүд өглөө сүүтэй будаа иддэг.
10. Америкчууд кофе уух их дуртай.
11. Сүхүү өчигдөр найзтайгаа ярьсан.
12. Жаргалмаагийн ах нар модон тоглоом хийж чадна.

Шинэ үг: заншил — tradition

орчим (-аад) — about, гаруй — more than, шахам — almost

Тэр эмэгтэй **40 орчим** настай.	That woman is **about 40** years old.
Тэр эмэгтэй **40-өөд** настай.	That woman is **about 40** years old.
Тэр эмэгтэй **40 гаруй** настай.	That woman is **more than 40** years old.
Тэр эмэгтэй **40 шахам** настай.	That woman is **almost 40** years old.

Дасгал 2

Орчим, гаруй, шахам гэдэг үгсийг ашиглан асуултад хариул. (Answer the questions using the words орчим, гаруй and шахам.)

1. Та хэдэн номтой вэ?
2. Та байрны мөнгөнд сард хэдэн төгрөг өгдөг вэ?
3. Та хэдэн жил ажилласан бэ?
4. Та төрсөн нутагтаа хэдэн жил амьдарсан бэ?
5. Танай мужийн хүн ам хэд вэ?
6. Америкийн хүн ам хэд вэ?
7. Нэг кило мах ямар үнэтэй байгаа вэ?
8. Долларын ханш хэдтэй байгаа вэ?
9. Таны монгол хэлний ном хэдэн хуудастай вэ?
10. Танай ерөнхийлөгч хэдэн настай вэ?

Шинэ үгс: нутаг — home land, муж — state, хүн ам — population, ханш — rate, хуудас — page, ерөнхийлөгч — president

Дасгал 3

Унш. (Read.)

хэд (how many)	**хэдүүлээ (how many of you, etc.)**	**хэд дахин (how many times)**	**хэд хэдээр (how many at a time)**
нэг	ганцаараа		нэг нэгээр
хоёр	хоёулаа	хоёр дахин	хоёр хоёроор
гурав	гурвуулаа	гурав дахин	гурав гурваар
дөрөв	дөрвүүлээ	дөрөв дахин	дөрөв дөрвөөр
тав	тавуулаа	тав дахин	тав таваар
зургаа	зургуулаа	зургаа дахин	зургаа зургаагаар
долоо	долуулаа	долоо дахин	долоо долоогоор
найм	наймуулаа	найм дахин	найм наймаар
ес	есүүлээ	ес дахин	ес есөөр
арав	арвуулаа	арав дахин	арав арваар

Дасгал 4

Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та гэртээ хэдүүлээ амьдардаг вэ?
2. Та нар ангидаа хэдүүлээ сурдаг вэ?
3. Та өрөөндөө хэдүүлээ ажилладаг вэ?
4. Хамгийн сүүлд та нар хэдүүлээ хөдөө явсан бэ?
5. Байрны үнэ 15 жилийн өмнөхөөс хэд дахин нэмэгдсэн бэ?
6. Махны үнэ 10 жилийн өмнөхөөс хэд дахин нэмэгдсэн бэ?
7. Та чихрийг хэд хэдээр нь иддэг вэ?
8. Та мөнгийг хэд хэдээр нь тоолдог вэ?
9. Та витаминыг хэд хэдээр нь уудаг вэ?

Шинэ үгс: сүүлд — last time, нэмэгдэх — to be added/to be increased

Дасгал 5

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. — How many of you went to the countryside?
   — Five of us went to the countryside.
2. — How many of you live in your house?
   — 10 of us live in our house.
3. — How many of them study together?
   — 40 of them study together.
4. — How many of us were in the ger yesterday?
   — 25 of us were there.
5. Eat twice as much food as this.
6. I paid her five times as much money.
7. I worked so fast and I did twice as much work as last week.
8. You have to pay twice as much as this.
9. Eat these fruits one by one.
10. Sit in two's together. (Sit together by two's.)
11. Put in groups of five. (Put 5 by 5.)
12. Put apples in the bags, ten by ten. (... 10 per bag.)
13. Take this medicine two at a time, three times a day.

Давтлага хичээл

Дасгал 1

Үйл үгийг бичгийн хэлбэрт оруулж бич. (Write the verbs in appropriate written form.)

Жишээлбэл: Та хаана [baisii]? → Та хаана байсан юм бэ?

1. Та ямар хоол [idsii]?
2. Тэд нар хэзээ [yavhii]?
3. Та нар юу [hiijaigaaii]?
4. Чи манайд [irsiimuu]?
5. Чи юу идэх [durtaiii]?
6. Танай гэр хаана [baidii]?
7. Би энийг авч [bolhiimuu]?
8. Чи энэ цамцыг хэзээ [avsii]?
9. Чи энийг хийж [chadhiimuu]?
10. Та хаашаа явах [heregteiii]?
11. Та жимс идэх [durtaimuu]?
12. Та маргааш энд [baihiimuu]?
13. Та нар одоо ажиллах [heregteimuu]?
14. Та нар хичээлээ [hiijaigaamuu]?

Дасгал 2

Өгүүлбэрүүдийн ялгааг багштайгаа ярилц. (Talk about the differences between the sentences with your teacher.)

1. Таны нэр хэн билээ?
2. Таны нэр Болдхүү билүү?
3. Таны нэр Болдхүү биз дээ?
4. Таны нэр Болдхүү, тийм ээ?
5. Тэр хүн хэн билээ?
6. Тэр хүн таны найз билүү?
7. Тэр хүн таны найз биз дээ?
8. Тэр хүн таны найз, тийм ээ?
9. Банк хаана байдаг билээ?
10. Банк циркийн ард байдаг билүү?
11. Банк циркийн ард байдаг биз дээ?
12. Банк циркийн ард байдаг, тийм ээ?

Дасгал 3

Өгүүлбэрийг орчуул. (Translate the sentences.)

1. I'm looking at one picture of a street. One woman is about to go into the store. Two girls are sitting outside and they are about to eat apples. One man is about to get into the bus (автобусанд суух). One boy is about to drink juice.
2. My family is going to do many things next year. I'm going to study at a university and my sister is going to work at a hospital. My parents are going to buy a new apartment. My younger brother is going to enter secondary school.
3. They were going to go to the countryside but it rained so much and they couldn't go.
4. I was going to play in that team last month but I was sick and couldn't play. Next month I'm going to play in that team.

Дасгал 4

А. Биед хамаатуулах "нь" нөхцөлийг хэрэглэн сайн найзынхаа талаар ярь.
(Talk about your good friend using the suffix "нь.")
Б. "Дараа нь" гэдэг холбох үгийг ашиглан өгөгдсөн нөхцөл байдлуудад тохирсон зөвлөгөөг өг. (Give advice that suits the given situations using the conjuction "дараа нь.")

Жишээ нь: Би англи хэл сайн мэдэхгүй. Гэхдээ юм орчуулмаар байна.
Зөвлөгөө (Advice): Чи эхлээд англи хэл сайн сураарай. Дараа нь юм орчуулаарай.

1. Надад мөнгө байхгүй. Гэхдээ би машин авмаар байна.
2. Би найзынхаа юмыг хэлэлгүй (without telling) авдаг.
3. Би олон хуушуур идсэн. Харин ус уугаагүй. Одоо дахиад хуушуур иднэ.
4. Би пицца хиймээр байна. Харин би пицца яаж хийдгийг мэдэхгүй.
5. Би гэрийн даалгавраа хийгээгүй. Гэхдээ гадаа тогломоор байна.

В. Асуултад хариул. (Answer the questions.)

1. Та хэдэн сайн найзтай вэ? Хэд нь оюутан, хэд нь ажилчин бэ?
2. Та хэдэн номтой вэ? Хэд нь монгол, хэд нь англи ном бэ?
3. Та хэдэн цамцтай вэ? Хэд нь зуны, хэд нь өвлийн цамц вэ?
4. Та хэдэн гуталтай вэ? Ямар ямар өнгөтэй вэ?

Дасгал 5

Өгүүлбэрүүдийг унш. (Read the sentences.)

1. Та ч энийг хийж чадна.
2. Та л энийг хийж чадна.
3. Би зөвхөн нэгдэх өдөр хичээлгүй.
4. Би нэгдэх өдөр ч хичээлгүй.
5. Аав онгоцоор л явах дургүй.
6. Аав онгоцоор ч явах дургүй.
7. Би савхаар л хоол иддэг.
8. Би савхаар бас хоол иддэг.
9. Тэр зөвхөн монголоор сайн ярьдаг.
10. Тэр монголоор ч сайн ярьдаг.
11. Тэр өчигдөр л тоглоогүй.
12. Тэр өчигдөр ч тоглоогүй.

Дасгал 6

Туслах үгс "орчим, гаруй, шахам" -ыг ашиглан асуултад хариул. (Answer the questions using the words "орчим, гаруй and шахам.")

1. Танай улсын/Монголын хүн ам хэд вэ?
2. Танай төрсөн хотын/Улаанбаатар хотын хүн ам хэд вэ?
3. Та хэдэн найзтай юм бэ?
4. Та хэдэн монгол хүн таньдаг вэ?
5. Та Монголд хэр удаж байна вэ?
6. Монголд/Танай оронд нэг кило мах/цагаан будаа/төмс/гурил ямар үнэтэй байна вэ?

Тест

Зөв хариултуудын өмнөх үсгийг дугуйл. Зөв хариулт бүр нэг оноо авна.
(Circle the letters in front of the correct answers. Every correct answer is worth one point.)

1. Чи хаана байх юм бэ?
   А. [baihii]
   Б. [baisii]
   В. [baidii]

2. Та хаашаа явж байгаа юм бэ?
   А. [yavjaigaa]
   Б. [yavjaisii]
   В. [yavjaigaaii]

3. Чи хэдэн номтой юм бэ?
   А. [nomtoiii]
   Б. [nomtoi]
   В. [nomtoimuu]

4. Та маханд дургүй юм уу?
   А. [durguuyu]
   Б. [durguuii]
   В. [durguumuu]

5. What is this again?
   А. Энэ юу юм бэ?
   Б. Энэ юу билээ?
   В. Энэ юу билүү?

6. Is this yours? (I can't remember.)
   А. Энэ таных юм бэ?
   Б. Энэ таных билээ?
   В. Энэ таных билүү?

7. This is your hat, isn't it?
   А. Энэ таны малгай билүү?
   Б. Энэ таны малгай, тийм ээ?
   В. Энэ таны малгай биз дээ?

8. You are Enhmaa's mother, right?
   А. Та Энхмаагийн ээж, тийм ээ?
   Б. Та Энхмаагийн ээж биз дээ?
   В. Та Энхмаагийн ээж билүү?

9. Тэд дуулах гэж байна.
   А. [duulahgjiin]
   Б. [duuljiin]
   В. [duulahgjaisan]

10. Би Герман руу явах гэж байгаа.
   А. [yavahgjiin]
   Б. [yavjaigaa]
   В. [yavahgjaigaa]

11. Тэдний ажил дуусах гэж байсан.
   А. [duusahgjiin]
   Б. [duuschiin]
   В. [duusahgjaisan]

12. I eat only vegetables.
   А. Би ногоо л иддэг.
   Б. Би ногоо ч иддэг.
   В. Би ногоо бас иддэг.

13. You can do this too.
   А. Та зөвхөн энийг хийж чадна.
   Б. Та ч энийг хийж чадна.
   В. Та л энийг хийж чадна.

14. Хорин хоёр
   А. Хорь шахам
   Б. Хорь гаруй
   В. Хорь орчим

15. Арван есөөс хорин нэг
   А. Хорь шахам
   Б. Хорь гаруй
   В. Хорь орчим

16. Арван ес
   А. Хорь шахам
   Б. Хорь гаруй
   В. Хорь орчим

Оноо (point): 16/.....

Дасгалуудын хариу (Key to Exercises)

Гуравдугаар хичээл

Дасгал 2, 3

Brother's heart

One night when Torhuu left his office and came close to his car, one boy with tattered clothes was going around his brand new car and looking at it with admiration. When the boy asked Torhuu "Is this your car?" he said to him "Yes, my brother gave this to me as a gift for my birthday." The boy said "Wow! If I ..." and he became silent. Torhuu thought maybe he wished to have a brother like his, but when he heard what the boy said, he was very surprised. The boy said "I wish I was a brother like yours."

When Torhuu asked the boy "Do you want to go in this car?," he said yes and got into his car. They went a little way and the boy said "Would you please stop next to the stairs." He got out of the car and run upstairs. After a little while, he carried his crippled brother on his back and came down stairs and said to him "His brother gave this car to him as a gift for his birthday. One day I will give you a car as a gift too and you will go yourself in your car and will see the things I told you about."

Дасгал 4

Friends

One blind girl hated everyone. She even hated herself too. She had a boyfriend with whom she shared both her happy and difficult times. One day the girl said to her boyfriend "If I get a chance to see this world even one time, I will marry you and live with you all my life."

Soon after that day, one eye donor was found and she had eye surgery. The girl wanted to see her boyfriend first and when the doctor took her bandage off, her boyfriend was standing in front of her and his two eyes were bandaged. Exactly at that moment, her desire to be married to him went away. When her boyfriend asked her, "You will marry me, won't you?" she didn't say anything.

After some days, she received one message from her boyfriend and it said "Please take care of your two eyes. They were mine!"

Дасгал 5

The honest boy

Erdene's parents told him "You are playing football and not doing your lesson. We will watch tomorrow's competition and make a decision about whether you will play football later on or not."

The competition was very interesting and it was the last game, Eredene's team played with one team for the city championship. Both teams had got one goal each. Because time was almost over, it was very important to get another goal. One boy from Erdene's team passed the ball to him and he got a goal. The children were very happy and they were congratulating him, but he wasn't excited. After some minutes, it was time to get the award, but Erdene refused to take it. People were very surprised. Erdene asked the people for forgiveness and he told them when his teammate passed the ball to him, it touched his hand.

Дөрөвдүгээр хичээл

Дасгал 5

А. миний, таны, Улаанбаатар, Монгол, цүнх, оюутан, харандаа, төгрөг, доллар, багш, дэвтэр, ном

Дасгал 6

А.

1. –тай	5. –тай	9. –тэй	13. –тай
2. –тэй	6. –тэй	10. –тэй	14. –тай
3. –тай	7. –тай	11. –тэй	15. –тэй
4. –тэй	8. –тэй	12. –тай	16. –той

Б. 1-12 –гүй

Тавдугаар хичээл

Дасгал 1

1. харандаатай юу?/харандаатай вэ?
2. сандалтай юу?/сандалтай вэ?
3. цүнхтэй юү?/цүнхтэй вэ?
4. эгчтэй юү?/эгчтэй вэ?
5. дүүтэй юү?/дүүтэй вэ?
6. дүүтэй юү?/дүүтэй вэ?
7. найзтай юу?/найзтай вэ?
8. жолоочтой юу?/жолоочтой вэ?
9. охинтой юу?/охинтой вэ?
10. хүүтэй юү?/хүүтэй вэ?
11. оюутантай юу?/оюутантай вэ?
12. хүүхэдтэй юү?/хүүхэдтэй вэ?
13. багштай юу?/багштай вэ?

Дасгал 2

1–10 вэ?

Дасгал 3

1. Би хоёр үзэгтэй. Та хоёр үзэгтэй юү? Та хэдэн үзэгтэй вэ? Хэн хоёр үзэгтэй вэ?
2. Би сайн харандаатай. Та сайн харандаатай юу? Хэн сайн харандаатай вэ?
3. Багш арван ширээтэй. Багш арван ширээтэй юү? Багш хэдэн ширээтэй вэ? Хэн арван ширээтэй вэ?
4. Тэр сайн багштай. Тэр сайн багштай юу? Хэн сайн багштай вэ?
5. Би гурван ахтай. Та гурван ахтай юу? Та хэдэн ахтай вэ? Хэн гурван ахтай вэ?
6. Би нэг эгчтэй. Чи нэг эгчтэй юү? Чи хэдэн эгчтэй вэ? Хэн нэг эгчтэй вэ?
7. Би таван дүүтэй. Чи таван дүүтэй юү? Чи хэдэн дүүтэй вэ? Хэн таван дүүтэй вэ?
8. Тэр, хоёр найзтай. Тэр, хоёр найзтай юу? Тэр хэдэн найзтай вэ? Хэн хоёр найзтай вэ?
9. Тэр арван хүүхэдтэй. Тэр арван хүүхэдтэй юү? Тэр хэдэн хүүхэдтэй вэ? Хэн арван хүүхэдтэй вэ?

Дасгал 5

1. Би нэг эгч, хоёр ахтай.
2. Манай/Миний багш 125 номтой.
3. Тэр гэр сайн хаалгатай.
4. Танай/Таны ах цүнхтэй.
5. Тэр (эрэгтэй) байртай.
6. Тэр байргүй.
7. Би сайн найзтай.
8. Би муу найзгүй.
9. Тэр багш 20 оюутантай.
10. Энэ ресторан 50 сайн тавагтай.
11. Чи/Та ахтай юу?
12. Чи/Та хэдэн ахтай вэ?
13. Чи/Та дүүтэй юү?
14. Чи/Та хэдэн дүүтэй вэ?
15. Танай/Таны ах эхнэртэй юү?
16. Чи/Та номтой юу?
17. Чи/Та дэвтэртэй юү?
18. Чи/Та монгол найзтай юу?
19. Чи/Та хэдэн настай вэ?
20. Таны эхнэр/нөхөр хэдэн настай вэ?
21. Чи аягатай юу?
22. Чи халбагатай юу?

Дасгал 6

4. Энэ өгүүлбэр 4 үгтэй.

Дасгал 8

1. үү 2. үү 3. юу 4. юү 5. уу 6. үү 7. үү 8. үү 9. юу 10. юү 11. уу 12. үү 13. уу 14. үү 15. уу 16. үү 17. юү 18. юү 19. юү 20. уу 21. уу 22. үү 23. юү 24. уу 25. бэ 26. вэ 27. бэ 28. бэ 29. вэ 30. вэ

Дасгал 9

1. үү, үү 2. үү, үү 3. юу, юу 4. юү, юү 5. уу, уу 6. уу, уу 7. үү, үү 8. юү, юү 9. юу, юу 10. юү, юү

Нэгээс тавдугаар хичээлийн давтлага

Дасгал 2

Smile

A smile is free but it does so many things. It makes a person who is receiving it rich, but it doesn't make the person who is giving it poor. A smile happens in a few seconds, but sometimes it's never forgotten in a life time.

A smile brings happiness to homes and helps in businesses. When someone is tired, it brings rest, when someone is sad, it brings light and when someone is sick, it becomes medicine. A smile is in a generous heart and no one can buy it or steal it. If you want to make people happy, keep smiling.

Дасгал 5

1. Та машинтай юу?
2. Та хэдэн багштай вэ?
3. Та хэдэн ахтай вэ?
4. Чи монгол номтой юу?
5. Тэр эмэгтэй нөхөртэй юү?
6. Чиний дүү хэдэн настай вэ?
7. Та хүүхэдтэй юү?
8. Чи сайн найзтай юу?
9. Танай найз хэдэн настай вэ?
10. Танай ээж эгчтэй юү?

Дасгал 6

1. Тийм, энэ миний ном.
2. Үгүй, тэр миний харандаа биш.
3. Үгүй, энэ манай гэр биш.
4. Тийм, энэ манай машин.
5. Тийм, энэ манай аймаг.
6. Тийм, энэ миний ширээ мөн.
7. Энэ миний цүнх./Энэ чиний цүнх.
8. Тэр миний аяга./Тэр таны аяга.
9. Энэ үзэг./Энэ харандаа.
10. Би ахтай./Би эгчтэй.

Дасгал 7

өгүүлбэр — sentence
үсэг — letter
англи — English
аймаг — province
халбага — spoon
сэрээ — fork
хутга — knife
таваг — plate
эхнэр — wife
үг — word
хэл — language
биш — not
байр — apartment
нөхөр — husband
хүн — person
нас — age
